

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

2022 (80)
20 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237
ISBN 978-99929-62-31-3

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Нямдорж БАТСАЙХАН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Байгалийн ургамлыг хууль бусаар түүж бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь /Хуш модны самар түүж бэлтгэх жишээн дээр/	Я.Билэгдэмбэрэл	5
Терроризмоос урьдчилан сэргийлэх ажиллагаан дахь террорист зан байдал судлалын түүхэн хөгжил	Г.Насантогтох	12
Криптовалют ба хууль сахиулах ажиллагаа: тулгамдсан асуудал	Г.Хосбаяр	22
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх зүйн орчин: Хэрэгжилтийн өнөөгийн байдал	Ж.Бат-Эрдэнэ	28
Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүрэг	М.Уянга	40

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Хүн барьцаалах гэмт хэргийн объектив шинж, зүйлчлэлийн асуудал	Д.Сундуйсүрэн	49
Олон улсын гэмт хэрэг болон олон улсын шинжтэй гэмт хэрэг гэх ойлголтуудыг судлах нь	А.Отгонжаргал	58
Хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл: эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал	О.Хишигмөнх	64
Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдал, харьцуулсан судалгаа	Б.Батбаяр	78

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Эрүүгийн процессын эрх зүйн зарчим: түүх, философи	Н.Манлайбаатар	84
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангах нь	Б.Батзаяа	90

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын асуудал	Д.Бат-Орших	99
--	-------------	----

СУДЛААЧИЙН ҮЗЭЛ БОДОЛ

Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэхэд тулгамдсан асуудал	А.Пүрэвдулам	104
Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо, тулгамдсан асуудал	Ц.Түвшинбаяр	113
Улс төрийн намын үзэл суртлын өөрчлөлт, харьцуулсан судалгаа	А.Мөнхцэцэг	118
Төгсөгчийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ /ДХИС-ийн ЭЗНУС-ийн жишээн дээр/	Д.Бадамцэцэг Э.Хишигбайгаль	129

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫГ ХУУЛЬ БУСААР ТҮҮЖ БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРЭГ,
ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ
/ХУШ МОДНЫ САМАР ТҮҮЖ БЭЛТГЭХ ЖИШЭЭН ДЭЭР/**

*Я.Билэгдэмбэрэл
ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албаны
Эрүүгийн цагдаагийн хэлтсийн нэгдүгээр
тасгийн дарга, цагдаагийн хошууч,
докторант*

Товч агуулга: Байгалийн ургамал болох хуш модны самрыг хууль бусаар түүж бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлж байгаа үр ашгийг тооцох, эрх зүйн орчныг судалж, боловсронгуй болгох талаар санал-зөвлөмж боловсруулж, экосистемийн тэнцвэрт байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон болно.

Түлхүүр үг: Байгалийн ургамал, хуш модны самар, гэмт хэрэг, зөрчил, нөхцөл байдал, эрх зүйн орчин, эдийн засагт үзүүлж байгаа үр ашиг, экосистемийн тэнцвэрт байдалд үзүүлэх нөлөөлөл.

Удиртгал

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, тэр дундаа байгалийн ургамлыг хууль бусаар түүж бэлтгэх гэмт хэргийн ойлголт, нийгмийн хор аюул, бүрэлдэхүүний шинж талаас нь манай хуульч эрдэмтдээс академич С.Нарангэрэл¹, доктор (Sc.D), профессор С.Жанцан², Т.Сэнгэдорж³, Ж.Болбаатар⁴, доктор (Ph.D), профессор Н.Баатаржав⁵, Х.Доржпалам⁶, доктор (Ph.D), дэд профессор С.Гантулга, Б.Энхболд⁷, ургамлын зүй тогтол талаас нь судлаач Б.Удвал, Д.Хоролгарав,⁸ Г.Ганзориг, М.Хишигжаргал нар өөрсдийн бүтээлд дурдсан байна.

Харин хуш модны самрыг хууль бусаар түүж бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, эрх зүйн орчин, Монгол Улсын эдийн засагт үзүүлж байгаа үр ашгийг тооцсон нэг сэдэвт бүтээл хараахан байхгүй байна.

Эрх зүйн орчныг судалсан байдал

Монголчууд байгаль орчноо хайрлан хамгаалах арга ухааныг нүүдэлчин ахуй амьдралынхаа туршлагаас буй болгож, түүнийгээ олон зууны турш хүрээлэн байгаа байгаль орчныхоо экологийн тэнцвэрт байдлыг хангах иш үндэс, хууль дүрэм болгон даган мөрдөж хойч үедээ өвлүүлэн ирсэн бөгөөд энэ нь байгаль орчныг хамгаалах сэтгэлгээг хувь хүнд төлөвшүүлэх хүмүүжлийн өвөрмөц арга болж монголын хүн амын ихэнх хэсгийн дотор эдүгээг хүртэл хөгжиж ирсэн түүхэн уламжлалтай.

¹ Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. УБ.1998

² Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал) УБ.2004. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги) УБ.2003

³ Сэнгэдорж Т. Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал уламжлал шинэчлэл. Докторын зэрэг горилсон бүтээл.УБ.1994

⁴ Болдбаатар Ж. Эрүүгийн эрх зүй. (ерөнхий ба тусгай анги) УБ.2016, Эрүүгийн эрх зүй.

⁵ Баатаржав Н. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги. УБ.2012

⁶ Доржпалам Х. Эрүүгийн эрх зүйн тусгай анги. УБ., 2020

⁷ Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги (сурах бичиг).УБ.2018,

⁸ Удвал Б., Хоролгарав Д. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын ойн дагалт баялаг ашиглалт.УБ.2015. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн дагалт баялгийн ашиглалтын талаар хийсэн.эрдэм шинжилгээний өгүүлэл

Энэ утгаараа байгалийн ургамал болох хуш мод, самрыг хайрлан хамгаалах, зүй зохистой хэрэглээг дэмжиж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлэл, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж заасан нь бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох төрийн бодлогын үндэс суурь нь болсон байдаг.

Байгальд сибирийн болон Солонгос гэсэн хоёр зүйл хуш мод байдаг нь зөвхөн Оросын Холбооны Улс, Монгол Улсын газар нутагт байршин ургадаг экологийн болон эдийн засгийн чухал ач холбогдолтой шилмүүст мод юм. Хуш мод нь ойн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж ус, хөрсийг хамгаалахын зэрэгцээ ойн олон төрөл, зүйлийн амьтан, шувууны амьдрах орчин, хүнс, тэжээлийн бааз, нөөц нь болдог бөгөөд хушны самар буюу үр нь цаашид ойн нөхөн ургах, нас залуу байхад өндөр ач холбогдолтой ажээ.⁹

Манай орон нь сибирь хуш мод нөөцийн хэмжээгээрээ хэдийгээр энгийн нарснаас илүү боловч дэлхийд байх нөөц нь бага гэдэг утгаараа Монгол орны ховор ургамлын төрөл, зүйлд хамаардаг, нас гүйцсэн нь 30-40 метр өндөр, 400 хүртэл жил насалдаг, 25-45 насандаа үр өгч эхэлдэг, үрийн жил нь 5-7 жил тутамд давтагддаг бөгөөд самрын дундаас дээших ургацын хугацаа нь 2-4 жил байдаг.

Манай оронд дэлхийн хуш модны нөөцийн 1.8 хувь буюу 612.925 га талбай бүхий хушин ой Архангай, Баян-Өлгий, Булган, Төв, Завхан, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотын ногоон бүсэд тархан ургаж байгаагаас 488.58 га талбай нь улсын тусгай хамгаалалтай газар нутагт хамаарч байна.¹⁰

Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан нэн ховор, ховор, элбэг тархацтай гэж ангилдаг. Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтыг баталж 274 дугаарт Сибирийн хуш модыг ховор ургамалд оруулсан байдаг. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 165-р тогтоол, 2015 оны 410 дүгээр тогтоолоор түүний үр буюу самрыг 355 дугаарт нэмэлтээр ховор ургамлын жагсаалтад оруулсан байдаг.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал /хуш модны самар/, тэдгээрийн үр, эрхтнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь байгаль орчин, байгаль хамгаалах журам, ургамал хамгаалах, зохистой ашиглах журамд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.¹¹ Гэмт хэргийн объект нь байгаль орчин, байгаль хамгаалах журам, ургамал хамгаалах, зохистой ашиглах журам бөгөөд халдлагын зүйл нь нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр эрхтэн байна¹² гэж үзжээ. Дээрх эрх зүйн зохицуулалтаас харахад самрыг хууль бусаар түүж бэлтгэх, худалдан борлуулах нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл болж байна.

Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт 2020, 2021 онд самар түүж бэлтгэхээр ууланд давхардсан тоогоор 13.000 орчим иргэд гарч Экологийн цагдаагийн албанаас мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийслэлийн 2 дүүрэг, 3 аймгийн 5 сумын нутаг дэвсгэрт 9 удаагийн хяналт шалгалт зохион явуулж 2659 иргэний үйлдлийг таслан зогсоож, 524 тээврийн хэрэгслийг шалгаж, бүртгэл

⁹ “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт” эрдэм шинжилгээний хурал. Б.Ууганболд “Хуш модны самар түүж бэлтгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын асуудал” илтгэл. УБ.2022.


¹⁰ Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа “Ойн судалгаа хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас гаргасан тоон үзүүлэлт.

¹¹ Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги” сурах бичиг. УБ.,2020. 390 дэх тал

¹² Мөн тал

судалгаанд хамруулан, 216 отгийг буулгаж, 11 морьтой 1133 иргэнийг 101.6 тонн самрын хамт тусгай хамгаалалттай газар нутгаас гарган, гэмт хэргийн шинжтэй 12 үйлдлийг илрүүлсэн. 2020, 2021 онд Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн ууланд самар түүж байгаад 7 хүн гэмтэж, 21 хүн нас барсан тоон үзүүлэлт гаргасан байдаг.¹³

Экологийн цагдаагийн албаас авсан гэмт хэргийн тоон мэдээллээр 2020, 2021



онд хууль бусаар самар түүж бэлтгэх гэмт хэргийн шинжтэй нийт 37 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 29 буюу 78,3 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 7 буюу 18,9 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1 буюу

2,7 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн, 13 хэрэгт мөрдөн шалгах ажилллагаа явуулснаас 3 буюу 23 хувийг нь эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 8 буюу 61.5 хувийг нь хааж, 7 буюу 53,8 хувийг нь шүүхэд шилжүүлэн тус тус шийдвэрлэсэн байна.

Хууль бусаар самар түүж бэлтгэсэн иргэнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйлд заасны дагуу Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 8/5 дугаар тогтоолоор торгуулийн ял, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 2022/ШЦТ/164 дугаар шийтгэх тогтоолоор хорих ял тус тус оногдуулсан.

Эрх зүйн орчныг судалж, тоон үзүүлэлтээс харахад хууль бусаар самар түүж бэлтгэсэн иргэний үйлдлийг гэмт хэрэгт тооцож шалгалтын ажиллагаа явуулан шүүхээр эцэслэн шийдвэрлэж байгаа бөгөөд гэмт хэргийн шалтгаан нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/166 дугаар тушаалаар батлагдсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 хэсэгт зааснаар “ойн дагалт баялаг” гэж ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг хэлнэ гэж хуульчилсан.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8 дугаар зүйлд зааснаас гадна Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйл “Байгалийн ургамлын тухай хууль зөрчих”-ийн 1 дэх хэсэгт заасан “Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж”, 7.9 дугаар зүйл “Ойн тухай хууль зөрчих”-ийн 1 дэх хэсэгт заасан “Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн” бол гэсэн заалтуудтай давхцаж байдаг.


Зөрчлийн тухай хуульд “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” хэмээн тодорхойлсон.

“Байгалийн ургамлын тухай хууль зөрчих” зөрчил нь зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж, байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан; Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн

¹³ Экологийн цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан, 2020, 2021 оны сэтгүүл

газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн; Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан зэрэг шинжтэй байдаг.¹⁴

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас сүүлийн 4 жилийн хугацаанд самар түүж бэлтгэхтэй холбоотой зөрчилд арга хэмжээ тооцсон байдлыг графикаар үзүүлбэл:



Самар түүж бэлтгэсэн зөрчлийн үйлдлийг мэдээллийн хүснэгтээр харуулбал:

№	Хушны самартай холбоотой зөрчлүүд	Он							Бүгд
		2015	2016	2017	2018	2019	2020	2021	
1.	Хушны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар хууль бусаар тээвэрлэсэн зөрчлийн мэдээ	-	2	5	-	2	4	1	5
2.	Хууль бусаар тээвэрлэсэн хушны самрын хэмжээ /тонн/	-	110,0	2,5	-	1,0	1,9	1,0	16,4
3.	Торгуулийн хэмжээ /мян.төг/	-		3500,0	-	1000,0	4890,0	300,0	690,0

Дээр дурдсан хуулийн заалтууд, тоон үзүүлэлтээс үзэхэд дараах схемийг гаргаж болох юм.



Дүгнэлт: Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор самрыг ховор ургамалд, Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-т зааснаар “Ойн дагалт баялаг”-т давхардуулан оруулсан нь аль

¹⁴ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. Байгаль, орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь сургалтын гарын авлага.УБ., 2019он, 111 дахь тал

хуулийн заалтыг баримтлан шийдвэрлэх эсэх, гэмт хэрэг үү? Зөрчил үү? гэдгийг ялган зүйлчлэх боломжгүй байна.

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэн гарч байгаа шалтгааныг судлаачийн зүгээс дүгнэхэд самар түүж бэлтгэхээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-д заасны дагуу бэлтгэх талбайг зааж өгдөггүй, хяналт сул, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд нь самар түүж бэлтгэх гэрээг сумын Засаг даргатай байгуулж өөрсдийн ажилчдаар бэлтгүүлэх ёстой боловч гэрээний нөхцөлийн дагуу газар дээр нь очиж түүж бэлтгэхгүйгээр бусдаас өндөр үнээр худалдан авч, хяналт шалгалт ирсэн үед самар түүж бэлтгэх гэрээг үзүүлж хууль ёсны мэт харагдуулж байна гэж дүгнэж байна.

Байгалийн ургамал болох самрыг хууль бусаар түүж бэлтгэх, боловсруулахад эдийн засагт үзүүлж байгаа үр ашгийг тооцоолол, сөрөг нөлөөлөл

Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэгт “боловсруулаагүй ойн дагалт баялгийг экспортлох”-ыг, Байгалийн ургамлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно”¹⁵ гэж тус тус заасан нь самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж гадаад улсад экспортлох боломжгүй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/166 дугаар тушаалаар баталсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-д хуш модны самрын тухайн жилийн ургацын байдлыг ойн анги судалж тогтоон “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт ургацын байдлын мэдээ, дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д ирүүлснийг үндэслэн тухайн жилд самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах шийдвэрийг тухайн оны 09 дүгээр сарын 1-ний дотор бүсчлэн гаргадаг.

Монгол Улсын ойн сан бүхий 8 аймгийн 25 сумаас 2020 онд 25,233 тонн самар үйлдвэрийн зориулалтаар бэлтгэх боломжтой гэж Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-аас нөөц тогтоосон.¹⁶ Үүний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/577 дугаар тушаалаар Архангай, Булган, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий зэрэг 8 аймгийн 25 суманд хуш модны самрыг үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар бэлтгэх зөвшөөрлийг олгож, ойн дагалт баялаг бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй 67 аж ахуйн нэгжээс сумдын Засаг даргатай 32 нэр бүхий аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн зориулалтаар самар түүж бэлтгэх гэрээ байгуулж 20,186,400,000 /хорин тэрбум нэг зуун наян зургаан сая дөрвөн зуун мянга/-н төгрөгийн байгалийн дагалт баялаг ашигласны татварын¹⁷ орлого орон нутагт орсон.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/255 дугаар “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” тушаалаар Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий гэсэн 4 аймгийн 12 сумдын нутгаас хуш модны самрыг үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар бэлтгэх зөвшөөрлийг олгосон байна. Дээрх сумдад нийт 6000 тонн самрын нөөц байгааг сумын ойн анги тогтоож, сумын Засаг даргатай 21 аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн зориулалтаар самар түүж бэлтгэх гэрээ байгуулсан байна.

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгээс 2016 онд үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэсэн Хуш модны 1 килограмм самраас 700 грамм эдээ буюу чөмөг гарна гэж дүгнэлт гаргасныг үндэслэн Байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас аж ахуйн нэгжүүдэд нийт бэлтгэсэн самрын 70 хувьтай тэмцэх хэмжээний эдээ экспортлох зөвшөөрөл өгч байгаа бөгөөд 2020 онд нийт 17,663.17

¹⁵ Байгалийн ургамлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт

¹⁶ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан мэдээлэл

¹⁷ Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тогтоох тухай” А/125 дугаар тушаал.

тонн самрын эдээ экспортод гаргаж улсын төсөвт 52,989,510,000 /тавин хоёр тэрбум есөн зуун наян есөн сая таван зуун арван мянга/ төгрөгийн тэмдэгтийн хураамжийн татварын орлого орсон тооцоололтой байна.

Самар бэлтгэж экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг шалгах явцад ашиглаж туршилт хийж 1 килограмм самрыг яснаас нь салгаж эдээг өндөр температураар шарж чийгийг гаргаж хатаахад 400 грамм орчим эдээ гарч байгаа нөхцөл байдал тогтоогдсон бөгөөд 2020 онд бэлтгэсэн самраас 10,093.24 тонн орчим эдээ экспортод гаргах боломжтой байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зөвшөөрөл олгогдох 17,663.17 тонн самрын эдээг экспортлохын тулд аж ахуйн нэгжүүд нийт 44,157 тонн самар бэлтгэж, 18,925 тонн самрыг зохих зөвшөөрөлгүй, хууль бусаар бэлтгэсэн байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон.

Самрыг байгальд үлдээхгүй их хэмжээгээр илүү бэлтгэх нь зэрлэг амьтны идэж тэжээлгүй болох нөхцөл байдалд хүрч байна. Амьтад идэж тэжээлгүй болсны улмаас 2019 онд Сэлэнгэ, Төв аймаг, Хэнтий зэрэг аймгийн нутагт ойролцоогоор 70 орчим *баавгай уулнаас бууж ирсэн*¹⁸ тоо баримт байдаг.

Дүгнэлт: 2021 онд иргэд, аж ахуйн нэгжүүд 150,000,000,000 /нэг зуун тавин тэрбум/ орчим төгрөгийн ашиг хууль бусаар олж, улсын төсөвт орох 15,140,000,000 /арван таван тэрбум нэг зуун дөчин сая/ орчим төгрөгийн татварын орлого орохгүй, нийт 161,140,000,000 /нэг зуун жаран нэгэн тэрбум нэг зуун дөчин сая/ гаруй төгрөгийн далд эдийн засгийн эргэлт бий болсон байж болзошгүй гэж дүгнэж байна.

Нэгдсэн дүгнэлт

Дээрх судалгааны ажлаас дүгнэхэд Байгалийн ургамлын тухай хууль, Ойн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 153 дугаар тогтоол зэрэг эрх зүйн актуудад хуш модны самрыг нэр томъёоны хувьд давхардуулан тайлбарласан байгаа нь хууль бусаар түүж бэлтгэсэн үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь тодорхойгүй байдлыг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор самрыг ховор ургамалд тооцож бэлтгүүлснээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар 1 килограмм самар тутамд 14835-19780 төгрөгийн төлбөр төлөгдөж их ургацын жилүүдэд орон нутгийн төсөвт төвлөрөх орлого 18-24 дахин нэмэгдэх боломжтой. Энэхүү эрх зүйн зохицуулалт нь хэрэгжиж 2020 онд бэлтгэсэн 1 килограмм самар тутамд 14835 төгрөгийн байгалийн нөөц ашигласны төлбөр авсан бол 374.331.555.000 төгрөгийн орлого ойн сан бүхий орон нутгийн дансанд төвлөрч зарцуулагдах боломжтой байжээ. Мөн газар дээр нь очиж ажиллаагүй эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээллийг үндэслэн самрын нөөцгүй болсон газарт сумын Засаг дарга нь аж ахуйн нэгжтэй бэлтгэх талбайг зааж өгөхгүйгээр гэрээ байгуулж, иргэдийн түүж бэлтгэсэн самрыг худалдан авч байгаа нь иргэд самар түүх зорилгоор ууланд гарч нөхцөл байдлыг хүндрүүлэх, амь нас, эрүүл мэндээрээ хохирох шалтгаан болж байна гэж дүгнэж байна.

Санал

- Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь хэсэгт "ойн дагалт баялаг" хэмээн тодорхойлсон заалтаас самар гэсэн нэр томъёог хасаж, Сибирь хуш мод, үр, идээг ховор ургамлын жагсаалтад оруулсан эрх зүйн актыг нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлснээр, дүгнэлтэд дурдагдсан ач холбогдлуудаас гадна хуш модны үрийн нөөц бий болно.
- Байгальд ээлтэй технологиор хуш модны самрыг түүж бэлтгэх стандарт, журам боловсруулж дагаж мөрдүүлснээр ойн эрүүл ургалтад учрах сөрөг нөлөөллийг бууруулна.
- Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-д заасны дагуу тусгаарлалт хийж өгсөн

¹⁸ Niisleltimes.mn сайд 2019.10.07-ны өдрийн мэдээлэл

талбайгаас бэлтгүүлэн, иргэдээс худалдан авах үйл ажиллагааг зогсоосноос гэмт хэргийн гаралт буурах болно.

- Сибир хуш модны 1 килограмм самарнаас гарах идээний хэмжээг зөв тодорхойлж, түүнийг зөвшөөрөгдсөн хэмжээнд түүж бэлтгэж, гадаад улсад экспортлох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээс гарсан дүгнэлтийг эрх зүйн хэлбэрт оруулан дагаж мөрдүүлэх.

Ном зүй

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Ойн тухай хууль
- Ойн дагалт баялагийг зохистой ашиглах журам
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тогтоох тухай" А/125 дугаар тушаал

Ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

- Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. УБ.1998
- Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал) УБ.2004. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги) УБ.2003
- Болдбаатар Ж. Эрүүгийн эрх зүй. (ерөнхий ба тусгай анги) УБ.2016, Эрүүгийн эрх зүй.
- Баатаржав Н. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги. УБ.2012
- Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги /сурах бичиг/. УБ., 2020
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. Байгаль, орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь сургалтын гарын авлага.УБ., 2019

Илтгэл, өгүүлэл, сэтгүүл, тайлан

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан "Байгаль орчны мэдээлэл" сэтгүүл
- "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт" эрдэм шинжилгээний хурал. Б.Ууганболд "Хуш модны самар түүж бэлтгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын асуудал" илтгэл.УБ.2022
- Удвал Б., Хоролгарав Д. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын ойн дагалт баялаг ашиглалт. "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн дагалт баялгийн ашиглалт" эрдэм шинжилгээний өгүүлэл УБ.2015
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа "Ойн судалгаа хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газраас гаргасан тоон үзүүлэлт

ТЕРРОРИЗМООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ТЕРРОРИСТ ЗАН БАЙДАЛ СУДЛАЛЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Г.Насантогтох
Хууль зүйн магистр

Товч агуулга: Террорист зан байдал судлалын шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, терроризмоос урьдчилан сэргийлэх ажиллагаанд террорист зан байдал судлалыг ашиглаж байгаа туршлагын талаар дурдсан.

Түлхүүр үг: Терроризм, террорист, террорист зан байдал, урьдчилан сэргийлэх ажиллагаа, профайлинг.

Удиртгал

Терроризм нь улс төрийн стратегийн нэгд тооцогддог улс төрийн аливаа зорилгод хүрэх рационал хэрэгсэл бөгөөд энэ ч үүднээс террористуудын нийгэмд айдас, заналхийлэл төрүүлэх гол сэдэл нь олон нийтийн анхаарлыг татах явдал байдаг. Харин зарим эрдэмтдийн үзэж буйгаар терроризм бол улс төрийн тодорхой санаа зорилгогүй сэтгэцийн эмгэгтэй этгээдийн эсхүл аливаа төрлийн хатуу итгэл үнэмшилтэй бөгөөд *эмгэгт нарциссизм* мэтийн сэтгэл зүйн онцлог бүхий нийгэмд аюултай этгээдүүдийн оршихуйн төлөөлөл юм. Аль ч тохиолдолд терроризмын нийгэм учруулах аюул занал, хор хөнөөлийг урьдчилан тогтоох, хохирлыг бууруулах, түүнээс сэргийлэх арга ажиллагааг боловсруулах нь дэлхий дахины терроризмын эсрэг зарласан дайны (*War on Terror*) цөм юм. Иймд терроризмоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй, нарийн төлөвлөгдсөн аюулгүйн тогтолцоог бий болгохын тулд олон жилийн турш зохистой удирдлага дор шинжлэх ухаанч арга хэрэгслээр цуглуулж, бэлтгэсэн сэтгэлзүйн онцлог дүр төрхийг бий болгох хэрэгцээ шаардлага нь энэхүү салбар судлалын үндэс байв. *“Террорист профайлинг”* буюу террорист зан байдал судлалын арга зүйн үндсэн зорилго нь энгийнээс террорист этгээд болон энгийн иргэн хоорондын ялгааг зааглан тогтоох явдал юм. Терроризмын эсрэг хийсэн олон жилийн тэмцлийн явцад эрдэмтэд эдгээр хоёр бүлгийг хооронд нь ялгах олон төрлийн оролдлого хийсэн байдгаас тэдгээрийн хоорондын ялгааг сэтгэл зүй, нийгэм-эдийн засаг, бие махбод болоод арьс өнгөний хүрээнд судлан тогтоох хандлага хамгийн түгээмэл дэлгэрсэн байв.

XX зуунд террорист профайлинг буюу террорист зан байдал судлалын чиглэлээр эрдэмтэд олон жилийн турш арьсны өнгө, нас, хүйс, сэтгэл зүй – эмгэг судлал болон нийгэм-эдийн засгийн олон талт судалгаа боловсруулж энэ салбарын судалгааны тэргүүлэх параметруудийг тогтоосон. Харамсалтай нь, дээр дурдсан аргууд нь эмпирик болон прагматик түвшинд төдийлөн бие даасан судалгааны объект болж чаддаггүй бөгөөд терроризмтой хийх бодит тэмцэлд үр дүн муутай гэж үнэлэгдэх нь бий. Энэ чиглэлд хийгдэж буй судалгааны дийлэнх нь цөөн тооны хүмүүст эсхүл түр зуурын үзэгдэлд суурилан, жижиг хүрээг хамарсан, дотоод болон гадаад хүчин зүйлсээс хэт хамааралтай бөгөөд цаашлаад практик хэрэглээнд бүрэн нэвтрээгүй зэрэг нь эдгээр аргуудын шүүмжлэгдэх гол шалтгаан болдог байна.

Иймд энэхүү судалгааны ажлын тэргүүлэх зорилт нь *“Террорист профайлинг”* буюу террорист бие хүн судлалын шинжлэх ухаанд анхлан нэвтэрсэн үеэс өнөөдрийг хүртэлх хувьсалд түүхчилсэн анализ хийж, орчин цагт хүн төрөлхтний нүүр тулаад буй терроризмын гамшигт хэр үр нөлөөтэй, хэрэгцээтэй байх талаар шинжлэх ухаанч үнэлэлт, дүгнэлт хийхэд оршино.

Энэхүү судалгааг шинжлэх ухааны аргууд болох түүхчлэх, ерөнхий түүврийн аргуудыг ашигласан ба гол төлөв оюун дүгнэлтийн дедуктив, индуктив аргуудыг ашигласан болно. Ингэхдээ, энэхүү террорист профайлинг арга зүйн уг үндэс хаанаас эхлэлтэй болох? Судалгааны арга хэрэгсэл болохын хувьд түүний түүхэн ололт, нээлт болоод алдаа, төөрөгдөл юу байсан бэ? Энэхүү бие хүн, зан байдал төвтэй терроризмтой тэмцэх арга хэрэгсэл нь өнөө цагийн хэрэгцээ шаардлагад нийцэх эсэх? зэрэг нь судалгааны цөм асуултуудад хариулах замаар судалгааны

дүгнэлт хэсэгт энэхүү терроризмтой хийх тэмцэлд бие хүн, түүний зан төрх судлалын арга зүйн хэрэгцээ, шаардлагыг нэгтгэн дүгнэсэн болно.

Террорист зан байдал судлалын шинжлэх ухааны үндэс

Орчин цагийн террорист бие хүнийг илрүүлэх ажил нь 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн террорист халдлагын дараах үед ахин сэргэлтээ авсан урт удаан үйл явц байсан. Үүнээс өмнө 1970, 1980-аад оны үед олон сэтгэл судлаач, социологич, улс төр судлаач, олон улсын аюулгүй байдлын эрдэмтэн судлаачид янз бүрийн параметруудад системтэй профайлыг бий болгохын тулд террористуудын мэдээллийг цэгцтэйгээр бүртгэхийг эрэлхийлж байсан.

Нийгэмд өөрсдийн улс төрийн үзэл суртал, нөлөөллийг тархаах зорилгоор байлдаж, эцэстээ үхэж буй жишээг хувь хүнд ирэх ашиг тусынх нь хувьд авч үзвэл ойлгоход бэрх хэдий ч тэдний уг үйлдэлдээ хандаж буй сэтгэхүй болон тэдгээрийг залгамжлан үлдэгчдийн хооронд буй рационал холбоосоос харвал хамгийн үр дүнтэй стратеги бол бусдын үйлдлийг үнэ төлбөргүй ашиглах явдал юм. Улс төр судлаач Дэвид Ч.Рапопорт (1999) шашны итгэл үнэмшил, номлол зэрэг бүлгийн түвшний ёс суртахууны үүрэг хариуцлага нь тэдэнд хөндөшгүй ариун үнэт зүйлийг бий болгох замаар хамтын ажиллагааны хэм хэмжээг бэхжүүлдэг хэмээн үздэг.¹⁹ Дээрх хөндөшгүй ариун байдлын талаарх таамаглалуудын нийгмийн гэрээнээс ялгаатай нь тэдгээрийг бүрэн илэрхийлж, дүн шинжилгээ хийх боломжгүй байдаг. Учир нь тэдгээр нь арга зүйн тооцооллоор хүрэх боломжгүй ёс суртахууны зохистой байдлын логикийг агуулсан байдаг.

Алан хядагч бүлэглэлүүд үргэлж мадрасуудаас²⁰ төрөн гардаггүй бөгөөд үүний учир нь ихэнх мадрас нь дайсагнагч орнуудад амжилттай ажиллагаа явуулахад шаардлагатай нийгэм, хэл шинжлэл, техникийн ур чадвар дутмаг нийгмийн ядуу хэсэгт үйлчилдэг. Лалын шашинт амиа золиослогч болон бусад Жихадистуудын²¹ тохиолдлуудыг судалж үзэхэд цөөхөн хүн уламжлалт шашны боловсрол эзэмшсэн болох нь харагддаг. Үнэн хэрэгтээ, бие даасан судалгаагаар Аль-Каидагийн гишүүд болон хамтран ажиллагсдын дийлэнх нь коллежид суралцдаг, сонгосон мэргэжлийн чиглэл нь ихэвчлэн шашнаас ангид шинжлэх ухаан төвтэй байсан бөгөөд Аль-Каидагийн гишүүд дунд инженер, эмнэлгийн эмч нар бол хамгийн түгээмэл таарах мэргэжил гэдгийг цохон дурдсан байна²². Түүнчлэн томоохон террорист халдлагууд болон амиа золиослогчдын хэргийн оролцуулан хийсэн дүн шинжилгээгээр дээрх халдлагад оролцогчдын дийлэнх нь Хадис²³ болон Коран судрын талаарх цэгцэрсэн мэдлэггүй үедээ, цаашлаад ихэвчлэн өсвөр насныхаа сүүл үе эсхүл хорь гаруйхан насандаа радикал Исламд орсон болохыг харуулдаг байна.

Түүнээс гадна шашны үнэт зүйл тулгууртай алан хядах сэдэл нь хэн террорист болохыг урьдчилан таамаглах ажилд төдийлөн нөлөөтэй үзүүлэлт болж чаддаггүй байхад найз нөхөд, гэр бүлийн хүрээлэл, хөдөлмөр эрхлэлт, гадаад улс орнуудын хөндлөнгийн оролцоо, үндэсний ичгүүр доромжлол зэрэг бусад хүчин зүйлүүд нь хамаагүй илүү үр нөлөөтэй байдаг байна²⁴. Жишээлбэл, Палестинчуудын дунд амиа золиослох халдлагыг дэмжих хандлага болон шашны сүсэг бишрэл хооронд аливаа хэлбэрийн харилцан хамаарал байхгүй хэмээн Жереми Жинжэс болон Скот Атран тэргүүтнээ судлаачид үзсэн байдаг. Гэсэн хэдий ч энэ нь

¹⁹ Jeremy Ginges, Scott Atran et al. "Psychology Out of the Laboratory the Challenge of Violent Extremism" Michigan (online), 8 Aug. 2011. p. 4. Available from: https://www.researchgate.net/publication/312511111_Psychology_Out_of_the_Laboratory_The_Challenge_of_Violent_Extremism

²⁰ Араб хэлний "Madrasah" буюу "сургууль" нь Исламын шашны сургууль бөгөөд Талибанчуудын олонх нь Саудын Арабаас эхтэй Исламын шашны хатуу чанд бөгөөд ширүүн хэлбэр болох Ваххабизмыг заадаг Пакистан дахь мадрасуудад боловсрол эзэмшсэн хэмээн үздэг.

²¹ "Jihad" нь Араб хэлнээ тэмцэл, хүчин чармайлт гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд этгээд радикал Исламын шашинт амиа хорлогчид нь голдуу ижил шүтлэгтнүүдийнхээ эсрэг чиглэсэн шинжтэй байдаг.


²² Мөн талд.

²³ "Hadith" буюу Бошиглогч Мухаммедын өдөр тутмын айлдваруудыг агуулсан уламжлалт түүвэр нь Коран судраас гадна Мусульманчуудын шашны хууль, ёс суртахууны хэм хэмжээний гол эх сурвалж болдог.

²⁴ Мөн талд.

Мусульман жихадистуудын зан байдал нь тэдний шашны итгэл үнэмшилтэй ямар ч холбоогүй гэсэн үг биш юм.

Нэгэн тодорхой зураглал харуулахад, амиа хорлогчдын ар гэрийнхэн өөрт учирсан гарз хохирлоо санхүүгийн хувьд нөхөн төлүүлэх нь зүй зохистой эсэх талаар 2005 онд Палестины баруун эрэг, Газын зурваст оршин суугчид дунд үйл явдал болон хувь хүний зохиомол таамаглал бий болгон, нэг гэр бүлийн нөхөн төлбөрт шаардагдах мөнгөн дүнг өөр хоорондоо ялгаатай дурын хэмжээгээр тогтоон судалгаа явуулсан байдаг. Судалгааны үр дүнг хураангуйлбал, судалгаанд оролцогчид нөхөн төлбөр байх зүй зохисгүй бөгөөд түүний хэмжээ ихсэх нь нөхөн төлбөрийг улам ч хүлээн зөвшөөрөх боломжгүй болгож байна гэсэн үр дүн гарсан байна. Доорх зурагт А) Амиа золиосолсон хүмүүсийн ар гэрт өгөх нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарч энэ нь хүлээн зөвшөөрч болохоор бөгөөд Ислам нь амиа хорлох ажиллагааг дэмждэг гэж үзсэн болон В) Ислам нь амиа хорлох ажиллагааг дэмждэггүй хэмээн үзсэн хүмүүсийн хувь хэмжээг графикаар харуулсныг хуваалцаж байна²⁵. /График А, В/



(JD – 10,000, 100,000, эсхүл 1,000,000 Иорданы динар; буюу ойролцоогоор \$14,000, \$140,000, \$1,400,000 нэрлэсэн дүнгээр)

Өөрөөр хэлбэл, судлаачид дунд түгээмэл дэлгэрээд буй “Зардал болон үр ашиг”-н тооцооны үр дүнд хүмүүс өөрийн ашиг сонирхлыг рационал байдлаар дүгнэж, эцэстээ олонх нь террорист болох сонголт хийдэг хэмээн үзэх хандлага нь хүчирхийлэл болон өөрийгөө золиослох замаар бий болгосон нийгмийн айдас түгшүүрийг ашиглан хийж буй улс төрийн үйл ажиллагааг ойлгох суурийг төдийлөн хангалттай бүрдүүлдэггүй болох нь харагдаж байна. Сүүлийн үеийн судалгааны чиг хандлагыг харахад хоёр зүйлийн хооронд мөргөлдөөн гарахад тооцоолсон боломжоос илүүтэй өөрийн болон бүлгийн үнэт зүйл, үзэл баримтлал нь дагуу хийж буй хүмүүсийн зарчмын үйлдлийг судлан таних хэрэгцээ шаардлага үүсээд байна.

1.1. Гэмт хэрэгтэн бие хүн судлал террорист зан байдал судлалын үндэс болох нь

Гэмт хэрэгтэн бие хүн судлалын асуудлаар криминологич, сэтгэл судлаач Ричард Н.Кочисын үзсэнээр “профайл”-ыг тодорхойлох нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, оновчтой нэр томьёо хараахан байдаггүй. Учир нь “профайл” үүсгэх буюу аливаа этгээдийн тодорхой зан төлөв, гадаад шинж, нийгэм-эдийн засаг, сэтгэл зүйн онцлог цаашлаад биеийн хэлэмж, халдлагын арга хэрэгсэл зэрэг судалгааны олон талт хувьсагчуудыг нэгтгэсэн арга зүйн оновчтой нэршил олох нь тийм ч амар биш бөгөөд судлаач, эрдэмтэд өнөөг хүртэл энэхүү нэр томьёог өөр өөрийн судалгааны цар хүрээ, онцлогт тааруулан өөр өөрөөр орчуулан хэрэглэсээр ирсэн.

Цуврал алуурчин, хүчингийн гэмт хэрэг үйлдэгчдийг янз бүрийн дүрд баривчлах тодорхой үүрэг гүйцэтгэдэг байсан XIX зууны уран зохиолын гарал үүслийг олж харж болно. "Орчин үеийн профайлыг 1960-аад оны сүүлээр Нью-Йорк хотод бөмбөгдөгчийг амжилттай дүрсэлсэн сэтгэцийн эмч Жеймс Брюсселийн

²⁵ Тэнд., ху. 5

бүтээлүүдтэй холбож болно." Брюсселийн ашигласан арга нь хоёр үе шаттай үйл явцыг хамарсан: нэгдүгээрт, тэрээр бөмбөгдөгч этгээдийн цагдаад өгсөн захидал, шаардлагын дүн шинжилгээг багтаасан бөмбөгдөгч этгээдийн талаарх бүх мэдээллийг судалжээ. Хоёрдугаарт, тэрээр Нью-Йорк хотод халдлага үйлдэхэд бөмбөгдөгч этгээдийн ашигласан аргуудыг судалж үзсэн.

Зарим судлаачид гэмт хэрэгтэн бие хүн судлалын үндсийг 19-р зууны үеийн утга зохиолын салбараас үүсэлтэй гэж үздэг бол орчин үеийн бие хүн судлал, хувь хүний зан байдал тодорхойлох арга хэрэгслийг 1960-аад оны сүүлээр Нью-Йорк хотод бөмбөгдөгчийг амжилттай дүрсэлсэн сэтгэцийн эмч Жеймс Брюсселийн бүтээлүүдтэй холбож болно.

Брюсселийн ашигласан арга нь хоёр үе шатнаас бүрддэг: нэгдүгээрт, тэрээр бөмбөгдөгч этгээдийн цагдаад өгсөн захидал, шаардлагад дүн шинжилгээ хийн бөмбөгдөгч этгээдийн талаархи хамааралтай бүхий л мэдээллийг судалжээ. Хоёрдугаарт, тэрээр Нью-Йорк хотод халдлага үйлдэхэд бөмбөгдөгч этгээдийн ашигласан халдлагын арга хэрэгслийг судалж үзсэн. Түүний гаргасан тодорхойлолт нь цагдаа нарт үл мэдэгдэх гэмт хэрэгтний боломжит хувийн зан төлөв, дүр төрхөд анхаарлаа төвлөрүүлж, мөрдөн байцаалтаа зохион байгуулах боломжийг олгосон.

Террорист профайлинг” буюу террорист зан байдал судлалын салбар, төрөл

1.2. Террорист зан байдал судлал дахь арьс өнгө/угсаатан зүйн нөлөө

Уламжлалт гэмт хэрэгтэн бие хүн судлал нь хууль сахиулах алба хаагчид урьд нь гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хувийн хэрэгт тулгуурлан тэдний хоорондын нийтлэг шинжийг дүрслэн гаргаж, түүнийгээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох ажиллагаанд ашиглах болсон. Энэхүү алба хаагчид болон олон нийт дунд дэлгэрсэн дүрслэлд гэмт хэрэгтний бие махбодын дүрслэл, зан үйлийн хэвшмэл шинжүүд, нийгэм болон гэмт хэрэг хоорондын холбоос зэргийг багтаасан байдаг. Гэвч түүнээс ч өмнө Дэлхийн II дайны үед АНУ-ын Засгийн газар болон түүний иргэдийн Япончууд, Япон гаралтай Америкчуудын эсрэг сөрөг харьцаа даамжирч гаднын хүн буюу дайсагнагч этгээд гэх арьс өнгөний хэвшмэл ойлголтыг нийгэмд бий болгосноос аливаа бие хүнийг арьс өнгөөр нь ялган зан байдлыг нь тодорхойлох үзэл баримтлалын үндэс тавигдсан гэж үздэг.

Цаашлаад 1980-1990-ээд оноос эхлэн энэхүү гэмт хэрэгтэн бие хүн судлалын чиг хандлага нь хурдацтайгаар хувьсаж арьс өнгөний болоод угсаатан зүй тулгууртай бие хүн судлал нь хууль сахиулагч нар болоод нийт хүн ам дунд хурдацтайгаар газар авч эхэлсэн. Үүний тод жишээ нь, АНУ-ын 40 дэх Ерөнхийлөгч Рональд Рейганы эхлүүлсэн хар тамхины эсрэг дайн цагдаагийн ажилтнуудыг хар тамхи ихээр худалдаалагдаж буй дүүргүүдэд хяналтаа чангатгахад хүргэсэн бөгөөд харамсалтай нь тэдгээр дүүргүүд нь Кавказаас өөр бусад цөөнх үндэстнүүд илүүтэй суурьшсан болж таарсан юм²⁶. 1990 оны сүүл гэхэд хууль сахиулагчдын арьс өнгө болон үндэс угсааг гэмт этгээдийг тогтоох гол хүчин зүйл болгон ашиглах явдал нь ихээхэн маргаан дагуулах болсон бөгөөд энэ дагуу гаргасан шийдвэр бүр эрсдэл дагуулах болсон. Тухайлбал, хууль сахиулах алба хаагчдын Африк болон Испани гаралтай Америкчууд руу чиглэсэн шударга бус хандлагын²⁷ улмаас цагдаа, хууль сахиулагчдад үл итгэх байдал иргэдийн дунд дэлгэрсэн.

Түүнчлэн, терроризм судлалын хүрээнд нас болоод улс төрийн харьяаллыг хувь хүнд нөлөөлөгч хүчин зүйлд тооцон арьс өнгөөр ялган дүрсэлж, зан төрхийг

²⁶ Amanda L. Smith and Susan E. Mason, "The age of racial profiling in the context of terrorism", 2016. p.75. Available from:

<https://core.ac.uk/download/pdf/215399787.pdf>


²⁷ Сүүлд "Driving while black" хэмээн алдаршсан иргэний эрхийн маргаан нь АНУ-ын Мичиган муж дахь замын цагдаа нар жолоо барьж буй Латин болон Африк гаралтай америкчуудыг тодорхой үндэслэлгүйгээр зогсоон шалгаж ялгаварлан гадуурхах явдлаас эхэлсэн ба Америкийн Иргэний эрх чөлөөний холбоо /ACLU/-с 1999 онд Мэриленд мужид явуулсан судалгаагаар нийт цагдаад зогсоон шалгагдсан жолоочдын 72% нь Африк гаралтай америк жолооч нар байсан хэдий ч, тэд нийт жолоочдын ердөө 14%-ийг эзэлдэг болох нь тогтоогджээ.

тодорхойлох ажилд нэмэлтээр ашиглах болсон. Өнөөгийн сэтгэл судлал, улс төр судлал, социологи, криминологи, эрүүгийн эрх зүйн салбарын судалгаа, бүтээлүүдэд тулгуурлан Ойрхи-Дорнодоос гаралтай алан хядагч болох магадлалтай хүмүүсийн нийтлэг хэв шинж нь залуухан насанд хүрэгчидтэй харьцуулахад ахмад настнууд дунд, түүнчлэн өөрийгөө либерал үзэлтэй гэж тодорхойлсон хүмүүстэй харьцуулахад консерватив үзэл бодолтой гэж тодорхойлсон хүмүүсийн дунд илүү түгээмэл байдаг гэсэн зан байдлын таамаглал дэвшүүлсэн байдаг. /Смит ба Мейсон, 2016, х77/

Нортумбриягийн их сургуулийн профессор Жонатан Рэй өөрийн бүтээлдээ “Террорист бие хүний зан байдлыг тодорхойлох хамгийн зүй бус бөгөөд хамгийн бүдүүлэг арга бол арьс өнгөний байдалд үндэслэн гэмт этгээдийг илрүүлэх явдал юм” хэмээсэн байдаг. Энгийн дээр арьс өнгөөр ялган тодорхойлох хандлага нь тодорхой нэг төрлийн үндэстэн бусдаасаа илүүтэй террорист үйлдэл хийх магадлал өндөртэй байдаг гэсэн логикт итгэсэн явдал юм. Энэ ч утгаараа тэрхүү харь буюу дайсагнагч үндэстэн нь хүн ам зүйн хувьд байнгын анхаарал, хяналтад байх шаардлагатай хэмээн үздэг. АНУ-д болсон 9-р сарын 11-ний халдлагын дараа арьс өнгөөр ялган дүрслэх явдал нь болзошгүй террористуудыг илрүүлэх ашигтай систем болон сэргэж, олон орны хилийн аюулгүй байдлын агентлагууд, тэр дундаа АНУ-д голлон хэрэгжсэн. Нью-Йоркийн хуулийн их сургуулийн профессор Стивен Ж.Эллманн өөрийн бүтээлдээ “Үндэс угсаа тэргүүтэй харьцуулж болохуйц хүчин зүйлсийн үндсэн дээр аливаа этгээдийн зан төлөвийг дүрслэн тодорхойлох нь ямар ч тохиолдолд ялгаварлан гадуурхаж буй явдал бөгөөд тэнэглэл юм. Арабууд болон Лалын шашинтнууд-өнөө үед Америк улсад зонхилох ялгаварлан гадуурхах явдлын хамгийн тод хоёр бай... гэвч дийлэнх нь терроризмтой ямар ч холбоогүй энгийн иргэд байдаг. Ингэж биднийг гэмгүй хүмүүсийг хардаж байх хооронд Арабаас өөр гаралтай хүмүүс Аль-Кайда дахь манай дайснуудтай нэгдсэн нь маргаангүй”²⁸ гэж бичсэн.

АНУ-ын Холбооны Мөрдөх товчооноос 1972-2015 онд террорист халдлага үйлдсэн “Ганцаар алан хядагчдын арьс өнгө/угсаатан зүйн байдал”-ын судалгааг гаргасан ба тэдний дийлэх нь АНУ-ын иргэншилтэй, тэнд төрсөн ганц бие хүмүүс байсан байна.²⁹

/График №1/



Өнөөгийн олон улсын террористуудын дийлэнх нь Араб эсвэл Исламын шашинтай байгаа нь үнэн боловч үүнтэй дүйцэхүйц үлдсэн хэсэг нь өөр бусад үндэстнээс бүрдэж байгаа гэдгийг үл тоомсорлож болохгүй. Жишээ нь, Америкийн түүхэн дэх хамгийн их үхэл дагуулсан хоёр дахь террорист болох Тимоти МакВей Америкийн иргэншилтэй цагаан арьстан байсан байдаг. Мөн Их Британийн үйлдэгдсэн террорист халдлагын ихэнхийг цагаан арьст бүгд найрамдах намын тэрс үзэлтнүүд зохион байгуулж, гүйцэтгэсэн байдаг. Цаашлаад, 1972 онд Тель-Авив дахь Лод нисэх онгоцны буудалд Палестиныг чөлөөлөх ардын фронт (PFLP)-н нэрийн өмнөөс аллага үйлдсэн Японы Улаан арми (JRA) /Жонатан Рэй, 2012, ху. 65/ зэргээс харахад олон улсын террорист байгууллагууд энэхүү хэвшмэл ойлголтоор

²⁸ Jonathan Rae, “Will it Ever be Possible to Profile the Terrorist?”, Scotland, 2012, p. 65. Available from: <https://research-repository.st-andrews.ac.uk/bitstream/handle/10023/3986/380-947-1-PB.pdf?sequence=1&isAllowed=y>

²⁹ <https://www.statista.com/chart/19968/the-race-ethnicity-of-lone-offender-terrorists/>

далимдуулан хүлээгдэж буй үйл ажиллагааныхаа талбайгаас гадуур гэж үзсэн байруу халдлага үйлдэх замаар өөрийн зорилгод ойртох болсон. Иймээс ч профессор Жонатан Рэй террористыг тодорхойлох гол хүчин зүйл бол түүний арьсны өнгөнд найдах биш бөгөөд энэ нь хэзээ ч терроризмын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах бодит шийдэл болж чадахгүй гэж үзсэн.

1.3. Террорист зан байдал ба тэдгээрийн хүйсээс хамаарах онцлог хүчин зүйл

Террористуудын дүр төрхийг тодорхойлоход ашигладаг өөр нэг өөрчлөгдөшгүй хэмжигдэхүүн бол биологийн хүйс юм. 2002 онд Сингапурт баривчлагдсан Жема Исламиягийн 21 алан хядагчдын нэгэн адил 9 дүгээр сарын 11-ний өдрийн халдлагыг үйлдсэн 19 алан хядагч бүгд эрэгтэй байсан гэж жендэрийн мэдээллийг дэмжигчид үзсэн байна. Гэсэн ч эрэгтэй алан хядагчид давамгайлж байгааг хэт дэвэргэн үзэж болохгүй. Хэдий тооны хувьд давуу талтай ч профессор Рассел, Миллер нар эр хүн төвтэй энгийн профайлыг ашиглахдаа сэрэмжтэй байхыг зөвлөдөг. Учир нь: “Эмэгтэй террористууд аюулгүй байдлын ажилтнуудын хардлагыг давахдаа илүү чадварлаг байдаг. Үүний үр дүнд тэд өөрсдийгөө эхнэр эсвэл эхийн дүрээр эрэгтэйчүүдэд хязгаартай газрууд руу орох боломжтой байдаг” /Жонатан Рэй, 2012, х66/.

Сүүлийн жилүүдэд эмэгтэй алан хядагчдыг элсүүлэх хандлага олон улсын хэд хэдэн террорист бүлэглэлүүд дунд дэлгэрээд байгаа бөгөөд энэ дундаа эмэгтэйчүүдийг амиа золиослогчоор элсүүлсэн Ясир Арафатын Фатах /Yasser Arafat's Fatah/ бүлэглэлтэй холбоотон болох Аль-Акса шашны амиа золиослогчдын бригад /Al-Aqsa Martyr's Brigade/ нь Палестины тусгаар тогтнолын төлөө тэмцэж буй эмэгтэйчүүдийг оролцуулахыг зөвшөөрдөг анхны шашингүй бүлэг юм.

Конгрессын номын сангийн холбооны судалгааны хэлтсийн судлаач Рэкс А.Хадсоны олсноор Латин Америкийн хот суурин газрууд дахь олон тооны террорист ажиллагаанд эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэжээ. Латин Америкийн хамгийн аюултай эмэгтэй террористуудын тоонд Сандинист Дора Мария Теллез; Фарабундо Марти Үндэсний чөлөөлөх фронтын Ана Мария; Монтонеросын Норма Эстер Аrostито; 1980 онд Богота дахь Доминиканы Элчин сайдын яам, 1985 онд Колумбын Хууль зүйн ордныг булаан авах ажиллагаан дахь М-19-ийн оролцоо зэрэг нь ихээхэн хэсгийг эзэлдэг байна. Тэрээр “Хууль зүйн ордныг бүслэх үеэр эмэгтэй террористууд хамгийн ширүүн тэмцэгчдийн нэг байсан” тухай өөрийн 1999 онд гаргасан “Терроризмын социологи ба сэтгэл судлалын асуудал: Хэн, яагаад террорист болдог вэ?” бүтээлдээ цохон тэмдэглэсэн байдаг. Тус халдлагад Дээд шүүхийн 11 шүүгч, Колумбын 48 цэрэг амь үрэгдэж, хууль зүйн ордон бүхэлдээ галд шатжээ. Бусад орны алдартай эмэгтэй террористуудын тоонд Японы Улаан арми (JRA)-ийн Фусако Шигенобу; Палестиныг чөлөөлөх ардын фронт (PFLP)-ын Лейла Халид; Ирландын Бүгд найрамдах армийн Үхлийн эгч дүүс; Улаан армийн фракцийн Гудрун Энссин, Сюзанна Альбрехт; болон Баадер-Мейнхоф /Baader-Meinhof/-ын Улрике Майнхоф нар нэрлэгддэг байна. Үнэн хэрэгтээ, Баадер-Мейнхоффын бүлэглэлийн 60% нь, түүнчлэн Роте Зора хэмээх зэвсэгт феминист бүлэглэл бүхэлдээ эмэгтэйчүүдээс бүрддэг байв.³⁰

Угсаа гарал үүслийн нэгэн адил хүйсийг террорист бие хүн тодорхойлох ажиллагаанд зонхилох хүчин зүйл болгон ашиглахад террорист бие хүний талаарх хэт ерөнхий ойлголтын эсрэг бусад шинжлэх ухааны тайлбаруудын нөлөө ихээхэн хамааралтай. Өөрөөр хэлбэл, террористуудын зан үйлийг илүү тодорхой харуулсан өөр өөр хувьсагчуудыг ашиглан үр дүнтэй террорист профайлыг бий болгох хэрэгтэй байгаа бөгөөд ингэснээр терроризмын дараа дараачийн давлагаанд элсэгчдийн тоог бодитоор бууруулах боломж бүрдэх юм.

³⁰ Rex A.Hudson, “The Sociology and Psychology of Terrorism: Who becomes a Terrorist and why?”, Federal Research Division, Library of Congress, Washington, D.C., 1999, p. 52. Available from: <https://apps.dtic.mil/sti/pdfs/ADA442836.pdf>

1.4. *Террорист зан байдал ба тэдгээрийн наснаас хамаарах онцлог хүчин зүйл*

Террористуудын дүр төрхийг тодорхойлоход ашиглагддаг олон төрлийн хувьсагч дундаас хүн амыг насаар нь ангилан бүлэглэж тэр дундаас алан хядагчдыг нэрлэн заах оролдлого хамгийн хүнд нь байв. Хэдийгээр энэ төрлөөр хийгдсэн судалгаанууд үр дүнгийн хувьд давхцан огтлолцох боломжтой ч тэдгээрийн нийлбэрт террорист халдлага үйлдэгчийн насны дундаж хувилбарыг заах нь бараг боломжгүй. Тодруулбал, алан хядагчдын дийлэнх нь хорин нас хүрээд байгаа ч хэд хэдэн террорист бүлэглэлийн дундаж нас үүнээс нэлээд доогуур байна. Судлаач А.Хадсон Тамил Эиламын чөлөөлөх барууд (LTTE)-д 16-17 насны олон гишүүд, түүгээр ч зогсохгүй өсвөр насныхан байсан талаар судалгаандаа дурдсан байдаг³¹. Нөгөө талаар террорист байгууллагуудын удирдлагын шатлал нь нийт гишүүдийнхээ дундаж наснаас илт өндөр байдаг. Осама бин Ладен, Карлос Маригелла нар алагдахдаа 50 гаруй настай байсан нь үүний нэгэн жишээ бөгөөд Аль-Каидагийн шинэ толгойлогч Айман аль-Завахири өдгөө 70 настай.

Түүнчлэн, Холбооны Мөрдөх товчооноос 2001 онд хамгийн их эрэн сурвалжлагдаж буй террористуудын жагсаалтыг гаргахад жагсаалтад орсон 22 хүний дундаж нас 37 настай байжээ. Энэ олон янз байдлыг харгалзан үзэхэд нас бол болзошгүй террористуудын профайлыг тодорхойлоход бэрхшээлтэй хэмжүүр болох нь тодорхой байна. Иймд гэмт хэрэгтнүүдийг эрэн сурвалжлах ажлын хүрээнд эргүүлийн цагдаа нар хар арьст залуу эрэгтэйчүүдийг голлон эрэн сурвалжлах зэргээр арьсны өнгө, нас, хүйсийн мэдээлэлд хэт найдах нь өрөөсгөл бөгөөд үндсэн хуульд харш бүтцийн алагчлал хэмээн буруушааж байгааг энд тэмдэглэх нь зүйтэй.

1.5. *Террорист зан байдал судлал дахь нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийн хамаарал /Socioeconomic Profiling/*

Энэ төрлийн террорист бие хүн судлалын төрөл нь аливаа этгээдийн террорист үйл ажиллагаа явуулах хүсэл эрмэлзлийг тухайн хүний нийгмийн байдал, боловсрол, амьжиргаа, гэр бүлийн байдал зэрэг бусад хүчин зүйлсийн талаарх мэдээллээр дамжуулан тогтоож болно гэсэн үндэслэлд тулгуурладаг. Десмонд Туту, Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Дэ Жон тэргүүтэй дэлхийн удирдагчдын дунд тархсан нийтлэг ойлголт бол “Терроризмын гол цөм нь ядуурал юм” хэмээгддэг бөгөөд Далай лам, Нобелийн шагналт Эли Визель нарын дэмждэгээр “*боловсрол нь терроризмыг бууруулдаг*” гэж үздэг.

Эдгээр ерөнхий таамаглал нь бодит ертөнцийн судалгаатай үргэлж холбоотой байдаггүй. Энэхүү үл нийцлийн жишээг Рассел, Миллер нарын 1966 оноос хойшх 10 жилд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан 18 өөр террорист байгууллага, 350 алан хядагч дунд хийсэн дүн шинжилгээнээс харж болно. Тэдний судалгаагаар “Ажиглалтад оролцсон террористууд голдуу ганц бие, зарим хэсэг нь коллеж биш юмаа гэхэд их сургуульд суралцсан эрдмийн зэрэгтэй эрчүүд байсан...” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Үүнээс үзэхэд алан хядагчид ганц бие байх магадлал өндөр бөгөөд хамгийн гайхалтай нь тэд дээд болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн байх хандлагатай байдаг байна. /Жонатан Рэй, 2012, ху. 69/.

1960, 1970-аад оны хүн ам зүйн судалгаагаар жирийн алан хядагчийн дүр төрхийг дундаж амьдралтай, 20 гаруй насны, сайн боловсролтой ганц бие эрэгтэй хэмээн тодорхойлсон байдаг. Жишээлбэл, 1976 онд арван найман хэт даврагч бүлгийн дунд хийсэн судалгаанд үзүүлснээр гишүүдийн дундаж нас 23.2-31.3 хооронд хэлбэлзэж байв. Олонд танигдсан эсхүл хийсэн үйлдэлдээ ял сонссон террористуудын ихэнх нь нийгмийн дунд болон дундаас дээш ангийн хүмүүс байсан бөгөөд ихэнх нь коллежийн боловсролтой байжээ³².

³¹ Rex A.Hudson, “The Sociology and Psychology of Terrorism: Who becomes a Terrorist and why?”, Federal Research Division, Library of Congress, Washington, D.C., 1999, p. 48. Available from: <https://apps.dtic.mil/sti/pdfs/ADA442836.pdf>

³² Jeff Victoroff, “The Mind of the Terrorist”, California (online), Sage Publications. 2005. p. 7. Available from: http://www.holger-strulik.org/seminar-terror/Victoroff_2005.pdf

Ловелын Их сургуулийн профессор Ж.С.Хандлэр 1990 онд Холбооны мөрдөх товчооны 1960-1970-аад онд АНУ-д идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан баруун, зүүн жигүүрийн террористуудтай хийсэн ярилцлагын мэдээллийг хүснэгтээр гаргаж, улс төрийн чиг баримжаа ба нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг судалсан байна. Тэрээр хэлэхдээ, зүүн жигүүрийн террорист бүлгүүд дунд эмэгтэйчүүд баруун жигүүрийн террористуудтай харьцуулахад хамаагүй их хувийг эзэлдэг (46.2 эсрэг 11.2 хувь), коллеж төгссөн байдал нь ч мөн адил баруун жигүүрийн террористуудаас хамаагүй өндөр (67.6 эсрэг 19.0 хувь), зүүн жигүүрийн террористуудтай харьцуулахад баруун жигүүрийнхэн илүүтэй цэнхэр захтны хөдөлмөр (ХАА, *хөнгөн үйлдвэр, уул уурхай, бүтээн байгуулалт зэрэг биеийн хүч төвтэй ажил мэргэжил*) эрхэлдэг (74.8 эсрэг 24.3 хувь). Түүнчлэн зүүн болоод баруун жигүүрийн алан хядагчид дунд хэдий коллежийн боловсрол эзэмшсэн байлаа ч өрхийн орлогын хэмжээ нь дундаас доогуур байх нийтлэг хандлага ажиглагдаж байв. Вайнберг ба Юбанк (1987) нарын Италийн 451 террорист эмэгтэйг оролцуулан хийсэн судалгаанд мөн л дийлэнх нь багш эсвэл цагаан захтнууд байсан ч 20-иод насныхан давамгайлж байсныг харуулсан байна. /Викторов, 2005, ху. 7/

Гэвч энэхүү нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийн хамаарал нь байнгын тогтмол зүйл биш бөгөөд 1980-аад онд Америкийн алан хядагч бүлэглэлүүд харьцангуй нам гүм болж, Европын хувьсгалт Анархист-марксист бүлгүүд устгаж, дэлхий даяар Исламын радикал террористуудын нэр хүнд өсч байсан үед ахин савалгаанд орсон. Тэр үеийн Палестины ердийн алан хядагч нь 17-23 насны, ядуу амьдралтай, өнөр өтгөн гэр бүлээс гаралтай, боловсролын амжилт муутай байжээ. Цаашлаад 1990-ээд оны сүүл, 21-р зууны эхэн үеийн Ойрх Дорнодын террористууд нь их дээд сургуулийн оюутнууд, мэргэжилтнүүд, 40 орчим насны гэрлэсэн эрчүүд, залуу эмэгтэйчүүд зэрэг хүн ам зүйн өргөн хүрээнээс гаралтай болж ирсэн байх жишээтэй.

1.6. *Террорист бие хүний оюун санаа, сэтгэл зүйн онцлог зан төлөв*

Терроризм үйлдэгчдийн зан байдал нь олон янзын хувьсагчид хуваагддаг тул түүнийг төрөлжүүлэх нь ээдрээтэй бөгөөд маргаантай байдаг. Жорж Вашингтоны их сургуулийн Эллийоттын олон улсын харилцааны сургуулийн доктор Жерролд М.Пост 2004 хийсэн судалгаандаа улс төрийн дэд терроризмыг (1) нийгмийн хувьсгалт терроризм, (2) барууны терроризм, (3) үндсэрхэг-салан тусгаарлагч терроризм, (4) шашны хэт даврагч терроризм, (5) нэг асуудалт (жишээ нь: амьтны эрхийн төлөө тэмцэгчид) терроризм гэсэн төрлүүдэд хуваасан ба төрөл тус бүр нь өөрийн гэсэн онцлог нийгэм-сэтгэл зүйн хөгжлөөр холбогддог хэмээн үзсэн.

Энэ дагуу дээр дурдсан терроризмын улс төрийн ангилал ба оюун санааны тодорхой төлөв нь үнэхээр өөр хоорондоо пропорционал бус байдлаар ямарваа нэг холбоос агуулдаг эсэх нь нээлттэй асуулт хэлбэрээр урган гарч байна. Түүнчлэн “Террористын оюун ухаан”-ы талаарх сэтгэлзүйн судалгаанд тулгарч буй өөр нэг сорилт бол террорист бүлгүүд нь ердийн байдлаараа шаталсан зохион байгуулалттай байдаг бөгөөд тухайн шатлалаасаа хамаараад тус бүр өөр өөрийн гэсэн үүрэг оролцооны хуваарийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулдаг явдал юм. Ийм олон талт бүхий матриц дээрх орон тоо бүр өөр хоорондоо ялгаатай нөхцөлд бүрэлдсэн, сэтгэл зүйн хүчин зүйлээсээ хамаарч өөрийн оролцоог өргөдөг өөр өөр бие хүмүүсийг татдаг. Жишээлбэл, зарим удирдагчид өөрсдийгөө идеалист эсвэл альтруист гэж төсөөлдөг, зарим нь Мессиагийн төөрөгдөл, бусад нь үндэстэн ястны болон шашны дайсагнал, бусад нь бизнес эрхлэх хүсэл тэмүүлэлээр хөтлөгдөн террорист үйл ажиллагаанд нэгддэг гэж хэлж болно.

Бусад төрлөөсөө ялгаатай нь энэ хандлагын илэрхийлэхээр зорьж буй санаа нь хэвийн бус сэтгэг эмгэг судлалын зан үйл ба терроризмын цаашдын хандлага хоёрын хооронд учир шалтгааны холбоо байгаа гэдэгт итгэх итгэл юм. Өөрөөр хэлбэл, хувь хүний тодорхой онцлог зан чанарууд эсвэл амьдралын эмзэг туршлага зэрэг нь аливаа этгээдийн терроризмд чиглэсэн хандлагатай байгааг илтгэнэ гэж үздэг. Хэд хэдэн сэтгэл судлаачид хүчирхийллийн зан үйлийн хэв маягийг гэмт

этгээдийн өнгөрсөн үеийн сэтгэцийн гэмтэл, бэлгийн хомстол эсхүл дарангуйлах уур амьсгалтай холбон авч үзсэн байдаг. Тухайлбал, Германы философич, сэтгэл судлаач Теодор В. Адорногийн сайн дурын Холокостын оролцогчидтой хийсэн эмнэлзүйн ярилцлага, психометрийн туршилтыг ашиглан өрөөсгөл болон тоталитар удирдамжийн нөлөөнд өртөмтгий **“авторитар зан чанар”** байдаг гэж дүгнэсэн. Түүний энэхүү онолыг Английн сэтгэл судлаач Лестер тэргүүтэй эрдэмтэд өлгөн авч, дотоод гэм буруугаа гадагш цацах, уур хилэнгээ бусдад халдаах, уламжлалт үзэлд захирагдах, хатуужил, зоригтой байх хүсэл эрмэлзэл, өрөвдөх сэтгэлгүй байх гэх мэт хандлагыг Исламын террористуудад хамаатуулах замаар терроризм судлалын салбарт татан оруулсан байдаг.

Дээрхтэй ижил төстэй судалгааг Европын алан хядагчдын сэтгэл зүйн дүр төрхийг тодорхойлох хүрээнд хийгдсэн байдаг. Италийн шүүхийн сэтгэц эмгэг судлаач, криминологич Франко Ферракути болон Францеско Бруно нар Италийн баруун жигүүрийн терроризмд дүн шинжилгээ хийхдээ тэдэн дунд эмгэг судлалын хямрал, үзэл суртлын хоосон байдал, бодит байдалтай сэтгэл зүйн холбоогүй байдлаар тодорхойлогддог **“авторитар хэт даврагч зан чанар”** байгааг тодотгосон байдаг.³³

Терроризм болоод галзуурал хоорондын хамаарлын талаарх Франко Ферракутийн боловсруулсан дүгнэлт нь нийгмийг үзэн ядах сэтгэцийн эмгэгтэй этгээд (ASPD) болон терроризм хоорондын харилцаанд мөн адил хамаатай байж болно. Гэвч бид түүний онолыг ердийн логикоор бодит байдалтай холбож үзвэл, хэдийгээр нийгмийг үзэн ядах сэтгэцийн эмгэгтэй этгээд (ASPD) террористуудын дунд байж болох ч террористууд нь өөрийн улс төрийн сэдэлтэй хүчирхийллийн үндсэн дээр нийгмийг үзэн ядах сэтгэцийн эмгэгтэй (ASPD) болохгүй юм. Иймээс террорист бие хүнийг зан төрхийг сэтгэл судлал болоод сэтгэц эмгэг судлалын чиглэлд тодорхойлох ажил нь нийтээрээ эмпирик болоод прагматик түвшинд тогтмол судлагдах, нотлогдох боломжгүйгээсээ болж шүүмжлэлд өртдөг.

Дүгнэлт

Цуврал алуурчид, пироманиакууд (*импульсийн хяналтын эмгэгийн нэг төрөл бөгөөд гал гаргаж тайвшрах хэлбэрээр илэрдэг*), хүчингийн хэрэг үйлдэгчдээс ялгаатай нь террорист сэтгэлгээ нь тэдний оновчтой шийдвэр гаргалтыг дагаж хүчирхийллийг стратегийн болон харилцан ойлголцлын чухал хэрэгсэл болгон ашиглахад тустай улс төрийн философийг баримталдаг гэдэг нь өдгөө нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэн юм. Террористуудын сэдэл нь угаасаа нийгэм-улс төрийн шинжтэй бөгөөд хувь хүний сэтгэл зүй гэхээсээ илүү бүлгийн философитой холбоотой байдаг. Энэ үүднээсээ терроризм нь хэдийгээр зориудаар олны анхааралд өртөх гэсэн улс төрийн тэмцлийн илрэл боловч түүний үйл ажиллагааны зүй зохистой байдлыг зорилгоос нь тусад нь авч үзэх ёсгүй юм.

Террорист зан үйл нь үргэлж төрөлхийн хүчин зүйл, биологийн хүчин зүйл, хөгжлийн эрт үеийн хүчин зүйл, танин мэдэхүйн хүчин зүйл, хувь хүний темперамент, хүрээлэн буй орчны нөлөөлөл, бүлгийн динамикийн хослол зэрэг хэд хэдэн хүчин зүйлийн нөлөөн дор тодорхойлогддог. Эдгээр хүчин зүйлс тус бүр нь тухайн үйл явдалд нөлөөлж буй түвшингээрээ алан хядагчид, бие даасан бүлэг, бүлэглэлүүдийн төрөл хооронд харилцан адилгүй байж магадгүй юм. Эдгээр нөлөөллийн аль нэг нь бусдаас давамгайлдаг хэмээн үзэж буй онолууд нь хараахан бүрэн боловсрогдоогүй бөгөөд, учир нь эдгээр хувь хүний зан төлөв, сонголтыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн нэг юм уу хоёроос илүүг системтэйгээр судалсан, эсхүл аль нэг хүчин зүйлийг нь эмпирик байдлаар судлахдаа давхар бусдынх нь үзүүлэх нөлөөг мөн адил хянаж гаргасан судалгаа хараахан байхгүй байна. Өөрөөр хэлбэл, судлаачид анхлан Исламын, Араб эсхүл Ойрх Дорнодоос гаралтай этгээдүүдийг терроризмын уршиг тарих өндөр эрсдэлтэй хэмээн үзэж байсан ч зөвхөн АНУ-ын түүхэнд гэхэд хамгийн

³³ Jonathan Rae, “Will it Ever be Possible to Profile the Terrorist?”, Scotland, 2012. p. 69. Available from: <https://research-repository.st-andrews.ac.uk/bitstream/handle/10023/3986/380-947-1-PB.pdf?sequence=1&isAllowed=y>

их үхлийн аюул дагуулсан террористийн хоёрт орох Тимоти Маквей нь Америкийн цагаан арьст иргэн байсан байдаг.

Үүний нэгэн адилаар террорист болох эрсдэлтэй хүмүүс нь ямарваа нэгэн хувь хүнээс хамааралтай сэтгэл зүйн болоод зан үйлийн гаралтай хүчин зүйлийн нөлөөнд автдаггүй, тийм хүчин зүйл байх боломжгүй хэмээн няцааж буй судалгаанууд олон хэдий ч мөн л бодитоор туршигдсан нотолгоогүйгээс уналтад ордог. Учир нь терроризм өөрийн төрөлх мөн чанараараа тогтмол ойлголт биш бөгөөд тухайн нийгэм, цаг үеийн шинжтэй олон гадаад болоод дотоод хүчин зүйлүүдээс шалтгаалан тогтмол өөрчлөгдөж байдаг. Энэ нь эргээд шинжлэх ухааны салбарын судалгааг тасралтгүй үргэлжлүүлэх, тогтмол мэдээллийн бааз үүсгэхэд хүндрэл болдог. Тухайлбал, зарим террорист халдлага нь нийгэмд болж өрнөж буй цаг үеийн шинжтэй үзэгдэлд тулгуурлан бий болсон тохиолдолд түүний талаар хангалттай дата бааз үүсгэх боломж хязгаарлагдмал байдаг.

Зөвхөн амиа хорлогчдын жишээг харахад, энэ төрлийн террорист ажиллагааг гардан явуулж буй этгээдийг тодорхойлоход эмпирик судалгаа байхгүйгээс хамгийн их хүндрэл учирдаг бөгөөд иймээс ч энэ төрлийн судалгаа голлон сэтгэл судлал, социологи зэрэг бусад салбар онолуудаас иш татан хэрэглэсэн байдаг ба эргээд үр дүнг нь практик ажил болгох боломжгүй байдал үүсдэг байна.

КРИПТОВАЛЮТ БА ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА: ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Г.Хосбаяр

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
албаны сургуулийн дэд профессор, хошууч*

Товч агуулга: Криптовалютын хөгжлийн үе шат, хэрэглээний цар хүрээ, эрх зүйн зохицуулалт, хууль сахиулах үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс, цаашид анхаарах асуудлын талаар судалсан.

Түлхүүр үг: Криптовалют, блокчейн, DeFi, Coin, Token, зориулалт, хууль сахиулах үйл ажиллагаа, төлбөр гаргуулах ажиллагаа.

Удиртгал

Дэлхий дахинд техник, технологийн дэвшил хурдастай хөгжих болсноор санхүүгийн тогтолцооны шинэ төрлийн төлбөр тооцооны бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгсэл олноор бий болсон. Үүнээс дурдахад блокчейн³⁴ (blockchain) технологид суурилсан Биткойн (Bitcoin), Итериум (Ethereum) бусад криптовалютууд (cryptocurrency) юм.

Криптовалют нь мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор үүссэн холбооны кодчилолын технологи бөгөөд бусад цахим мөнгөнөөс ялгаатай нь өөрөө төвлөрсөн бус, компьютерүүдийн сүлжээ буюу үүлэн технологи (Cloud) дээр тогтдог гэдгээрээ онцлогтой. Энгийнээр хэлбэл, криптограф гэдэг нь маш өндөр хэмжээний тоо бодож байж компьютерууд хоорондоо холбогдон мэдээлэл солилцдог блокчейн технологид суурилсан математик алгоритм бөгөөд биет баталгаагүй цахим ухагдахуун ба ямар нэгэн үнэт металиар баталгааждаггүй.

Мөн криптовалютыг бусад төлбөр тооцооны хэрэгслээс ялгагдах тал нь түүнийг зохицуулдаг төв банк, зохицуулагч байгууллага, хуулийн этгээд гэж байхгүй бөгөөд төлбөр тооцоо, санхүүгийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах, хязгаарлах зорилготой үүссэн гэж үздэг.

Криптовалют буюу цахим мөнгөний анхдагч Биткойныг анх 2008 оны 11 дүгээр сард өөрийгөө Сатоши Накамото гэж нэрлэсэн хүн загварыг анх боловсруулж, эх кодыг бичсэн бөгөөд банк санхүүгийн байгууллага шиг зууч байхгүй, мөнгийг өөрийн дураар шимтгэл маш бага, өөр хоорондоо чөлөөтэй шилжүүлэхэд шаардлагатай технологи болон тэдгээрийг нэгтгэсэн мөнгө, түүнийг илгээх системийг олон нийтэд анх санал болгосон.

Биткойн болон бусад криптовалютаар төлбөр тооцоо хийхэд “Visa”, “MasterCard”, “PayPal”, “Western Union” зэрэг хөндлөнгийн байгууллагын оролцоо хэрэггүй бөгөөд интернет, гар утас байхад хангалттай.

Уламжлалт аргаар онлайн төлбөр тооцоо хийхэд 3-8 хувь, улс дамнасан мөнгөн гуйвуулга хийхэд 5-10 хувийн шимтгэл төлөх шаардлагатай бол криптовалютаар гүйлгээ хийх, түүнийг бэлэн мөнгө болгоход ердөө 1 хувь болон түүнээс доош хувийн шимтгэл төлдөг байна. Энэ нь төлбөр тооцоог хямд өртөгөөр, хурдан шуурхай, найдвартай, эрсдэл багатай хийх боломжийг бүрдүүлж чаджээ гэж судлаачид үздэг.

Цахим мөнгө буюу криптовалют нэгэнт дэлхийн санхүүгийн тогтолцоонд өөрийн гэсэн байр суурийг эзэлж, төлбөр тооцоо, хөрөнгө оруулалтын чиг хандлагыг тодорхойлох болсон. Өнөөдөр дэлхийд 10587 гаруй криптовалют гарсан гэсэн мэдээ байна.³⁵ Үүний зэрэгцээ дэлхийн томоохон 100 гаруй банк төлбөр тооцооны хэрэгсэлд нэвтрүүлэхээр сонирхож байгаагаас зарим нь өөрсдийн төлбөр тооцооны

³⁴ Блокчэйн (англ. Blockchain, мөн Block Chain) гэдэг нь бие даасан хэрэглэгчдийн сүлжээ хооронд цахим мэдээллийн сан үүсгэх болон хуваалцах боломжтой болгох мэдээллийн зохион байгуулалт юм. Блокчэйн нь ямар нэг мэдээллийн урсгалыг зохицуулагч төвлөрсөн удирдлагагүй peer-to-peer систем юм.
<https://mn.wikipedia.org/wiki/%D0%91%D0%BB%D0%BE%D0%BA%D1%87%D1%8D%D0%B9%D0%BD>

³⁵ 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар дэлхийн тэргүүлэх криптовалютын бирж coingecko дээр 10587 криптовалют бүртгэлтэй байна.
<https://www.coingecko.com/en>

хэрэгсэлд нэвтрүүлэх, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд зарим улсад криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрч³⁶ бэлэн бус гүйлгээнд ашиглаж байгаа бол зарим улс орнууд хориглож байна.

Япон Улс криптовалют буюу цахим мөнгийг хүлээн зөвшөөрч өөрийн гэсэн хуультай болоод байна.³⁷

Дэлхийн улс орнууд, үндэстэн дамнасан корпораци, хуулийн этгээд, хувь хүмүүс яагаад криптовалютыг сонирхох болов гэсэн асуулт гарч ирэх болно.

Түүхэнд алт, мөнгө, үнэт чулуу, цай, торго зэрэг зүйлс, эсвэл ан амьтан, ургац, ногоо, тариа зэрэг ахуйн хэрэгцээ өндөр, хөрвөх чадвартай зүйлс мөнгөний үүргийг гүйцэтгэж байсан. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын иргэд, компаниудын эзэмшиж буй мөнгөний ердөө 4% нь бэлнээр буюу цаасан хэлбэрээр эргэлддэг бол харин үлдсэн 96% нь банкны дансанд буюу цахим хэлбэрээр оршдог.

Монгол Улсын хувьд, улсын мөнгөний нийлүүлэлтийн 7% орчим нь нэгтээс хорин мянгатын дэвсгэрт хэлбэрээр оршиж байна. Харин үлдсэн нь санхүүгийн байгууллагуудын компьютерийн санах ойд хадгалагдаж буй тоо гэж ойлгож болно. Мөнгө ийнхүү цахим хэлбэрт шилжсэн нь хаях гээгдүүлэх, тээвэрлэх эсвэл шилжүүлэх, алдах гэх мэт олон асуудлыг хялбарчлахын зэрэгцээ, бидний цагийг хэмнэж, зардлыг бууруулж байна.

Үндсэн хэсэг

Цахим хувьсгал, дижитал шилжилтийн өнөө үед эдийн засгийн болон нийгмийн бүхий л харилцаа хувьсан өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ хувийн болон нийтийн эрх зүйн салбарт шинэ харилцаа урган гарч ирсээр байна.

Криптовалютын харилцааг зохицуулах эдийн засгийн болон эрх зүйн тогтолцоо олон улсад бий болоогүй байгаа бөгөөд дэлхийн зарим орнууд криптовалютыг санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зохицуулалтын төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглаж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, /Европын холбоо/ зэрэг улс криптовалютын үйл ажиллагаанд төрийн оролцоо зайлшгүй байхыг чухалчилж холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, судлах ажлыг эхлүүлсэн бол БНХАУ тэргүүтэй 10 гаруй улс (Катар, Бүгд Найрамдах Турк Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Умард Македон Улс, Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, Мароккогийн хаант улс, Бүгд Найрамдах Ирак Улс, Бүгд Найрамдах Нигер Улс г.м) криптовалютыг хориглосон.

Криптовалют нь банк, санхүүгийн байгууллага зэрэг зуучлагч шаардлагагүй, гүйлгээний шимтгэл маш хямд, төлбөр тооцоо хийж буй хүний хувийн мэдээлэл нууцлагддаг, хэн нэгэн зохицуулагчийн зүгээс хяналтгүй, нэгэнт орсон мэдээллийг өөрчлөх боломжгүйгээс гадна мөн буцаах боломжгүй байдаг. Мөн хэн нэгэн этгээдээс бусад хүн рүү шилжүүлсэн криптовалютын мэдээллийг замаас нь харах, хянах боломжгүй зэрэг онцлогууд нь эдгээр төрлийн цахим мөнгийг илтгэх шинэлэг байдлыг бий болгосон технологи юм.

Анх зардлаа хэмнэхийг хүссэн жижиг бизнесүүд, өвөрмөц санааг турших сонирхолтой хүмүүс, хууль бус худалдаа арилжаанд криптовалютыг ашиглах нь түгээмэл байсан бол 2021 онд Кэмбрижийн их сургуулиас хийсэн нэгэн судалгаанд криптовалют хадгалах цахим түрийвч (wallet) эзэмшигчдийн тоог 78.85 сая гэж тооцоолжээ.³⁸

³⁶ Эл Салвадор улс нь биткойныг улсынхаа албан ёсны төлбөрийн хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрсөн анхны улс болсон.

<https://cointelegraph.com/news/el-salvador-president-bitcoin-law-will-be-approved-tonight>

³⁷ Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн ахлах эдийн засагч Б.Түмэнцэнгэлтэй peak.mn сайтын сурвалжлагчтай хийсэн ярилцлага.

<http://www.peak.mn/news/btumentsengel-kriptowalyut-tsoo-shine-oilgolt-uchraas-zokhitsuulalt-agma>

³⁸ 2022 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 78.85 сая хэрэглэгч цахим түрүүвч ашиглаж байна. <https://www.statista.com/statistics/647374/worldwide-blockchain-wallet-users/>

Энэхүү цахим мөнгөний нэг том давуу тал бол зардал хямд. Бэлэн мөнгийг үйлдвэрлэхээс эхлээд тээвэрлэх, хадгалах, бохирдож муудсан үед нь устгахад зориулагддаг ихээхэн хэмжээний зардлууд нь цахим мөнгө хэрэглэснээр хэмнэгдэх боломжтой. Хөгжсөн орнуудын хувьд бэлэн мөнгөтэй холбоотой зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 1-2% орчим байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд энэхүү үзүүлэлт 5-7% хүрдэг.

Дэлхийн томоохон сүлжээ банкуудын хувьд бэлэн мөнгийг удирдахтай холбоотой зардал нь жилдээ \$1 тэрбум долларт хүрдэг³⁹ гэсэн тооцоо бий.

Аливаа зүйлд эерэг тал байхад, сөрөг тал хүртэл байдаг. Энэ блокчейн технологид суурилсан криптовалюта нь хууль сахиулах байгууллагын өмнө томоохон сорилт, хүндрэлийг бий болгосон. Эрх зүйн хувьд зохицуулалтгүй байгаа энэ салбарт технологийн дэвшлийг сөргөөр ашиглаж байгаатай холбоотой бөгөөд хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг нуух, авлига, хээл хахууль өгөх, мөнгө угаах, залилан мэхлэх, терроризмыг санхүүжүүлэх, компьютерийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх, бусдыг сүрдүүлэх, хар тамхи, сэтгэцэд нөлөөтэй эм бэлдмэл, галт зэвсгийн худалдаанаас олсон орлогыг криптовалюта руу хөрвүүлэх болсон явдал юм.

Ийм учраас хууль сахиулах байгууллага нь энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, мөн төлбөртэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас төлбөр гаргуулах зэрэг ажиллагаанд анхаарах цаг болжээ. Улс орнуудын үндэсний хууль тогтоомжид хуульчлагдаагүйгээс хууль сахиулах үйл ажиллагаанд хүндрэл учрах болсон.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт” оруулсан.

Монгол Улс 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-аас гарсан боловч (FATF)-ын 15 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийг хүлээсэн.

Дэлхий дахинд хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буй технологийн дэвшилтэй зэрэгцэн криптовалюта буюу виртуал хөрөнгийн салбарын зах зээл манай оронд ч эрчимтэй тэлж байна. Үүнтэй зэрэгцэн салбарын зохицуулалт, олон нийтийн тодорхойгүй байдлыг арилгах, санхүүгийн залилан, луйвраас хамгаалах, олон улсын стандарт шаардлагыг хангах хүрээнд тус салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага үүссэн.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулан 2021 оны 5 дугаар сард Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр соёрхон баталсан.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай⁴⁰ хууль хэрэгжиж эхэлснээр аливаа этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхгүйгээр виртуал хөрөнгийн үйлчилгээг үзүүлэх боломжгүй болсон бөгөөд хуульд заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлээгүй компани Санхүүгийн зохицуулах хорооноос албан ёсоор бүртгэсэн шийдвэр гараагүй байхад виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгох (ICO-Initial Coin Offering⁴¹, IEO буюу Initial Exchange Offer⁴², мөн

³⁹ <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1688&tid=2>

⁴⁰ “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”. “Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ хот., 2021 он. №6

⁴¹ Койн болон токений анхдагч (ICO) зах зээлийг захиалгыг бүртгэж буй бас нэг хэлбэр бөгөөд захиалгыг крипто бирж бус тухайн криптовалютыг гаргаж байгаа компани явуулж байгаа үйл ажиллагаа.

⁴² Анхдагч зах зээлийн арилжаа (IEO) нь криптовалютын бирж болон платформуор дамжуулан олон нийтэд давуу эрх олгох токен зарж хөрөнгө босгох арга юм.

IDO-Initial DEX Offering⁴³), худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

Монгол Улсад Виртуаль хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдахаас өмнө 14 гаруй биржээр 41 токеныг олон нийтэд санал болгож 2.2 их наяд төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Энэ нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр криптовалют худалдан авчээ.

Үндэсний төлбөрийн системийн тухай⁴⁴ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.25-т “цахим мөнгө” гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгслийг” хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд үүнд криптовалют хамаарахгүй юм.

Иймээс үнийн савлагаа, тогтворгүй байдал өндөр криптовалют руу хөрөнгө оруулалт хийх нь өндөр эрсдэлтэй болохыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтмол анхааруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага мөн⁴⁵ бөгөөд иргэний, захиргааны, зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичигт “төлбөр гаргуулах хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрх болон шүүх, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг гүйцэтгэх арга, журам”⁴⁶-ыг шүүх тогтоохоор заасан. Гэвч төлбөртэй иргэн, хуулийн этгээдийн криптовалютыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрхэн битүүмжлэх, барьцаалах, банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, хураах, төлбөр гаргуулах ажиллагаа нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалтгүй, мэдлэг мэдээлэл дутмагаас ажиллагаа явагдах боломжгүй байдал үүсээд байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Криптовалют, блокчэйн технологийн эерэг үр нөлөөг инноваци, бизнесийн болон эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, үр өгөөжийг нь хүртэхэд дараах гол сорилтуудтай тулгарч байна. Үүнд:

1. Институцийн хувьд криптовалютууд нь зах зээл дээр өргөн тархаагүй ч цаашид үүсэж болох эрсдэл болон боломжуудад анхаарч хуулийн байгууллагууд судалгаа, шинжилгээ хийх нь чухал. Ирээдүйд мөнгө нь эдийн засагт нийлүүлэгдэх арга зам, төлбөр тооцоо хийгдэх зарчим сууриараа өөрчлөгдөж, төвлөрсөн бус (Decentralized finance) шинж чанар руу шилжлээ.

2. Технологийн хувьд блокчейн технологид суурилсан криптовалютын мэдээллийн нууцлалын бодлогоос үүдэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг хадгалах, бусдад шилжүүлэх найдвартай арга хэрэгсэл болоод байгаа нь хууль сахиулах байгууллагад хүндрэлийг авчирч байна.

3. Эрх зүйн орчны хувьд криптовалютууд нь хөгжлийн эхний шатандаа явж байгаа тул хэрхэн, яаж оновчтой зохицуулалт хийх вэ гэдгийг тодорхойлоход эрт байна. Криптовалют хэрэглэгчдийн тоо, криптовалютуудын мөнгөн дүн нь системийн эрсдэл үүсгэх хэмжээнд хараахан хүрээгүй тул аливаа улс орны засгийн газар, Олон Улсын Валютын сан, төв банкууд, мөн хууль сахиулах байгууллага түүний үйл явцыг анхааралтай ажиглах байр суурь давамгайлж байна.

⁴³ Анхны DEX санал буюу IDO нь төвлөрсөн бус, зөвшөөрөлгүй олон нийтийн санхүүжилтийн платформын шинэ бөгөөд сэтгэл хөдөлгөөн төрөл бөгөөд крипто орон зайд хөрөнгө босгох шинэ арга.

⁴⁴ “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. УБ хот., 2017 он. №28.

Дээрх хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

⁴⁵ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 257.1 дэх заалт. “Төрийн мэдээлэл эмхэтгэл”, УБ хот., 2017 он. №24

⁴⁶ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 20.1.6 дахь заалт. “Төрийн мэдээлэл эмхэтгэл”, УБ хот., 2017 он. №24

Дүгнэлт-санал

Цахим мөнгө буюу криптовалютаар холбоотой үйл ажиллагааг судалж дүн шинжилгээ хийх, үүнтэй холбоотой инновацийг нэвтрүүлэх, хууль сахиулах ажиллагаанд тулгарч буй сөрөг үр дагаврыг тооцоолох, урьдчилан сэргийлэх, олон нийтэд зөв мэдээлэл өгөх буюу хэрэглэгчдийг бүртгэлжүүлэх шаардлагатай байна.

Дараах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх, нэвтрүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Хууль сахиулах ажиллагаанд тулгамдаж болзошгүй энэ төрлийн үзэгдлийн мөн чанар, зүй тогтлыг судлах;
- Криптовалютын арилжаанд оролцогч байгууллага, хувь хүнийг бүртгэлжүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;
- Криптовалютын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Иймд хууль сахиулах ажиллагаанд криптовалютын хэрэглээтэй холбоотой дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна. Үүнд:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 зүйлийн 6.1.1.2-т “Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.19 дүгээр зүйл /Виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах/, 18.20 дугаар зүйл /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулах ашиглах⁴⁷/ гэмт хэрэгт тагнуулын байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар, Зөрчлийн тухай хуулийн 11.33 дугаар зүйлд заасан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль зөрчих” үйлдэлд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч зөрчил шалган шийдвэрлэхээр харьяаллыг тогтоосон.

Цаашид эрх бүхий албан хаагчдын энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх мэргэжлийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

- **Холбогдох үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;**

Ирээдүйд криптовалютыг бараа буюу төлбөр тооцооны хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрөхөөс шалтгаалаад криптовалютын арилжаанд нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ногдуулах асуудал хөндөгддөг ба энэ чиглэлээр ихэнх улс орнууд криптовалютыг татвар ногдуулахгүй байх хандлагыг баримталж байна.

Криптовалютын арилжаанаас олж болох ашгийн хувьд хөрөнгийн орлогод тооцон хувь хүний, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах нь түгээмэл байна. Жишээлбэл, БНСУ 2022 оны татварын жилээс эхлэн криптовалютын арилжаанаас олсон орлогын дүнд 20 хувийн татвар ногдуулахаар шийдвэрлэсэн.

Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.50-т хэсэгт “виртуал хөрөнгийн үйлчилгээ⁴⁸”-г албан татвараас чөлөөлөхөөр хуульчилсан. Цаашид криптовалютын арилжаанд хяналт тавих, орлогод татвар ногдуулах тогтолцоог бий болгох нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагаанд эерэг нөлөөтэй ба криптовалютын ашиглалтыг бусад хууль бус үйл ажиллагаанаас ангид байлгах үр дагавартай.

- **Криптовалют худалдах, худалдан авах, түүгээр үйлчлэх, эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан журамлах**

Криптовалют буюу виртуал хөрөнгийн шилжүүлгийг иргэн, хуулийн этгээд нэг виртуал хөрөнгийг өөр виртуал хөрөнгийн төрөл рүү эсвэл нэг данснаас өөр дансад шилжүүлэх бүрэн боломжтой. Виртуал хөрөнгө нь хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээг өндөр нууцлалтай, түргэн шуурхай, хялбар, зардал багатайгаар хүргэх, уламжлалт санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжгүй этгээд ашиглах боломжтой зэрэг давуу талтай ч олон улсын стандартад нийцсэн хяналт, зохицуулалтгүйгээр өмч хөрөнгийг нуун дарагдуулах, хөрөнгийн эх үүсвэрийг нууцлах, татвараас зайлсхийх, гэмт хэрэгтнүүд болон террорист этгээдүүдийн санхүүгийн гүйлгээг дамжуулах, мөнгө

⁴⁷ “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. УБ хот., 2017 он, №23

⁴⁸ “Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хууль”. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. УБ хот., 2015 он, №29

угаах болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлээд 3 сарын сарын хугацаа өнгөрсөн боловч дагалдан гарах холбогдох журам, зааврууд Санхүүгийн зохицуулах хорооноос эцэслэгдэн батлагдаагүй, холбогдох харилцаа зохицуулалтгүй байна.

1. Авлигын эсрэг хуульд болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлэгт виртуал хөрөнгийг бүртгүүлэх, мэдүүлэх;

Одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон ХАСХОМ-т криптовалютыг мэдүүлэх, бүртгүүлэх боломжгүй байна нь гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг нуух, хөрвүүлэх боломжийг бий болгож байна.

2. Криптовалютын үйл ажиллагаатай холбоотой гадаадын орнуудын эрх зүйн зохицуулалт, практикийг судлан дэвшилтэд хэм хэмжээг жишгийг өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн нутагшуулан хэрэгжүүлэх зэрэг болно.

Ном зүй

- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017 он, №28
- “Цахим алт” ном, Ард санхүүгийн нэгдэл ХК, 2021 он

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ж.Бат-Эрдэнэ
Хууль зүйн магистр

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого ба байгаль орчны асуудлын уялдаа холбоо, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо, өнөөгийн байдал, ангилал, төрөл, гүйцэтгэх үүрэг, хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийн талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Байгаль орчны стратегийн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ.

Удиртгал

Байгалийн баялгийн тэгш хувиарлалт, түүний ашгийг ард түмэнд хүргэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал олон жил нийгмийн томоохон сэдэв болсоор ирсэн.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн хоёр арга хэлбэр байдгийн нэг нь хууль, стандартаар хянаж шалгах, эсхүл зах зээлийн эдийн засгийн хөшүүргийг ашиглан байгалийн нөөц ашиглалтыг зохицуулан хамгаалах явдал байдаг.

Манай Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн байгаль орчныхоо бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, эрх зүй, эдийн засаг, удирдлага зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх талаар онцгой анхаарал хандуулж, холбогдох эрх зүйн орчныг бий болгох ажлыг 1995 оноос эхлэн эрчимтэй эхлүүлж, энэ салбарт одоогийн байдлаар байгаль орчинтой холбоотой нийт 26 хууль, 370 орчим стандарт, нэмэлт 75 эрх зүйн баримт бичиг холбогдох дүрэм журам, боловсруулан мөрдүүлж байна.

Харин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг анх 1998 онд баталж, 2012 онд шинэчлэн найруулсан бөгөөд тус хуулиар 4 төрлийн үнэлгээг зохицуулж байна. Эдгээр нь Байгаль орчны стратегийн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болно.

Байгаль орчинд хохирол, сөрөг нөлөөлөл тохиолдохоос урьдчилан хамгаалж болох оновчтой арга механизм нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх асуудал юм.

Үндсэн хэсэг

Монгол Улс анх 1995 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх асуудлыг анх удаа хуульчлан тусгасан.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн зорилго, зарчим, агуулгад нийцүүлж 1995 онд баталсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь байгаль орчны салбарын суурь хууль юм. Тус хуульд 1998 оноос хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, хийдэл, давхардал, зөрчлийг нь арилгасаар ирсэн байна.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд анх баталж, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчилсэн найруулжээ. Тус хуульд 2012 оноос хойш 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх үйл ажиллагаа нь дараах эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулагдаж байна. Үүнд:

д/д	Баримт бичгийн төрөл	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Зохицуулах харилцаа
1	Хууль	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995-03-30 Дагаж мөрдөх	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг

			огноо 1995.06.08 Төлөв 24 нэмэлт өөрчлөлт;	байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна
2		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль <i>/Шинэчилсэн найруулга/</i>	2012.05.17 Дагаж мөрдөх огноо 2012.06.21 Төлөв 2 нэмэлт өөрчлөлт;	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулна.
3	Засгийн газрын тогтоол	“Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”	2013.11.16 №374	Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
4		Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”	2013.11.16 №374	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, түүнтэй холбогдсон шийдвэр гаргах, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна
5		Байгаль орчныг хамгаалах хөрөнгийн байршлын тухай /Засгийн газрын 2001 оны 136 дугаар тогтоол/	2001.06.27 №136	Төрийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих болсонтой холбогдуулан гадаад, дотоодын төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувь хүмүүсээс байгаль орчныг хамгаалах чиглэлээр хандивласан хөрөнгийг төрийн бус байгууллагын дансанд байршуулж, уг хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж жил бүр Засгийн газарт танилцуулж ажиллахыг Байгаль орчны сайдад даалгасан.
6	Сайдын тушаал	Байгаль орчинд нөлөөлөх байдлын	Байгаль орчны сайдын	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан

		нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам	2006.06.21 №195	үнэлгээ болон тайланд үнэлгээний шинжилгээ хийх, эдгээр харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулна
7		Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.10.29 А/618	Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна
8		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний комиссын ажиллах журам	Байгаль орчны сайдын 2006- 04-27 №119	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.4-т заасны дагуу томилогдсон комисс энэхүү журмыг мөрдөж ажиллана.
9		Уул уурхайн ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015.03.30 А-138	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 417 дугаар тушаалаар баталсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ыг УИХ-аас 2012 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан байгаль орчны багц хуулиуд болон өнөөгийн мөрдөж буй бусад хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамтай нийцүүлэх, нөхөн сэргээлтийн талаарх орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололт, гадаадын улс орнуудын туршлагыг судлан харьцуулалт хийх, боломжтойг нь өөрийн орны нөхцөлд тохируулан аргачлалд тусгах, өмнөх аргачлалд тусгагдаагүй газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын ордыг нөхөн сэргээх аргачлалыг шинэчлэн боловсруулах харилцааг зохицуулна.
10		Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.08.28 А/181,А458 дугаар	Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон холбогдох бусад хуулийн хүрээнд уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хаалтын үйл

			хамтарсан тушаал	ажиллагаанд шаардагдах бэлтгэл ажил болон тэдгээрийн хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
11		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.01.06 А-03	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.
12		Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2010.05.27 А-156	Эдэлбэр газарт учруулах хохирлын үнэлгээг тооцох, Хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцох, Ургамлын нөөцийн экологи- эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцохдоо тус аргачлалыг баримтална.
13		Байгаль орчны аудит хийх эрх олгох	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.12.25 А/809	Байгаль орчны аудит хийх эрх олгох, сунгах, цуцлах болон байгаль орчны аудитын мэргэшсэн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
14		Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.01.06 А-04	Төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах төрийн сангийн тусгай дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавихтай холбогдсон бусад харилцааг зохицуулна.
15		Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал	Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010.05.10 А-132/112 дугаар хамтарсан тушаал	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 болон 15.1.3, "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1.8 мөн 39 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтыг хэрэгжүүлэхэд "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлыг тооцоход энэхүү аргачлалыг ашиглана.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийн талаарх дүн шинжилгээ:

Давхардал: Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд даврахдуулан хуульчилсан эсэх:

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
-----	-----------------------	---------------

1	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	7 дугаар зүйл.Байгаль орчны үнэлгээ 4.Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	12 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох, хүчингүй болгох 12.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.6-д заасан тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын аж ахуйн нэгжид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Дүгнэлт, санал: Агуулгын хувьд давхардуулан хуульчилсан тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хүчингүй болгох, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эшлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах; 39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 39.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.5, 39.1.7.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаасаа хойш 30 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ

Дүгнэлт, санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг болон Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага буюу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага менежментийн төлөвлөгөөг баталж зөвшөөрөл өгөхөөр агуулгын хувьд давхардуулан хуульчилсан байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгох.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.15.Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 39.8.Энэ хуулийн 38.1.8, 39.1.9-д заасан тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
--	--	---

Дүгнэлт, санал: Агуулгын хувьд давхардсан боловч нэр томьёоны хувьд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэж өөр өөрөөр хуульчилсан байна. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 15 дахь хэсгийн “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	7 дугаар зүйл.Нөлөөллийн үнэлгээ 7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. 8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: 8.4.1.төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал; 8.4.2.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн; 8.4.3.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж; 8.4.4.төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах зөвлөмж; 8.4.5.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр заасан бол төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ; 8.4.6.газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ;
	Газрын хэвлийн тухай хууль /1988.11.22/	41¹ дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх 1.Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор газрын хэвлийг болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. 2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг арилгах, ашигт малтмалын орд, түүний хэсэг дэр малтсан газрыг дарах буюу цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах, хөрсийг нь нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дүгнэлт, санал: Газрын хэвлийн тухай хуулийн 41¹ дүгээр зүйлд заасан үнэлгээний асуудал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан. Харин тус хуульд заасан ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ гэдэгт юуг хамааруулах нь тодорхойгүй байна. Иймд Газрын хэвлийн тухай хуулийн 41^{1.2} дэх хэсгээс “...болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ” гэснийг хасах, тус зүйлд заасан

магадлан шинжилгээ гэдэгт юуг хамааруулахыг тодорхойлж бусад хуульд нийцүүлэх, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг эшлэх.

Зөрчил: Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой, хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
1	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	9 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 3.Нөлөөллийн үнэлгээний зардлыг захиалагч этгээд санхүүжүүлнэ.
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	8 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ 8.6.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

Дүгнэлт, санал: Дээрх 2 хуульд үнэлгээний зардлыг нэг этгээд санхүүжүүлэхээр ижил зохицуулсан байна. Иймд нэг нэр томъёог хэрэглэх, захиалагч этгээд эсвэл төсөл санхүүжүүлэгч гэж аль нэг үгийг сонгож хэрэглэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. 9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.1.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна. 9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах; 38.1.2.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булаах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах; 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах;

Дүгнэлт, санал: Ашигт малтмалын тухай хуульд байгаль хамгаалах төлөвлөгөө гэсэн ойлголт байдаггүй, ийм төлөвлөгөө батлагддаггүй байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг нэр томъёоны зөрүүтэй зохицуулсан байна. Иймд Ашигт малтмалын

тухай хуулийн байгаль хамгаалах төлөвлөгөө гэсний байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болгож өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.5.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	28 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах 28.1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2-оос доошгүй жилийн өмнө түүнийг эзэмшигч нь төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу хугацаа сунгуулах тухай өргөдөл гаргаж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана: 28.1.3.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт.

Дүгнэлт, санал: АМТХ-ийн 28 дугаар зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах бичиг баримтыг бүрдүүлэхдээ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хавсаргахаар заасан. Гэтэл БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтад Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ гэж заасан байна. Иймд АМТХ-ийн 28 зүйлийн 28.1.3 дах хэсэгт заасан нэр томьёо нь БОНБҮТХ-ийн нэр томьёотой уялдахгүй байгаа тул Ашигт малтмалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дах заалтад заасныг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гэж өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/	9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.1.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;

Дүгнэлт, санал: АМТХ-ийн 38.1 дэх хэсэгт тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулахаар заасан нь БОНБҮТХ-ийн 9.1 т заасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна гэсэнтэй уялдахгүй байна. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
-----	--------------------	---------------

5	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	10 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ 10.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж нь ерөнхий үнэлгээнд заасан хугацаанд үнэлгээний ажлын тайланг холбогдох бусад бичиг баримтын хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ. 8 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ 8.3.Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. 9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах; 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах; 38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

Дүгнэлт, санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд менежментийн төлөвлөгөө нь нарийвчилсан үнэлгээний салшгүй хэсэг гэж заасан бөгөөд менежментийн төлөвлөгөөг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулахаар заасан байна. Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд менежментийн төлөвлөгөөг хайгуулын талбай байрших орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлж тухайн сум дүүргийн засаг дарга батлахаар зөрүүтэй зохицуулжээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
6	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/	9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах; 38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

Дүгнэлт, санал: Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.3 дэх заалтад энэ хуулийн 38.1.1 дэх хэсэгт заасан тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах гэсэн нь БОНБУТХ-ийн 9.3-т заасан ерөнхий

үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлаж төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно гэсэнтэй уялдахгүй байна. АМТХ-ийн 38.1.4-т байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хүргүүлэхээр заасан бол БОНБҮТХ-ийн 9.3-т байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийсэн байгууллага нь хүргэхээр заасан. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/	9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9.14. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ хуулийн 9.15-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ. 9.15. Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 38.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

Дүгнэлт, санал: АМТХ-ийн 38.3-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна гэж заасан бол БОНБҮТХ-ийн 9.14, 9.15-д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан журмаар зохицуулжээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх заалтыг “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 9.15-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ” гэсэн агуулгаар өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
8	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/	7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ 7.2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.
	Газрын тухай хууль /2002.06.07/	34 дүгээр зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам 34.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэсний дараа тэдгээртэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.

Дүгнэлт, санал: Газрын тухай хуулийн 34.2 дахь хэсэг нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар

эзэмших эрх авсныхаа дараа хийлгэхээр заасан байхад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсэгт газар эзэмших, ашиглах эрх авахаасаа өмнө үнэлгээ хийлгэх талаар заасан нь хоорондоо зөрчилджээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсгийг Газрын тухай хуульд нийцүүлэх.

Хийдэл: Хуульд байх шаардлагатай зохицуулалтыг тусгах эсэх:

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	7 дугаар зүйл.Нөлөөллийн үнэлгээ 7.3.Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ. 8 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ 8.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ. 8.6.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна. 10 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ 10.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж нь ерөнхий үнэлгээнд заасан хугацаанд үнэлгээний ажлын тайланг холбогдох бусад бичиг баримтын хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

Дүгнэлт, санал: Төсөл хэрэгжүүлэгч нь үнэлгээний компани буюу нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжээр үнэлгээ хийлгэдэг. Үнэлгээ хийлгэхдээ зардлаа төлдөг бөгөөд тухайн төсөл батлагдсан эсэхээс үл шалтгаалан төлбөрөө төлдөг юм байна. Төсөл нь батлагдаагүй байсан ч төлбөрөө буцаан авч чаддаггүй. Иймд төсөл нь батлагдаагүй тохиолдолд төлбөрийн тодорхой хувийг буцаах талаар зохицуулалт тусгах.

Нэгдсэн дүгнэлт

Манай улс нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар мэргэжлийн 131 байгууллагад олгож, тус өдрийн байдлаар нөлөөллийн ерөнхий үнэлгээний 9483 дүгнэлт, нөлөөллийн үнэлгээний 6541 тайлан, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний 2 тайланг тус тус гарган ажилласан байна.

Иргэд, олон нийтийн байгууллага, төр засгийн зүгээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж иргэдийн эрхийг улам бататгах асуудлыг олон жил ярьж хэлэлцэж ирсний үр дүнд Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэсэн зохицуулалт орсон.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Төлөвлөгөө батлах тухай" 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах замаар 2020 онд багтаан нийцүүлэх, холбогдох заалтуудыг боловсронгуй болгохоор төлөвлөгөө баталсан хэдий ч одоогоор тус хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдаагүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд давхардуулан хуульчилсан эсэх, нэр томъёо, зүйл, заалт зөрчилдөж байгаа эсэх асуудлыг судлахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох зүйл, заалт нь Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хуулиудын тодорхой зүйл заалтуудтай давхардсан 4 зохицуулалт, 8 зөрчил, 1 хийдэл байна гэж үзэж байгаа тул дээрх 13 давхардал, хийдэл, зөрчлийг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нийцүүлэх.

Мөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь төслийн үйл ажиллагааг төлөвлөх, сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутагтай хамтын ажиллагаа эхлүүлэхэд чухал үйл явц хэдий ч бодит байдал дээр цөөнгүй тулгамдсан асуудлууд байгаа тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналыг сайжруулах, төслүүдийн төрөл, нөлөөлөл, ангилал, хамрах хүрээнээс хамаараад иргэдийн оролцоог хангах асуудлыг ялгаатай тусгах зэрэг асуудлыг шийдвэрлэх нь энэ салбарын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байна.

Санал

Ковид-19 цар тахлаас шалтгаалан 2020, 2021 онуудад мэргэжлийн эрх бүхий байгууллагуудын боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд олон нийтийн оролцоог хангах үйл явц зогсонги байдалд орж улмаар улс орны эдийн засагт нэмэр болохуйц төсөл, бүтээн байгуулалтуудын үйл явц зогсонги байдалд ороод байгаа тул Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 66 дугаар “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, улс орны эдийн засагт нэмэр болохуйц төслүүдийг хөдөлгөх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ном зүй

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль

Ном, сурах бичиг, судалгааны тайлан:

- Сэнгэдорж. Экологийн эрх зүй. УБ хот. 2001 он.
- Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он.
- Т.Оюунчимэг, Ц.Мөнхсайхан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ. УБ хот. 2013 он

Цахим эх сурвалж:

- <https://www.eic.mn>
- <https://mn.wikipedia.org/wiki>

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙН САЛБАРЫН НИЙГЭМД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

М.Уянга
Хууль зүйн магистр

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл, Монгол Улсад мэдээллийн хэрэгслийн хүртээмж, иргэд, олон нийтийн мэдээлэл олж авч буй эх сурвалж, түүний харьяалал, түүнчлэн, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүргийг хэрхэн тодорхойлж, нийгэмд эзлэх байр суурийн талаар товч авч үзсэн.

Түлхүүр үг: Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл зүй, нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл, радио, цахим мэдээллийн хэрэгсэл.

Удиртгал

Хэвлэл мэдээллийн салбар бол нийгмийн эмзэг салбар юм. Учир нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх гэсэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний суурь эрх хөндөгдөж байдагт оршдог.

Төр хэрхэн үндэсний аюулгүй байдлыг хангах, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, олон ургалч үзлийг дэмжих, улсын түүх, соёлын онцлогийг түгээх хүрээнд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зохицуулахын зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд баталгаажсан суурь эрхийг хангах тухай асуудал нь энэ судалгааны хүрээнд тодорхойлогдох юм.⁴⁹

Тэр дундаа сэтгүүлчийн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрэн дүүрэн зохицуулагдах нь нийгмийн салбарын үйл явцыг олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх, түүнтэй холбоотой үүсэн гарах харилцааг зохицуулахад чухал ач холбогдолтой байх юм. Нөгөө талаар сэтгүүл зүй гэж юу болох, түүний үр нөлөө хэрхэн нийгэмд нөлөөлж байгааг судалж, түүнийг нийгэмд бүтээмжтэй байдлаар ашиглах явдал өнөөгийн тулгамдсан асуудлын нэг юм.

Үндсэн хэсэг

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа тунхаглаж, чөлөөт эдийн засаг бүхий ардчилсан тогтолцоонд шилжээд 30 жил гаруй хугацаа өнгөрч, энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөө, гадаад харилцаа, чөлөөт хэвлэл, зах зээлийн чөлөөт эдийн засаг зэрэг ардчиллын олон чухал үзүүлэлтүүд Монголын хөрсөнд нутагшин хөгжсөн нь түүхэн ололт юм.

Зар сурталчилгааны тухай хуулийн 3.1.5-д “мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг⁵⁰ ойлгоно гэж заасан. Тэгвэл хэвлэл мэдээллийн байгууллага гэдэг нь дээрх хуулиар тодорхойлсон “хэвлэл мэдээллийн хэрэгсэл”-д хамаарах үйл ажиллагааг эрхлэн явуулахын тулд холбогдох эрх бүхий байгууллагаас хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авч, эрх бүхий бүртгэх байгууллагад бүртгүүлэн албан ёсоор хэвлэл мэдээллийн хэрэгслийн чиглэлээрх үйл ажиллагааг эрхлэн явуулж буй байгууллагуудыг ойлгож байна.

Тодруулбал; хэвлэл мэдээллийн байгууллагад сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, цахим сайт зэрэг хэвлэн нийтлэх эрхийг бүхий л хэлбэрээр хэрэгжүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хамаарах юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл бол “хэвлэн нийтлэх үйл ажиллагаа” буюу Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-д заасан “хэвлэн нийтлэх эрх чөлөө”⁵¹-ний тусламжтайгаар ард нийтийн дуу хоолойг төрд хүргэх, төрийн чиг үүргийг ард нийтэд таниулан сурталчлах явдал юм.

⁴⁹ <https://nli.gov.mn/?p=1921>

⁵⁰ Төрийн мэдээлэл. 2002. №23. Зар сурталчилгааны тухай хууль

⁵¹ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно”.⁵²

Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэл нь үнэн бодитой, тогтмол, шуурхай, хүртээмжтэй, багтаамж сайтай, идэвхтэй, ашигтай, чиглэсэн зорилготой байх зэрэг шинжээрээ бусад бүх төрлийн мэдээллээс ялгардаг.

Сэтгүүл зүй бол хүлээн авагчдад хандсан аливаа үйл явдлын судалгаа шинжилгээ ба үр дүнгийн тайлан юм. Сэтгүүл зүйн олон төрөл байдаг боловч туйлын зорилго нь хүлээн авагч, үзэгч, уншигчдад улс төр, бизнесийн бүтэц зохион байгуулалт, нийгмийн соёлын нүүр царай болсон урлаг соёлын тухай мэдээллүүдийг хүргэхэд оршино.

Орчин үеийн нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь мэдээллийг ханган нийлүүлэгч болон нийгмийн хэрэг явдлын бодол санаа нь болж байвч сэтгүүл зүйн үүрэг, эрх зүйн хэм хэмжээ нь өргөн олны мэдээллийн хэрэгслүүд, цахим орчингийн үр дүнгийн өөрчлөлт юм.⁵³

Сэтгүүл зүйг баримталж буй үзэл баримтлал, хэрэглэж буй тоног төхөөрөмж, хамрах хүрээ зэргээр нь маш олон янзаар ангилж нэрлэж байгаа бөгөөд зарим нэр төрөл дээр нэлээд маргаан дагуулдаг. Өдгөө шинэ шинэ үзэл баримтлал бий болж байна.

Аливаа орны чөлөөт хэвлэл төрийн мэдлийн бус, намын харьяалалгүй, статус, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан, эрх зүйн хувьд баталгаажсан, нийгэм улс төрийн нийтлэг хэвлэлийн хүрээнд үйлчилдэг, хяналтын буюу сөрөг хүчний үүргийг биелүүлж чаддаг зэрэг шалгууртай байдаг.

Дэлхийн “Фридом хаус”, “Фридом форум”, “Хил хязгааргүй сэтгүүлчдийн байгууллага” зэрэг бие даасан, нөлөө бүхий байгууллагууд тухайн орны чөлөөт хэвлэлийн зэрэглэлийг төрийн мэдлийн бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, улстөрч, эрх мэдэлтнүүдийг шүүмжилж болох эсэх, төрийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үзүүлэх улс төр, эдийн засгийн шууд ба дам дарамт, шахалт байгаа эсэхийг хамгийн түрүүнд харгалзан үздэг.⁵⁴

Сэтгүүл зүйг юуг тусгаж, юуны тухай өгүүлж байгаа чиглэл хандлага буюу тусгаж буй сэдвээр нь ангилж үздэг. Сэтгүүл зүйн сэдвийн ангилал ч мэдээллийн эрин зуунаас шалтгаалж маш олон төрлийн болж байгаа юм.

Сэтгүүл зүйг үзэл баримтлалаар нь дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

1. Сурталчилгааны сэтгүүл зүй
2. Өргөн нэвтрүүлгийн сэтгүүл зүй, */Радио сэтгүүл зүй, ТВ сэтгүүл зүй/*
3. Судалгааны сэтгүүл зүй
4. Гудамжны сэтгүүл зүй
5. Шар хэвлэл (Дуулиан шуугиант)
6. Социалист сэтгүүл зүй
7. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй
8. Дэлхий нийтийн сэтгүүл зүй
9. Сонин хэвлэлийн сэтгүүл зүй
10. Мэдээллийн сангийн сэтгүүл зүй, Дата сэтгүүл зүй
11. Гонзо сэтгүүл зүй
12. Гэрэл зургийн сэтгүүл зүй
13. Иргэний сэтгүүл зүй, Оролцооны сэтгүүл зүй
14. Нөлөөллийн сэтгүүл зүй, Өмгөөллийн сэтгүүл зүй
15. Интерактив сэтгүүл зүй

⁵² Төрийн мэдээлэл. 1998. №10. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

⁵³ <https://mn.wikipedia.org/wiki>

⁵⁴ <https://ikon.mn/n/xwl>

16. Дрон сэтгүүл зүй

17. Барууны сэтгүүл зүй гэх мэт ангилна.⁵⁵

Дэлхий дахинд тогтмол хэвлэл 300 жилийн турш олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүргийг дангаараа гүйцэтгэж байсан бөгөөд кино, радио, телевиз бий болсноор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл цоо шинэ тогтолцоо бий болжээ.

Орчин үед цахим хэвлэл эрчимтэй хөгжиж, мэдээллийн шинэ орон зай, боломжийг нээж, хэрэглэгчдийн тоо эрс нэмэгдэж байна. Мэдээллийн хэрэгсэл болгон өөрийн гэсэн давуу ба сул талтай. Мэдээллийн хэрэгслүүдийн харилцан нөхцөлдсөн нэгдмэл үйл ажиллагаа нь тэр давуу талыг оновчтой ашиглаж, сул талыг нөхөх замаар сэтгүүл зүйн үйл ажиллагаа жам ёсоор хэвийн явагдах онцлогтой юм.

Мэдээллийн хэрэгсэл бүр өөрийн гэсэн онцлог шинж, давуу талын ачаар мэдээллийн зах зээлд орон зайгаа эзэлж, байнгын хүлээн авагчаа бий болгодог, өрсөлдөх шинэ боломжийг эрж хайдаг, нийтлэл, нэвтрүүлгийг агуулга хэлбэр, ур чадвар, арга барилын хувьд үргэлж шинэчилж, хөгжүүлэн баяжуулж байдаг. Энэ нь оршин тогтнох, амьдрах чадварын эх үндэс болдог байна.

Монгол Улсад сонин сэтгүүл, радиогоос илүүтэй телевиз, интернет хэрэглэгчийн хувь хэмжээ өндөр байдаг байна. Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2019 оны эхний 10 сарын байдлаар 84 сонин, 73 сэтгүүл, 51 радио, 140 телевиз, 154 мэдээллийн сайт тогтмол үйл ажиллагаа явуулж байна.⁵⁶

№	Ангилал	2015	2016	2017	2018	2019
1	Сонин	101	89	88	92	84
2	Сэтгүүл	86	80	71	78	73
3	Радио	69	56	48	50	51
4	Телевиз	131	125	127	128	140
5	Мэдээллийн сайт	98	96	100	109	154
	Нийт	485	446	434	457	502

Манайд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн мэдээллийг олж авахад хүндрэлтэй байдаг. Телевиз, радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг харилцаа холбооны зохицуулах хорооны <http://www.crc.gov.mn> сайтаас үзэх боломжтой ч хувь эзэмшигчдийн хэмжээ тодорхой бус, харин сонин, сэтгүүлийн эзэмшигчдийн мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамаарагддаг бөгөөд ил тод бус байдаг байна.

Мэдээллийн сайтыг нэгдсэн журмаар, албан ёсоор бүртгэдэггүй, Харилцаа холбооны зохицуулах хороонд байх бүртгэл нь сайн дурын шинжтэй байдаг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернет хэрэглэгчдийн тоог албан ёсоор гаргадаг бөгөөд 2018 оны эцсийн байдлаар Монгол Улсад давхардсан тоогоор 4295400 орчим хүн интернэт хэрэглэж байна. Эдгээр интернет хэрэглэгчдийн 72 хувь нь өдөр бүр ямар нэг хэмжээгээр интернэтэд холбогдож буй бөгөөд 34 хүртэлх насныхан байна. Газарзүйн байршлаар ангилж үзвэл Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 80 хувь, хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн 66 хувь нь интернетэд өдөр бүр холбогддог байна.

Сонин, сэтгүүлийн уншигчид болон телевиз, радиогийн үзэгч, сонсогчдын тоог Харилцаа холбооны зохицуулах хороо болон бусад байгууллагаас тооцож гаргадаггүй. Харин хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн хүртээмж, хэрэглээний байдлыг түүвэр судалгааны дүнд үндэслэн гаргадаг.

Хэвлэлийн хүлээлэнгээс 2018 онд улсын хэмжээнд 1000 хүнийг хамруулан хийсэн судалгаагаар тус судалгаанд оролцогчдын тал нь сонин огт уншдаггүй гэжээ. Харин Улаанбаатар хотоос оролцогчдын 7 хувь нь, хөдөө орон нутгийн 3 хувь нь өдөр бүр сонин уншдаг байна. Сонины борлуулалтын хэмжээ жил ирэх тусам буурсан

⁵⁵ <https://mn.wikipedia.org/wiki>

⁵⁶ Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль боловсруулах ажлын хэсгин тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

үзүүлэлттэй байна. Сонины нийт борлуулалтын 84 хувийг захиалгаар, 16 хувийг өдөр тутмын худалдаагаар борлуулдаг байна.

Телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авдаг хүн амын хувь хэмжээг албан ёсоор гаргадаггүй. Гэхдээ өргөн нэвтрүүлгийн 16 телевиз радио давтамж ашиглан нэвтрүүлгээ орон даяар цацдаг. Мөн хиймэл дагуул, кабель болон IPTV-н тусламжтайгаар дээрх 16 сувгаас гадна дотоодын 52+ сувгийг орон даяар хүлээн авах боломжтой юм байна.

Телевизийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчийн тоо 2018 оны эхний хагас жилийн байдлаар 916.000 байна. Нийт хэрэглэгчдийн 5 хувь нь кабель, 44 хувь нь хиймэл дагуул, 30 хувь нь IPTV, 21.1 хувь нь DTV-ээр хүлээн авч байна. Түүнчлэн 14 телевизийн сувгийг өөрийнх нь веб сайтаар дамжуулан, www.looktv.mn веб сайтаар дамжуулан 27 монгол сувгийг интернетээр, дэлхий даяар хүлээн авч байна.

Радиогийн тухайд Монголын үндэсний олон нийтийн радио, Лавайн эгшиг радио, Шинэ монгол радио үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацаж байгаагаас 11 радиог онлайнаар шууд сонсох боломжтой, 8 радио ухаалаг утасны аппликэйшн ашиглан сонсож болдог байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны веб сайтад радиогийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчдийн тоо тавигдаагүй байна.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2019 оны жилийн эцсийн байдлаар манай улсад 502 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4749 хүн ажиллаж байгаагаас 49 хувь нь бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч байна.⁵⁷

Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүрэг. Сэтгүүл зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудлын нэг бол үүргийн тухай асуудал юм. Сэтгүүл зүй цаг ямагт нийгмийн амьдралын төвд байсан бөгөөд нийгэм өөрөө байнга сэтгүүл зүйг өөрчилж байдаг онцлогтой.

Нийгмийн амьдралын аль ч салбар хүрээнд гарч ирсэн аливаа асуудал эцсийн үр дүнд хүмүүсийн өдөр тутмын ажил үйлстэй салшгүй холбоотой. Ямар нэгэн тулгамдсан асуудал зөвхөн хүнтэй холбогдон гарч ирдэг бөгөөд түүнийг томъёолон, шийдвэрлэх боломж гагцхүү хүнд л байдаг.

Германы судлаачдын тодорхойлсноор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хоорондоо нягт холбоотой гурван үндсэн үүрэгтэй байдаг байна. Энэ нь:

1. Иргэдийг мэдээллээр хангах;
2. Олон нийтийн үзэл бодлыг бүрдүүлэхэд нөлөө үзүүлэх;
3. Шүүмжлэл гаргах, хяналт тавих гэсэн байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүч нөлөө, ач холбогдол туйлын өндөр учраас тэр нь заримдаа “дөрөв дэх засаглал” бий болгох боломжтой, тиймээс үүнийг буруугаар ашиглах, эсвэл үүргээ биелүүлж чадахгүй байдалд оруулахгүйн тулд үйл ажиллагааг нь хуулийн хүрээнд зохицуулан, хяналт тавьж байх шаардлагатай.

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбар дараах үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

д/д	Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүрэг	Тайлбар
1	Мэдээлэлх /Олон түмнийг мэдээллээр хангах/	Энэ бол чөлөөт хэвлэлийн төдийгүй, сэтгүүл зүйн гол үүрэг бөгөөд нийгмийн зорилгоос урган гарсан түүний мөн чанартай холбоотой. Сэтгүүл зүй гэдэг нь анх гарч ирэхдээ мэдээлэл түгээх, олон түмний мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилтын үүднээс бий болсон байна. Хэзээ, хаана, юу болж байгааг хүмүүс байнга мэдэхийг хүсдэг. Тэгвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээ бол хүмүүсийн

⁵⁷ Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль боловсруулах ажлын хэсгин тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

		сонирхож байгаа нийгмийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн, үйл явдлын баримтыг шуурхай, үнэн зөв, ойлгомжтой, товч, хүртээмжтэй, тодорхой мэдээлэх явдал юм. Тиймээс мэдээлэх үүрэг бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн угийн шинж чанарыг тодорхойлогч үндсэн үүрэг болдог байна. Францын судлаач Б.Буайен: “Нийгмийн доторх бүлгүүд нь материал баялгийг солилцохгүй байж яасан ч чадахгүй. Тэгвэл үзэл санаа, сэтгэл хөдлөл, мэдээг эс солилцвол нийгмийн доторх холбоо тасарч, бүлэг хэсгүүдийн хийгээд нийгмийн доторх хүмүүсийн нийтлэг ч үгүй болно.” гэж хэлсэн нь нийгэм дэх мэдээллийн үүрэг ямар чухал байхыг илэрхийлж байгаа баримт мөн.
2	Танин мэдүүлэх <i>/Боловсрол олгох, соён гэгээрүүлэх/</i>	Танин мэдэхгүй бол хүрээлэн буй ертөнцийг тусгахад чиглэсэн ухамсрын үйл ажиллагаа мөн. Мэдээлэл, тэр тусмаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэг гол сэдвээ зөв тусгах нь ухамсрын үйл ажиллагаа мөн тул тус асуудлаас бид танин мэдүүлэх үүргийн үндсийг тодорхойлж байдаг. Мэдээ, нийтлэл, нэвтрүүлэг болгон уншигч, сонсогч, үзэгчдийг танин мэдэхүйн зөв чиглэлд хөтлөн жолоодож, бүх юмны учрыг олох гэсэн хүн төрлөхтний хүсэл эрмэлзэлд нь тус нэмэр болж байх үүрэгтэй юм. Нийтлэл дэх танин мэдүүлэх элементийн хирээр ч уг материалын үнэ цэнэ тодорхойлогдоно.
3	Удирдлагын хэрэгсэл болох <i>/Хяналт тавих/</i>	Сэтгүүл зүйг “дөрөв дэх засаглал” гэх буюу хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага хийгээд шүүхийн дараа дөрөв дэх засаглалд ордог. Гэхдээ дөрөв дэх засаглал гэсэн үгийг ямар утгаар нь авч үзэх талаар бодох хэрэгтэй. Логик үүднээс авч үзвэл сэтгүүл зүй шууд утгаар авч үзвэл сэтгүүл зүй хэзээ ч засаглалын үүргийг гүйцэтгэж чадахгүй, харин өөрийнхөө идэвхитэй үйл ажиллагаагаар төр засгийн ажилд нөлөөлж чаддаг байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь төр засгаас гаргаж байгаа удирдах, зохион байгуулах аливаа түгээмэл шийдвэрийг олон түмэнд дамжуулдаг. Түүнийг олон түмэн хэрхэн хүлээн авч байгааг эргээд мэдээнэ. Эргэх мэдээллээр дээд удирдлага шийдвэр ээ хэрхэн зохион байгуулах, эсвэл засч өөрчлөх арга аа ахин дахин боловсруулах, үр дүнд хүрч байгааг мэдээд дараачийн шийдвэр ээ боловсруулж эхэлдэг. Бас удирдлагын объект, субъект хоёроос хүлээн авч байгаа мэдээллээ ашиглаад оновчтой арга зарчмыг ч хэвлэл мэдээллийн байгууллага боловсруулан шинэ санаа, ажил хэрэгч шинэ эхлэл, хөдөлгөөнийг санаачилдаг. Энэ утгаараа сэтгүүл зүй нь удирдлагын үүрэгтэй байдаг байна.
4	Зохион байгуулах <i>/Олон түмний үзэл бодлыг бүрүүлэхэд нөлөөлөх/</i>	Энэ үүрэг нь чөлөөт хэвлэлийн бусад үүрэгтэй харилцан уялдаж байж, хэвлэл мэдээллийн байгууллагын цацаж буй нийтлэл, нэвтрүүлэг нь үр нөлөөтэй байдаг. Сэтгүүл зүй өөрийнхөө зохион байгуулах үүргийг дараах гурван чиглэлээр явуулдаг байна. Үүнд: 1. Төр засаг болон удирдах дээд байгууллагуудын чухал баримт бичгүүдийг нийтлэх, сурталчлах, тайлбарлах; 2. Нийгмийн практик ажлын нэг салбар нэгжийн ажил үйлсийг сурталчлах, ололт угагдлыг илрүүлэх замаар шинэ санал зөвлөмж дэвшүүлэх, мөн зохион байгуулах ажлын нэг чухал хэлбэр болох редакцийн газарт ирж буй санал, гомдол, шүүмжлэл, хүсэлт зэргийг судалж үзсэний үндсэн дээр янз бүрийн арга хэмжээ зохион байгуулж, захидлын мөрөөр томоохон нийтлэл бэлтгэн, доторхой үр дүнд хүрэх, тэдний саналыг зохих байгууллагуудад томжуулан шийдвэрлүүлэх; 3. Шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих үйл ажиллагаа зэргээр тус үүргээ хэрэгжүүлдэг байна.
5	Харилцааны үүрэг	Сэтгүүл зүйн хүрээн дэх мэдээллийн харилцан нөлөөллийн урьдчилсан болон зайлшгүй нөхцөл нь хэрэглэгчидтэй, өөрөөр хэлбэл олон түмэн, нийгмийн институттай холбогдсон харилцаа байдаг. Энэ харилцааны үр дүнд сэтгүүл зүйн систем дэх сонин, хэвлэл, нэвтрүүлэг болгон хэрэглэгчдийнхээ мэдээллийн хэрэгцээг хангах замаар өөрийнхөө дүр төрх, өвөрмөц шинжийг олж, тодорхойлж

		байдаг байна.
6	Зугаацуулах <i>/Гоо зүйн хүмүүжил олгож, алжаал тайлах/</i>	Сэтгүүл зүй хүмүүсийн амралт, чөлөөт цагийг зөв өнгөрөөх алжаал тайлах, гоо зүйн таашаал хүртээх, соёл боловсролын хүрээг өргөтгөхөд чухал үүрэг гүйцэтгэдгийг үгүйсгэх аргагүй юм. Радио телевизээр өгч байгаа уран сайхны нэвтрүүлгүүд, уран сайхны кино, концерт, тогтмол хэвлэлд нийтлэгдэж буй уран сайхны болон уран зохиолын, танин мэдэхүйн чиглэлийн янз бүрийн материалууд хүмүүсийн сонирхлыг хамгийн ихэд татдаг.

Тэгвэл аль нэг хэвлэл мэдээллийн байгууллага, тодорхой нэг нийтлэл туурвиж байгаа сэтгүүлч хүртэл бүгд өөр өөрийн нийтлэлийн бодлогодоо дээрх үүргийн хослол нийлэмж хэр зэрэг зөв зохицож чадаж байгаа эсэхээс тэдгээр мэдээллийн үр нөлөөтэй байх эсэх нь шалтгаална гэдгийг нийтлэлийн бодлогынхоо шалгуур болгон харгалзан үзэх нь сэтгүүл зүйн үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хэвлэл мэдээллийн салбарын эдгээр үүрэг нь нэг мэдээнээс эхлээд нийтлэл, нэвтрүүлгийн хэд хэдэн жилийн хэтийн төлөвлөгөөнд харгалзан үзэх нэг гол чиглэл байхын дээр энэхүү чиглэл нь үүргээ хэрхэн биелүүлж байгаагийн эцсийн шалгуур нь болох юм.

Өнгөрсөн зууны эцэст дэлхийн олон оронд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь арилжааны хэрэгсэл болох хандлага улам хүчтэй өрнөх болов. Сонин, сэтгүүлийг хэвлэх, нэвтрүүлэг бэлтгэх үйл явц мэдээллийн үйлдвэрлэлийн салбар болон хувирч, хэрэглэгчдийн зах зээлийн шаардлагыг харгалзсан ажил хэрэгч шинж, үр ашигтай ажиллах менежмент, маркетингийн стандарт нэвтэрч байна. Америкийн мэдээллийн салбарынхан «Америкийн мэдээллийн үйлдвэрлэл бол бизнес мөн» гэж тунхагладаг нь үүнтэй холбоотой юм.

Арилжааны чиглэл бүхий сэтгүүл зүйд (profit seeking) сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл тодорхой зах зээлд үйлчилдэг ёстой гэсэн үзэл баримтлал өргөн дэлгэрсэн бол сэтгүүл зүйн бусад чиглэлийн төлөөлөгчид юуны өмнө иргэдэд, олон нийтийн санаа бодолд, эсвэл хувь хүн болох уншигчид хандах хэрэгтэй гэж үздэг байна.

Сэтгүүл зүйн арилжааны шинж өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд зах зээлийн механизмаар дамжин хэрэгждэг хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон сэтгүүлчдийн үйл ажиллагааг эдийн засгийн хувьд зохицуулах нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Зах зээлийн дарамт нь өрсөлдөөний орчинд үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн мэдээллийн хэрэгслийн болон сэтгүүлчдийн давуу тал, «тоглоомын дүрэм»-ийг тодорхойлж өгдгөөрөө онцлогтой юм.

Арилжааны хүчин зүйл орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгааг Америкийн сэтгүүл зүйн жишээгээр тайлбарлаж болно. 1990-ээд оны дунд тус улсын сонины төсвийн 80 хувийг сурталчилгааны орлогоос, зөвхөн 20 хувийг захиалга болон борлуулалтаас олсон мөнгөөр бүрдүүлж байв. Өөрөөр хэлбэл, сурталчилгаа олгогчид ба хүлээн авагчдын сонины санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг харьцаа нь 4:1 болж өөрчлөгдсөн.

Ийм сурталчилгааын нөлөө сонин хэвлэлийн агуулгад бас нөлөөлж, аль болохоор олон уншигчийн анхаарлыг татахуйц нийтлэл мэдээ нийтлэхийг чухалчилдаг болж байна. Тухайлбал, 90-ээд оны эхэнд АНУ-ын сонины сурвалжлагчдын 19 хувь нь спортын, 8 хувь нь гэмт хэрэг, шүүхийн үйл ажиллагааны асуудлаар, 7 хувь нь бизнесийн чиглэлийн сэдвээр дагнан мэргэших болжээ. Тэгвэл нийгмийн болон боловсролын асуудлаар мэргэшдэг сэтгүүлч ердөө 4 хувийг тус тус эзэлж байв.⁵⁸

XX зууны сүүлчийн 25 жилд арилжааны телевиз нэлээд эрчимтэй хөгжихийн хамт төлбөртэй нэвтрүүлэг, хөтөлбөр явуулах явдал өргөн нэвтэрчээ. Энэ асуудал өнөөдөр Европын холбооны орнуудын олон нийтийн санааг зовоож байгаа бөгөөд төр, засгийн зүгээс олон нийтийн телевизийг хөгжүүлэх, дэмжих талаар тодорхой

⁵⁸ <https://mn.wikipedia.org/wiki>

алхмуудыг хийж байна. Гэвч арилжааны телевизтэй хүссэн хүсээгүй өрсөлдөх шаардлагатай болсон олон нийтийн телевизийн компаниуд зар сурталчилгаа, арилжааны үйл ажиллагааны нууц хэлбэрийг түгээмэл ашиглах болсон юм.

МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D), Соёлын гавьяат зүтгэлтэн Маулетиин Зулькафиль 2017 онд өгсөн ярилцлагадаа “Сүүлийн жилүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн түүх, онол, практикийн асуудлыг хөндсөн судалгааны цөөнгүй бүтээл гарсан нь үүний тод илрэл юм. Харин сэтгүүл зүйн шүүмж зогсонги байдалд байна гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Сэтгүүлчийн уран бүтээлийн барометр байх ёстой шүүмж үгүйлэгдэж буй нь сэтгүүл зүй судлал дахь сул тал мөн. Энэ нь хэд хэдэн шалтгаантай холбоотой.

Шүүмж бичнэ гэдэг бол асар их хүч хөдөлмөр, мэдлэг, чадвар шаардсан хүнд ажил. Маш их хөдөлмөр гаргаж, асар их юм уншиж, судалж бичсэн тэр бүтээлийг үнэлэх, дэмжих ямар ч сэтгэлгээ, механизм алга байна. Нөгөө талаар манай практик сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад шүүмж хүлээж авах сэтгэлгээ огт бүрдээгүй. Шүүмж бичсэн хүний эсрэг бяцхан “дайн” зарлаж, ХМХ-ийг ашиглан хариу арга хэмжээ авах, харааж зүхэх нь энгийн үзэгдэл болсон.

Өнөөдөр шүүмж сонсох дургүй, өөрийнхөө алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй хүмүүс манай хэвлэл мэдээллийн хэрэгслээр дүүрэн байна. Энэ бол шүүмж зогсонги байдалд ороход нөлөөлж буй нэг гол хүчин зүйл юм. Шүүмж хөгжихгүй байгаагаас нийтлэл, нэвтрүүлгийн агуулга ч сайжрахгүй байна.

Мэдээллийн багтаамж, танин мэдэхүйн ач холбогдол сайтай, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх чадвартай, агуулга ба хэлбэрийн нэгдлийг өндөр төвшинд хангасан, гэгээлэг нийтлэл, нэвтрүүлэг үзэгдэхээ больсон гэж хэлж болно. Дээр нь зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа сайтууд олон нийтийг мэдээллээр хангах, гэгээрүүлэхийн оронд бохир аргаар буюу бусдыг шантаажилж мөнгө олох хэрэгсэл болон хувирсан нь нууц биш юм.

Шаардлагатай бол тийм сайт, сэтгүүлчдийг нэр бусаар нь баримттай хэлж болно. Энэ бол Монголын олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд дорвитой өөрчлөлт гарахгүй байгаагийн шинж юм. Судлаач хүний нүдээр харахад ийм хандлага манай сэтгүүл зүйд нэг хэсэгтээ үргэлжлэх төлөвтэй байна. Энэ бол тооны хойноос хөөцөлдөх сэтгүүл зүйн аливаа бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарах цаг болсны илрэл юм.”⁵⁹ гэсэн байдаг.

Нийгэмд сэтгүүл зүйн салбарын үүрэг оролцоог нэмэгдүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж чадвал нийгэм эрүүлжих, гэмт хэрэг, зөрчил буурах боломжтой юм гэж судлаачийн хувьд үзэж байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуулийн 3.1.“Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”, 3.2.“Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй”⁶⁰ гэж заасан хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчийн эрх зүйн байдлыг өнөөг хүртэл тодорхойлж өгөөгүй, мөн нийгэмд гүйцэтгэх үүрэг тодорхойгүй, зөвхөн зарчмаар нийгэмд гүйцэтгэх үүрэг нь тодорхойлогдож байгаа нь цаашид энэ талаар зайлшгүй авч үзэх шаардлага байгааг илэрхийлж байна.

Даяаршил бий болж буй өнөөгийн нийгэмд мэдээллийн шинэ технологийн хөгжлийн үр дүнд мэдээлэлд орон зай, цаг хугацаа үгүй болсон. Үүнд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гол үүрэг гүйцэтгэж байгаа нь бодит үзэгдэл юм. Хуучин цөөн хэдэн мэдээллийн хэрэгсэлд ханддаг хүлээн авагчид өнөөдөр хүссэн мэдээллийн хэрэгсэлд хандаж, хүссэн мэдээллийг чөлөөтэй хүлээн авдаг болсон нь задралын илрэл гэж үзэж болох юм.

⁵⁹ <https://ikon.mn/n/xwl>

⁶⁰ Төрийн мэдээлэл. 1998. №10. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хууль

Дүгнэлт

Өнөөдөр ардчиллын тулгуур баганын нэг бол чөлөөт хэвлэл мөн гэдгийг дэлхий даяар хүлээн зөвшөөрч байна. Чөлөөт хэвлэлийн хөгжил нь ямар хэмжээнд байгаагаар нь тухайн орны ардчиллын хөгжлийг хэмждэг нь энгийн үзэгдэл болжээ.

Сүүлийн 20 жилд нэвтрүүлгийн томоохон компаниуд олон нийтийн анхаарлыг онцгой татдаг спортын уралдаан, шоу зэрэг үйл явдлуудыг дагнан нэвтрүүлдэг эрх олж авах явдал өргөн дэлгэрч байна. Ийм эрхийг гол төлөв санхүү, эдийн засгийн нөөц боломж сайтай арилжааны телекомпаниуд авч байгаа нь олон нийтийн телевизийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг болжээ. Үүнээс үзэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн арилжааны шинж улам гүнзгийрч, компьютерийн сүлжээг өргөн ашиглах болсон нь ХХ зууны эцэст баян, ядуугийн хоорондох зөрчил дээр мэдээллээр хангах гэсэн өөр нэг томоохон шалгуур нэмэгдэхэд хүргэжээ. Уншигчдын нэг хэсэг нь интернетээс эхлэн мэдээллийн бүх суваг, эх сурвалжийг ашиглаж байхад нөгөө хэсэг нь хөрөнгө мөнгөний хүчин зүйлээс шалтгаалан мэдээлэл хүлээж авах боломж нь эрс хязгаарлагдмал байна.

Өнөөдөр манай улсын хууль тогтоомжид хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль өнөөг хүртэл гараагүй байгаа, гагцхүү зарчмаар нийгэмд гүйцэтгэх үүрэг тодорхойлогдож байгаа нь тулгамдсан асуудлын нэг болжээ.

Санал

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн салбарын нийгэмд үзүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх үүднээс дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлт оруулах;

1.1. Хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны зарчим” /шинээр/;

1.2. Хуулийн 3 дугаар зүйл “хуулийн нэр томъёо” /шинээр/;
 (“хэвлэл, мэдээллийн байгууллага”, “сэтгүүлч” гэх мэт нэр томъёоны тодорхойлолт);

1.3. Хуулийн 4 дүгээр зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын эрх” /шинээр/;

1.4. Хуулийн 5 дугаар зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг” /шинээр/;

1.5. Хуулийн 6 дугаар зүйл “Сэтгүүлчийн эрх” /шинээр/;

1.6. Хуулийн 7 дугаар зүйл “Сэтгүүлчийн үүрэг” /шинээр/;

1.7. Хуулийн 8 дугаар зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа” /шинээр/;

1.8. Хуулийн 9 дүгээр зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүжилт” /шинээр/;

1.9. Хуулийн 10 дугаар зүйл “Мэдээлэлд хяналт тавихыг хориглох”;

2.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн байгууллага гэж олон нийтийн мэдээллийн хэрэгслийг бэлтгэн гаргаж байгаа аж ахуйн нэгж байгууллагыг хэлнэ”, “Сэтгүүлч гэж олон нийтийн хэвлэл мэдээллээр дамжуулан сэдвийн мэдээлэл ба үзэл бодлыг олон нийтэд нийтлэх, түгээх ажлыг үндсэн мэргэжлээ болгон ажилладаг хүнийг хэлнэ” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг шинээр тусгаж өгөх;

3.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүжилттэй холбоотой харилцааг аливаа улс төрийн нам, хүчнээс хараат бус, зөвхөн зар сурталчилгаанаас олох зохицуулалтыг нарийвчлан тусгаж өгөх.

Ном зүй

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль

- Зар сурталчилгааны тухай хууль
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

Цахим эх сурвалж:

- <https://nli.gov.mn/?p=1921>
- <https://mn.wikipedia.org/wiki>
- <https://ikon.mn/n/xwl>

Судалгааны тайлан

- Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль боловсруулах ажлын хэсгийн 2017-2021 оны судалгааны мэдээ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХҮН БАРЬЦААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОБЪЕКТИВ ШИНЖ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ

*Д.Сундуйсүрэн
ДХИС-ийн Удирдлагын академийн Удирдахуйн ухааны
профессорын багийн профессор,
доктор (Ph.D), цагдаагийн хурандаа*

Товч агуулга: Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинж, түүний онцлог, зүйлчлэлийн асуудлыг авч үзсэн.

Түлхүүр үг: Хүн барьцаалах гэмт хэрэг, объект, объектив тал, халдлагын зүйл, хүний эрүүл мэнд, эрх чөлөө, хор уршиг.

Хүн барьцаалах гэмт хэргийн объект, объектив тал, түүний онцлог

Хүн барьцаалах гэмт хэргийн объектив тал нь гэмт этгээдийн Эрүүгийн хуулийн хамгаалсан нийгмийн эрх ашиг сонирхолд халдсан гэмт ажиллагааны илрэх гадаад хэлбэрийг тодорхойлох объектив шинжүүдийг өөртөө багтаасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бие даасан, заавал байх хэсэг юм.

Объект гэдэг үг хэллэг латины objectum буюу ямар нэг үйл ажиллагаа чиглэсэн юмс үзэгдлийг нэрлэдэг үгнээс гаралтай хэмээн гадаад үгийн толь⁶¹ тайлбарлажээ.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд нарийн төвөгтэй, маргаан, мэтгэлцээнтэй асуудлын нэг байсаар ирсэн юм.

Объектын талаарх мэтгэлцээн түүний олон талын агуулга, ач холбогдлыг илэрхийлж байна. Тухайлбал, эрүүгийн эрх зүйн онолд гэмт хэргийн объектыг янз бүрээр тайлбарлан өгүүлжээ. Академич С.Нарангэрэл гэмт хэргийн объектыг "гэмт халдлагын явцад гэм хор учирсан буюу учирч болох байсан эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг"⁶² гэж тодорхойлсон юм. Харин доктор, профессор Г.Гантөмөр "гэмт хэргийн улмаас гэмт этгээдийн халдлагад өртөгдөж байгаа нийгмийн харилцаа"⁶³ гэж үзсэн байна. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг нийгмийн харилцаа гэж үзэх явдал манай улсын эрүүгийн эрх зүйн онолын хувьд Монголын нэрд гарсан эрүүгийн эрх зүй судлаачид Б.Содовсүрэн⁶⁴, Г. Совд нар⁶⁵-ын бүтээлээс эх үүсэлтэй билээ. Сүүлийн үеийн эрүүгийн эрх зүйн ном зохиолд ч гэмт хэргийн объектыг "...гэмт этгээдийн халдлагад өртөгдөж байгаа нийгмийн харилцаа..."⁶⁶ гэж үзсээр байна.

Оросын эрдэмтэн Н.И.Коржанскийн саналаар бол "Гэмт хэргийн объект" гэж эрүүгийн хуулийн хамгаалалтад байдаг нийгмийн харилцаа бөгөөд түүнийг зөрчсөнөөс болж нийгэмд аюултай хор хөнөөл учирдаг. Гэмт хэргийн объект аливаа гэмт хэргүүдэд өртөж байдаг бай юм. Ийм бай нийгмийн харилцаа болно⁶⁷ гэжээ. Үүнээс үзэхэд гэмт хэргийн объект эрүүгийн хариуцлагын хууль зүйн үндэс өөрөөр хэлбэл гэмт хэргийн бүрэлдэхүүний салшгүй хэсэг, объектив шинжүүдийн нэг мөн. Гэмт этгээдийн гэмт зан үйл тодорхой объект буюу Эрүүгийн хуулиар гэмт халдлагаас хамгаалсан нийгмийн харилцаанд (эрх ашиг, сонирхол, үнэт зүйл) халдаж

⁶¹ Словарь иностранных слов. -М., 1989. С. 349.

⁶² Нарангэрэл С., Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж. – Уб., 2019. 277 дахь тал.

⁶³ Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. -Уб., 2011. 36 дахь тал.

⁶⁴ Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй (Ерөнхий анги). -Уб., 1969.

⁶⁵ Совд Г. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. -Уб., 1973.

⁶⁶ Насанбат Б. нар. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. (Сурах бичиг). -Уб., 2018, 79 дэх тал.

⁶⁷ Коржанский Н.И. Объект и предмет уголовно-правовой охраны. -М., 1980. С. 27.

байж сая гэмт хэрэг болдог. Тухайн объектын тусламжтайгаар гэмт хэргийн шинж, нийгэмд учруулах хор аюул зэрэглэлийг (далайцыг) нээн илрүүлдэг онцлогтой.

Хүний ухамсартай үйл ажиллагаа нийгмийн олон төрлийн харилцааг үүсгэж болохын зэрэгцээ түүний ухамсартай үйл ажиллагааны салшгүй хэсэг болох гэмт хэрэг нийгмийн тодорхой харилцаанд халдаж, нийгэмд аюултай хор уршгийг учруулах буюу тийм хор уршгийг учруулах нөхцөлийг үүсгэж байна.

Гэмт хэргийн объектыг эрүүгийн хуулиар хамгаалсан бөгөөд гэмт халдлагын улмаас гэм хор учирсан буюу учирч болох байсан эрх ашиг учраас энэ чанараараа эрх зүйн бусад зөрчлөөс гэмт хэргийг зааглаж ялгах нэг гол шалгуур гэж үзэж болно.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг явцуу утгаар тодорхойлбол гэмт хэргийн улмаас халдагдаж зөрчигдөж байгаа Эрүүгийн хуулиар хамгаалсан хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх ашиг, сонирхол юм⁶⁸.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг ангилах явдал түүний мөн чанарыг танин мэдэх боломжийг олгоод зогсохгүй хууль тогтоох (эрүүгийн хуулийг системчлэх) болон практик үйл ажиллагаанд (гэмт хэргийг зүйлчлэх) ач холбогдолтой асуудал юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг босоо түвшинд түүний шинж чанараас хамаарч: а) ерөнхий (нийтлэг); б) төрлийн; в) шууд гэж ангилж болох бөгөөд 1938 онд Зөвлөлтийн Эрүүгийн эрх зүйн эрдэмтэн В.Д.Меньшагин анх ийм ангиллыг санал болгожээ⁶⁹.

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийг судалж үзэхэд гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий объектыг Эрүүгийн хуулийн зорилгод гол төлөв тусгаж ирсэн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал”-д хор аюул учруулсан үйл явдлуудыг гэмт хэргийн халдлагын ерөнхий объект болгон заасан байна. Хүн барьцаалах үйлдлийг “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар шинээр гэмт хэрэгт тооцож хуульчилсан байдлаас харахад хүн барьцаалах гэмт хэргийн ерөнхий объектыг хүний эрх, эрх чөлөө, нийгмийн (нийтийн) аюулгүй байдал, ашиг сонирхол гэж үзсэн байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн объект гэж Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий хэд хэдэн нийгмийн харилцааг хэлдэг. Манай улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой бүлгүүдэд гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн объектыг тусгасан байдаг.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн объект ерөнхий объектын салшгүй хэсэг бөгөөд акад. С.Нарангэрэлийн бичсэнээр⁷⁰ нэг төрлийн эрх ашгийг багтаасан байдаг. Хууль зүйн ухааны доктор Г.Гантөмөр “Гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн объект Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн нэг буюу хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий хэсэг бүлэг харилцаа байж болно”⁷¹ гэж үзжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийг бүлэг болгосон шалгуур гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн объект болно. Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгүүдэд төрлийн объектыг буруу системчлэх явдал эцсийн дүндээ шууд объектыг буруу тогтооход хүргэдэг.

Хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн объектыг 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар бүлэгт “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”⁷² гэж тодорхойлжээ. 1961 оны Эрүүгийн хуулийн “Төрийн эсрэг гэмт хэрэг” хэмээх бүлгийн төрийн эсрэг бусад гэмт хэргүүдэд 1996 онд “Хүнийг барьцаалах” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хамааруулан нэмж хуульчилсан байдаг.

⁶⁸ Гантөмөр Г. Дурдсан бүтээл. 40 дэх тал

⁶⁹ Советское уголовное право (под ред В.Д.Меньшагина). -М., 1938. С. 46.

⁷⁰ Нарангэрэл С. Дурдсан бүтээл. 119 дэх тал.

⁷¹ Гантөмөр Г. Дурдсан бүтээл. 43 дахь тал.

⁷² Төрийн мэдээлэл (эмхэтгэл). -УБ., 2016. №07

Оросын судлаач Н.Н. Козлова: Хүн барьцаалан авах гэмт хэргийн объект хүн байх авч энэ гэмт хэргийн үед эрүүгийн эрх зүйн объектод хохирол учраагүй боловч хүнд хохирол ямагт учирдаг гээд тэрээр цааш нь тэмдэглэхдээ: Гэмт хэргийн нэр нь өөрөө "хүн барьцаалах" гэж буй, үнэн чанартаа бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл гэсэн үг. Ингэснээр эхний ээлжид хүнд хохирол учруулж байгаа хэрэг мөн гэж үзжээ.

Хүний эрх, эрх чөлөө, хувийн халдашгүй байдлыг хамгаална гэдэг тэргүүлэх зэргийн объектыг хамгаална гэсэн үг юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт "...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно ..." гэж заасан байна.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, хамгаалж ирсэн. Тухайлбал Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд "Хүн бүр ... эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд "Хүн бүр эрх чөлөөтэй байх болон халдашгүй дархан байх эрхтэй" гэж заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүний бие махбод, нэр төр, эд хөрөнгө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалсан бөгөөд хүнийг барьцаанд авч, тодорхой болзол, шаардлага тавьж байгаа явдал хүний бие махбодын халдашгүй чөлөөт байдалд шууд халдаж буй хэрэг юм.

Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэг нийгмийн хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн эрх ашиг, сонирхолд шууд халдаж хор уршгийг учруулсан байх ба ийм гэмт хэргийг Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд давхар объектод гэмт хэрэг гэж нэрлэдэг.

Давхар объектод гэмт хэргийн улмаас халдлагад өртөгдөж байгаа хэд хэдэн шууд объектуудын шинж, гэмт этгээдийн үйлдэл, гэмт этгээдийн санаа бодол, түүний чиглэлийг харгалзан: а) үндсэн шууд, б) нэмэгдэл шууд объект гэж ангилна.

Үндсэн шууд объект гэдэг гэмт этгээдийн санаа бодол шууд (зорилго) чиглэсэн, гэмт этгээдийн халдлагад шууд өртөж хор уршиг учирч байгаа нийгмийн харилцаа, эрх ашиг, сонирхлыг хэлнэ.

Нэмэгдэл шууд объект гэмт этгээдийн гэмт санаа бодол шууд (зорилго) чиглээгүй боловч үндсэн шууд объектод халдах явцад шууд бусаар гэмт этгээдийн халдлагад өртөж хор уршгийг учруулсан нийгмийн харилцаа юм.

Давхар объектод гэмт хэрэг дээр тухайн объект үндсэн ба нэмэгдэл шууд объект болохыг гэмт этгээдийн гэмт санаа бодол, түүний чиглэл, зорилго, гэмт үйлдлийн шинж, учруулсан хор уршгийн шинжийг үндэслэн тогтооно.

Хүн барьцаалах гэмт хэргийн явцад авто машин агаарын болон усан хөлөг гэмтэж устгагдах, аюултай хүчирхийлэл хэрэглэсний улмаас хүний амь нас эндсэн бол хүний эрүүл мэнд, амь нас гэмт хэргийн нэмэгдэл объект болж хувирна. Хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх юм⁷³.

Хүн барьцаалах гэмт хэргийг давхар объектод гэж үзнэ. Хүн барьцаалах гэмт хэргийн шууд объектыг Эрүүгийн эрх зүйн онолын судлаачид нийгмийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, иргэдийн халдашгүй, чөлөөтэй байх эрх, эрх чөлөө хүн барьцаалах гэмт хэргийн нэмэгдэл объектыг хүний эрүүл мэнд, амьдралын аюулгүй байдал зэргээр тодорхойлсон байдаг. Тухайлбал, 1996 онд Авдрантын хорих ангийн гянданд ял эдэлж байсан ялтан Л, Ч, Т нар хянагч А, О нарт буу тулгаж, тэднийг гар хөлийг хүлж, аманд нь даавуу чихэж, дүрэмт хувцсыг тайлж өөрсдөө өмсөж, улмаар ялтан эмэгтэй Б, Ц, Ч камераас гаргаж жадаар хутгалж алсан, дараа нь хянагч Б-г алсан, хүлэгтэй байсан хянагч А, О нарыг жадаар хутгалан хянагч А-г алсан юм. Түүнчлэн хорих ангийн эмнэлгийн өрөөнд байсан сувилагч М-ийн суганд буу тулган шалганы байранд авч очиж, хянагч Ц, Г нарт мөн АК буу тулгаж хүлээд, аманд нь алчуур чихэж үлдээсэн. Шоронгийн байрнаас ялтан Л, Ч, Т нар сувилагч М-г

⁷³ Совд Г. Монгол Улсын Үндсэн хууль-Хүний эрх (харьцуулсан эрх зүй). -УБ., 1999. 50 дахь тал.

авч явах замдаа машины жолооч С, Х нарт буу тулган машинтай нь авч явсан боловч бензин нь дууссан учир “Комби-24” маркийн машиныг зогсоолгож, ялтан Л буу гарган тулгаж, эд зүйлсийг нь дээрэмдэж, тэдгээр хүмүүсийг машинтай нь буу тулган авч явсаар модтой уулын ойролцоо буулгаж уул руу тууж авч явах үед цагдаагийнханд бүслэгдэн тэр даруй барьцаалагдсан хүмүүсийг сулласан⁷⁴ байна.

Дээрх анхаарал татахуйц жишээнээс харахад ялтан этгээдүүд шоронгоос оргохын тулд буу зэвсэг хэрэглэж 2 хянагч, 3 ялтан эмэгтэй нийт 5 хүнийг алсан, хүн барьцаалсан, бусдын амь нас эрүүл мэндэд халдсан, бусдыг айлган сүрдүүлж эд хөрөнгийг дээрэмдсэн, танхайрсан, хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан зэрэг онц жигшүүртэй гэмт хэргүүдийг үйлдсэн байна. Хүн барьцаалах гэмт хэргийн үндсэн шууд объект “хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал” хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний нэмэгдэл шууд объект “хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, төр, олон нийтийн байгууллага, гадаад орны болон олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагаа, улс хоорондын хэвийн харилцаа, үндэсний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал” зэрэг байж болно. Түүнчлэн, хүний эрүүл мэндэд ноцтой гэм хор учирсан, барьцааны хүнийг чөлөөлөхийн тулд их хэмжээний зардал гарсан, барьцаалах явцад төр, нийгмийн эд хөрөнгө ихээр сүйтгэгдсэн, төрийн болон бусад байгууллагын хэвийн үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан, ашиг орлого алдсан, улс хоорондын хэвийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлсэн, үндэсний аюулгүй байдалд бодит аюул занал учирсан, нийгмийг хамарсан айдас түгшүүр, эмх замбараагүй байдал бий болсон зэргийг хамааруулж байна.

Хүн барьцаалах гэмт хэрэг зарим тохиолдолд төр, түүний байгууллагуудад улс төрийн нөлөө үзүүлэх зорилготой байх боловч энэ нь дан ганц төрийн эсрэг чиглэх албагүй. Өөрөөр хэлбэл, амар хялбар аргаар хөрөнгө мөнгө олох, тодорхой газраас чөлөөтэйгөөр зугтан зайлах гэсэн гэмт этгээдийн явцуу ашиг сонирхлоор ч үйлдэж болно.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын тухай асуудлын хүрээнд гэмт хэргийн халдлагын зүйлийг хамааруулан авч үзнэ.

Хүний ухамсартай үйл ажиллагаа болох гэмт хэрэг бодит шинж чанартай байдгийн илрэл гэмт этгээдийн гэмт санаа бодол, үйл ажиллагаа тодорхой нийгмийн харилцааны эсрэг чиглэсэн, түүнд халдсан, хор уршиг бий болгосон байхаас гадна уг үйл ажиллагаанд ямагт тодорхой нэг материаллаг зүйл өртөж байдаг, түүнд энэ ажиллагаа нь чиглэсэн байдаг явдал юм.

Гэмт хэргийн халдлагын зүйл гэдэг гэмт этгээдийн санаа бодол шууд чиглэсэн, гэмт хэргийн бүрэлдэхүүний объектод халдах явцад түүний халдлагад шууд өртөж байгаа объектын материаллаг илэрхийлэл болсон юмс, эд зүйлийг хэлнэ.⁷⁵

Хүний бие махбодын халдашгүй дархан байдалд халдсан гэмт хэргийн хувьд халдлагын зүйл гэж томъёолох явдал зохимжгүй гэсэн чиг хандлага давамгайлж байна. Иймээс хүнийг барьцаалах гэмт хэргийн халдлагад өртөгч нь тодорхой хүн юм. Хүн гэдэгт Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүний аль аль нь хамаардаг.

Хууль тогтоогчийн зүгээс халдлагад өртөгч (халдлагын зүйл)-ийн онцлогоос шалтгаалж зарим гэмт хэргийг хүндрүүлж үзэхээр тогтоосон байдаг. Тухайлбал: хүнийг барьцаалах гэмт хэрэг дээр хоёр буюу түүнээс олон хүнийг, насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж барьцаанд авсан бол хүндрүүлж үзэхээр тогтоожээ.

ОХУ-ын Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн халдлагын зүйлд гэмт халдлагад өртсөн материаллаг юмс, эд зүйл хамаарна гэж ерөнхий байдлаар тодорхойлж байсан бол сүүлийн жилд гарсан эрүүгийн эрх зүйн сурах бичиг, бусад бүтээлд гэмт хэргийн халдлагын зүйлд зөвхөн материаллаг эд зүйлийг бус гэмт халдлагад өртсөн хүнийг хамааруулан хохирогч (пострадавший) гэсэн ойлголт, нэр томъёогоор

⁷⁴ Төв аймгийн шүүхийн 04 дугаартай таслан шийдвэрлэх тогтоол. 1996, УЕПГ-ын Эрүүгийн хэргийн төв архив. 621001 дугаартай эрүүгийн хэрэг.

⁷⁵ Гантөмөр Г. Дурдсан бүтээл. 51 дэх тал.

тодорхойлох, Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн хохирогч гэдгийг Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хохирогч (потерпевший) гэдэг ойлголтоос ялган үзэх саналыг дэвшүүлсэн байна⁷⁶.

Энэ үзэл сүүлийн үед Эрүүгийн эрх зүйн онолын сэтгэлгээнд өөрийн байр суурийг эзэлж ОХУ-д хэвлэсэн ихэнх эрдэмтдийн бүтээлд зонхилж байна⁷⁷.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн “хохирогч” гэсэн ойлголтыг Эрүүгийн эрх зүйд хэрэглэхгүйгээр, гэмт халдлагад өртсөн хүнийг “гэмт халдлагад өртөгч” (пострадавший) гэсэн шинэ нэр томъёогоор тодорхойлон гэмт хэргийн халдлагын зүйлээс салгаж объектын нэг бие даасан шинж болгож авч үзэх асуудлыг чухлаар тавьж байна.

Халдлагад өртөгч гэдэгт гэмт халдлагад өртсөн хувь этгээд буюу амь нас, эрүүл мэнд, бусад ашиг сонирхол шууд зөрчигдөж бие махбодын болон сэтгэл санааны зовлон, шаналал зүдүүрийг өөрийн биеэр амсч байгаа этгээд буюу хувь хүнийг ойлгохоор байна.

Акад. В.Н.Кудрявцевын “Гэмт үйлдэл нь гэмт хэрэг бүхэлдээ биш. Тэр бүү хэл түүний объектив бүх тал нь ч биш” гээд цааш нь тэмдэглэхдээ: “Гэмт хэргийн объектив тал нь нийгмийн аюултай, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлын эсрэг гэмт үйлдэл бөгөөд түүнийг үйл явдал үзэгдлийн өрнөх байдлыг гадна талаас нь харвал субъектын гэмт үйлдэл (эс үйлдэл) -ээс эхэлж гэмт үр дагаварт хүрснээр дуусч буй нь тогтоогдоно”⁷⁸ хэмээсэн явдал бодит ажиглалт байжээ. Үйлдэгдсэн гэмт хэрэг нийгмийн аюултай халдлага, эрүүгийн хуулиар хамгаалж буй объектод гарч буй үүсэх хөдөлгөөнүүдийн нийлбэр цогц гэж тодорхойлох боломжтой. Иймээс гэмт үйлдлийн эхний агшин нь эхэлсэн хөдөлгөөн эрүүгийн гэмт хэргийн шинжтэй нийгмийн аюултай дүр төрх чиглэлд ороход л гэмт хэрэг эхэлсэн гэж үзэж болохоор байна. В.Н.Кудрявцевын тэмдэглэснээр: Гэмт хэргийн объектив тал нь цаг хугацаа орон зайд өрнөж буй үйл явц бөгөөд энэ үйл явцын үр дагаварт янз бүрийн механик, физик болон бусад зүй тогтол илрэх бөгөөд эдгээр бүх үйл явц объектив шинжтэй.⁷⁹

Энэ зүй тогтол гэмт хэргийн тодорхой бүрэлдэхүүний шинжид тусгалаа олсон байдаг. Тийм элемент байхгүй байгаа нөхцөлд гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал үйлдэл (эс үйлдэл)-ийн хувьд эрүүгийн хариуцлагын асуудлыг шууд авч үзэх боломжгүй юм. Шинжилж буй гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нарийн төвөгтэй шинж нь хүн барьцаалах үйлдлээр илрэх бөгөөд эсвэл барьцааны хүн (хүмүүс)-ийг хүчээр барьж хоргоосноор илэрнэ⁸⁰.

Хүн барьцаалах гэмт хэргийн нийгэмд учруулах аюул нь уг хэргийн үр дагаварт иргэдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул тулгарч төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хэвийн ажиллагаа алдагдаж тээврийн үйл ажиллагаа тасалдах зэрэг байдалд хүрдэг.

Объектив тал нь гэмт хэргийн бүрэлдэхүүний бие даасан элементийн хувьд өөрийн гэсэн шинжүүдтэй байдаг. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжүүдийг тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хэрхэн нөлөөлж байгаагаас, тэдгээрийг Эрүүгийн хуулийн тусгай ангид хэрхэн хуульчилснаас нь хамааруулан үндсэн болон нэмэгдэл шинж гэж хоёр ангилдаг. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын үндсэн шинжид гэмт үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг, шалтгаант холбоо, нэмэгдэл шинжид гэмт хэрэг үйлдсэн арга, цаг хугацаа, газар, нөхцөл байдал, багаж зэвсэг, хэрэгсэл орно.

Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг ямар бүтэцтэйгээр хуульчилснаас хамаарч: а) бодит (материаллаг) бүрэлдэхүүнтэй

⁷⁶ Курс уголовного права. Общая часть. Том 1. -М., 1999. С. 111.

⁷⁷ Анощенкова С.В. Уголовно-правовое учение о потерпевшем. -М., 2006, В.Е. Батюкова. Потерпевший в уголовном праве. Автореф. дисс... канд. юрид. наук. 1995, И.А. Фаргиев. Потерпевший от преступления: уголовно-правовые вопросы. Хабаровск. 2001, А.В. Сумачев. Пострадавший как субъект уголовного правоотношения. Автореф. дисс...канд. юрид. наук. Рязань. 1997.

⁷⁸ Кудрявцев В. Н. Объективная сторона преступления. -М., 1960. С.38.

⁷⁹ Кудрявцев В. Н. Дурдсан бүтээл. С.35.

⁸⁰ Резепкин О. Ю., Журавлев И. А. Захват заложника. Уголовно-правовая регламентация проблемы. -М., 2003. С.51.

гэмт хэрэг, б) хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэж ангилдаг.

Материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэж тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт этгээдийн нийгэмд аюултай үйлдлийн улмаас заавал хор уршиг учирсан байхаар, хор уршиг учруулсан тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүн төгссөн байхаар хуульчилсан байхыг хэлнэ. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэж тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг Эрүүгийн хуулийн тусгай ангид тухайлсан зүйлийн диспозицод тодорхойлсон нийгэмд аюултай үйлдлийг хийснээр гэмт хэргийн бүрэлдэхүүн төгссөн байхаар хуульчилсныг хэлдэг.

Хүнийг барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан идэвхтэй үйлдлээр илэрнэ. Өөрөөр хэлбэл, хүний эрх чөлөөг хязгаарлаж, гуравдагч этгээдэд тодорхой болзол шаардлага тавьснаар төгсдөг, гэмт зорилгоо гүйцэлдүүлсэн эсэх нь хамаагүй байдаг. Ийм учраас хүнийг барьцаалах гэмт хэрэг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг мөн.

Судлаач Г.Совд “Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал хүнийг барьцаанд авсан, барьцаанд өгсөн үйлдэл байдаг. Учир нь барьцаалах гэдэг үг нь барьцаанд авах, барьцаанд өгөх хоёрыг хамтад нь илэрхийлж байна”⁸¹ гэжээ.

Хүнийг барьцаалах гэмт хэрэг гагцхүү гэмт үйлдлээр илрэх бөгөөд эс үйлдэхүйгээр үйлдэгдэх боломжгүй юм. Хүнийг барьцаанд авах нь хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий хэд хэдэн гэмт үйлдлээр илэрдэг. Тухайлбал, эхэлж хүний биеийн эрх чөлөөнд нь халдах, дараа нь тусгай байр саванд аваачиж хорих, эцэст нь гуравдагч этгээдэд болзол шаардлага тавих зэрэг үйлдэл хийж болно. Үүнийг эрүүгийн эрх зүйн онолд нэгдмэл үйлдэлтэй гэмт хэрэг гэж нэрлэдэг.

Барьцаалагдагч гэдэг түүнийг чөлөөлөх үүрэгтэй буюу сонирхолтой улс юм уу байгууллага, эсвэл иргэн ямар нэг шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлнэ гэсэн баталгаа болон хүчээр баригдаж байгаа хүн юм. Барьцаалагдагч нь нас, хүйс, үндэс угсаа, арьс өнгө, хөрөнгө чинээнээс үл хамаарч, ямар ч амьд хүн байж болно⁸².

Хүнийг барьцаалах явдал барьцааны хэлбэрээр хүнийг (хүмүүсийг) олзлон авах болон саатуулах байдлаар илэрч байдаг. Хүнийг барьцааны хэлбэрээр олзлон авах буюу барьцаанд байлгах явдал хүний биеийн эрх чөлөөт байдлыг хязгаарлаж, түүнийг өөр газарт, эсвэл тусгайлан бэлтгэсэн байранд тодорхой хугацаагаар хүчээр байлгахыг хэлнэ. Хүчээр барьцаанд байлгах үйлдлийг дагалдаж хүч хэрэглэх, эсвэл хүч хэрэглэхээр заналхийлэх явдал гардаг.

Хүч хэрэглэх явдал зодох, цохих, хүлэх болон амь нас, эрүүл мэндэд аюул учруулахааргүй бусад үйлдлүүдээр илэрдэг.

Хүч хэрэглэхээр заналхийлэх нь алах, бие махбодид нь гэмтэл учруулах, түүнчлэн эд хөрөнгийг устгах, гэмтээх зэрэг сүрдүүлгээр илэрнэ. Харин хүнийг барьцааны хэлбэрээр саатуулах гэдэг хүнийг оршин байгаа байрлалаас, жишээлбэл, байгууллагын албан контор, банк, вокзал, нисэх буудал зэргээс явуулахгүйгээр хүчээр тогтоон барихыг хэлнэ⁸³. Гэмт этгээд хүнийг барьцааны хэлбэрээр саатуулахдаа галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хутга, халуун, хүйтэн зэвсгийг ихэвчлэн ашигладаг байна.

Хүнийг барьцааны хэлбэрээр саатуулах үед гэмт этгээд ам хэлээрээ заналхийллээ ойлгуулахаас гадна биеийн тодорхой үйлдлээр өөрийгөө илэрхийлж болно. Жишээлбэл, гэмт этгээд бусдын өмнө үг хэлэлгүйгээр хохирогчийн толгойд буу, хоолойд хутга тулгах гэмт үйлдлийг хэрэгжүүлж хүнийг барьцаалах явцдаа ихэвчлэн гуравдагч этгээдэд хандаж ямар нэгэн болзол шаардлага тавьдаг байна.

Гуравдагч этгээд гэдэгт аль нэг улс, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд (аж ахуйн нэгж, байгууллага), нэг буюу хэд

⁸¹ Совд Г. “Эрүүгийн хуулийн тайлбар”. -Уб., 2002. 178 дахь тал.

⁸² Уголовное право Российской Федерации. Особенная часть. Под ред. Б.В.Здравомыслова. -М., 1999 . С. 254.

⁸³ Уголовное право России. Том 2. Особенная часть. Под ред. А.Н.Игнатова. -М., 1999. С. 353.

хэдэн хүнийг хамааруулж ойлгоно. Гэмт этгээд төр улсад шаардлага тавихдаа түүний байгууллагуудад хандаж тавьдаг. Төрийн байгууллагад шаардлага тавьж буй явдал угтаа төрд хандаж байгаа хэрэг юм. Хүнийг барьцаалах гэж нэг буюу хэд хэдэн хүний бие махбодын эрх чөлөөг хууль бусаар, хүчээр хязгаарлахыг хэлнэ. Ингэж барьцаалахдаа дор дурдсан 3 болзлыг суллах нөхцөл болгон бусад этгээдэд тавьсан байна. Үүнд: 1) Мөнгө хөрөнгө гаргуулах; 2) Өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, тухайлбал, баривчлагдагч болон хоригдлыг суллах, гэм буруутай этгээдийг зэвсэг, тээврийн хэрэгслээр хангах зэрэг; 3) Өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэхээс татгалзуулах⁸⁴, тухайлбал, тусламж үзүүлэхийг болиулахыг шаардах, тодорхой эрх зүйн акт гаргуулахгүй байхыг шаардах зэрэг байж болно.

Мөнгө, бусад эд хөрөнгө гэдэгт үндэсний мөнгөн тэмдэгт болон гадаад валют, төрөл бүрийн үнэт цаас, түүнчлэн тодорхой өртөг бүхий үнэт зүйл, эд юмсыг хамааруулж ойлгодог. Өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх гэдэгт дээрхээс бусад гэмт этгээдийн хувьд ашигтай ямар нэгэн үйлдлүүдийг барьцаалагчийн зүгээс хийлгэх гэснийг ойлгоно. Жишээлбэл, тодорхой газар болон бүс нутгаас гарч явах тээврийн хэрэгсэл (автомашин, мотоцикл, онгоц, нисдэг тэрэг, усан онгоц гэх мэт) өгөх, шоронгоос хоригдол суллуулах, улс төр, эдийн засаг, нийгмийн шинжтэй тодорхой шийдвэр гаргуулах зэрэг үйлдлүүдийг гүйцэтгүүлэхээр хүмүүсийг барьцаалах явдал нэлээд гарч байдаг.

Үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах гэдэгт тэрхүү үйлдлийг гүйцэтгэх нь гэмт этгээдийн ашиг сонирхолд харшлах тийм үйлдэл хийхийг барьцаалагчийн зүгээс болиулах гэсэн явдлыг ойлгоно. Тухайлбал, улс төр, эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий ямар нэг баримт бичигт гарын үзэг зуруулахаас, тодорхой бүс нутагт цэрэг оруулахаас, мөрдөн байцаалтын болон хар тамхи, мансууруулах бодис бэлтгэдэг ба хадгалдаг газрыг эрж хайх ажиллагааг явуулахаас татгалзуулах гэх мэт байж болно.

“Барьцаанд авах” гэдэгт бусдаас мөнгө, эд хөрөнгө гаргуулах, эсхүл аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зэрэг болзол тавьж, хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж, энэ тухайгаа хэн нэгэнд мэдэгдэн, шаардсан идэвхтэй үйлдлийг ойлгоно⁸⁵ гэж тайлбарлажээ.

“Болзол” гэдэгт гэмт этгээдээс иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад гаргаж буй хууль бус аливаа шаардлага хамаарна⁸⁶ гэжээ.

Хүнийг барьцаанд авах, тодорхой болзол шаардлага тавих хоёрын хооронд цаг хугацааны зөрөө байж болно. Хүнийг (хүмүүсийг) барьцаанд байлгасан хугацааны урт, богино зүйлчлэлд нөлөөлөхгүй бөгөөд гэмт этгээдэд шүүхээс ялыг ялгамжтай оногдуулахад харгалзах хүчин зүйл болж болно.

Барьцаалагч этгээд тавьж буй болзол шаардлагаа гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх арга нь барьцаалагдагчийн амь насыг бусниулах, бие махбодид гэмтэл учруулах, дархлалын олдмол хомстлын өвчин халдаах, урт удаан хугацаагаар барьцаанд байлгаж заналхийлэх явдал байдаг. Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.3 дугаар зүйлийн үндсэн бүрэлдэхүүнд тусгалаа олсон байдаг.

Хүнийг барьцаалах үед тавьсан шаардлага нь нийтэд зарласан шинжтэй байхаас гадна хууль сахиулах байгууллагуудын хараа хяналтаас гадуур тодорхой нэг болон хэсэг хүнд хандсан, зөвхөн тэдгээр хүмүүсийн хүрээнд мэдэгдэж байж болно.

Барьцаалагч этгээд болзол шаардлагаа тавихдаа телефон утас, факс, шуудан, цахилгаан, телевиз, радио, мөн түүнчлэн электрон шуудан гэх зэргийг ашигладаг. Электрон шуудан (e-mail) ашиглаж шаардлага тавих явдал мэдээлэл сүлжээний харилцаа өндөр хөгжсөн өнөө үед цөөнгүй тохиолдол болсон байна. Үүнийг интернэтийн сүлжээгээр и-мэйл явуулахад байгаа газрыг тогтоох боломж хомс байсан ч, түүнийг орчин үед шийдвэрлэх боломжтой болжээ. Барьцаалагдсан хүнийг (хүмүүсийг) барьж хорино гэдэг хүчээр буюу хүч хэрэглэхээр заналхийлж байгаа газраа орхиж явахад саад болно гэсэн үг. Энэ нь тухайн хүнийг байр байшинд

⁸⁴ Нарангэрэл С. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” Тусгай анги. -Уб., 1998. 36 дахь тал.

⁸⁵ УДШ-ийн тогтоол. -Уб., 2009. №14

⁸⁶ УДШ-ийн тогтоол. -Уб., 2009. №21

усан болон агаарын хөлөгт, автобус бусад тээврийн хэрэгсэлд цагдан хорино гэсэн үг. Тэнд л хохирогч тухайн газрыг өөрийн дураар орхин явж чадахгүй болно гэсэн үг. Барьж хорих нь ихэнх тохиолдолд хүн барьцаалж авах гэмт хэргийн үргэлжлэл болдог. Гэхдээ барьж хорих явдал түүнийг баривчлахгүйгээр явагдах (засаг төрийн төлөөлөгчийн шийдвэрээр буюу өөр хүний шийдвэрээр урьд нь баригдсан хүнээр солих тохиолдол) тал бий.

Дүгнэлт

Хүн барьцаалах гэмт хэргийн объект нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан, тухайн гэмт хэргийн (үйлдэл, эс үйлдэхүй) улмаас зөрчигдөж, нийгэмд аюултай хор уршиг учирсан буюу учирч болох байсан нийгмийн харилцаа (эрх ашиг, сонирхол, үнэт зүйл) юм.

Хүн барьцаалах гэмт хэргийг давхар объектоор гэж үзэж болно. Хүн барьцаалах гэмт хэргийн үндсэн шууд объект нь хүний эрх, эрх чөлөө, халдашгүй, чөлөөтэй байх эрх, нэмэгдэл шууд объект нь хүний амь нас, эрүүл мэнд, өмч, төр, олон нийтийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, гадаад орны болон олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагаа, улс хоорондын хэвийн харилцаа, үндэсний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал байж болох юм.

Хүнийг барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал төр, байгууллага, хүнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан идэвхтэй үйлдлээр илэрнэ. Өөрөөр хэлбэл, хүний эрх чөлөөг хязгаарлаж, зохих этгээдэд тодорхой болзол шаардлага тавьснаар гэмт үйлдэл төгсөх боломжтой. Иймээс хүнийг барьцаалах гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм.

Хүнийг барьцаалах гэмт хэрэг нь эс үйлдэхүйгээр үйлдэгдэх боломжгүй юм. Хүн барьцаалах гэмт хэргийн объектив шинж нь тухайн этгээд өөрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх боломжтой аливаа хүнийг барьцаа болгон барих, хорих, эрх чөлөөг нь хязгаарлах зэргээр тогтоон барьж, суллах болзол болгон зохих этгээдээр тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс татгалзуулахын тулд барьцааны хүний амь нас эрүүл мэндэд хүч хэрэглэхээр заналхийлэх, хүч хэрэглэх байдлаар тулган шаардаж буй үйл явцаар илэрнэ.

Ном зүй

- Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973.
- Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль-Хүний эрх (харьцуулсан эрх зүй). УБ., 1999.
- Г.Совд. “Эрүүгийн хуулийн тайлбар”. УБ., 2002 он.
- Б. Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй (Ерөнхий анги). УБ., 1969.
- С.Нарангэрэл., Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж. УБ., 2019.
- С.Нарангэрэл С. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” Тусгай анги. УБ., 1998.
- Ж.Болдбаатар. Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголтууд. УБ., 2002.
- Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2011
- Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги. УБ., 2020
- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018, 2020
- Б.Насанбат., А.Цэнгэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги (Сурах бичиг). УБ., 2018
- Төрийн мэдээлэл (эмхэтгэл). УБ., 2016. № 07
- УДШ-ийн тогтоол. УБ., 2009. № 14, 21
- Төв аймгийн шүүхийн 04 дугаартай таслан шийдвэрлэх тогтоол.1996. УЕПГ-ын Эрүүгийн хэргийн төв архив. 621001 дугаартай эрүүгийн хэрэг.
- Кудрявцев В. Н. Объективная сторона преступления. М., 1960.
- Н.И.Коржанский. Объект и предмет уголовно-правовой охраны. М., 1980.

- Советское уголовное право (под ред В.Д.Меньшагина). М., 1938.
- С.В.Анощенко С.В. Уголовно-правовое учение о потерпевшем. М., 2006.
- Резепкин О. Ю., Журавлев И. А. Захват заложника. Уголовно-правовая регламентация проблемы. М., 2003.
- Уголовное право Российской федерации. Особенная часть. Под ред. Б.В.Здравомыслова. М., 1999 .
- Словарь иностранных слов. М., 1989.

ОЛОН УЛСЫН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ОЛОН УЛСЫН ШИНЖТЭЙ ГЭМТ ХЭРЭГ ГЭХ ОЙЛГОЛТУУДЫГ СУДЛАХ НЬ

*А.Отгонжаргал
Хууль зүйн магистр*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд олон улсын шинжтэй гэмт хэрэг болон олон улсын гэмт хэрэг гэх ойлголтыг эрдэмтэн, судлаачид хэрхэн тайлбарласан, ямар төрлийн гэмт хэргийг дээрх ангилалд хамруулан үзэж байгаа эсэхийг судалсан болно.

Түлхүүр үг: Олон улсын шинжтэй гэмт хэрэг, олон улсын гэмт хэрэг, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм.

Удиртгал

Олон Улсын эрх зүй, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд олон улсын шинжтэй гэмт хэрэг, олон улсын гэмт хэрэг гэх ойлголтуудыг судлаачид өөр өөрийн өнцгөөс тайлбарлан боловсруулж тус нэршилд хамруулах гэмт хэргүүдийг ангилан үзэж ирсэн билээ. Олон улсын гэмт хэрэг, олон улсын шинжтэй гэмт хэрэг гэх ойлголтын талаар шинжлэх ухааны тодорхойлолт боловсруулж ангилахдаа олон улсын гэрээ хэлэлцээр, хууль, дүрмүүдийг баримтлахаас гадна гэмт хэргийн үндсэн шинжийг харгалзан үздэг.

Олон Улсын гэмт хэргийн тухай анхны ойлголтыг хуульч Маркус Туллиус Цицероны зохиолууд болох “hostes humani generis”-ийн тухай ойлголттой хамт Ромын эзэнт гүрэнт бий болсон. Энэхүү ойлголтыг XVII зуунаас эхлэн зохиолчид далайн дээрэм, боолчлол гэх мэт олон улсын гэмт хэрэг үйлдэгчдэд зориулан ашиглаж байжээ. Хүнд гэмт хэрэгт буруутгагдсан удирдагчдыг яллах зорилгоор Дэлхийн II дайны дараа байгуулагдсан Нюрнберг, Токиогийн шүүхүүд зарим гэмт хэргийг олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцсон нь өнөөгийн бидний нэрлэж заншсан олон улсын эрүүгийн эрх зүйн үндэс суурийг тавьсан⁸⁷.

1927 онд Варшав хотноо эрүүгийн эрх зүйг ойртуулах, төрөлжүүлэн эмхтгэх асуудлаар олон улсын бага хурал болж тус хурал дээр далайн дээрэм, зоос болон улсын үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, боол, эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, мансууруулах бодис хууль бусаар наймаалах, садар самууныг сурталчилсан зураг, зохиол нийтэлж тараах түүнчлэн олон улсын гэрээнд хариуцлага хүлээлгэхээр заасан бусад гэмт үйлдлийг олон улсын эрүүгийн гэмт хэрэгт тооцохоор тогтсон байна. Үүний дараа гурван бага хурал хуралдаж олон улсын алан хядах үйлдэлтэй тэмцэх гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх асуудлаарх улс гүрнүүдийн хууль тогтоомжийг ижилсүүлэх оролдлого хийсэн байна. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 96(1) тогтоолд устгах явдлыг “Олон Улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн гэмт хэрэг” гэж заасан бөгөөд төрөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг яллан шийтгэх тухай 1948 оны Конвенцийн удиртгал хэсэгт болон энэ асуудлаарх олон улсын бусад гэрээ хэлэлцээрүүдийн хэм хэмжээнд энэ томъёоллыг нэмжээ. Югославын асуудлаарх Олон Улсын цэргийн шүүхийн Дүрэмд (8 дугаар зүйл) цэрэг дайны үйл ажиллагааны бүсэд гарсан олон улсын эрүүгийн гэмт хэргийг “Олон Улсын хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг” гэж нэрлэжээ. Дээрх бүх гэмт хэргүүд нь олон улсын дэг журам, олон улсын эрх зүйн хэм хэмжээг ноцтой зөрчдөг. Олон Улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр хориглогдсон байдал бөгөөд энэхүү нийтлэг шинжээр нь **“Олон Улсын эрүүгийн гэмт хэрэг”** гэж нэрлэж болно. Үүнийг дотор нь гэмт хэргийн бүрэлдэхүүн, халдлагын объект, онцлог шинжээр нь:

1. Олон Улсын гэмт хэрэг
2. Олон Улсын шинжтэй гэмт хэрэг гэж ангилна⁸⁸ гэж тусгасан байна.

⁸⁷ <https://www.asser.nl/nexus/international-criminal-law/international-crimes-introduction/2021.09.29./20:32/>

⁸⁸ Д.Мөнхтуяа. Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал. УБ., 2000. 34 дэх тал

Энх амгалан байдлыг хангах хувь хүний болон олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал ашиг сонирхлыг хамгаалахад үндэс суурь болох Олон Улсын эрх зүйн зарчим хэм хэмжээнүүдийг хүн төрөлхтний соёл иргэншилд онцгой аюултайгаар зөрчсөнийг **олон улсын гэмт хэрэг** гэж үзнэ⁸⁹ гэж үзжээ.

Үүнээс дүгнэхэд олон улсын гэмт хэрэг, олон улсын шинжтэй гэмт хэрэг гэж ангилсан нь үндэслэлтэй байна гэж үзэхээр байна.

Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Ромын дүрмээр төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг гэсэн 4 төрлийн гэмт хэргийг уг шүүхэд харьяалуулан шийдвэрлүүлж байхаар зохицуулсан байдаг. Олон Улсын гэмт хэргийн жагсаалтыг анх 1945 оны Олон Улсын Цэргийн шүүхийн Дүрэм болон үүнтэй ижил Алс-Дорнодын асуудлаарх дүрэмд томьёолон тусгасан бөгөөд Олон Улсын Цэргийн шүүх Трибуналын дүрэм (1945)-ийн 6 дугаар зүйлд олон улсын гэмт хэргийг дараах байдлаар ангилсан. Үүнд:

1. Энх тайвны эсрэг гэмт хэрэг /түрэмгий дайн буюу олон улсын гэрээ хэлэлцээр, амлалт зөрчин дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, явуулах эсхүл дээр дурдсан үйлдлүүдийн аль нэгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ерөнхий төлөвлөгөө буюу хуйвалдаанд оролцох/

2. Цэргийн гэмт хэрэг /дор дурдсан дайны хууль, хэв заншлыг зөрчсөн үйлдлийг хамааруулна. Үүнд: эзэлж авсан нутаг дэвсгэрийн энгийн ард иргэдийг алж устгах, тарчлаан зовоох гэх мэт/

3. Хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг /алан хядах, хүйс тэмтрэх, боолчлох, цөллөгөнд явуулах, болон дайнаас өмнө буюу дайны явцад энгийн иргэдийн эсрэг үйлдсэн бусад харгислал, улс төрийн, арьс өнгөний болон шашин шүтлэгийн улмаас хүнийг мөрдөн мөшгөх үйлдэл бөгөөд эдгээр гэмт үйлдэл нь үйлдэгдсэн улс гүрний дотоодын эрх зүйг зөрчсөн эсэхээс үл хамаарна/

4. Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг /хүн төрөлхтний эсрэг ба цэргийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай 1968 оны Конвенцоор олон улсын гэмт хэргийг тусгай бүлэг болгон тодорхойлсон бөгөөд тэдгээрийн тоонд улс гүрэнд зэвсэглэн халдлага хийх буюу түрэмгийлэн эзэлсний дүнд иргэдийг нь цөллөгөнд хөөх, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бодлогын үр дагавар болох энэрэнгүй, хэрцгий үйлдэл, түүнчлэн төрлөөр устгах үйлдлүүдийг хамруулжээ. Мөн арьсны өнгөөр гадуурхах апартеидтэй ижил төстэй арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үйлдлийг гэмт хэрэгт тооцсон/⁹⁰.

Харин олон улсын шинжтэй гэмт хэрэг нь улс гүрний дотоодын эрх зүйн дэг журамд халдахын зэрэгцээ улс гүрнүүдийн хамтын ажиллагаа болон олон улсын харилцааны бусад талыг хөндөн бусад улс гүрэн буюу дэлхийн хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд хохирол учруулна гэж үзжээ.

ОХУ-ын профессор И.И.Карпец олон улсын шинжтэй гэмт хэргүүдийн тоонд "...онгоц хулгайлах, хүн барьцаалах, олон улсын хамгаалалтад байдаг этгээдүүдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, байгаль орчныг бохирдуулах, улс түмний үндэсний соёлын үнэт зүйлсэд халдах, садар самууныг сурталчилсан зүйлсийг түгээх, далайн хөлөг онгоцууд мөргөлдөх, далай, тэнгист тусламж үзүүлэхгүй байх, тивүүдийн эрэг орчмын далайн гүехэн устай бүсэд гэмт хэрэг үйлдэх..."⁹¹ зэрэг гэмт үйлдлийг шинээр авч үзсэн байдаг.

Олон Улсын гэмт хэрэг, олон улсын шинжтэй гэмт хэргүүд нь Олон Улсын хамтын нийгэмлэгийн эрх ашгийг хөнддөг бөгөөд тэдгээрийг мөрдөн шалгахад гадаадын эрх бүхий зохих байгууллагууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах зайлшгүй шаардлага тулгардаг. Хамтран ажиллахын тулд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулсан байх хэрэгцээ шаардлага үүсдэг. Цаашид "Олон улсын шинжтэй гэмт хэрэг", "Олон улсын гэмт хэрэг" гэсэн

⁸⁹ Дурдсан бүтээл. 34 дэх тал

⁹⁰ Дурдсан бүтээл. 35-37 дахь тал

⁹¹ И.П. Блищенко, Р.А. Каламкьян, И.И.Карпец. Международное уголовное право. идр.— М.Наука, 1995; Карпец И.И.Преступления международного характера.М., 1979. С-3.

ойлголтуудыг хооронд нь ялган ангилж, тусгайлан тайлбарлах эсхүл нэг ангилалд багтаан тайлбарлах эсэхийг нэг мөр болгох, энэ ангилалд ямар төрлийн гэмт хэргүүд багтах эсэхийг тогтоох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Үндсэн хэсэг

Зарим судлаачид олон улсын шинжтэй гэмт хэргийг дэлгэрэнгүй тодорхойлохдоо “Энэ нь хүн төрөлхтөн, энх тайван, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт үл хамаарах боловч улс хоорондын тогтвортой харилцаанд халдсан, уг харилцааны (эдийн засгийн, нийгэм соёлын, эд хөрөнгийн гэх мэт) янз бүрийн салбар дахь хамтын ажиллагаа, түүнчлэн иргэд байгууллагад хохирол учруулсан, нэг бол олон улсын гэрээгээр тогтоосон хэм хэмжээнд зааснаар эсхүл эдгээр гэрээний дагуу үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээнд зааснаар шийтгэл ногдуулах, олон улсын гэрээнд заасан гэмт үйлдэл юм⁹² гэжээ. Үүнийг үндэслэн энэ гэмт хэргийн нэлээд өвөрмөц онцлогийг дурдаж болно. Үүнд:

- Олон улсын шинжтэй гэмт хэргийн олон улсын хор уршиг нь олон улсын гэмт хэргийнхээс үлэмж бага байдаг учраас эдгээр гэмт үйлдлийн хариуцлагыг улс гүрнүүд биш харин бие хүн хүлээдгээрээ олон улсын гэмт хэргээс ялгагдана.
- Гэмт халдлагын объект нь олон улсын энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдал бус, зөвхөн улс хоорондын хамтын ажиллагаа, хэвийн харилцаа, хүний эрх болон олон улсын эрх зүйгээр хамгаалсан хүн төрөлхтний бусад нийтлэг үнэт зүйлс болдог,
- Эдгээр гэмт хэргийн төлөө хүлээх эрүүгийн хариуцлага олон улсын гэрээний үндсэн дээр, гэхдээ эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх үндэсний хууль тогтоомжийн хэм хэмжээгээр үүснэ.

Олон улсын шинжтэй гэмт хэргүүд нь өөрийн агуулга, шинжээрээ ялгаатай бөгөөд тэдгээрийн дийлэнхэд “гадаадын элемент” тод илэрсэн байна. Бусад нь олон улсын дэг журамд шууд үл халдах нийтлэг эрүүгийн гэмт хэрэгт зааг хязгаар нэг ижил байх боловч тус хэргийг илрүүлэх, шүүн таслах ба таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх ажиллагаанд улс гүрнүүдийн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа шаардагдана. Энд дурдагдаж буй дийлэнх гэмт хэргийг үйлдсэний төлөө хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хууль зүйн ном зохиолд хангалттай тусган тайлбарласан хэдий ч ямар гэмт үйлдлийг олон улсын шинжтэй гэмт хэргийн тоонд хамааруулах нарийн тодорхой шалгуур одоогоор байхгүй байна.

Судлаач Б.Жаргалсайхан олон улсын шинжтэй гэмт хэрэг (2 буюу хэд хэдэн улс орны сонирхол хөндөгддөг, шийтгэлийн институцээр дамжуулж оногдуулдаг)-т хуурамч мөнгө үйлдвэрлэх, автын эргэлтийн хууль бус эргэлт, зэвсэг, хар тамхи, нууц цагаачлал, контрбанд, гэмт үйлдлийн улмаас олсон орлогыг угаах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис худалдаалах⁹³ зэрэг гэмт хэрэг орно гэж үзжээ. Дээрх гэмт хэргүүдийг олон улсын шинжтэй гэмт хэрэгт хамааруулан үзэх боломжтой гэж үзэж байна.

Академич С.Нарангэрэл олон улсын шинжтэй гэмт хэргийн үндсэн шинжийг “улс хоорондын хэвийн харилцаанд халдсан ба янз бүрийн салбарт энх тайвнаар хамтран ажиллахад хохирол учруулсан, олон улсын гэмт хэрэгт хамаардаггүй, олон улсын гэрээнд заасан нийгэмд аюултай үйлдэл”⁹⁴ гэж тайлбарласан байна. Үүнээс үзэхэд олон улсын шинжтэй гэмт хэргийн үндсэн шинжийг дараах байдлаар тоймлон тодорхойлж болох юм.

1. Улс хоорондын хэвийн харилцаанд халдсан,
2. Янз бүрийн салбарт энх тайвнаар хамтран ажиллахад хохирол учруулсан,
3. Тухайн улсын дотоодын эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэрэгт тооцсон,
4. Олон улсын гэмт хэрэг бус байна
5. Нийгэмд аюултай үйлдэл болохыг олон улсын гэрээнд заасан байна.⁹⁵

⁹² Международное уголовное право. М., 1995. С-2.

⁹³ Б.Жаргалсайхан. Олон улсын эрх зүй. УБ., 2020. 184 дэх тал.

⁹⁴ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Гурав дахь хэвлэлт. б., 2011. 127 дахь тал.

⁹⁵ Б.Алтанбагана. Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг. УБ., 2014. 41 дэх тал.

2002 оны Эрүүгийн хуульд заасан дараах гэмт хэргийг олон улсын шинжтэй гэмт хэрэг хэмээн үзэж болно гэж доктор Б.Алтанбагана үзжээ. Үүнд: Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах (101 дүгээр зүйл), хүн хулгайлах (108 дугаар зүйл), хүнийг барьцаалах (112 дугаар зүйл), хүн худалдаалах (113 дугаар зүйл), садар самууныг сурталчлах (123 дугаар зүйл), мөнгө угаах (166 дугаар зүйл), эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх (175 дугаар зүйл), мөнгөн тэмдэгт, үнэт цаас хуурамчаар үйлдэх (176 дугаар зүйл), терроризм (178 дугаар зүйл), терроризмыг санхүүжүүлэх (178 дугаар зүйл), тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт авч явах (184 дүгээр зүйл), галт зэвсэг, байлдааны хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол улсын хилээр нэвтрүүлэх (188 дугаар зүйл), олон улсын нислэгийн журам зөрчих (224 дүгээр зүйл), агаарын хөлөг авч зугтаах (225 дугаар зүйл), хээл хахууль авах (269 дүгээр зүйл) зэрэг юм.⁹⁶ Дээрх гэмт хэргүүдийг олон улсын шинжтэй гэмт хэрэгт хамааруулан үзэх боломжтой гэж дүгнэж байна.

Олон улсын шинжтэй гэмт хэргүүд нь үндэсний эрх зүйн хэв журамд халдаж, олон улсын хамтын нийгэмлэгийн эрх ашгийг хөнддөг үндсэн шинжтэй бөгөөд зарим эрдэмтэн судлаачид “олон улсын гэмт хэрэг”-ийг конвенцын гэмт хэрэг гэж нэрлэдэг. Шалтгаан нь улс хоорондын хамтын ажиллагаа нь олон улсын шинжтэй тодорхой гэмт хэргүүдтэй тэмцэх зорилготой олон талын гэрээнүүдийн үндсэн дээр хэрэгждэг⁹⁷ гэж үзсэн.

Харин академич С.Нарангэрэл олон улсын гэмт хэргийн үндсэн шинжийг “Энх тайвныг сахин хангах, хувь хүнийг хамгаалах тулгуур үндэс болсон, олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал эрх ашигт бүхэлд нь ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн зарчим ба хэм хэмжээг зөрчсөн, хүн төрөлхтний соёл, иргэншилд онц аюултай хэрэг”⁹⁸ гэж тодорхойлжээ. Эндээс үзэхэд олон улсын гэмт хэргийн хамгийн гол онцлог шинж нь олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал эрх ашигт бүхэлд нь ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн зарчим ба хэм хэмжээг зөрчсөн, хүн төрөлхтний соёл иргэншилд онц аюултай хэрэг байх явдал юм.

НҮБ-аас 1998 онд баталсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд олон улсын гэмт хэргийн талаар тодорхойлолт өгсөн байна. Энэхүү гэмт хэрэгт дараах дөрвөн төрлийн гэмт хэргийг хамруулжээ. Үүнд: Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг⁹⁹

Доктор Б.Алтанбагана олон улсын гэмт хэргийг 1998 оны Олон улсын эрүүгийн шүүхийн тухай Ромын статутад заасан дөрвөн төрлийн гэмт хэргийн хүрээнд ойлгох шаардлагатай байна. Хэрэв энэ хүрээнээс хальж ойлгож хэрэглэхэд хүрвэл олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй хольж хутгах асуудал үүсэж болзошгүй байдаг¹⁰⁰ гэж үзсэн байна.

Мөн судлаач И.И.Карпец “...Олон улсын шинжтэй гэмт хэрэг гэдэг нь олон улсын гэрээнүүдэд тусгагдсан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгтэй хамааралгүй боловч улс орнууд хоорондын хэвийн харилцаанд халдсан, харилцааны янз бүрийн салбарын (эдийн засаг, нийгэм-соёл, эд хөрөнгө, цахим орчин гэх мэт) хамтын ажиллагаанд, түүнчлэн, байгууллага, иргэнд хохирол учруулдаг, олон улсын гэрээгээр тогтоосон хэм хэмжээний дагуу эсхүл эдгээр гэрээтэй нийцсэн үндэсний эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээний дагуу шийтгэдэг үйлдлүүд юм...” гэж тодорхойлсон.¹⁰¹ Оросын Холбооны Улсын эрх зүйн акт болон олон улсын хэлэлцээрүүдэд “Олон улсын шинжтэй гэмт хэрэг” гэх ойлголтыг дурдсан байдаг.

Манай улсын зарим судлаач олон улсын гэмт хэрэг нь улс үндэстний оршин тогтнох үндэст халдсан олон улсын эрх зүйг зөрчсөн, хүн төрөлхтний энх тайван, аюулгүй байдалд аюул заналхийлсэн ноцтой гэмт хэрэг бөгөөд олон улсын гэмт

⁹⁶ Дурдсан бүтээл. 42 дахь тал.

⁹⁷ Международное право. /Под ред.Л.Н.Шестакова.–М.: Юридическая литература, 2005., С.284.

⁹⁸ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Гурав дахь хэвлэлт. УБ., 2011. 126 дахь тал.

⁹⁹ Б.Алтанбагана. Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг. УБ., 2014. 38 дахь тал.

¹⁰⁰ Дурдсан бүтээл. 39 дэх тал.

¹⁰¹ И.П.Блищенко, Р.А. Каламкарян, И.И. Карпец. Международное уголовное право. идр.М., Наука, 1995. С.116.

хэргийн объект нь хүн төрөлхтний энх тайван, олон улсын аюулгүй байдал, улс үндэстнүүдийн сайн хөршийн харилцаа, үндэстэн ард түмний өөртөө засан тогтнох эрх, дайны хууль, ёс заншил зэрэг байж болно¹⁰² гэж тэмдэглэжээ.

Дүгнэлт

Дээр дурдсан эрдэмтэн, судлаачдын тайлбарласан ойлголтуудыг нэгтгэн үзэхэд, олон улсын гэмт хэрэг, олон улсын шинжтэй гэмт хэрэг гэх ойлголтуудыг нэгтгэн дүгнэж үзэх боломжгүй. Хоёр өөр ойлголт мөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Олон Улсын гэмт хэрэг гэж энх тайвныг сахин хангах, хувь хүнийг хамгаалах тулгуур үндэс болсон, олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал эрх ашигт бүхэлд нь ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн зарчим ба хэм хэмжээг зөрчсөн, хүн төрөлхтний соёл, иргэншилд онц аюултай шинжтэй, НҮБ-аас 1998 онд баталсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн тухай Ромын дүрэмд заасан төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэргийг хэлнэ гэж тодорхойлж болохоор байна. Олон Улсын гэмт хэрэгт НҮБ-аас 1998 онд баталсан Олон Улсын Эрүүгийн шүүхийн тухай Ромын дүрэмд тусгагдсан төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэргүүдийг хамруулан үзэх. Үүнд манай улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин есдүгээр бүлэгт заасан гэмт хэргүүдийг хамруулан үзэх боломжтой.

Олон Улсын шинжтэй гэмт хэрэг гэж улс хоорондын хэвийн харилцаанд халдсан, энх тайвнаар хамтран ажиллахад хохирол учруулсан, олон улсын гэмт хэрэгт хамаардаггүй, олон улсын гэрээгээр тогтоосон хэм хэмжээнд зааснаар эсхүл эдгээр гэрээний дагуу үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээнд зааснаар шийтгэл ногдуулах, олон улсын гэрээнд заасан гэмт үйлдлийг хэлнэ гэж дүгнэж байна. Олон улсын шинжтэй гэмт хэрэгт одоо мөрдөгдөж байгаа эрүүгийн хуулийн тусгай ангид заасан *хүн худалдаалах, хүн хулгайлах, хүн барьцаалах, хүнийг хүчээр алга болгох, албадан хөдөлмөрлүүлэх, худал мэдээлэл тараах, хүний цус эд эрхтний хууль бусаар авах, бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, мөнгө угаах, мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэх мэт* хэргийг хамааруулан авч үзэж болох юм гэж үзлээ.

Санал

1. Олон улсын гэмт хэрэг нь энх тайвныг сахин хангах, хувь хүнийг хамгаалах тулгуур үндэс болсон, олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал эрх ашигт бүхэлд нь ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн зарчим ба хэм хэмжээг зөрчсөн, хүн төрөлхтний соёл, иргэншилд онц аюултай шинжтэй, НҮБ-аас 1998 онд баталсан Олон Улсын Эрүүгийн шүүхийн тухай Ромын дүрэмд заасан төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт гэмт хэрэг байна. Харин олон улсын шинжтэй гэмт хэрэг нь улс хоорондын хэвийн харилцаанд халдсан, энх тайвнаар хамтран ажиллахад хохирол учруулсан, олон улсын гэмт хэрэгт хамаардаггүй, олон улсын гэрээгээр тогтоосон хэм хэмжээнд зааснаар эсхүл эдгээр гэрээний дагуу үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээнд зааснаар шийтгэл ногдуулах, олон улсын гэрээнд заасан гэмт үйлдлийг хэлнэ гэж ойлгож болохоор байх тул цаашид **олон улсын гэмт хэрэг, олон улсын шинжтэй гэмт хэрэг** гэх ойлголтуудыг тус тусад нь ойлгох.

2. Олон улсын гэмт хэрэг, олон улсын шинжтэй гэмт хэрэг үйлдэгдэн гарахаас урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, нотлох баримтыг түргэн шуурхай цуглуулж, бэхжүүлэн хэрэгт хавсаргахад анхаарч үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулах зорилгоор гадаадын улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнүүдийг дахин нягталж үзэн боловсронгуй болгуулах

¹⁰² Д.Тунгалаг. Эдийн засгийн аюулгүй байдлын тайлбар толь. УБ., 2005. 89 дэх тал.

хэрэгцээ шаардлага үүсээд байна. Дараах гэрээнүүд нь 1968-1988 оны хооронд байгуулагдсан. Гэрээ байгуулсан цаг хугацаанд дагаж мөрдөгдөж байсан хууль тогтоомжууд өөрчлөгдөж, шинэчлэгдсэн тул гэрээнд тусгасан зарим заалтуудад одоо дагаж мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад тусгасан нэршил, агуулгыг оруулах, эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх даалгаврын биелэлтийг хүргүүлэх хугацааны талаар нарийн тусгуулах саналтай байна. Үүнд: Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын хооронд Иргэний болон гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх тухай гэрээг 1969.04.30-ны өдөр, “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Болгар Ард Улсын хооронд иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 1968.11.27-ны өдөр”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хооронд иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 1988.10.29-ний өдөр”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Унгар Ард Улсын хооронд иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 1968.11.22-ны өдөр”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Чехословак Улсын хооронд иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх болон эрхийн харилцаа тогтоох тухай гэрээг 1976.10.25-ны өдөр”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын хооронд иргэний болон гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх тухай гэрээг 1972.11.25-ны өдөр”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иргэний болон Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 1989.08.31-ний өдөр” тус тус байгуулсан.

3. Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “төв байгууллага” гэж БНМАУ-ын хувьд БНМАУ-ын Хууль зүй, арбитрын яам, БНМАУ-ын Дээд Шүүхийг; БНХАУ-ын хувьд БНХАУ-ын Шүүх яам, БНХАУ-ын Ардын Дээд Шүүхийг тус тус хэлнэ гэж тусгасан байх тул төв байгууллагын нэршлийг зөвтгөн тусгах. Мөн 15 дугаар зүйл /Биелэлтийг мэдэгдэх/-д эрх зүйн туслалцаа хүссэн даалгаврын биелэлтийг ирүүлэх хугацааны талаар нэмж оруулах.

Ном зүй

1. Д.Мөнхтуяа. Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал. Уб., 2000
2. И.П.Блищенко, Р.А.Каламкарян, И.И.Карпец. Международное уголовное право. идр. М., Наука. 1995; Карпец И.И.Преступления международного характера.М., 1979
3. Международное уголовное право. М., 1995
4. В.П.Панов “Сотрудничество государств в борьбе с международными уголовными преступлениями”.-М.:1993
5. Б.Жаргалсайхан. Олон улсын эрх зүй. Уб., 2020
6. С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Гурав дахь хэвлэлт. Уб., 2011.
7. Б.Алтанбагана. Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг. Уб., 2014.
8. Международное право. /Под ред.Л.Н.Шестакова. М., Юридическая литература, 2005.
9. University Of Internal Affairs, Mongolia “Law Enforcement Theoretical And Methodological Quarterly Journal” 2019
10. Д.Тунгалаг. Эдийн засгийн аюулгүй байдлын тайлбар толь. Уб., 2005
11. <https://www.asser.nl/nexus/international-criminal-law/international-crimes-introduction/2021.09.29./20:32/>

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ: ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

*О.Хишигмөнх
ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,
хуульч, докторант*

Товч агуулга: Хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүнтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Хохирогч, аюулгүй байдал, хүүхэд хамгаалал, олон нийтийн оролцоо, хохирол.

Удиртгал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаарх долоо дахь¹⁰³ цувралыг эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр олон нийтэд хүргэж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хамгийн том хохирогч бол хүүхэд юм. Хүүхдийн өсөх, хөгжих, хамгаалуулах анхдагч орчин хэдий ч хүүхдийн эрхийг чимээгүй зөрчих байдал гэр бүлийн орчинд түгээмэл байна. Хүүхдийг гэр бүлд аюулгүй байдлыг нь хангах асуудал нэн чухал учраас төрөөс хүүхэд хамгааллын бодлогыг оновчтой тодорхойлох, урьдчилан сэргийлэх, эрхийг нь зөрчсөн этгээдэд хариуцлагын үр дүнтэй арга хэмжээ авах нь ач холбогдолтой. Хүүхэд өөрийгөө хүчирхийлэлд өртөж байна гэж ухамсарладаггүй, биеэ хамгаалах чадваргүй, насанд хүрсэн гэр бүлийн гишүүнээс хамааралтай байдаг нь хүчирхийлэлд өртөх шалтгаан болж хамгаалах үүрэг хүлээсэн субъектүүд нь хүүхдийн эрхийг зөрчиж буй үйлдэл нь энэ нийгэмд тулгамдсан асуудлын нэг болж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-д зааснаар “Хүчирхийллийн бүх хэлбэр болон хүчирхийллийн шалтгаантай нас баралтын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулах” хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах, тамлан зовоох зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох”¹⁰⁴, ...эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тухайлбал хүн худалдаалах, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөгийг таслан зогсоох”¹⁰⁵ тухай заасан. Монгол Улс нь гишүүн улсын хувьд тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг батлан хэрэгжүүлж байна. Хэрэгжилтийн хүрээнд хүний эрх ялангуяа хүүхдийн эрхийн асуудал чухал бөгөөд үр дүнтэй байх талаас нь бүх талууд хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг хуулийг шинэчлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөх субъектүүдийг өргөн хүрээнд тусгаж хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулж буй хэдий ч гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг төдийлөн буурахгүй байна. Ялангуяа хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй, хохирол арилгах асуудал хүүхдийн хувьд орхигдох хандлагатай байдаг. Иймд материаллаг болон процессын хуулийн уялдаа

¹⁰³ “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2020 оны №1 “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал” өгүүлэл, “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2020 оны №2 “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: практик хэрэгжилт, тулгамдсан асуудал” өгүүлэл, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүлийн 2020 оны №4 “Монгол Улс дахь албадан сургалтын эрх зүйн зохицуулалт” өгүүлэл, Отгонтэнгэр эрдэм шинжилгээний бичиг сэтгүүлийн 2020 оны №1 “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: хяналт, санхүүжилтын асуудал” өгүүлэл, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүлийн 2021 оны №2 “Ахмад настны эсрэг хүчирхийлэл нь гэр бүлийн хүчирхийллийн нэг төрөл болох нь” өгүүлэл, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, ОТИС-ийн Хууль зүйн сургууль хамтран зохион байгуулсан “Хууль зүйн хариуцлага” эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн “Тусгай хэрэгцээт иргэний эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх эрх зүйн хариуцлагын зарим асуудал” илтгэл.

¹⁰⁴ Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилт-2030 (2015) 16 дугаар зүйл 16.1, 16.2

¹⁰⁵ Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилт-2030 (2015) 5 дугаар зүйл 5.2

холбоо болон практикт хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг судлах, хохирогч хүүхдийг хамгаалах асуудал нь онолын төдийгүй практик ач холбогдолтой.

Хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, онолын үзэл баримтлал

Монгол Улсын хүн амын гуравны нэгийг хүүхэд эзэлдэг. “Хүүхэд” гэж Хүүхдийн эрхийн тухай конвенцид зааснаар 18 нас хүртэлх бүх хүнийг хэлнэ.¹⁰⁶

Монгол Улс нь Хүүхэд хамгааллын тухай хуулиараа “Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэлх, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэлх насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно¹⁰⁷ гэж заажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах, үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг”, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т “Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно” гэж тус тус заасан.

АНУ-ын Шинжлэх ухааны академи нь гэр бүлийн хүчирхийллийг “Гэр бүлийн хүрээнд байх хүүхэд, насанд хүрэгчдийг хамааруулан үзнэ. Бие махбодын болон сэтгэл санааны хувьд хүүхдэд хөнөөлтэй үйлдэл эсвэл бие махбодын хохирол бусдаас үзүүлэх боломжтой байдлыг хэлнэ”. Түүнчлэн, хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүүхдийн хэвийн өсөлт хөгжилд бие болон сэтгэл зүйн хувьд дэмжлэг үзүүлэхгүй байх, бэлгийн мөлжлөг, алахыг сүрдүүлэх зэрэг хамаарна¹⁰⁸ гэжээ.

Хүүхдийн эрхийн конвенцид “Хүчирхийлэл” гэдэгт “гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр хэмээн тодорхойлжээ. Үүнээс үзэхэд “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэдэг нь хүүхдийн жам ёсны болон хуулиар тогтоосон боломж, хэрэгцээг хязгаарлаж, өөрийгөө буюу бусдыг хүндэтгэдэг бие хүн болон төлөвших, хөгжихөд саад болсон сэтгэл зүйн, биеийн хүчний, бэлгийн харилцааны болон үг хэл, үл хайхарч шоовдорлогдох замаар сэтгэл санаа, бие махбодод гэмтэл учруулж болохуйц, эсвэл учруулсан аливаа үйлдэл, эс үйлдлийг ойлгож болохоор байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэм буруугийн хэлбэр нь ямагт санаатай үйлдэгддэг бөгөөд дараах хэлбэрээр илэрнэ. Үүнд:

- I. Бэлгийн
- II. Бие махбодын
- III. Сэтгэл санааны
- IV. Эдийн засгийн

-Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн харилцан хамааралтай этгээд хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг зөрчсөн, бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн, садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан эсхүл мэдсээр байж хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх зэргийг ойлгоно. Үүнийг хүүхдийн итгэж болох ойр дотнын танил, хайрлаж хүндэтгэдэг хүн үйлддэг нь түгээмэл бөгөөд хүүхдийн биеэ хамгаалах чадваргүй, итгэмтгий, цайлган байдлыг ашиглан бэлгийн харилцааны зорилгоор үйлдэгддэг гэмт хэрэг юм.

-Бие махбодын хүчирхийлэл гэдэг нь хүүхдийг гараар болон ямар нэгэн зүйлээр цохих, алгадах, өшиглөх, мушгих, сэгсчих, түлэх, хайрах, чимхэх, үснээс нь зулгаах, нүцгэн хөөж гаргах, хоолойг нь боох, шахах, хүлэх, ороолгох, савах, эрхтнийг нь гэмтээх, хугалах, машинаар дайрах, мөргүүлэх, татаж унагах, зэвсэг хэрэглэх гэрийн ажил хүчээр хийлгүүлэх, дэглэх, залхаах, хүүхдийг тав тухгүй буюу

¹⁰⁶ 1990 онд Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон.

¹⁰⁷ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 3 дугаар зүйл 3.3

¹⁰⁸ National Research Council, 1998, P.19

доромжилсон хэлбэр байдалд хүчээр байлгах, хүүхдээр биеийн хүчний хүнд дасгалуудыг албадан хийлгэх зэрэг үйлдэл, эс үйлдэхүй хамаардаг.

-Хүүхдийн эсрэг сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл нь хэн нэгэн этгээд хүүхдийг дээрх зорилгоор хүч хэрэглэх буюу хэрэглэхгүйгээр үг хэл, үйл хөдлөлөөрөө нөлөөлөх байдлаар сэтгэл санааны дарамтад оруулсныг эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.

-Хүүхдийг эсрэг эдийн засгийн хүчирхийлэл нь хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж, аюулгүй байдлыг нь хангах зэрэг суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл мэдсээр байж хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг ойлгоно. Энэ хүчирхийллийн хэлбэр нь байнга өлсгөлөн байлгах, хог түүх, хувийн ариун цэвэр тааруу байх, байнга бохир хувцаслах, бусдыг царайчилсан шинжтэй байх, хайр энэрлийг хүссэн байдалтай байх, цаг агаарт тохиромжгүй хувцаслах, бусдыг үзэн ядах шинжүүдээр түгээмэл илэрдэг.

Монгол Улсын хувьд хүчирхийллийн бие махбодын, бэлгийн, эдийн засгийн, сэтгэл санааны хэлбэрийг хуульд тодорхойлон заасан хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчилд үл хайхрах, гачигдуулах хүчирхийллийн хэлбэрийг хуульчилж өгсөн нь сайшаалтай байна. Гэвч сүүлийн 3 жилийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгааг харвал төдийлөн буурахгүй байгаа нь шалтгаан нөхцөлийг судлах, бууруулах, хамгийн их хүчирхийлэлд өртөгч хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах асуудал нэн чухал болохыг илтгэнэ. Монгол Улсад сүүлийн 3 жил гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил болон хүүхэд өртсөн байдлыг холбогдох албан ёсны эх сурвалжаас авч харьцуулан харьцуулбал:

Хүснэгт 1. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, хүүхэд өртсөн байдал

	2018	2019	2020
Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг	1070	8962	10306
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил	2821	985	1138
Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн	1136	1193	1152
Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо	93	90	141
Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ авсан хүүхэд	1369	2020	2898

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлангаас үзэхэд, гэр бүлийн хүчирхийлэлд 2018 онд 93, 2019 онд 90, 2020 онд 141 хүүхэд¹⁰⁹ өртсөн, цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн статистик тайланд гэр бүлийн хүчирхийлэлд автсан хохирогч 2018 онд 796, 2019 онд 894, 2020 онд 1082 болж өссөн нь хамгаалалт нэн шаардлагатай хүүхдэд онцгой анхаарал хандуулах, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг хөндөх хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг судлах практик хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

2018-2021 онд 12,461 хүн түр хамгаалах байраар үйлчлүүлсэн байна.¹¹⁰ Үүнээс 2021 онд улсын хэмжээнд ажиллаж байгаа 35 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр 4275 хүн үйлчлүүлсэн байна. Үүний 67,8 хувь буюу 2898 нь хүүхэд бөгөөд 70 хувь нь гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүчирхийлэлд өртөж хохирсон. 47 хувь нь хоёроос дээш удаа түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан¹¹¹ байна. Цагдаагийн байгууллагаас 2021 онд аюулын зэргийн үнэлгээг үндэслэж хамгаалах байранд 347 иргэнийг

¹⁰⁹ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны тайлан” 2018, 2019, 2020

¹¹⁰ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны статистик мэдээлэл, 2021 он

¹¹¹ Үндэсний статистикийн хороо. Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа, 2020 он

хүргэсэн¹¹² байна. Энэхүү судалгаанаас үзэхэд, илэрсэн зөрчлийн ихэнх гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрхийг зөрчиж удаа дараа түр хамгаалах байрны үйлчилгээ авч буй нь гэр бүлийн хүчирхийллийн суурь хүчин зүйлтэй буюу архидалт, ажилгүйдэлтэй тэмцэх шаардлагатай илтгэнэ.

Сэдвийн хүрээнд социологийн, сэтгэл судлалын, биологийн хандлагаар тайлбарласан онолын үзэл баримтлалаас сэдэвтэйгээ уялдуулан авч үзлээ. Харилцан хамаарлын онолоор хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг шалтгааныг “хүүхдүүд насанд хүрэгчдээс сул дорой, өөрийгөө тэжээн тэтгэх чадваргүй, тухайн орчноос зугтах боломжгүй байдаг” нь хүчирхийлэгчээс хараат байх нөхцөлийг бүрдүүлдэг¹¹³ гэж үздэг.

Нийтээс суралцах онолын үзэл баримтлалаар хүүхдүүд өсөх явцдаа өөрийн зан төлөвийн талаар бусдаас эргэх холбоо, хариу үйлдэл хүлээн авч үүнээсээ тэд өөрсдийн зан төлөвт дүн шинжилгээ хийх стандартыг боловсруулан эдгээр стандартад нийцсэн зан төлөвийн загварчлалаа хайж эхэлдэг. Хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн хүүхэд хүчирхийлэлд суралцан, энэхүү зан авирыг дуурайн цаашдын ирээдүйн харилцаандаа ийм зан төлөвийг давтдаг. Нэлээд хэдэн судалгаад хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөж байсан хүмүүс насанд хүрээд өөрийн хүүхдээ хүчирхийлэх эрсдэл илүү өндөр байдаг⁷ байна. Нийтээс суралцах онол нь хүчирхийлэл үеэс үед удам дамжин ирдэг болохыг тайлбарлахыг оролдсон бол объект харьцааны онолын хувьд хүмүүс бүр хүүхэд наснаасаа л бусадтай тодорхой харьцаанд байх хэрэгцээгээр сэдэлжсэн байдаг ба хувь хүмүүс нь өөрсөдтэйгөө болон бусад хувь хүмүүсийн оюун санааны төлөөлөл, нялх нярай болон хүүхэд наснаас эхлээд үүсдэг өөрсдийн хооронд болон бусадтай харилцах харилцаагаа хөгжүүлдэг. Эдгээр оюун санааны төлөөлөл нь үргэлжлэн нийт амьдралынх нь туршид бусадтай харилцах харилцаанд нь нөлөөлдөг гэж тус тус үзсэн нь хүүхдийн өсөж хүмүүжиж буй орчин, нөхцөл, харилцаа хандлага ямар чухал нөлөөтэй болохыг илтгэнэ.

Хүчирхийлэл бол гэмтэл мөн гэж үздэг онолын үзэл баримтлалаар хүчирхийллийн хохирогчид нь энэ үйлдлийг ямар нэгэн шархлуулах үйлдэл гэж үздэг тул хувь хүмүүсийн хариу үйлдэл нь гэмтлийн дараах стресст сэтгэцийн гажиг хэлбэртэй байдаг¹¹⁴. Хувь хохирогч нь энэхүү гэмтэл бэртлийн талаарх мэдээллийг ой санамждаа хэрхэн боловсруулдгийг ойлгох нь чухал. Учир нь энэхүү гэмтэл нь ирээдүйн мэдээллийг хэрхэн боловсруулах арга замд нь, ялангуяа үйлдлийг хэрхэн кодчилох, хадгалах, дараалуулахад нь нөлөөлдөг гэж үзсэн байна. Энэ онолын талаас авч үзвэл хувь хүний дотоод сэтгэлийн бүтцэд дотоод хамгаалалт нь хэрхэн нөлөөлдөг сэтгэл зүйн байдал нь нөлөөлдөг болохыг тайлбарлажээ.

Дээрх онолуудын үзэж буйгаар амьдралын эхний жилүүд нь хувь хүний хувьд цаашдын амьдралын сэтгэл хөдлөл, эрүүл мэндийг зохистой хөгжүүлэхэд маш чухал. Нялх үед нь болон хүүхэд насанд хэрэгцээ нь хангагдаагүй хүмүүс хожмын амьдралдаа эрүүл хэв маягтай байж, өөрийн сэтгэл санааны байдлаа хэвийн авч явах, сэтгэл зүйгээ удирдахад нь хүндрэл үүсэх эрсдэлтэй байдаг байна. Хүүхэд насанд байсан хариу туслалцаа үзүүлэхгүйгээр бусдаас хараат байх хэрэгцээ нь насанд хүрсэн хойно ч хэвээр байж, хэрэгцээ шаардлагыг нь хангасангүй гэх уурлан хилэгнэх мэдрэмжтэй хамт зэрэгцэн оршдог. Үүнээс болоод насанд хүрсэн ч бусдаас хараат байх хэрэгцээ шаардлагаа хангах эрэл хайгуул нь цөхөрч, эрэл хайгуул болсноор¹ тухайн хүнийг эсвэл хүчирхийлэгч эсвэл хохирогч болохуйц харилцаанд хүргэдэг байна. Судлаачдын үзэж буйгаар, нийгмийн сөрөг зан төлөв нь бага насан дахь гэр бүлийн сөрөг хандлага, туршлага, ялангуяа аюултай нийцлийн хэв маягуудтай холбоотой байж болно. Хэд хэдэн судалгаанд харуулснаар аюултай нийцэл нь бие махбодын хүчирхийлэл болон дарамтад байсан хүүхдүүдэд ихэнхдээ

¹¹² Цагдаагийн байгууллагын статистик мэдээ, 2021 он

¹¹³ Finkelhor D, Dzuiba-Leatherman J. Victimization of children. Am Psychologist. 1994;49:173-183

¹¹⁴ Putnam FW Diagnosis and Treatment of Multiple Personality Disorder. New York, NY: Guilford; 1989. Spiegel D. Multiple personality as a post-traumatic stress disorder. Psychiatry Clin North Am. 1984; 7:101-110

тохиолддог байна.¹¹⁵ Түүнээс гадна нийцлийн онол нь хүүхэдтэй харьцах зүй бус харьцаа болон хүчирхийлэл нэг үеэс дараагийн үед хэрхэн үе дамжин шилждэг талаар тайлбарлаж үр дагаврыг тодорхойлсон¹¹⁶ байна.

Хүчирхийлэл хүчирхийллийг төрүүлэх, дараагийн үедээ шилжих эрсэлтэй нь дээрх онолуудаас харагдаж буй нь өнөөгийн нийгэмд буй хүүхдийн эсрэг хүчирхийлэл дараагийн үедээ хүчирхийлэгч болох үндэс болох магадлал өндөр байгааг харуулж байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл нь энэ үеийн асуудал бус дараагийн үедээ шилжих эрсдэл байгааг анхаарч хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэл зүйг оношлох, сэтгэл зүйн талаас нь илүүтэй ажиллах нь үр дүнтэй байж болохыг онолын үзэл баримтлалуудаас харж болохоор байна.

Хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал

Монгол Улс нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Нийгмийн халамжийн тухай хууль, бодлогын баримт бичгүүд, дагалдах журмууд болон нэгдэн орсон олон улсын гэрээгээр зохицуулан хамгаалж байна. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, зөрчлийн хуулиар тус тус зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална¹¹⁷”, Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна¹¹⁸ гэж заасан. Энэ үүргийнхээ хүрээнд холбогдох хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрхийг зөрчих явдал буурахгүй байна. Хүүхдийн эрхийн конвенцод Монгол Улс нэгдэн орсноор хүн бүр, Засгийн газар, бүх салбарын бүх байгууллага хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах үүргийг хүлээсэн. Иймд тухайн үүргийг биелүүлэхэд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, бүх хэлбэрийн хуулийн этгээд, иргэний хамтын ажиллагаа, оролцоо чухал юм.

Хүүхдийн хөгжил, хамгааллын тухай үндэсний хөтөлбөр¹¹⁹-т нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт өртөхөөс хамгаална, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргаж дүн шинжилгээ хийх, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлд ойр байгаа, эсхүл эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлнэ, хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа байгууллагыг чадавхжуулах зэрэг ажлыг хийхээр тусгажээ.

Хүүхдийн эрхийг хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар болон холбогдох журмуудаар нарийвчлан зохицуулж гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүүхдэд үзүүлэх үйлчилгээг тодорхойлон зааж өгсөн.

115 Lyons-Ruth K, Connell D, Zoll D. Patterns of maternal behavior among infants at risk for abuse: relations with infant attachment behavior and infant development at 12 months of age. In: Cicchetti D, Carlson V, eds. Child Maltreatment, Theory and Research on the Causes and Consequences of Child Abuse and Neglect. New York, NY: Cambridge University Press; 1989. Main M, Goldwyn R. Predicting rejection of her infant from mother's representation of her own experience: implications for the abused-abuser intergenerational cycle. Int J Child Abuse Negl 1984; 8:203-217

116 Morton N, Brown KD. Theory and observation of attachment and its relationship to child maltreatment: a review. Child Abuse Negl. 1998;22 1093- 1105

117 Монгол Улсын Үндсэн хууль (1992) 16 дугаар зүйл 16.11

118 Монгол Улсын Үндсэн хууль (1992) 19 дүгээр зүйл 19.1

119 Монгол Улсын Засгийн газрын тогтоол (2017) №27

Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд нь дараах хамгаалуулах эрхтэй байхаар заасан.¹²⁰ Үүнд:

- Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.
- Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.
- Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй юм.

Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авах, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хариу үйлчилгээг үзүүлэх¹²¹-ээр заасан.

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг гэмт хэрэгт тооцсноос гадна Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дараах зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.8-д хүнийг алах гэмт хэргийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэхээр;
- Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйл, 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр, хөнгөн хохирол учруулсан бол хүндрүүлэхээр;
- Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйлд заасан хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэргийг эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр;
- Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан хүчиндэх гэмт хэргийг хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр;
- Мөн зүйлийн 12.2.3-т гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр тус тус заасан.

Эрүүгийн хуулийн 11.7 зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр хуульчилсан.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг гэр бүлийн хамаарал бүхий этгээд нь хүчирхийлэл үйлдэх, тодорхой эс үйлдэхүй хийх нь зөрчил болон гэмт хэрэг хэмээн үзэж, хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

Хүснэгт №2. 2002 оны болон 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулалт

¹²⁰ Хүүхдийн эрхийн тухай хууль (2016) 7 дугаар зүйл

¹²¹ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 10 дугаар зүйл 10.1

Эрүүгийн хууль 2015	Эрүүгийн хууль 2002
11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга: 1.1. зодсон; 1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; 2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; 2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	120¹ дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 120¹ Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 120¹ 2. Энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн, эсхүл асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн, эсхүл гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хүндрүүлэх нөхцөлд хамаарах эсэх	
Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн¹²²	Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, бага насны хүүхэд, өндөр настан, биеэ хамгаалж чадахгүй хүн, түүнчлэн эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн¹²³

Харин 2002 оны Эрүүгийн хуульд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, бага насны хүүхэд, өндөр настан, биеэ хамгаалж чадахгүй хүн, түүнчлэн, эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол ял хүндрүүлэх нөхцөл байдал¹²⁴ гэж тооцохоор, өндөр настан, бага насны, өвчний болон бусад шалтгааны улмаас биеэ хамгаалж чадахгүй хүнийг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь туслах бололцоотой бөгөөд халамжлах үүрэгтэй этгээд тусламж үзүүлээгүй зориуд орхисон, эсхүл түүнийг амь биед нь аюултай байдалд зориуд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр¹²⁵ хуульчилсан байсан.

2015 оны Эрүүгийн хуулийн хувьд байнга¹²⁶ гэсэн шинжийг хангасан байж гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай байгаа нь цаг хугацааны хувьд давтамж хэдий хугацаанд үйлдэгдсэн байх тодорхой зохицуулалт байхгүйгээс хэрэглэхэд хүндрэл учирч байна. Мөн харгис, хэрцгий догшин авирласан үйлдэлд ч байнга гэсэн шинжийг хангасан байх нь зохистой эсэхийг эргэн харах шаардлагатай байна. Эрүүгийн хуульд хүчирхийллийн хэлбэр тус бүр уг хуулийн агуулгад тусгалаа олсон хэдий ч хууль хэрэглээнд бие махбодын хэлбэрт хариуцлага хүлээлгэх бусад хэлбэрийн хувьд нотлох баримт байхгүй, гэмт хэрэг үйлдсэн гэж тогтоогдохгүй байна гэх үндэслэлээр хэрэг үүсгэдэггүй нь хуулийг хэрэгжүүлэхэд нэг мөр ойлголтыг бий болгох,

¹²² Эрүүгийн хууль (2015) 6 дугаар зүй 6.6.1.6

¹²³ Эрүүгийн хууль (2002) 56.1.6

¹²⁴ Эрүүгийн хууль (2002) 56 дугаар зүйл 56.1.6

¹²⁵ Эрүүгийн хууль (2002) 107 дугаар зүйл 107.2

¹²⁶ Улсын Дээд Шүүхийн 2019.10.16-ны өдрийн 506 дугаар тогтоол "Байнга гэдэг нь тоон илэрхийллийн хувьд гурав болон түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг авч үздэг хууль хэрэглээний ойлголт юм".

материаллаг хохирол шаарддаг, заавал гомдол гаргаснаар хүүхдийг хохирогчоор тогтоох, хохирлыг барагдуулах асуудал байгаа нь хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байх, хүүхдийн эрх зөрчигдсөөр байх шалтгааны нэгээхэн хэсэг болж байна.

2002 оны Эрүүгийн хуульд хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт гэсэн бүлгээр гэр бүлийн хүчирхийлэл болон насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, хүүхэд хаях, төөрүүлэх, асран хамгаалах үүргээ урвуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх¹²⁷ зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор зохицуулж байсан.

Одоогийн үйлчилж буй Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг¹²⁸ тусдаа бүлэг болгон хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах, хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхэд солих, хүүхэд худалдах, хүүхэдтэй хэрцгий харьцах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэхтэй холбогдсон үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Өмнөх хуультай харьцуулахад хүүхэдтэй хэрцгийн харьцах үйлдэл нэмэгдсэн бол өмнөх хуульд байсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх үйлдлийг Эрүүгийн хуулиас хасаж, Зөрчлийн тухай хуулиар¹²⁹ зохицуулсан.

Хүснэгт №3. Зөрчлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн харьцуулалт

Зөрчлийн тухай хууль 2017	Захиргааны хариуцлагын тухай хууль 1993
Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна. ¹³⁰	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, мөрдөн мөшгөсөн, заналхийлсэн, бусадтай харилцахыг хязгаарласан, гутаан доромжилсон, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулж, албадан сургалтад хамруулна. ¹³¹

Монгол Улсад 2016 оноос Захиргааны хариуцлагын тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд шийтгэл оногдуулж эхэлсэн¹³² бөгөөд 2017 онд Зөрчлийн тухай хууль батлагдснаар зөрчлийн шинж, шийтгэлийн төрөл, хэмжээнд өөрчлөлт ороогүй. Ихэнх гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэлд Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулж байна. Энэ нь гэмт хэрэгт тооцогдохын тулд байнга гэсэн шинжийг хангасан байх, 3 ба түүнээс дээш давтамжтай үйлдэл нь ямар хугацаанд үргэлжилсэн байх асуудал тодорхой бус нэг мөр болоогүйгээс практикт хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Хууль тогтоогчийн зүгээс хүчирхийллийн бэлгийн хэлбэрээс бусад бие махбодын, сэтгэл, санааны эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрт үйлдлийн шинжээс нь хамааруулан Зөрчлийн тухай хуулиар хариуцлага

¹²⁷ Эрүүгийн хууль (2002) 114-122 дугаар зүйл

¹²⁸ Эрүүгийн хууль (2015) 16.1-16.11 дүгээр зүйл

¹²⁹ Зөрчлийн хууль (2017) 6.20.1.4

¹³⁰ Зөрчлийн хууль (2017) 5.4.4

¹³¹ Захиргааны хариуцлагын тухай хууль (1992) 22¹ зүйлийн 22¹.1

¹³² Захиргааны хариуцлагын тухай хуульд 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр нэмсэн

хүлээлгэхээр зохицуулсан нь харагдаж байна.

Мөн Зөрчлийн тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд хариуцлага хүлээлгэхээс гадна хүүхдийн эрхийг зөрчих¹³³тэй холбогдож хариуцлага хүлээлгэхээр заасан дараах зохицуулалттай. Үүнд:

1. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан, хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн, хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй, хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хүн, хуулийн этгээд нь хүүхдэд утаат тамхи татахыг санал болгосон, бэлэглэсэн, эсхүл утаат тамхи олж авах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлсэн, хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, өв залгамжлах, эсхүл ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарласан, хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Хүүхдийг аливаа төлбөр, хураамжийг төлөөгүй үндэслэлээр хүүхдийн сурч боловсрох эрхийг хууль бусаар хязгаарласан, өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дууны, дүрсний дуу-дүрсний бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор хууль бусаар хүүхдийн нэрийг барьж, ашиг олох, эсхүл амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд нь харшлах, аюул учруулах тоглоом, наадам, бусад арга хэмжээнд оролцуулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Сургууль, сургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, асрамж, халамжийн төв, хүүхэд хамгааллын төв болон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн эрх зөрчигдсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
7. Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидаг согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдэгдэх, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹³³ Зөрчлийн хууль (2017) 6 дугаар зүйл 6.20

Дээрх хүүхдийн эрхийн зөрчилд хүүхдийг гачигдуулах, үл хайхарсан, хүүхдэд харш, хүсэл зоригийг хязгаарласан шинжтэй үйлдлүүдийг тодорхой нэрлэн заан хариуцлага хүлээлгэхээр байгаа нь бусад хамгаалалт шаардлагатай субъектүүдтэй /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн/ харьцуулахад илүү тодорхой, нарийвчилсан зохицуулалтыг хийсэн давуу талтай байна.

Мөн хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байх тохиолдолд тухайлсан хуулийн зохицуулалт болоод холбогдох зохицуулалтыг нарийвчлан үзэх шаардлагатай. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.5.2-т гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх, мөн хуулийн 45.1-т энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ гэж заасан боловч зөрчлийн хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухайлсан зохицуулалт байхгүй.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.8-т “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг, мөн хуулийн 24.1-т Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно заасан бөгөөд зарим зохицуулалт нь хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт, зарим нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хамаарахаар зохицуулжээ. Энэ нь субъектийн хувьд гэр бүлийн хамааралтай болон хамааралгүй субъектээс хүчирхийлэл үйлдэх гэсэн агуулга бүхий боловч зарим зохицуулалт нь тодорхой бус, зарим нь давхцалыг бий болгохоор байна. Дээрхээс дүгнэхэд материаллаг хуулиудын уялдаа холбоог хангахад анхаарах нь хэрэг маргааныг шийдвэрлэх, тухайн эрх зүйн харилцаанд оролцогчид хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хууль хэрэглээний алдаа гарах эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой юм.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэлд үүрэг хүлээлгэх албадлагын шинжтэй хариуцлагыг хүлээлгэхдээ үр дүнтэй, нөлөөлөх байдалд анхаарах шаардлагатай байна. Ялангуяа гэр бүлийн хүрээнд гэр болон орон сууцанд үйлдэгдсэн, ихэнх нь согтуугаар үйлдэгдэг¹³⁴ байдлаас үзвэл хүчирхийлэл үйлдсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх болон мансуурах, согтуурах ундаа хэрэглэхийг хориглох албадлагын арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Хариуцлагын талаасаа үйлдсэн этгээдийн үйлдлийн шинж гэм буруу, нийгмийн аюулын хор уршигт тохирсон байдал, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалсан байх зэрэг асуудалд анхаарч эрүүгийн хууль болон зөрчлийн хууль зохих нэмэлт өөрчлөлтүүдийг хууль тогтоогчийн хийх шаардлага байна.

Одоогийн байгаа хариуцлагын зохицуулалтын хувьд тодорхой болгох, ялгамжтай болгох, үйлдлийн шинж, аюулын хэр хэмжээнээс нь хамаарч зохих шийтгэлийг хүлээлгэх, хүчирхийллийн бүх хэлбэрийг орхигдуулалгүй хамруулах зохицуулах, шударга хариуцлагын асуудал дутагдалтай байгаа хэдий ч байгаа зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх асуудалд анхаарах, ялангуяа дахин давтан гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс сэргийлэх зорилгоор ялангуяа үүрэг хүлээлгэх, албадлагын арга хэмжээг үр дүнтэй болгоход анхаарах хэрэгтэй юм. Хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд гэмт, хэрэг зөрчлийг илрүүлэх, хариуцлага хүлээлгэхэд анхаарч хохирогчийг хохирлыг сэргээх асуудалд хангалтгүй байгаа нь гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг арилгах асуудал ялангуяа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд орхигдох хандлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн биед гэмтэл учирсан нь шүүх

¹³⁴ Үндэсний статистикийн хороо, Цагдаагийн ерөнхий газрын “Гэр бүлийн хүчирхийлэл” статистикийн тойм 2020 х.9 Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 91.8 хувь зөрчлийн 94.2 хувь ахуйн хүрээний архидалтын хүрээнд гарсан нь тогтоогджээ.

эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэн байсан ч Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл (Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4 дүгээр зүйл (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 11.6 дугаар зүйл (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах) гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд хамааруулан зүйлчилж, шийдвэрлэдэг практик байна.

Гэмтэл учруулахгүйгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хоригдох бол гэмтэл учруулж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх хөнгөн шийтгэл ногдуулахаар заасан нь хөнгөнөөс хүндрүүлэх зарчим алдагдаж ял завших боломжийг хууль тогтоогчийн зүгээс олгосон гэж үзэхээр байгаа тул эргэн харах нь зүйтэй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийн ихэнх нь Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдэж хүчирхийлэл үйлдсэн этгээдэд баривчлах, албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээ авч байна.

Баривчлах хугацаанд хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж маргааныг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, уур бухимдал, сэтгэл зүйгээ удирдах зэрэг зөв амьдралын дадал хэвшлийг суулгахад анхаарч сургалтыг зохион байгуулж байгаа хэдий ч хүчирхийлэл үйлдэгч үйлдлээ давтах, засарч сайжрахгүй байгаа нь цөөнгүй байна. Тиймээс Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх хариуцлагын нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарах, тэр дундаа хууль зүйн болон сэтгэл зүйн шинжлэх ухааныг хослуулан хөгжүүлэх хэрэгцээ, шаадлага гэр бүлийн харилцааны хүрээнд тулгарч байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхэд хохирлоо нэхэмжлэх, зөрчигдсөн эрхээ сэргээх асуудал нь хүүхэд бие даан холбогдох байгууллагад хандах эрх зүйн бүрэн чадамжгүй байх, эцэг, эх, гэр бүлийн харилцан хамааралтай хүн гэх талаас нь харж хохирлоо барагдуулахгүй байх, төлөөлөх эрх бүхий этгээд нь хуулийн дагуу хамгаалах хүчин чармайлтыг төдийлөн гаргадаггүйгээс хүүхэд бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн аль ч хэлбэрт өртсөн насаараа хохирогч байх, сэтгэлзүйн гэмтэл авах, айдас түгшүүртэй амьдрах шалтгааны нэг хэсэг болж байгаа нь харамсалтай байна. Тухайлбал, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо¹³⁵-ны үйлчилгээг 2019-2020 онд авах шаардлагатай үйлчлүүлэгчийн 68-71 хувийг хохирогч, гэрч-хохирогч эзэлж байна, хохирогч хүүхдэд хууль зүйн тусламж үзүүлэх албан тушаалтнууд хангалтгүй ажиллаж байна¹³⁶ гэж тайланд дурдсан байгаа нь хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ хангалтгүй, хохирлоо барагдуулах асуудал орхигдож байгааг нь Үндсэн хуульд заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна, гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална, Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” гэсэн зохицуулалт бодит байдалд биеллээ олохгүй байгааг илтгэнэ.

Гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол Улсын эдийн засагт ихээхэн хохирол, сөрөг үр дагавар учруулдаг, хүчирхийллээс үүдэлтэй нийт өртөг 601.2 тэрбум төгрөг¹³⁷ байна гэсэн нь зөвхөн үнэлэгдэн тогтоогдсон тоон судалгаа юм. Үүний цаана хохирол нэхэмжлээгүй, хохирол нь тодорхойлогдоогүй маш их хохирол байгаа гэдгийн мартаж

¹³⁵ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 4 дүгээр зүйл 4.3.1 гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг хэлнэ.

¹³⁶ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа, үнэлгээний тайлан 2021

¹³⁷ Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг, зардлын тооцоо, МУ-ын Засгийн газар, НҮБХАС, ШХА, 2020 он

үл болно.

“Аливаа улс орон гагцхүү бүх хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд ойртож очсоноор хөгжлийн салбарт болон энхийг тогтоох үйлсэд зорилгоо биелүүлэхэд ойртоно” гэж Кофи.А.Аннан¹³⁸ онцолсон нь хүүхдийн эрхийг хамгаалахад улс онцгой анхаарах, хамгаалах оновчтой тогтолцоог бий болгох нь тухайн улсыг хөгжлийг илтгэх нэг хүчин зүйл гэж ойлгож болох юм.

Гадаадын зарим улсын зохицуулалтаас үзэхэд Албани Улсын Гэр бүлийн харилцаан дахь хүчирхийллийн эсрэг авах хариуцлагын тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэр бүлийн гишүүд, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн хуулийн арга хэрэгслээр дамжуулан хамгаалалтыг баталгаажуулах явдал” хэмээн хуулийн зорилгоо тодорхойлсон байна. Уг хуулийн 1 дүгээр зүйлд хүчирхийлэл (Violence) гэдэг нь нэг нь нөгөө хүнийхээ эсрэг бие махбод (physical), ёс суртахууны (moral), сэтгэл зүйн (psychological), бэлгийн (sexual), нийгэм, эдийн засгийн (social and economic) бүрэн бүтэн байдлыг зөрчих ямар нэгэн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Мөн хуулийн 2 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай эсхүл урьд нь тийм харилцаатай байсан хүмүүсийн хооронд 1 дүгээр зүйлд заасан хэлбэр, аль нэг үйлдлийн аргаар үйлдсэн аливаа хүчирхийллийг хэлнэ¹³⁹ гэж заажээ.

Серби Улсын Эрүүгийн хуульд гэр бүл, гэр бүлийн холбоотой гэмт хэрэг гэсэн¹⁴⁰ 193 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Насанд хүрээгүй хүүхдийг үл хайрах, гачигдуулах буюу насанд хүрээгүй хүнийг асран хүмүүжүүлэх үүргээ зохих ёсоор гүйцэтгэхгүй, гэр бүл, асран хамгаалагч, бусад асран хүмүүжүүлэх үүрэгтэй хүмүүс насанд хүрээгүй хүүхдээ гачигдуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Мөн хуулийн 193 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эцэг эх, үрчилж авагч, асран хамгаалагч эсвэл насанд хүрээгүй хүүхдийг үл хайхарсан эсвэл түүнийг насандаа тохирохгүй хэт их хөдөлмөр хийлгэсэн, эсхүл түүнийг хөгжүүлэхэд нь сөргөөр нөлөөлөх бусад үйл ажиллагаа эрхлэхийг өдөөсөн эцэг, эх, үрчлэгч, асран хамгаалагч, бусад этгээдэд гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Тус улсын Эрүүгийн хуулийн 194 дүгээр зүйлд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан. Тухайлбал, “Хүчирхийлэл, амь нас, бие махбодын эсрэг заналхийлэх, үл хайхрах, харгис хэрцгий зан үйл хийх замаар гэр бүлийн гишүүний тайван байдал, бие махбодын бүрэн бүтэн байдал, сэтгэцийн байдалд аюул учруулсан бол гурван сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Серби Улсын Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь “Гэр бүл, гэр бүлийн холбоотой гэмт хэрэг” гэсэн бүлэгт хамаардаг бөгөөд бусад төстэй гэмт хэргийг бүлэглэн авч үзсэн байдаг. Ялангуяа үл хайхрах, гачигдуулах хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг болон хүүхдийг үл хайрах, гачигдуулах, тэжээн тэтгэх үүргээ гүйцэтгэхгүй байх, гэр бүлийн үүргээ гүйцэтгэхгүй байх зэрэг хэдэн гэмт хэргийг ялгамжтайгаар хуульчилсан.

Бүгд Найрамдах Турк Улсын Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй боловч зарим төрлийн гэмт хэргийн шинжид дараах байдлаар хуульчилжээ. Эрүүгийн хуулийн 82.1/д дугаар зүйлд “Хүнийг санаатай алах”, 86.3/а дугаар зүйлд “Санаатай гэмтэл учруулах гэмт хэрэг”-т гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх замаар дээрх гэмт хэргүүдийг төгсгөсөн тохиолдолд оногдуулах ялыг хүндрүүлэх байдлаар хуульчилсан. Тухайлбал,

¹³⁸ Гана Улсын дипломатч бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар 1997-2006 онд ажилласан, Нобелийн энх тайваны шагналт юм.

¹³⁹ ON MEASURES AGAINST VIOLENCE IN FAMILY RELATIONS No. 9669 of 18.12.2006 <https://www.osce.org/files/f/documents/4/6/30436.pdf>

¹⁴⁰ Serbia: Criminal Code, 2005, available at: <https://www.refworld.org/docid/48ff404a2.html> [accessed 16 July 2021]

- 82.1/д дугаар зүйлд “Хүнийг санаатай алах гэмт хэргийг дээд ураг, доод ураг эсхүл эхнэр, нөхөр, ах дүүгийн эсрэг хийсэн бол хүндрүүлсэн тусгай зэрэглэлийн хорих ангид бүх насаар нь хорих ял шийтгэнэ.”
- 86.3/а дугаар зүйлд “Санаатай гэмтэл учруулах гэмт хэргийг дээд ураг, доод ураг эсхүл эхнэр, нөхөр, ах дүүгийн эсрэг үйлдсэн бол 2-4 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.” БНТУ-ын Эрүүгийн хуулийн зохицуулалтын хувьд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай субъектүүдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан нь Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай төстэй бөгөөд хүнийг санаатай алах гэмт хэрэгт дээрх хүндрүүлэх нөхцөл байгаа бол бүх насаар нь хорихоор хуульчилжээ.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Гэр бүлийн хүчирхийллийн шийтгэлийн тухай¹⁴¹ хуулиар гэр бүлийн хүчирхийллийг тодорхойлж, хариуцлага хүлээлгэх асуудлыг Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйл төрөл, садангийн хүнд гэмтэл учруулсан этгээдийг долоон жилээс дээшгүй хугацаагаар хорих, арван жилээс дээшгүй хугацаагаар мэргэшүүлэх эрхийг түдгэлзүүлэх, арван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Уг гэмт хэргийг эхнэр, нөхрийнхөө удам угсаа залгамжлагчдын эсрэг үйлдсэн этгээдийг арван жилээс илүүгүй хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл арван таван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна.

Эрүүгийн хуулийн 260 зүйлд зодох, байнга зодож хүний биед халдсан этгээдэд хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ял, таван сая воноос хэтрэхгүй торгууль, цагдан хорих, насанд хүрээгүй хүүхдийг шийтгэнэ. Эхнэр, нөхрийнхөө удам угсааны эсрэг уг гэмт хэргийг үйлдсэн этгээдийг таван жилээс илүүгүй хугацаагаар хорих эсвэл долоон сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Мөн хуулийн 261 дүгээр зүйл дээрх хэсэгт заасан гэмт хэргийг хэрцгийгээр зодох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг таван жилээс илүүгүй хугацаагаар хорих, арван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Уг хэргийг давтан үйлдсэн бол гэмт хэрэгт оноосон ялыг $\frac{1}{2}$ хүртэл хүндрүүлнэ.¹⁴²

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлэг айлган сүрдүүлэх гэмт хэрэг, 283 дугаар зүйлийн 283.2-т эхнэр, нөхрийнхөө удам угсаа залгамжлагчийн эсрэг айлган сүрдүүлэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг таван жилээс илүүгүй хугацаагаар хорих эсхүл долоон сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна гэж заасан.

БНСУ-ын хувьд гэр бүлийн хамаарал бүхий этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт ногдуулах хариуцлага нь хорих ялын хувьд ч торгууль нь өндөр байна.

Дүгнэлт

Хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хүчирхийллийн хэлбэр тус бүрээр хариуцлага хүлээлгэх агуулгатай зохицуулалт байгаа хэдий ч практикт бие махбодын хүчирхийллийн хэлбэрт хариуцлага хүлээлгэж бусад хэлбэрт хариуцлага хүлээлгэх байдал төдийлөн хангалтгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд заасан эрхээ эдэлж зохих ёсоор хамгаалуулж чадахгүй байгаа нь бидний гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг арилгах асуудлыг орхигдуулж, зөвхөн үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх байдлаар асуудлыг шийдвэрлэж ирсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Хохирогч хүүхэд үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, шаардлагатай санхүүжилт олгох, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, уялдуулах нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хохирлыг барагдуулах ажлыг эрчимжүүлэхэд ач холбогдолтой.

Хүүхэд бие даан эрхээ хамгаалах, хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө илэрхийлэх боломж хязгаарлагдмал байдгаас эрх зөрчигдөх, зөрчил, гэмт хэргийн

¹⁴¹ Бүгд найрамдах Солонгос улсын гэр бүлийн хүчирхийллийн шийтгэлийн тухай хууль 2015 оны 07 сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

¹⁴² Бүгд найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль 1953 онд батлагдсан. Үүнээс хойш 22 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

хохирогч болсоор байна. Бодит байдалд эцэг, эх нь уламжлалт хандлага, үл хайхрах байдлаар хүүхдийнхээ эрхийг зөрчих, хязгаарлах асуудал цөөнгүй байгаа нь гэр бүл төлөлт, гэр бүл, хүүхдийн талаарх төрийн бодлого хэлбэрийн төдий халамжийн хэдхэн төгрөгөөр аргацаах байдлаар явж ирсэнтэй холбоотой. Тиймээс төрөөс гэр бүлийн талаарх баримталж буй бодлогоо оновчтой тодорхойлох, хэрэгжилтэд анхаарах, хяналт тавих хэрэгцээ, шаардлага байна.

Ихэнх гэр бүлийн хүчирхийлэл нь Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдэж буй тул гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд чиглэсэн зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн албадан сургалтыг үр дүнтэй явуулах, хохирогч субъектийн онцлог, үйлдлийн давтамжаас нь хамаарч ялгамжтай хөтөлбөрөөр сургалтыг явуулах шаардлагатай байна. Тухайлбал, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хүүхэдтэй хэрхэн харьцах, ойлгох, хүүхдийн сэтгэл зүй болон нөлөөлөх хор уршиг үр дагаврыг таниулж ойлгуулах нь чухал нөлөөтэйг анхаарах хэрэгтэй байна.

Эрүүгийн хуулиар хүүхдийн эсрэг гэр бүлийн хамаарал бүхий этгээд байнга харгис, хэрцгий догшин авирласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх эсэх, субъектын хувьд хүүхэд хохирогч байх тохиолдолд тухайн үйлдлийн давтамжийг давахгүй амь эрсдэх нөхцөл байдал тулгарах эрсдэл байгааг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай байна.

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016
- Эрүүгийн хууль. 2015
- Зөрчлийн тухай хууль. 2017
- Захиргааны хариуцлагын тухай хууль. 1992
- Улсын Дээд Шүүхийн 2019.10.16-ны өдрийн 506 дугаар тогтоол
- Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1989
- Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилт-2030
- Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны тайлан” 2018, 2019, 2020
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа, үнэлгээний тайлан 2021
- Үндэсний статистикийн хороо, Цагдаагийн ерөнхий газрын “Гэр бүлийн хүчирхийлэл” статистикийн тойм-2020
- Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн статистик 2018,2019,2020, 2021
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны статистик мэдээлэл, 2021 он
- Үндэсний статистикийн хороо. Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа, 2020 он
- National Research Council, 1998, P.19
- Серб улсын эрүүгийн хууль 2005
- Бүгд Найрамдах Солонгос Улсын гэр бүлийн хүчирхийллийн шийтгэлийн тухай хууль 2015
- Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль 1953 он
- <http://www.fcy.gov.mn/news/178>
- <https://police.gov.mn/a/5512>
- <https://www.osce.org/files/f/documents/4/6/30436.pdf>

**БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ
УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ,
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Б.Батбаяр

Хууль зүйн магистр, цагдаагийн дэслэгч

Товч агуулга. Бэлгийн эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ялангуяа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдалд харьцуулсан судалгаа хийж, санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Бага насны хүүхэд, хүчиндэх гэмт хэрэг, Эрүүгийн хууль, эрүүгийн хууль тогтоомж, харьцуулалт.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс хүүхдийг хамгаалах, эрүүгийн эрх зүйн зохицуулалтын талаар гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжийг харьцуулан судлах нь тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хууль зүйн хариуцлага хүлээлгэх, үндэсний хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгоход ач холбогдолтой. Судлаачийн зүгээс Орос, Казакстан, Герман, Франц, Дани зэрэг улсын Эрүүгийн хуульд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг хуульчилсан байдлыг харьцуулан судалж онцлог, ялгаатай талыг нээн харуулахыг зорьсон болно.

1.Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлд Хүчиндэх гэмт хэргийг насанд хүрээгүй буюу 15-18 насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх, хэрэв 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн, урьд нь насанд хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн этгээд бол тус тус онц хүндрүүлэхээр заасан. Тухайлбал,

- Хүчиндэх, өөрөөр хэлбэл хохирогч болон бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан хурьцал үйлдсэн бол 3-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Хүчиндэх үйлдлийг:
 - а.Зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн;
 - б. Алахаар буюу эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулахаар заналхийлж, мөн хохирогч буюу бусад этгээдтэй онц хэрцгийгээр харьцаж үйлдсэн;
 - в.Хохирогчид бэлгийн замын өвчин халдаасан бол эрх чөлөөг 2 жил хүртэл хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 4-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Хүчиндэх гэмт хэргийг:
 - а.Насанд хүрээгүй хүүхдийг;
 - б.Хохирогчийн бие махбодид болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан, бэлгийн замын халдварт өвчин халдаах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлаж, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-10 жил хүртэл хорих ял шийтгэнэ¹⁴³ гэж заасан.

ОХУ-ын Эрүүгийн хуульд 16 нас хүрээгүй этгээдтэй хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэлд хийх гэмт хэргийн үйлдлийг анх удаа үйлдсэн этгээд хохирогчтой гэр бүл болсон бол нийгмийн хор аюул арилсан гэж үзвэл шүүх ял шийтгэхээс чөлөөлж болно гэж хуульчилсан нь бусад улсын хуулиас шинэлэг талтай байна.

Тус 2 улсын Эрүүгийн хуульд харьцуулалт хийхэд хүүхдийн эсрэг гэмт хэргийн шинжийг заасан, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг

¹⁴³ (в ред. Федерального закона от 27.12.2009 N 377-ФЗ),

тодорхойлсон байдал зэрэг зохицуулалтын арга, хууль зүйн техникийн арга хэрэгсэл, ашигласан байдал нь агуулга, үзэл санааны хувьд адил болохыг харуулж байна.

Ялын санкцын тухайд хоёр улсын Эрүүгийн хуульд зөвхөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн /12.1.4/, /131.36/ ялыг харьцуулж үзвэл манай улсын ялын бодлого чанга байгаа нь дэвшилтэд алхам болж өгсөн.

2.Бүгд Найрамдах Казакстан Улсын Эрүүгийн хуулийн 120 дугаар зүйлд хүчиндэх, өөрөөр хэлбэл хохирогч буюу бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн тусламж авах чадваргүй байдлыг ашиглан хурьцал үйлдсэн бол 3-5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

121.3.а.насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн;

б.хохирогчийн бие махбодид болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан, бэлгийн замын халдварт өвчин халдаах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлах, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-15 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

Мөн хуулийн 124 дүгээр зүйл бага насны хүүхдийг садарлах асуудлыг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

1.Бага насны хүүхдийг санаатайгаар хүч хэрэглэхгүйгээр садарласан бол 7-10 жил тодорхой албан тушаал үйл ажиллагаа эрхлэхийг хориглож 5-10 хорих ял шийтгэнэ.

2.Энэхүү үйлдлийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгч эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал үйл ажиллагаа эрхлэх эрхийг бүх насаар нь хасаж, 7-10 жил хорих ял шийтгэнэ гэж тус тус заасан байна.¹⁴⁴

Казакстан Улсын Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн субъект нь зөвхөн эрэгтэй хүн, Монгол Улсад хүчиндэх болон бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийн гэмт хэргийн субъект нь эрэгтэй, эмэгтэй аль нь ч байхаар хуульчилж өгсөн нь шинэлэг байна.

Гэмт хэргийн субъектын хувьд Монгол Улс болон Казакстан улс нь эрүүгийн хариуцлага хүлээх чадварыг 14 наснаас эхлэн тооцсон нь нийтлэг тал болж байна.

Казакстан Улсын Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн зүйлчлэлийг системчилэн хуульчилсан нь хууль хэрэгжүүлэгчид илүү ойлгомжтой хэрэгжүүлэхэд хялбар болсон байна. Харин манай улсын тухайд бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг багцлан хүчиндэх гэмт хэрэгт тооцсон нь хуулийг хэрэгжүүлэхэд сөрөг талтай. Энэ төрлийн гэмт хэргийн /12.1.4/ хуулийн бодлогод зохих өөрчлөлт хийх, боловсронгуй болгох шаардлагатай болохыг харуулж байна.

3. ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох (176), ноцтой байдлаар бэлгийн харьцаанд орох (176а), Хүүхдийг үхэлд хүргэх бэлгийн аюултай үйлдэл (176б), Бага насны хүүхэдтэй бэлгийн үйлдэлд хамтрах (180) зэргийг бие даасан зүйл болгон хуульчилсан төдийгүй харгалзан дэмжиж, асран хамгаалж байгаа этгээдийн эсрэг үйлдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг бие даасан гэмт хэрэгт тооцож зүйлчилсэн байна. Мөн хуулийн (174) зүйлд зааснаар асран хамгаалуулсан буюу (хүмүүжүүлэх, боловсрол олгуулахаар) итгэн хариуцуулсан арван зургаан нас хүрээгүй этгээдийн эсрэг, эсхүл өөрийн цусан төрлийн (төрсөн) буюу үрчилж авсан 18 нас хүрээгүй хүүхэд буюу асран хамгаалуулагчтай хурьцал үйлдсэн, тийм үйлдлийг өөртэй нь хийхийг зөвшөөрсөн бол ял шийтгэхээр хуульчилсан байна.

ХБНГУ 2016 онд Эрүүгийн хуулийн 184 дүгээр зүйлд: “Бэлгийн албадлага”, “садар самуун үйлдэл” зэрэг нэр томъёоны зэрэгцээ “бэлгийн дарамт” гэсэн ойлголт, нэр томъёог шинээр бий болгосон. Мөн 176 дугаар зүйл хүүхэдтэй бэлгийн үйлдэл хийх, хэн нэгэн 14 нас хүрээгүй этгээдтэй бэлгийн үйлдэл хийсэн буюу түүнд өөртэйгөө хийх боломж бүрдүүлсэн бол 6 сараас 10 жил хүртэлх хугацаагаар,

¹⁴⁴ Казакстан улсын эрүүгийн хуулийн 120 дугаар зүйл, 2007 он

харгалзан /хөнгөрүүлэх/ үзэх тохиолдолд 5 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ гэж заажээ.¹⁴⁵

ХБНГУ нь эрх зүйн сонгодог тогтолцоотой улсын хувьд бэлгийн дарамт учруулахыг шинээр хуульчилж байхад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан бэлгийн дарамт учруулах буюу хохирогчид ажил, албан тушаал, нэр төр, эд хөрөнгө, сэтгэл санааны бусад байдлаар хохирол учруулах үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэж бэлгийн харьцаанд орох сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсвэл бэлгийн харьцаанд орохыг шаардсан үйлдлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон. Ялангуяа энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасныг гэмт хэргээс хассан нь эмгэнэлтэй. Үүнийг дахин хуульчлах шаардлагатай гэж судлаач миний хувьд үзэж байна. Мөн Эрүүгийн хуульд нь оногдуулах хорих ялыг тодорхойлохдоо хорих ялын доод хэмжээг тогтоож түүнээс дээш хэдэн жил нэмэгдүүлэн яллах боломжийг шүүхэд олгосон нь нэн чухал ач холбогдолтой гэж үзлээ.

ХБНГУ нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг тусгайлан авч хэд хэдэн зүйлд тусгасан нь бусад улсын хувьд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эрүүгийн эрх зүйн хамгаалалтын сонгодог жишээ болж байна. Мөн ХБНГУ нь Монгол Улсын адил хүчиндэх гэмт хэргийн субъектыг эрэгтэй, эмэгтэй хэн ч байхаар хуульчилсан нь нийтлэг байна.

Тус улсын Эрүүгийн хуульд бага насны хүүхдийг хүчиндэхээр завдсан бол шийтгэлтэй гэж заасан заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуульд нэвтрүүлэх шаардлагатай гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

4.Франц Улсын Эрүүгийн хуульд “Хүч хэрэглэх, албадах, айлган сүрдүүлэх буюу хууран мэхлэх замаар үйлдэх бэлгийн нэвтрэлт (222-23)”-ийг хүчиндэх гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. (Бэлгийн нэвтрэлт гэдгийг бэлэг эрхтнээр буюу бэлэг эрхтэнд нэвтрэх гэж ойлгоно.) 16 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр зааж 20 жилийн ял шийтгэнэ.

Мөн хуулийн 222-24 зүйлд:

1. Хэрэв гэмтэл учруулсан буюу архаг өвчин тусгасан
2. Хэрэв 16 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн
3. Биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан зориуд санаатайгаар үйлдсэн
4. Цусан төрлийн этгээд үйлдсэн
5. Эрх мэдлээ урвуулан ашиглаж үйлдсэн
6. Хэд хэдэн этгээд хамтран үйлдсэн
7. Зэвсэг хэрэглэж айлган сүрдүүлж үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх нөхцөлөөр 20 жил ял шийтгэнэ.¹⁴⁶

Гэмт хэргийн нийтлэг субъектын хувьд Монгол Улс, ХБНГУ, ОХУ, Казакстан, Япон, Солонгос Улсад эрүүгийн хариуцлага хүлээх насыг 14 наснаас эхлэн тооцсон бол Франц Улс 13 нас хүрсэн хүн хүчиндэх гэмт хэргийн субъект болохоор хуульчилсан байна. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын санкц өндөр байгаагийн зэрэгцээ энэ гэмт хэрэгтэй чанга, хатуу аргаар тэмцдэг хуулийн зохицуулалт нь ололттой. Тус улсын Эрүүгийн хуулийг судалж өөрийн орны онцлогт тохируулан боловсронгуй болгох боломжтой гэж үзлээ.

Тус улс нь хууль ёсны буюу өөрийн төрсөн, жам ёсны буюу ясан төрлийн төрөл садангаас өргөж авсан хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол онц хүндрүүлэхээр зааж хуульчилсанаараа ялгаатай байна.

5.Дани Улсын Эрүүгийн хуульд 15 нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон бол ял шийтгэнэ. Хэрэв хүүхэд 12 нас хүрээгүй буюу гэмт этгээд албадах, айлган сүрдүүлэх замаар бэлгийн харьцаанд ороход хүргэсэн бол хүндрүүлэхээр гяндан хорих ялыг 10 жил хүртэл нэмэгдүүлэхээр заажээ. /Бүлэг 24 бэлгэсийн гэмт хэргийн 222, 223 дугаар зүйл/

¹⁴⁵ Gesetz zur Änderung des stragesetzbuches-Verbesserung des Schutzes der sexuellen Selbstbestimmung. Drucksache 463/16 02.09.2016

¹⁴⁶ (в редакции закона № 98-468 от 17 июня 1998г)

Дээрх улсуудын Эрүүгийн хуульд хохирогчийг өөрөөр тодорхойлжээ. Гадаадын зарим улсад бэлгийн эрх чөлөө нь хүүхдийн хувьд 16-18 насанд хүлээн зөвшөөрөгдөх боловч бэлгийн халдашгүй эрх 16 нас хүртэл хохирогчийн хүсэл зоригоос үл хамааран эрүүгийн эрх зүйн хамгаалалтад байдаг байна. Харин Дани Улсад бэлгийн эрх чөлөөг 15 наснаас хүлээн зөвшөөрсөн бусад улсаас ялгаатай байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд хохирогчийг 14 насанд хүрсэн эсхүл 16 насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан бол харин Дани Улсын хуульд гэмт этгээд тухайн этгээдийн эрүүл мэндийн байдал, насыг мэдээгүй, хайхрамжгүй хандсан бол уг үйлдлийг санаатай бус гэж үзэж шийтгэлийг тэр хэмжээгээр багасгаж оногдуулна гэж заасан нь объектын андуурлыг харгалзан ялыг хөнгөрүүлэн авч үзснийг дээрх харьцуулалт, судалгаанд үндэслэн үзвэл гэмт этгээдэд оногдуулах ялыг хөнгөрүүлэх нь энэ гэмт хэргийг үйлдсэн этгээдийг ял завшихаар байна гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.¹⁴⁷

Эдгээр улсын Эрүүгийн хуулийг хуульчилсан байдлаас харахад хүчиндэх гэмт хэргийн объектив тал нь

1. Хүч хэрэглэх
2. Хүч хэрэглэхээр заналхийлэх /айлган сүрдүүлэх/
3. Хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах
4. Хурьцал үйлдсэн буюу бэлгийн харьцаанд орсон үйлдэл гэж томъёолсон нь

нийтлэг байна.

Дээрх улсуудын гэмт хэргийн субъектын хувьд авч үзвэл Орос, Казакстан улс хүчиндэх гэмт хэргийн субъектыг зөвхөн эрэгтэй хүн, Герман, Дани, Франц, Монгол Улс хүчиндэх гэмт хэргийн субъектыг эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүн байхаар хуульчилсан байна.

Ихэнх улсад бэлгийн албадлага буюу бэлгийг дарамтыг бие даасан бүрэлдэхүүн болгон хуульчилсан байхад манай улсын хувьд бэлгийн дарамт учруулах гэмт хэргийг хүчингүй болгосон. Энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасныг хүчингүй болгосон нь ухралт болсон нь анхаарал татаж байна.

Монгол Улсын болон гадаадын зарим улсын Эрүүгийн хуульд хүчиндэх, бага насны хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг харьцуулан үзвэл:¹⁴⁸ *Хүснэгт №1*

№	Монгол Улс	ОХУ	ХБНГУ	БНКУ	Франц Улс	Дани Улс
Хүчиндэх	Үндсэн				15 жил	
	Хүндрүүлэх	1-5 жил		15 жил хүртэл	20 жил	
	Онц хүндрүүлэх	5-12 жил	8-10 жил	10-15 жил	30 жил	
	Тусгай	12-20 бүх насаар	12-20 жил		Бүх насаар	
Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл	Үндсэн	6 сараас 2 жил			5 жил	
	Хүндрүүлэх	2-8 жил		8-15 жил	7 жил	

¹⁴⁷ Дани Улсын Эрүүгийн хууль, 1999 он

¹⁴⁸ Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс УБ, 2019 он

	Онц хүндрүүлэх	5-12 жил	8-15 жил		10-15 жил	10 жил	
	Тусгай	12-20 жил			15-20, бүх насаар		
Бэлгийн албадлага буюу бэлгийн дарамт	Үндсэн					1 жил	
	Хүндрүүлэх		5 жил хүртэл				
16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	Үндсэн	6 сараас 1 жил	4 жил хүртэл	1 жил	5 жил хүртэл		4 жил хүртэл
	Хүндрүүлэх	6 сараас 3 жил	6 жил хүртэл	6 сараас 10 жил	7-10 жил		6 жил хүртэл
	Онц хүндрүүлэх		8-15 жил	5-с доошгүй жил	10-15 жил		10 жил хүртэл
	Тусгай		12-20 жил бүх насаар	10-с дээш, насаар нь			

Гадаадын зарим улсын энэ төрлийн гэмт хэргийн харьцуулсан судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуульд бага насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгосон байдал нь зарим улс нь үндэсний эрх зүйн тогтолцоо, ёс заншил, амьдралын хэвшил, нийгэм эдийн засаг, соёлын түвшин зэргээс хамаарч өөрийн гэсэн онцлогтой байна.

Дүгнэлт

Харьцуулан судалсан улсуудын Эрүүгийн хуульд хүчиндэх, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгон авч үзэх нийтлэг хандлага байна. Тухайлбал, ОХУ, Бүгд Найрамдах Казакстан зэрэг улсад нарийвчлан хуульчилж өгсөн нь хуулийг хэрэгжүүлэхэд илүү ойлгомжтой, тодорхой байна. Харин ХБНГУ нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг тусгайлан хэд хэдэн зүйл болгон хуульчилсан нь бусад улсын хувьд эрүүгийн эрх зүйн хамгаалалтын сонгодог жишээ болсон байна.

Монгол Улсын хувьд зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог болсон, хохирогчийн бэлгийн халдашгүй байдлыг хүйсийн ялгамжгүйгээр Эрүүгийн хуулиар хамгаалсан зэрэг нь олон улсын жишигт нийцэж байна.

Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдлыг харьцуулан судлахад БНСУ, ХБНГУ-ын Эрүүгийн хуульд оногдуулах хорих ялыг тодорхойлохдоо хорих ялын доод хэмжээг тогтоож, түүнээс дээш хэдэн жил нэмэгдүүлэн яллах боломжийг шүүхэд олгосон нь сонирхол татаж байна.

Харьцуулан судалсан ихэнх улсын Эрүүгийн хуульд бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан байдлыг Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай байна.

Санал

- Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэг болгон хуульчилж, ялын бодлогыг чангатгах;
- Бэлгийн хүчирхийллийн хохирогчид учирсан шууд ба шууд бус хохирол буюу хохирогчийн сэтгэл санааны хохирлыг үнэлж барагдуулах аргачлалыг бусад улсын туршлагаас судалж, бий болгох;
- Гадаадын зарим улсын жишгээр бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, ял эдлээд суллагдсан этгээдийг хохирогчдод дахин халдахаас сэргийлж цахим хяналтын төхөөрөмжийн тусламжтайгаар хяналтад байлгах, хүүхэдтэй харьцах зарим ажил гүйцэтгэхийг хязгаарлах, хориглох албадлагын арга хэмжээ авахаар хуульчлах;
- Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн дэргэд байцаахад хохирогч айж эмээх, үнэн зөв мэдүүлэхгүй байх тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор бага насны хүүхдийг мөрдөх, нотлох ажиллагаанд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, мөрдөн байцаагч, шинжээч нараас бүрдсэн мэргэшсэн багийг ажиллуулах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Ном зүй

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц. НҮБ 1989
2. Эрүүгийн хууль. 2002, 2015
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017
4. Дэлхий дахины гэмт хэргийн загвар хууль. НҮБ., 2001
5. Карбоне Ж.И Юридическая социология. М.1986
6. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. Хөгжлийн академи ТББ. УБ., 2017
7. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ. Дотоод хэргийн их сургууль, Нээлттэй нийгэм форум. УБ., 2019

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ: ТҮҮХ, ФИЛОСОФИ

Н.Манлайбаатар

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Эрүүгийн процессын эрх зүйн зарчим нь уг салбар эрх зүйн үнэт зүйлсийн илэрхийлэл, товчилсон агуулга нь болж байдаг нэвтэрхий толь нь гэж үзвэл бид уг агуулгыг нээн илрүүлэх зорилгоор уг процессын эрх зүйн түүх, философи, үнэт зүйлсийн тухай авч үзсэн.

Түлхүүр үг: Эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, эрүүгийн процессын зарчим.

Салбар эрх зүйн мэдлэгийн тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль хийгээд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчимд үндэслэх¹⁴⁹ бөгөөд түүний үнэт зүйл, үзэл баримтлалд нийцсэн байна. Үүнийг эш болговол Эрүүгийн процессын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, үзэл баримтлал, үнэт зүйл нь хүн төрөлхтний бүтээсэн эрх зүйн хөгжлийн түгээмэл чиг хандлагад нийцсэн байх нь төрийн үйл ажиллагааны шударга ёс, хууль дээдлэх зарчмыг тодруулдаг гол үндэслэл¹⁵⁰ мөн.

Ардын багш, профессор Б.Чимид агсан энэ талаар “Хүн төрөлхтний үнэт зүйлс, ардчилсан хууль хийгээд ёс суртахууны аль алины нэг иш үндэс бол шударга ёс мөн бөгөөд түүнийг чанд сахиж, хууль дээдлэх нь засаг төрийн аливаа байгууллага, ямар ч албан тушаалтны дур зоргоор авирлахыг зориуд хаязгаарлаж хуулийн хүчээр хязгаарлан барьдаг. Үүгээрээ Үндсэн хууль эрх мэдэлтний зүгээс иргэнийг дарамтлан, хүний эрх, ашиг сонирхолыг зөрчихөөс сэргийлэх хүчин зүйл болно. Иргэн хүн хуулиар хориглоогүй зүйлийг хийж болох эрх чөлөөтэй байдаг бол засаг төрийн байгууллага, түүний албан тушаалтан гагцхүү хуульд заасан үүргийг мөн түүгээр олгогдсон эрхийн дотор биелүүлэх ёстой байдаг. Энэ бол шударга ёсны хэмжүүр болсон хууль дээдлэхийн үндсэн шаардлага мөн¹⁵¹” гэсэн нь Үндсэн хуулийн эрх зүйн зарчмын мөн чанар, үзэл санааг тодруулан таниулсан, позитив эрх зүйн философийн чиг хандлагыг тодорхойлжээ.

Мөрдөн байцаалт нь эрүүгийн процессын үе шат төдийгүй, тодорхой ажиллагааг илэрхийлдэг хууль зүйн шинжлэх ухааны онцгой судлагдахуун тул түүнд хамаарах зарчим нь үндсэн хуулийн, олон улсын, эрүүгийн процессын эрх зүйн зарчимтай давхцах, ондооших, нийтлэгших мөн чанартай.

Эрүүгийн процессын эрх зүйн зарчим үе шат бүхэнд хууль зүйн чиг баримжаа, эрх зүйн аливаа хийдэл, алдааг даван туулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох бололцоог олгож, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх үндэс болдог билээ. Ийм ч учраас бид эрүүгийн процессын эрх зүйн зарчмын агуулга, мөн чанар, хууль зүйн учир холбогдлыг авч үзэх нь мөрдөн байцаалтын агуулга, мөн чанар, үзэл санааг тайлбарлан таних бололцоог бүрдүүлэх юм.

Хуулийн ерөнхий, тусгай ангийн заалтууд өөр хоорондоо зөрчилдвөл ерөнхий ангийнхыг, ерөнхий ангийн хэм хэмжээнүүдийн утга, агуулга зөрчилдвөл зарчмуудыг юуны урьд тулгуур болгодог “жишиглэл”-ийг даяаршилд бүр хамрагдаж буй улс орнуудыг хууль зүйн амьдралаас ажиглаж болно¹⁵² гэсэн нь эрүүгийн процессын эрх

¹⁴⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйл. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> үзнэ үү.

¹⁵⁰ Хууль зүйн Академи. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 2020. 78 дахь тал.

¹⁵¹ Чимид.Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 36 дахь тал.

¹⁵² Бямбаа.Ж, Эрхэсхулан.Ж нар. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018. 80 дахь тал.

зүйн зарчмын хууль зүйн учир холбогдол, чиг үүрэг, төдийгүй үзэл санааны язгуур болохыг илэрхийлж буй явдал мөн.

Зарчим нь тухайн улсын төрийн дэглэмийг илэрхийлэх түгээмэл ойлголтыг бүтээнэ. Өөрөөр хэлбэл, 1992 оноос өмнөх эрүүгийн процессын зарчим үзэл санаанд монизм /нэг эшт/ түгээмэл илэрхийлэгдэж байсан¹⁵³, бол эдүүгээ плюралист /олон ургалч/ үзэл санаа хуулийн амин сүнс болж, хууль зүйн рецепци үндэсний эрх зүйн тогтолцоонд нөлөөлж, эрх зүйт хууль бүтээхийг эрдэмэн судлаачид шаардах буюу илэрхийлж, хууль тогтоогч эрмэлзэх болсон. Ийм ч учраас төрийн эрүүгийн болон эрүүгийн процессын бодлого императив зохицуулалтын аргыг диспозитив зохицуулалтын аргатай хослуулахыг хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтээс харж болохуйц байна. Зарчим нь зөвхөн эрх зүйн тогтолцооны төдийгүй улс төрийн тогтолцоо, төрийн байгууламж, дэглэмийг илэрхийлдэг өргөн хүрээтэй ойлголт, судлагдахуун юм.

Эрүүгийн процессын эрх зүйн зарчим харьцангуй түгээмэл судлагдсан бөгөөд үр дүн нь судалгаа, шинжилгээний эргэлтэд төдийгүй хууль тогтоох хийгээд эрүүгийн процессын эрх зүй, гэмт хэргийн нотолгооны онол, криминалистикийн тактик зүй, криминалистикийн арга зүй гэх зэргээр бакалавр, магистр, докторын сургалтанд мөн мөрдөн байцаалтын практикийн түгээмэл судагдахуун, ойлголт билээ. Тухайлбал, “Гэм буруугүйн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал¹⁵⁴”, “Шүүхийн мэтгэлцээн¹⁵⁵”, “Хүний халдашгүй эрх¹⁵⁶”, “Гэрч¹⁵⁷” зэрэг нэг сэдэвт бүтээлүүд нь эрүүгийн процессын эрх зүйн зарчмын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох анхдагч сурвалжууд мөн.

Бүтээлүүдэд агуулагдах үзэл санаа, тайлбар, судалгааны тайлан, харьцуулалт нь эрүүгийн процессын аль ч үе шатанд тухайн зарчим нь онол, практик, бүх л шатны сургалтад учир холбогдолтой болохыг бид судалсаар ирлээ. Бид бусад сурах бичиг, ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээл үнэ цэнэтэй болохыг үгүйсгээгүй болно.

Юуны өмнө эрх зүйн зарчим нь тухайн салбар эрх зүйн мөн чанар, нийгмийн ач холбогдол түүний зарчмуудаар дамжин илрэх бөгөөд эрх зүйн хамгийн гол шинж, чиглэлийг илэрхийлж харуулсан үзэл санааны нийлбэрийг эрх зүйн зарчим гэнэ¹⁵⁸ гэх ойлголт нэгэнт хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд хүлээн зөвшөөрөгдсөн. Харин “эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны зарчим гэдэгт төрийн эрх зүйн бодлогыг тусгасан, мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх чиг үүрэгтэй төрийн байгууллагын үйл ажиллагааны мөн чанарыг тодорхойлж буй, нийтээр заавал дагаж мөрдөх, хуулийн дээд хүчин чадалтай хэм хэмжээг ойлгоно¹⁵⁹ гэж авч үзжээ.

Түүнчлэн, Оросын эрдэмтэн Г.Н.Манов: эрх зүйн зарчимд хандах орчин үеийн хандлагыг эрх зүйн үндсэн тогтолцооны онцлогоор нь – уламжлалт, ром-германы, англо-саксоны эрх зүйн зарчим гэж ангилсан¹⁶⁰ бөгөөд өөр хоорондоо харилцан адилгүй эх сурвалж бүхий эрх зүйн тогтолцооны агуулгаар нь авч үзвэл зүйтэй ажээ. Мөн Францын их сэтгэгч Р.Давид эрх зүйн нийтлэг зарчмыг хуулийн үндсэн томъёолол (хуульд бэхэжсэн нийтлэг зарчмууд) ба хууль тогтоомжид тусгагдаагүй

¹⁵³ Марксист-Ленинист үзэл суртал, социалист эрх ашиг, нэг нам төвтэй тогтолцооны илэрхийлэлийг 1940 оны ЭБШ хуулийн үзэл санааны үндэс болгосныг тэмдэглэв.

¹⁵⁴ Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Д.Зүмбэрэлхам 2001 онд уг сэдвээр диссертаци хамгаалсан, 2005 онд Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйн презумпци номыг хэвлүүлсэн нь мөрдөн байцаалтын ажиллагаанд гэм буруугүйн презумпци нь онол, практикийн чухал суурь зарчим болохыг тодорхойлсон.

¹⁵⁵ Мөн Д.Зүмбэрэлхам 2002 онд Шүүхийн мэтгэлцээн номыг хэвлүүлсэн.

¹⁵⁶ Х.Эрдэнэбат 2002 онд Хүний халдашгүй эрх номыг хэвлүүлсэн.

¹⁵⁷ Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэг 2013 онд Гэрч номыг хэвлүүлсэн.

¹⁵⁸ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2017 он. 99 дэх тал.

¹⁵⁹ Х.Нямбаатар, Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. Сурах бичиг. Уб., 2020 он. 18 дахь тал.

¹⁶⁰ Ч.Нямсүрэн. Дурдсан бүтээл. 100 дахь тал.

нийтлэг зарчмууд (эрх зүйн шударга ёсны тухай уламжлалт үзэл санаа) гэж хоёр ангилсан¹⁶¹ нь өнөө үед ч анхаарал татаж байна.

Эрх зүйн зарчмыг эрх зүйн зүй тогтолт шинжээр нь: а) жам ёсны, б) хууль ёсны, в) зүй ёсны зарчим¹⁶² гэж ангилах бөгөөд жам ёсны зарчим нь төрөлхийн эрхийн мөн чанараар нөхцөлдсөн, хүний язгуур эрх ашгийг тусгасан нийгмийн шаардлагаар дэмжигдэж, хамгаалагдсан байдаг бол хууль ёсны зарчим нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан, хуульчлагдаж, зохицуулагдсан зарчмыг, харин ёс зүйн зарчим нь аливаа субъектийн /хувь хүн, иргэн, албан тушаалтан/ нийгэмд биеэ авч явах байдлын наад захын горим, баримтлал төдийгүй эрх зүйн харилцаанд оролцоход баримтлах ёс суртахуун-соёл, хүнлэг ёсны үнэт зүйлс, хэм хэмжээнүүд юм¹⁶³ гэсэн нь зарчмын илрэн гаргах хэлбэрээр нь түүний дотоод зүй тогтолыг илэрхийлжээ.

Эрх зүйн зарчим нь эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь¹⁶⁴ бол Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны¹⁶⁵ зарчим гэдэг нь Үндсэн хууль болон бусад хуулиудад бэхжиж тусгалаа олсон бөгөөд ЭБШ ажиллагааны ерөнхий журам, зохион байгуулалтыг тодорхойлж улмаар уг ажиллагааны мөн чанарыг илэрхийлж буй нийтлэг заалт мөн¹⁶⁶ гэсэнтэй бид санал нэг байна.

Мөн ЭБШ ажиллагааны үндсэн зарчим гэдэг нь эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хэм хэмжээгээр илэрхийлэгдсэн бөгөөд мөрдөн байцаах, шүүн таслах үйл ажиллагаанд удирдлага болгох үндсэн үзэл санаа¹⁶⁷ гэж үзэж байсан нь өнөөдөр ч позитив эрх зүйн үүднээс улам баяжин тайлбарлагдаж байна.

ЭБШ ажиллагааны бүх үе шатанд түүний хэлбэр, баталгаа, бүтэц, зохион байгуулалт, зорилтыг тодорхойлох ерөнхий агаад удирдлагын шинж чанартай хэм хэмжээг түүний зарчим гэнэ¹⁶⁸ хэмээн тодорхойлсон нь эрүүгийн процессын бүхий л үе шатанд удирдлага болгох хэм хэмжээ гэсэн утга илэрхийлжээ.

ЭБШ ажиллагааны ерөнхий зүй тогтол, цар хүрээ, арга хэлбэр, зохион байгуулалт, мөн чанар, үндэс суурийг тодорхойлж, ЭБШ ажиллагаа явуулахдаа, өөрөөр хэлбэл, гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл хүлээн авах, эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, прокурорын хяналт, шүүхээр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх зэрэг ажиллагаа нэг бүрт удирдлага болгодог үзэл санааны баримтлал, үндсэн чиглэлийг тодорхойлсон, Монгол Улсын Үндсэн хууль, ЭБШ хуульд тусгалаа олж баталгаажсан, эрх зүйн үндсийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчим гэнэ¹⁶⁹ гэж үзсэн нь эрүүгийн процессын үе шатыг тоочсон хэлбэрээр тайлбарласан нь бий.

Эрүүгийн процессын эрх зүйн зарчим нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх¹⁷⁰ ажиллагааны зорилго, зорилтыг хангахад чиглэгдсэн хууль зүйн баримтлал бөгөөд Үндсэн хуульд тусгагдаж, төрийн бодлогын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг¹⁷¹ нь түүний хууль зүйн учир холбогдол зайлшгүйг илтгэж, улмаар уламжлалт хэлбэрээр тайлбарлажээ. Нөгөөтэйгүүр, эрүүгийн процессын эрх зүй нь эрх зүйн зарчмын

¹⁶¹ Давид.Р. Основные правовые системы современности. 1999. С. 108-109.

¹⁶² Д.Баярсайхан. Эрх зүйн онол. Уб., 2018 он. 50 дахь тал, Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2020 он. 89-90 дүгээр тал.

¹⁶³ Мөн тэнд.

¹⁶⁴ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэлт. Уб., 2015 он. 663 дахь тал.

¹⁶⁵ Цаашид “ЭБШ” гэж бичнэ. “Эрүүгийн байцаан шийтгэх” хэмээх нэр томъёо 1935-2017 оныг хүртэл хэрэглэгдсэн бөгөөд тухайн үеийн тогтсон хууль зүйн нэршлийг хэрэглэсэн байна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчим, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн зарчим нь нэгдмэл утга, агуулгатай.

¹⁶⁶ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. (1.Ерөнхий анги). Уб., 1996 он. 44 дэх тал, Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. Гурав дахь хэвлэл. Уб., 2004 он. 59 дэх тал.

¹⁶⁷ Ж.Авхиа нар. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Уб., 1987 он. 13 дахь тал.

¹⁶⁸ Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. Уб., 2008 он. 17 дахь тал.

¹⁶⁹ Б.Ганболд. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. /ерөнхий анги/. Уб., 2008 он. 88 дахь тал.

¹⁷⁰ Цаашид ЭХХШ гэж бичнэ.

¹⁷¹ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2020 он. 87 дахь тал.

түүний үзэл баримтлалд үндэслэн өөрийн зорилно, зорилт, агуулга, мөн чанараа бүрэн илэрхийлж, нийгэмд нөлөөлөх чадвар, хүртээмж, эрх зүйн соёл, боловсролын хүрээгээ тэлж байдаг зүй тогтолтой.

Эрүүгийн процессын эрх зүйн зарчим, мөн чанар, зүй тогтол, агууламжийн хувьд: 1. ЭХХШ ажиллагааны зорилго, зорилт, чиг үүргийг хангах эрх зүйн чиглэмж; 2. ЭХХШ ажиллагааны хөгжлийн чиг хандлагын талаар төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлал; 3. Олон улсын төдийгүй улс, үндэстэн, нийгмийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүй, ёс суртахууны үнэт зүйлс жишиг ойлголтын түвшинд илэрхийлэгдэнэ¹⁷² хэмээн нэлээд өргөн утгаар түүний агуулга, мөн чанарыг илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн нөхцөлд улс орны эрх зүйн тогтолцоонд нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцийн хэм хэмжээ, зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид тусгах, зарчим, үзэл санааны хувьд нэгдмэл байх шаардлага тавигдаж буйг бид анхаарах шаардлагатай. Үүний зэрэгцээ Монгол Улсаас Олон улсын гэрээ, конвенц, хамтын нийгэмлэгт элсэх зэрэгт нэлээд хянуур хандах нь чухал болно. Энэ нь өнөөгийн эрүүгийн процессын тэр дундаа мөрдөн байцаалтыг олон улс, бүс нутагтаа хэрхэн зохион байгуулах тухайд ирээдүйд үүсэх асуудлын чиг хандлагыг илтгэх судлагдахуун, эргэлзээтэй асуудал үүсгэж болох онол, практикийн сонирхолтой сэдэв болохыг илтгэж байна.

Эрүүгийн процессын эрх зүйн зарчим нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд удирдлага болгох хэм хэмжээний нийлбэр цогц, зан үйлийн горим журам гэж үзэж байгаа дээрх тодорхойлолтууд нь бидний судлан буй мөрдөн байцаалтад онол арга зүй, практикийн гол чиглэл, баримжаа болж байдгийг энд авч үзэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны /эрүүгийн процесс/ зарчим нь дараах үндсэн шинжүүдийг өөртөө агуулдаг. Үүнд:

Нэгдүгээрт – хууль зүйн хэлбэрийг олсон төдийгүй зайлшгүй дагаж биелүүлэх шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, зарчим нь Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад ердийн хуулиудад тусгагдана.

Хоёрдугаарт – энэ нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хэрэг хянан шийдвэрлэх зэрэг төрөөс гүйцэтгэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, баримтлал болно.

Гуравдугаарт – зарчим нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хийгдэж буй үйлдэл, үйл ажиллагаа, хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийн үндсэн шалгуур болохыг зэрэгцээ эрх зүйн хийдлийг шийдвэрлэх хууль зүйн үндсэн болно.

Дөрөвдүгээрт – зарчим нь манай ардын төрийн улс төрийн бодлого, мөн чанарыг илэрхийлнэ¹⁷³ гэсэн нь мөрдөн байцаалтанд баримтлах зарчмын агуулга, мөн чанар, үзэл санааг илэрхийлнэ.

Эрүүгийн процессын зарчим нь эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг бүхэлд нь зохицуулж, хамгаалах үүрэгтэй. Уг ажиллагааны зарчмыг эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн бусад журмаас ялгах гол шинж чанар нь *хэм хэмжээ тогтоох, зохицуулах, эргэлзээгүй байх, зөрчилгүй байх, зөрчихгүй байх, нийтлэг байх* шинжүүдтэй¹⁷⁴ гэж авч үзжээ. Өөрөөр хэлбэл, дээрх шинж чанар нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зорилт, мөн чанар, онцлог, агуулга зэргээс гадна, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдмэл тогтолцоонд оруулах арга замыг оновчтой тодорхойлох боломж олгодог тул үүнд зарчмын ач холбогдол оршино¹⁷⁵ гэсэн нь оновчтой.

Дээрх онолын үзэл санааны үндэс болсон агуулга нь эрүүгийн процессын зарчмын агуулга, мөн чанарыг бүрэн нээхгүй байх үндэстэй тул бидний зайлшгүй авч

¹⁷² Д.Баярсайхан. Дурдсан бүтээл. Мөн тэнд, Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ., 2014 он. 87 дахь тал.

¹⁷³ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. (1. Ерөнхий анги). УБ., 1996 он. 44 дэх тал, Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. (1. Ерөнхий анги). УБ., 2004 он. 59 дэх талд "ардын" гэж үгийг хасаж бичсэн.

¹⁷⁴ Х.Нямбаатар, Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. Сурах бичиг. УБ., 2020 он. 19 дэх тал.

¹⁷⁵ Х.Нямбаатар, Т.Оюунчимэг нар. Дурдсан бүтээл. 19-20 дугаар тал.

үзэх шаардлагатай харьцуулалт хийх судлагдахуун нь мөрдөн байцаалтанд баримтлах зарчмын түүхийн зарим асуудал мөн тул бид мөрдөн байцаалтын түүхийн нэн эгзэгтэй үе болох өмнөх тогтолцооны эхэн үеийн зарим баримтуудыг авч үзэхийг зорьлоо.

Монгол Улсад Үндсэн хуульт байгуулалд 1924 оноос шилжсэн бөгөөд 1992 оны ардчилсан Үндсэн хууль батлагдах хүртэлх хугацааны мөрдөн байцаалт хууль ёсны гэхээсээ “улс төрийн хилс хэрэгт татагдаж амь насаа алдаж, хууль бусаар хоригдож, нутаг заагдан цөлөгдөж байсан, түүнчлэн хүн бүрийн амьдрал, хувь заяа улс төрийн дэглэмээс хамаарч байдаг¹⁷⁶” нь түүхэнд тэмдэглэгдэн, эдүүгээ судлагдаж байна. Анхдугаар Үндсэн хууль үйлчлэх хугацаанд эрүүгийн процессын хэм хэмжээ улам нарийн тодорхой болж шүүн таслах эрх зүйн үндсэн зарчим болох хууль ёс, ардчилсан ёс, энэрэнгүй ёс, хүний эрхийн халдашгүй байдал, тэгш эрхийн зарчмуудыг бататган бэхжүүлсэн боловч харамсалтай нь дангаар захирах тоталитари дэглэм ноёрхож байсан энэ үе нь хоосон хоосон тунхаглал болж үлдсэн¹⁷⁷ нь

Хуулиас гадуур дур зоргоороо бусдыг мөрдөн мөшгөж байсан 1930-1940 онд хүчин төгөлдөр мөрдөж байсан эрүүгийн процессын хуульд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмын шинжтэй хэм хэмжээ тогтоож хуульчилсан хэдий ч, түүнийг үл хэрэгсэн мөрдөн мөшгөж, хүнийг хэлмэгдүүлэх, хилсээр ял тулган шийтгэх явдал байсан нь ангийн байр суурь, нийгэм, улс төрийн онцгой шийдвэр, үйл ажиллагаатай холбогдсон гадаад, дотоод хүчин зүйлс, түүний зөрчилдөөний дотоод илэрхийлэл байсан нь бидэнд онцгой сургамж болон өвлөгдсөн билээ.

Ялангуяа, 1935-1939 он хүртэлх үеийн эрүүгийн хэрэг хянан шийвэрлэх ажиллагааны түүхэнд Сталины дэглэмийн үр дагавраас үүдэлтэй дангаар ноёрхох авторитари тогтолцоо бүрэлдснээр хүний халдашгүй эрх тэгш эрхийн болон хууль ёсны зарчим ноцтой зөрчигдөж, хуулиас гадуурх эрүүгийн процессын гаж тогтолцоо бий болоход хүрсэн¹⁷⁸ бөгөөд мөрдөн шалгах ажиллагааг хуучнаар Зөвлөл Холбоот Улсын Ерөнхий прокурор байсан А.Я.Вышинскийн онолд¹⁷⁹ үндэслэн явуулж нотлох баримт цуглуулж, бэхжүүлж, тэдгээрийг үндэслэн хэргийг шийдвэрлэж байжээ. Тухайлбал, нойр, хоолгүй олон хоногоор өндөр сандалд суулгаж жижүүрлэн байцаах, үзэг, харандаагаар хатгах, алгадах, өшиглөх, чихийг нь мушгих, үсийг нь зулгаах, ам багалзуурыг барьж шахах, ташуурдах, ширээний хэрэгсэл сандал модоор цохих, халуун пийшин том чийдэнгээр шарах, хүйтэнд нүцгэн гадаа гаргах, эсхүл цонх задгайлж дааруулах, эсхүл даавуунд элс, чулуу боож цохих, гар хөлд нь гав хийх, касчирт хорих, буу тулгаж сүрдүүлэх, хэргээ хүлээвэл хөнгөлнө, амь өршөөнө гэж ятгаж хуурах зэрэг олон арга хэрэглэж байсан нь баримтуудаар батлагдаж, 1937-1940 оны хооронд хувьсгалын эсэргүү хэрэгт 29188 хүнийг шийтгэсний дотроос 20822 хүнийг буудан алах ялаар шийтгэсэн¹⁸⁰ гэж тэмдэглэсэн байна.

Зарим судлаачдын тэмдэглэснээр улс төрийн хэлмэгдүүлэлт 1937 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр эхэлсэн гэж үзээд, Х.Чойбалсан тэргүүтэй Онцгой бүрэн эрхт комисс (ОБЭК) 1937 оны 10 дугаар сарын 02-нд байгуулагдаж, 1939 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл ажиллахдаа 51 удаа хуралдаж 25824 хүний хэргийг шүүж 20474 хүнд буудан алах ял өгч, 5103 хүнд 10 жил хорих ял, 240 хүнд 10-аас доош жилээр хорих ял оногдуулжээ¹⁸¹ гэсэн байна. Тооны хувьд өөр хоорондоо тохирохгүй байгаа дээрх нөхцөл байдал нь зарим талаар эх сурвалжийн түрүү, хожуу үеийг, эсхүл цаг хугацааны зай завсар харилцан адилгүйг илэрхийлэх мөрдөн байцаалт үндсэндээ явагдахгүй, шууд буудан хороох ял оногдуулж байсныг тодруулж байна.

¹⁷⁶ Чимид.Б. Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 2008. 83 дахь тал.

¹⁷⁷ Болдбаатар.Ж, Лүндээжанцан.Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. 272 дахь тал.

¹⁷⁸ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2020 он. 50 дахь тал.

¹⁷⁹ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын албадлага ба хүний эрх. Уб., 2018 он. 27 дахь тал.

¹⁸⁰ Г.Б.Батзориг. Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол. Уб., 2002 он. 64-65 дугаар тал.

¹⁸¹ О.Батсайхан нар. Хэлмэгдал ба цагаатгал. Түүх ба баримт. 2 дахь хэвлэл. Уб., 2021 он. 11 дүгээр тал.

Хэлмэгдүүлэлтийн талаар “Хэлмэгдсэн буддизм” нэвтрүүлгээр лам нарыг хэрхэн хэлмэгдүүлж байсан тухай түүхийн ухааны доктор Д.Өлзийбаатар болон бусад оролцсон хүмүүс онцлон тэмдэглэсэн тухайд: “Дотоодыг хамгаалахын газрын ажилтнууд хулхиар нь ташруулан буудахад нэг буудалтаар 5 хүн алж, зугаа болгож, хэн нь нэг буудалтаар олон хүн алахаа хүртэл үзэж байсан”, шашны хэргийн талаар байцаалт авахдаа “Жанлавцогзол¹⁸² уншсан уу?” гээд хэрэв уншсан, айлдсан бол “цаазлах ял шийтгэж, буудан хороож” байсан баримт¹⁸³ буй нь мөрдөн байцаалтын дүнд нотолсон бус харин эрүүдэх, тамлах хэсэг бүлэг хүмүүсийн үйлдсэн алан хядах /террорист/ үйл ажиллагаа байсан юм. Өөрөөр хэлбэл, тусгай комисс, онц бүрэн эрхт комиссын хэт дураараар авирлах явдал гэж үзэх үндэслэлийг бататгаж байна.

Уг баримтыг батлах шийдвэрийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1930 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хуралдсан тавдугаар хурлын хурлын тогтоол нь: “Дотоодыг хамгаалахын газрын дарга Намсрайгаас “ДХГ хүлээгдэн буй олны өмнө шүүх таслах шийдвэрлэж үл болох улс төрийн нууц холбогдолтой хэд хэдэн хэргүүдийг тамлан шийтгүүлэхийн тулд тусгай дүрмийн ёсоор таслан шийтгүүлэх Тусгай комиссыг байгуулахаар илтгэсэн тухай хэлэлцээд ийнхүү дотоод хамгаалахын дэргэд уг хэргүүдийг таслан шийтгэх Комиссыг байгуулах нь зүйтэй тул мөнхүү комиссын даргад Дотоодыг хамгаалахын Намсрай, гишүүдэд нөхөр Дэндэв, Чойбалсан нарыг томилж түүгээр зохих нөхдийг суулцуулан гүйцэтгэхээр тогтов. МАШ НУУЦ¹⁸⁴” гэсэн тогтоолыг баталсан нь хууль цаазыг умартан, дур зоргоор хэлмэгдүүлэлт явуулах эрх зүйн үндэсийг тухайн үед бүрдүүлжээ.

Мөн 1937 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Улсын бага хурлын тэргүүлэгчид ба ардын сайд нарын зөвлөлийн ерөнхий сайд мөн ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайд нарын хавсарсан хуралдааны онц хурлын тогтоолоор онцгой бүрэн эрхт комисс байгуулж, мөн даргаар Чойбалсан томилогдож¹⁸⁵, “хэлмэгдүүлэлтийн мөрдөн шалгах ажиллагаа” явуулжээ. Үүнээс хойш хэлмэгдүүлэлт явуулахын тулд элдэв хуурамч хэрэг зохиох, хорон явуулга хийх, эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх, объектийг шинээр бий болгох замаар ял шийтгэх өргөн хүрээтэй ажиллагааг явуулж байсан билээ.

Түүхийн философийн марксист-ленинист онолын ангич, порлетарийн үзэл санаа нь шашны эсрэг хийгээд хар феодал ангийн эсрэг тууштай тэмцсэн нь түүхийн тэр дундаа эрүүгийн процессын зарчмын агуулга, мөн чанарыг нээн илрүүлэхэд ихэд тустай тул судлаачдад өдөөлт өгөх төдий хэлбэрээр авч үзлээ.

¹⁸² Өндөр гэгээн Занабазар судар, тарни хоёрыг хослуулсан хоёр зохиол бичсэн бөгөөд түүний нэг нь дэлхий нийтийн хүн ард эв найрамдалтай амьдрах утга санааг илэрхийлсэн “Жанлавцогзол”, нөгөө нь буддын шашны гүн ухааны “Маанийг бүтээх арга” хэмээх зохиол юм. Хэлмэгдүүлэлтийн шалтгаан, хууль бус мөрдөн мөшгөлтийн үндэс болсон нэгэн баримт.

¹⁸³ Хэлмэгдсэн буддизм баримтат нэвтрүүлэг. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний телевиз. 2021 оны 01 дүгээр сарын 30-нд эфирээр цацагдсан.

¹⁸⁴ О.Батсайхан нар. Хэлмэгдэл ба цагаатгал. Түүх ба баримт. 2 дахь хэвлэл. УБ., 2021 он. 527 дахь тал.

¹⁸⁵ О.Батсайхан нар. Дурдсан бүтээл. Мөн тэнд.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

Б.Батзаяа

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Хүүхдийн хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хамгаалах, зөрчил гаргагч, гэмт хэрэг үйлдэгчид эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхэд хууль хяналтын байгууллага үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлдэг бөгөөд энэхүү чиг үүргийг хуулийн хүрээнд хэрэгжүүлдэг онцлогтой. Хүүхдийн эрхийг хамгаалах явцад дор дурдсан тохиолдлуудад хүүхдийн нийтлэг эрхийг хамгаалахаар хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах шаардлага үүсдэг. Иймд энэхүү илтгэлд хүүхдийн эрх ашгийг дээдлэх үзэл хандлагын талаар дурдсан болно.

Түлхүүр үг: Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, гэмт хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу нийгмийн бүх гишүүдийн угаас заяасан нэр төр, тэгш эрх, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно гэж үзэж, гэр бүл түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх жам ёсны орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, туслалцаа хүртэх ёстойг ойлгож¹⁸⁶, Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1990 оны 7 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталж, улмаар 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэхүү конвенцид нэгдэн орсноор хүүхдийн угаас заяасан нэр төр, эрх чөлөөг хамгаалж, энх тайван, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгод хүрэх том алхам болсон. Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн 18 насанд хүрээгүй этгээдийг насанд хүрээгүй хохирогч буюу хохирогч хүүхэд гэнэ.

Сүүлийн 7 жилийн байдлаар 11310 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсноос 790 буюу 6.9 хувь нь гэмт хэргийн улмаас нас барсан байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр тархаад буй халдварт өвчний улмаас хүүхэд нас барах тохиолдол буурч, 2020 онд 99 бүртгэгдэж 2019 оны мөн үетэй харьцуулахад 12 буюу 10.8 хувиар, 2021 онд 75 бүртгэгдэж өмнөх оны мөн үеээс 24 буюу 24.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдийн асуудлаар “Хүүхдийн хууль зүйн хороо”, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудлаар “Хамтарсан баг” ажиллахаар заасан боловч хэрэгжилт нь хангалтгүй, хүүхдийн эсрэг, хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирох, хүчирхийлэлд өртөх, зам тээврийн осолд орох, хаягдах, төөрөх, архидан согтуурах, мансуурах, цахим тоглоомд донтох, биеэ үнэлэх, гал түймэр, гол усны аюул, ахуйн осолд өртөх зэргийн улмаас амь нас, эрүүл мэнд нь хохирсоор байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдоос илүү нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэнээрээ хохирсон байдаг бөгөөд өөрийгөө тухайн гэмт хэрэгт буруутай мэтээр төсөөлөх, улмаар амиа хорлох, биедээ гэмтэл учруулахыг оролдох, бусдыг үзэн ядаж байдаг. Иймээс тэдэнд онцгой анхаарлыг хандуулж, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх, нийгэмшүүлэх, хамгаалах шаардлагатай. Хүүхдэд гэмт хэргийн улмаас бие махбодын хохирлоос гадна, ёс суртахууны, эд хөрөнгийн, санаа сэтгэлийн хохирол учирдаг. Ёс суртахууны хохирол нь тухайн хүүхдийн нэр төрийг нь гутаан доромжлох, сургууль, гэр бүлийн орчинд нэр хүндийг нь унагах, сэтгэлийг нь хямрааж шаналгах хэлбэрээр илэрнэ.

¹⁸⁶ Г.Агар-Эрдэнэ, Ц.Адьяахишиг. Хүний эрхийн Олон Улсын билл. Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн Олон Улсын гэрээний эмхэтгэл. Улаанбаатар, 2019. 202 дахь тал.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1.1 (өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг)-д заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно” гэж заасан нь өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй байхыг тэнцвэржүүлж, эрх зүйн хувьд бүрэн бус чадамжийг бүрэн болгож, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангаж буй заалт болж чадсан юм.

Хүүхдийн хамгаалалд нөлөө үзүүлэхүйц хуулиудад дараах хуулиуд хамаарна.

Үүнд:

- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
- Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль ;
- Хүүхдийн эрхийн тухай хууль;
- Иргэний хууль-зэрэг болно.

Дээр дурдсан хуулиуд хүүхдийн асуудлыг хамаарах хууль зүйн үндэс болдог бөгөөд дараах 4 хууль хүүхдийн хэрэг эрхлэх ажиллагаанд голлох үүргийг гүйцэтгэдэг. Үүнд: Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамтаар 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлжээ.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуульд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн бүтцийг баталгаажуулсан байна.

Цагдаа, хууль хяналтын байгууллагын зүгээс хохирогч, гэрч хүүхдээс хохирол, нотолгоо шаардах, гомдол, нэхэмжлэлээ буцаах, хэрэгсэхгүй болгох, эвлэрүүлэх оролдлого хийх, гэр бүлээс тусгаарлах нөхцөлд оруулах зэрэг байдал практикт элбэг байдаг.

Эрүүгийн хэргийг хянан шалгах үйл ажиллагаанд хохирогч хамгааллын сэтгэлгээ хандлага сул, хүүхдийн эрхийн мэргэжилтэн, шинжээчдийг оролцуулдаггүйгээс хүүхдийн эрх ашиг зөрчигддөг. Хүүхдийн хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах эрхийг зөрчих, тэр бүү хэл, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч хүүхдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр цацах зэрэг зөрчил түгээмэл гардаг.

Насанд хүрээгүй хохирогчийн дараах эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хангана. Үүнд:

- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

- Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;
- Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах;
- Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх;
- Шүүх хуралдааны танхимд хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;

Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.

Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.

Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ. Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

Хүүхдийн эрхийг хангах талаарх Хууль зүйн хорооны чиг үүрэг:

“Өсвөр насны хүнийг байцаах, шүүн таслах ажиллагаанд урьдчилан бэлтгэх, хэргийн оролцогчдын бүрэн оролцох боломжийг бүрдүүлэх, хүүхдийг байцаалтад дуудахдаа тэдгээрийн эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг заавал оролцуулах ба өсвөр насны хүн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг тайлбарлаж өгөх” нийтлэг чиг үүрэгтэй.¹⁸⁷

“Хохирогч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа хохирогч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг нэн даруй зохион байгуулах” туслалцаа үзүүлнэ.¹⁸⁸

Өмгөөлөгч авах хүсэлтэй, төлбөрийн чадваргүй хохирогч хүүхдийн эрхийг хангах асуудлаар хорооны хуралд санал оруулж, шийдвэр гаргуулах.¹⁸⁹

Зөрчил, гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан хохирол, гэм хорыг хууль зүйн дагуу барагдуулах, чухал шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг урьдчилан гаргуулах ажлыг зохион байгуулах.¹⁹⁰ Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг.

Сум, хорооны нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хохирогч хүүхэд, түүний эцэг, эх, хамтарсан баг, бусад оролцогчтой хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах нийгэм, сэтгэл зүйн эрүүл мэндийн, хууль эрх зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөө туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна.

¹⁸⁷ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.5.5.

¹⁸⁸ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.7.

¹⁸⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.7.

¹⁹⁰ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.4.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хохирогч хүүхдэд авах шаардлагатай тохиолдолд хуулийн 19.1-т заасан хамгаалалтыг хэрэглэх тухай хохирогч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлт, эсвэл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн саналыг бичгээр гаргуулах ажлыг зохион байгуулна.¹⁹¹

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч сурган хүмүүжүүлэгч нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтантай холбоо тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдэд хүндрэл бэрхшээлгүй шуурхай явуулах ажлыг зохион байгуулна.¹⁹²

Мөрдөгч, прокурор хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг сонгоход хүүхдийн эсрэг ашиг сонирхолтой эсхүл хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн эсхүл гэмт хэрэг үйлдсэн хүмүүстэй шууд болон шууд бус байдлаар хамааралтай тэдгээрийн нөлөөнд байдаг хүнийг оролцуулж болохгүй. Хууль ёсны төлөөлөгч тогтооход хүүхдийн санал болон хүүхдийн байгууллагын үнэлгээ, шийдвэрийг аль болох харгалзаж шийдвэр гаргах нь хэргийн шийдвэрлэлтэнд шууд нөлөө үзүүлж түүний эрхийг нь хангаж буй илрэл юм.

Зөрчил, эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагааны үед болон дараагийн шатанд хохирогч, гэрч, хууль зөрчсөн хүүхдийн эрх ашгийг ханган хамгаална.¹⁹³

Мөн хохирогч хүүхдээс байцаалт мэдүүлэг авах, хохирогч хүүхдийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүх байгууллагатай хамтран ажиллана.¹⁹⁴

Өмгөөлөгч авах хүсэлтэй, төлбөрийн чадваргүй хохирогч хүүхдийн эрхийг хангах асуудлаар хорооны хуралд санал оруулж, шийдвэр гаргуулах.¹⁹⁵

“Өсвөр насны хүнийг байцаах, шүүн таслах ажиллагаанд урьдчилан бэлтгэх, хэргийн оролцогчдын бүрэн оролцох боломжийг бүрдүүлэх, хүүхдийг байцаалтад дуудахдаа тэдгээрийн эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг заавал оролцуулах ба өсвөр насны хүн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг тайлбарлаж өгөх” нийтлэг чиг үүрэгтэй.¹⁹⁶ Хохирогч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа хохирогч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг нэн даруй зохион байгуулах” туслалцаа үзүүлнэ.¹⁹⁷

Гэрч хүүхдийн эрхийг хангах:

Гэрчийн насны хязгаарыг хуульчлан тогтоогоогүй. Тиймээс өнгөрсөн гэмт үйл явдлыг ойлгож, мэдүүлэх чадвар бүхий 18 хүртэлх насны хүүхдийг гэрчээр асууж болно. Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт мэдээлэл нь гэрчийн мэдүүлэг болон бусад баримтаар тогтоогдох тул нотлох баримтын нэгэн гол

¹⁹¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.8.

¹⁹² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.5.

¹⁹³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.1.

¹⁹⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.6.

¹⁹⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 5.2.7.

¹⁹⁶ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.5.5.

¹⁹⁷ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.7.

эх сурвалж нь гэрч юм. Гэрч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй.

Өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон этгээд, тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн шүүгч, өмгөөлөх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгчийг тус тус гэрчээр байцааж болохгүй.

Гэрчийн мэдүүлэг нь хэргийг нотлоход хамааралтай бүхий л байдал, түүний дотор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн хувийн байдал, түүнчлэн, тэдэнтэй ямар харилцаатай болохыг тогтооход чухал ач холбогдолтой байдаг. Гэрчээр хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, яллагдагч, иргэний нэхэмжлэгч, хариуцлагчийн төлөөлөгчийг асууж болохыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гэрчээр дуудагдсан мөчөөс насанд хүрээгүй этгээд эрх зүйн харилцааны субъект болж гэрч хэмээн нэрлэгдэх болно.

Насанд хүрээгүй гэрчийн дараах эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хангана:

- Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.¹⁹⁸
- Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.¹⁹⁹
- Шүүх хуралдааны танхимд гэрчтэй хамт сэтгэл зүйчийг хамт байлцуулах;²⁰⁰
- Гэрчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.²⁰¹

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд

35.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний оюун санааны байдал, учирч болох сөрөг нөлөөнөөс сэргийлэх нөхцөл байдлыг улсын яллагч, өмгөөлөгч нь шалгана.”

8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.”

3.Арван найман насанд хүрээгүй хүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг оролцуулахгүй байж болох ба өмгөөлөгчийг оролцуулна.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд

Гэрч хохирогчийн хамгаалалтанд байгаа хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцлалыг хамгаалах, (Энэ нь гэрч хохирогчийн хувийн орон зай, нэр төр болон аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хэрэгжих зарчим болохоос хамгаалах байрны үйл ажиллагааг нууцлах зохицуулалт биш юм гэдгийг хамгаалалалтанд байгаа гэрч хохирогчид ойлгуулах) шуурхай байх, хамтран ажиллах, гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

¹⁹⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 5.

¹⁹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6.

²⁰⁰ Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17.2.4.

²⁰¹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32.9

Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.

Гэрч, хохирогчийг нүүлгэн шилжүүлэх

Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ.

Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

17 дугаар зүйл. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

17.1. Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт аууулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

Шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, баталж мөрдүүлнэ.

Сэжигтэн, яллагдагч хүүхдийн эрх

Тухайн хүүхдийг зөвхөн гэмт хэрэгт сэрдэж байгаа тохиолдолд сэжигтнээр тооцдог бол харин гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон нотолгоог үндэслэн яллагдагчаар тооцдог. Хүүхэд ямар хэргээр сэжигтэн болсноо мэдэхгүй байвал энэ талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тайлбарлаж өгөөгүй, хүүхдийн ямар хэргээр сэжигтэн болсноо мэдэх эрхийг нь хангаагүй байна гэж ойлгож болно.

Хүүхэд сэжиглэгдсэн тохиолдолд нэн тэргүүнд хууль ёсны төлөөлөгчийн мэдэх ёстой зүйл нь:

-Хүүхэд холбогдсон хэрэгт заавал өмгөөлөгч оролцох ёстой.

Хүүхдэд өмгөөлөгч заавал авах үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй. Ийм учраас хүүхдийн хэрэгт сурган хүмүүжүүлэгчээр оролцож байгаа багш, нийгмийн ажилтан нь хуулийн байгууллагын ажилтан, мөрдөн байцаагч, прокуророос өмгөөлөгчөөр хангахыг шаардаж аль болох хамгийн богино хугацаанд хүүхдийг өмгөөлүүлэх бололцоогоор хангах нь чухал.

Оройтож өмгөөлөгч авах эсвэл хүүхдийн хэрэгт өмгөөлөгч оролцуулаагүйгээс хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөл үүсч болох талтай тул багш энэ асуудалд санаачлагатай оролцож, Өмгөөлөгчдийн Холбооны гишүүдийн нэрсийн жагсаалттай танилцах, эсвэл өмгөөллийн товчоонд хандаж болно. Өмгөөллийн тухай хуулинд зааснаар өмгөөлөгч нь жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх, өмгөөллийн холбооны томилолтыг биелүүлэх үүрэгтэй байдаг. Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа багш нь тухайн хүүхэд төлбөрийн чадваргүй бол хуулийн дээрхи заалтыг ашиглан өмгөөлөгч томилж өгөхийг хүссэн албан бичгийг сургуулийн захиргаа эсвэл цагдаагийн байгууллагаар хийлгэж, Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлэн асуудлыг шийдвэрлэж болно.

-Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх

Зарим эцэг эхчүүд хүүхдээ гэмт хэрэг үйлдсэнийг гэнэт дуулаад өөрсдөө зодож шийтгэхийг урьтал болгодог. Мөн хохирогчдын гэр бүлийнхний зүгээс заналхийлэх явдал ч гардаг. Энэ тохиолдолд хүүхдийн хамгаалуулах эрхийг хангахын тулд нийгмийн ажилтан гэр бүлийнхэнтэй нь ажиллах шаардлагатай. Хүүхэд хийсэн хэргийнхээ төлөө шаналан, ичиж эмээж өөрийгөө өөрөө шийтгэж байхад нь нэрмээс болохгүй байх талаар ойлгуулж, хүүхдийн хүчирхийлэл бол гэмт үйлдэл гэж таниулах нь зүйтэй. Хэрвээ хүүхэд, гэр бүлийн гишүүдийн хооронд энэ

мэт зөрчил, маргаан байвал харилцааг сайжруулах, бие биеэ ойлгох боломж олгох зөвлөгөө засал өгөх хэрэгтэй. Мөн хүүхдийн оршин сууж байгаа хорооны хэсгийн байцаагчтай холбоо тогтоож хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар идэвхитэй алхам хийж болно.

-Хүүхэд сэжигтэн, яллагдагч болж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хууль ёсны төлөөлөгчтэй байх эрхтэй.

Мөрдөгчийн тогтоолоор насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгчийг тогтоож, түүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад ямар эрхтэй оролцохыг тайлбарлана. Хууль ёсны төлөөлөгчөөр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтооно.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч нь дор дурдсан эрхтэй:

- Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг ямар хэрэгт сэрдэгдэж байгааг мэдэх;
- Яллагдагчаар тогтоогдож, мэдүүлэг байлцах;
- Байцаалт болон сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгчийг байлцуулан хийж байгаа бусад ажиллагаанд мөрдөгчийн зөвшөөрснөөр оролцох;
- Байлцсан ажиллагааны талаар саналаа бичгээр өгөх;
- Нотлох баримтын ач холбогдол бүхий зүйлийг шалгуулах хүсэлт тавих эрхтэй.

Хэрвээ амьдралын элдэв шалтгаанаар хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр томилох хүн байхгүй бол багш, нийгмийн ажилтан өөрөө байлцахаар санал тавьж болно. Нийгмийн ажилтны хийж гүйцэтгэж байгаа ажлаар нь тэднийг сурган хүмүүжүүлэгч гэж тооцож болох тул өнөөгийн хуулийн хүрээнд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч гэж тооцож болох боломжтой.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад сурган хүмүүжүүлэгчийг байлцуулж болох ба оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй гэж үзвэл сурган хүмүүжүүлэгчийг заавал байлцуулна.

Сурган хүмүүжүүлэгч нь насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн бодол санаагаа хэрхэн илэрхийлж байгаа, түүний хэлсэн тодорхой үг, өгүүлбэрийг яаж ойлгож болох зэргийг сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс тайлбарлах үүрэгтэй мэргэжилтний хувиар мэдүүлэг өгөхөд байлцана.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаахад байлцсан сурган хүмүүжүүлэгч нь мөрдөгчийн зөвшөөрснөөр сэжигтэн, яллагдагчид асуулт тавих эрхтэй.

Мэдүүлэг авч дууссаны дараа түүнд байлцсан сурган хүмүүжүүлэгч тэмдэглэлтэй танилцах ба түүнд бичигдсэн зүйл бүрэн зөв болсон эсэх талаар саналаа бичгээр өгөх эрхтэй.

Хуулийн байгууллагаас хөнгөн хэрэгт сэрдэгдсэн сэжигтэн, яллагдагч хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийнх нь хяналтад гадуур байлгаж мэдүүлэг авахаар дуудаж ирүүлдэг. Зарим мөрдөгч хүүхдийг олон дахин ирүүлж гаднаа олон цагаар хүлээлгэх, сургуульд нь зарлан дуудах хуудсаар дуудлага явуулах зэрэг нь хүүхдийг хашраах, улмаар хэргээ хурдан хүлээхэд хэрэгтэй гэж үздэг.

Насанд хүрээгүй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл мөрдөгч нь насанд хүрээгүй яллагдагчид хэргийн материалыг танилцуулахад түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг оролцуулахгүй байж болно. Энэ нь хүүхдийн талаар сөрөг мэдээлэл тараах боломжтой, эсвэл хүүхдийн эсрэг ашиг сонирхолтой, эрх хөндөгдөхөөр байвал оролцуулахгүй гэсэн үг юм.

Шүүгдэгч хүүхдийн эрх: Хүн бүр эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас ял шийтгүүлэх буюу иргэний шүүн таслах ажиллагаагаар эрх, үүргээ тодорхойлуулахдаа хэргээ хуулийн дагуу байгуулагдсан эрх мэдэл бүхий, бие даасан, шударга шүүхээр нээлттэй хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй. Эрүүгийн гэмт хэрэгт шүүгдэж байгаа хэн боловч шүүх ажиллагаанд биеэр оролцох, өөрийгөө өмгөөлөх буюу сонгож авсан өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх, өөрийн эсрэг мэдүүлж

байгаа гэрчийг байцаах буюу байцаахыг шаардах, орчуулагч авах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээр хангагдана.

Хүүхэд нь аль нэг талын ашиг сонирхлыг баримтлаагүй хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх ёстой. Шүүх бол зөвхөн ял шийтгэл оноох биш хууль зүйн туслалцааг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдийг нь байлцуулан үнэ төлбөргүй үзүүлэх ёстой. Хэргээ шүүлгэж байгаа хүүхэд шүүхийн өмнө өөрийгөө өмгөөлж гэрчид асуулт тавих эрхтэй байдаг.

Дүгнэлт

Хүүхэд гэмт хэрэгт өртөж хохирсон эсхүл гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүрт хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагад хандаж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэх ямар тусламж үйлчилгээ шаардлагатайг тогтоолгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулж, эрхийг нь хангадаг байх хэрэгтэй.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хууль ёсны төлөөлөгч томилуулж оролцуулах, өмгөөлөгч /*ихэнх тохиолдолд төлбөрийн чадваргүй байдаг*/ ийг, сонгон авах, үйл ажиллагаа хүндрэлтэй. Амралтын өдөр, эсхүл шөнийн цагаар үнэ төлбөргүй өмгөөлөл, хууль зүйн туслалцаа өгч, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох асуудлыг Хууль зүйн туслалцааны төвөөс хууль ёсны төлөөлөгч оролцуулах асуудлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь хэргийг бүрэн нотлох, шуурхай шийдвэрлэхэд ач холбогдолтой боловч дийлэнх тохиолдолд шөнийн болон ажлын бус цагаар явуулж буй мөрдөн шалгах ажиллагаанд дурдсан байгууллагын төлөөллийг оролцуулах ажиллагаа хангалттай бус байна.

Нөгөө талаар гэмт хэргийн халдлагад өртсөн хохирогчдын нээлттэй чөлөөтэй ярилцах, хууль зүйн туслалцаа авах оролцогч нь өмгөөлөгч тул энэ чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгчдийг бэлтгэх, өмгөөллийн төлбөрийг үл харгалзан оролцуулдаг болгох тогтолцоог бий болгох шаардлагатай.

Гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг бол гэр бүлийн орчин, эцэг, эхээс хүүхдэд тавих анхаарал халамж, шүүлтүүргүй цахим орчны хэрэглээ, хүүхдийн хүмүүжил, ухамсарт нөлөөлөх гэр бүл салалт, хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үл хайхарсан, хараа хяналт суларсан, өөрийнх нь хэрэгцээг хангаж чадахгүй байгаа зэргээс хүүхэд гэрээсээ дайжих, бүлэг бөөгнөрөл үүсгэн нийтийн байр түрээслэн хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийг амьжиргааны эх үүсгэвэр болгох, амар хялбар аргаар мөнгөтэй болохоор гэмт хэрэг үйлдэх, олсон мөнгөөрөө хоногийн хоол хүнс, хэрэгцээт зүйлс авахаасаа илүүтэй цахим тоглоом тоглох, архидан согтуурах, үзвэр үзэх зэргээр зугаацахад зарцуулж байна.

Иймд эмзэг бүлгийн болон гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, хүүхэд хамгааллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй хэлтэс, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, хүүхдийн байцаагч нартай хамтран эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан хөтөлбөрийг боловсруулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй.

Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон хүүхдүүд урьд нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд өөрсдийн эрхийг хэрхэн хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй байгааг харуулж байна. Мөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, сэтгэл санааны хохирлоо хэрхэн барагдуулах, түүнийг тооцох аргачлал тодорхой бус байгаа, мөн эрүүгийн болон иргэний шүүхээр олон шат дамжлага дамжиж явах нь тэднийг хохирлоо бүрэн барагдуулахад хүндрэл бэрхшээлтэй байгааг дурдах нь зүйтэй.

Ном зүй

Монгол Улсын олон улсын гэрээ

- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (1989)
- Хүүхдийн Эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам. 2017 он./ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 дүгээр тушаалын нэгдүгээр/

Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)
- Гэр бүлийн тухай хууль (1999)
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)
- Нийгмийн халамжийн тухай хууль (2012)
- Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль (1999)
- Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль (2013)
- Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)
- Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)
- Эрүүгийн хууль (2015)
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль (2017)

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХОРОО ХАРИУЦСАН ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

*Д.Бат-Орших
Хууль зүйн магистр*

Товч агуулга: Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагаа нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын харьяалах нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг олж тогтоох, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр ажилладаг. Энэхүү өгүүлэлд хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, ажлын ачаалал, тулгамдаж буй асуудал, ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох талаар тусгасан.

Түлхүүр үг: Эрүүгийн мөрдөгч, хороо, хууль, ажлын байрны тодорхойлолт, ажлын ачаалал, гэмт хэрэг.

1.Эрх зүйн зохицуулалтын асуудал

Хууль, тогтоомжийг нийгмийн хөгжилтэй уялдуулан боловсронгуй болгох асуудал нь тасралтгүй байнгын шинжтэй, цагийн зүүний хүрд мэт эргэлдэн хэрэгжих үйл явц бөгөөд хууль тогтоомжийг шинээр батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах зэргээр төгөлдөржүүлэн нийгмийн харилцааг зохицуулан, хэрэгцээ шаардлагыг хангаж байх зүй тогтолтой.

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай нь тухайн нийгмийн харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх, амьдралд хэрхэн нийцэн хэрэгжиж байгаа байдал, Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчдын ажилд яаж нөлөөлж байгаа зэрэгт зарим судалгаа явуулж санал бодлоо хуваалцахыг зорилоо.

Нийслэл Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын 50 хувиас дээш хувь нь ажиллаж амьдарч, цагдаагийн байгууллагад жилд бүртгэгдэж байгаа нийт гэмт хэргийн 60 орчим хувь нь Нийслэл хотын дүүргүүдэд үйлдэгддэг.

Засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны нутаг дэвсгэрт нууц далд аргаар, зохион байгуулалттай, захиалгаар үйлдэгдсэн гэмт хэрэгтэй тэмцэхэд тодорхой хүндрэл үүсэж байна. Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн нэг нь гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох явдал юм. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн гаралт корона вируст халдвартай холбоотойгоор буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хүнд, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тоо өсөж, түүнийг мэргэжлийн өндөр ур чадвараар илрүүлэх гэмт этгээдийг олж тогтоох нь цагдаагийн байгууллагын нэн тэргүүний чухал зорилт болоод байгаа билээ.

Өмнө нь мөрдөгдөж байсан Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар Эрүүгийн цагдаагийн алба, ажилтан нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрхгүй. Харин 2017 оноос хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, албан тушаалын нэршил өөрчлөгдсөнөөр Эрүүгийн төлөөлөгч гэх нэршлийг Эрүүгийн мөрдөгч болгон өөрчилж, хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн нөхцөл үүссэн бөгөөд хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, харъяалалын дагуу шилжүүлэх ажиллагаануудыг хийж хэрэгжүүлж ажиллаж байгаа нь Гүйцэтгэх ажлын чиглэлийн ажил, арга хэмжээ сүүлийн 3 жилийн хугацаанд буурч гэмт хэрэг илрүүлэх нууц далд аргаар үйлдэгдэж байгаа хэргийг гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлэх, туслах хүчний сүлжээ зохион байгуулах ажил чанаргүйдсэн

үзүүлэлттэй байгаа нь хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн хувьд тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байна.

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн эрх зүйн зохицуулалт, ажил үүргийн онцлог болон хариуцсан нутаг дэвсгэртээ гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохион явуулах үндсэн суурь болох гүйцэтгэх ажлын нөхцөл байдлын ойлголт, шинж бүрдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, үнэлэн дүгнэснээр Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчөөс хариуцсан хороо, харьяа дүүрэгтээ гүйцэтгэх ажлын сүлжээг зөв зохион байгуулах, хүч хэрэгслийг оновчтой байршуулах, нууц далд, зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон үйлдсэн байж болох сэжигтэй этгээдүүдийн талаарх мэдээ, мэдээллийг олж авах зэргээр гүйцэтгэх ажлын арга хэмжээг зохион явуулах асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

2.Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагааны асуудал

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн тасагт харяалагддагаараа бусад алба нэгжийн эрүүгийн мөрдөгчдөөс онцлогтой. Жишээ нь Хар тамхитай тэмцэх газрын эрүүгийн мөрдөгч зөвхөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр ажилладаг бол хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэнгүй хэрэг шалгахаас гадна сэжигтэй этгээдүүд, сэжигтэй объектын судалгааг хийж, өөрийн нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдэж байгаа болон үйлдхээр бэлтгэж байгаа бүхий л төрлийн гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн албаны чиглэл хариуцсан хэлтэс, тасагтай хамтарч илрүүлэх, таслан зогсоох чиглэлийн ажлыг хийдэг учир албан тушаалын хувьд маш их туршлага хуримтлуулах боломжтой, хамгийн их ачаалалтай ажилладаг нэгж юм.

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотойгоор цагдаагийн байгууллагаас албан тушаалын нэршил, бүтэц, орон тоог өөрчилж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн тасгуудын орон тоог 4-5 хүнээр нэмж, Мөрдөн байцаах тасагт ажиллаж байсан мөрдөгчдийг Эрүүгийн цагдаагийн тасагт шилжүүлэн томилогдсон нэг тасагт дунджаар хариуцсан хороо нутаг дэвсгэрээс шалтгаалж 15-20 эрүүгийн мөрдөгчтэй, хэрэг бүртгэлтийн 1700-1800 хэрэгтэй тухайн цаг хугацаанд ажиллаж байсан бөгөөд эрүүгийн мөрдөгчдийн гүйцэтгэх ажил явуулах, мэдээ мэдээлэл цуглуулах ажил орхигдож зөвхөн хэрэг бүртгэлтийн хэрэгт процессийн зөрчил гаргахгүй, хэргийн хугацаа алдахгүй, прокурорын шаардлага авахгүй гэсэн бодолтой байсан үе энүүхэнд санагдаж байна. Хуулийн өөрчлөлтөөр хэрэг бүртгэлтийн хэрэг шалгаж, ачаалалтай байх үед цагдаагийн байгууллагаас 2017-2020 онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон бусад албанд шилжин томилогдсон алба хаагчдын 70 хувь нь хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч байсан нь цалин хөлс бага, ажлын ачаалал ихтэй холбоотой бөгөөд цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн хэргийг шийдвэрлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсны үр дүнд нэг тасагт одоогоор 500-800 хэрэг бүртгэлтийн хэрэгтэй байгаа нь ачаалал өмнөх онуудаас 2-3 дахин буурсан байгаа нь эерэг үзүүлэлт боловч гүйцэтгэх ажлын чиглэл мөн л орхигдсон хэвээр байгаа.

Хэдийгээр хэрэг бүртгэлтийн хэрэг шалгахын хажуугаар гүйцэтгэх ажлыг хариуцсан хороо, дүүргийн нутаг дэвсгэртээ явуулж үндсэн ажлаа хийж байгаа боловч нэг эрүүгийн мөрдөгчийн ажлын зураг авалт хийж үзэхэд, цаг хугацааны хувьд 70/30 буюу сарын нийт ажлын 70 хувь нь хэрэг бүртгэлт үлдсэн 30 хувь нь гүйцэтгэх ажлын чиглэлийн ажил хийж байгаа нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хувьд хариуцсан нутаг дэвсгэртээ гүйцэтгэх ажил арга хэмжээ явуулахад ихээхэн хүндрэлтэй байгааг нэг шалтгаан болоод байна.

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн ажлын байрны тодорхойлолтонд хэрэг бүртгэлтийн хэрэг шалгах гэсэн асуудлыг хассанаар хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гүйцэтгэх ажлыг идэвхтэй зохион байгуулж, нууц далд аргаар үйлдэгдэж

байгаа болон эзэнгүй хэргүүд дээр ажиллах цаг хугацаа ихсэснээр хэргийн илрүүлэлт, алба хаагчдын ажлын ачаалал тэнцвэржиж эрүүгийн мөрдөгчийн албан тушаалд тогтвортой ажиллах нөхцөл болно гэж үзэж байна.

3.Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн ажлын ачааллын талаар

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчдийн ажлын ачааллыг дүүргийн хэмжээнд судлах зорилгоор Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нарын ажлын ачааллыг дүн шинжилгээний аргыг ашиглаж дараах судалгааг гаргажээ.

Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэр нь **9** хороо **305.3** га газар нутагтай, **51810** хүн амтай, **15243** өрх, **312** орон сууц, барилга, байгууламжтай, **4720** аж ахуйн нэгж, байгууллага, **13** худалдаа үйлчилгээний төв, их дээд сургууль, оюутны байр болон хүн ам ихээр төвлөрдөг дэд бүтэц эрчимтэй хөгжсөн нийслэлийн төвийн дүүрэг юм. Тус дүүрэг нь зүүн талаараа Баянзүрх дүүрэг, баруун талаараа Чингэлтэй дүүрэг, урд талаараа Хан-Уул дүүрэг, хойд талаараа Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан газар нутагтай хил залган оршдог нийслэлийн хүн амын нийт **7.6** хувь нь тус цагдаагийн хэлтсийн хариуцсан дүүргийн нутаг дэвсгэрт оршин сууж байна. Хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалж Сүхбаатарын талбай дээрх жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлж мэдээ мэдээлэл цуглуулан ажилладаг.

Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасаг нь ЦЕГ-ын даргын 2017 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн тушаалаар Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга 1, эрүүгийн ахлах мөрдөгч 2, эрүүгийн мөрдөгч 15 нийт 18 алба хаагчтайгаар ажиллахаар орон тоо батлагдсан байна.

Тус тасгийн алба хаагчид нь 2021 оны эхний 9 сарын байдлаар иргэд, байгууллагаас гаргасан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл нийт 1797 хүлээн авч шалгаснаас 378-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, харъяаллын дагуу 46 гомдлыг шилжүүлж, 762 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Шалгасан гомдол, мэдээллийг нэг алба хаагчид хувааж дунджаар тооцвол эхний 9 сарын байдлаар 1 эрүүгийн мөрдөгч 120-130 гомдол мэдээлэл, 1 сард 15-20 гомдлын материал шалгаж ачаалал ихтэй ажилласныг харуулж байна.

Эхний 9 сарын байдлаар Эрүүгийн цагдаагийн тасаг нь нийт 1875 хэрэг бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулснаас 788 хэргийг илрүүлж, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн, 46 хэргийг харъяаллын дагуу шилжүүлсэн, 1308 хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хааж шийдвэрлэсэн ба одоо 1489 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн тоог 1 алба хаагчид хувааж дунджаар тооцвол 9 сарын хугацаанд 1 эрүүгийн мөрдөгч 100-120 хэрэг бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулж ачаалал ихтэй ажилласан байна.

Одоо гар дээр шалгагдаж байгаа хэрэг бүртгэлтийн хэрэгт ачааллыг хувааж тооцвол нэг алба хаагч дунджаар 110-120 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Эрүүгийн цагдаагийн тасаг нь хэлтсийн илрүүлэлтийг хариуцахаас гадна эрүүгийн мөрдөгч бүрт урьд хөтлөгдөж хэвшисэн бүртгэл, судалгаанууд хөтлөгдөж байгаа ба улирал, хагас, бүтэн жилээр биелэлтийг гаргадаг Эрүүгийн цагдаагийн албанд хүргүүлэх албан даалгавруудын биелэлт, сар бүр Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газраас болон Эрүүгийн цагдаагийн албаны харъяа хэлтсүүд, бусад албадаас зохион явуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний явц, үр дүнг хариуцан ажилладаг.

Тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг сайжруулах арга зам талаар:

Эрүүгийн цагдаагийн тасгийн хэмжээнд нийт 1489 хэрэг бүртгэлтийн хэрэг шалгагдаж байгаа бөгөөд тухайн хэргүүдийг хорооны зохион байгуулалтын дагуу шалгаж ажиллах явцад ачаалал тэнцвэржүүлэх зорилгоор ачаалал ихтэй 1, 8 дугаар хороонд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулах тус бүр 3 алба хаагчийг ажиллуулж байна.

Хэдийгээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч эзэн холбогдогч тодорхой залилан мэхлэх гэмт хэргүүдэд хийгдэх процессын ажиллагаа, прокурорын байгууллагаас ирүүлж байгаа даалгавар, тогтоол, өдөр тутамд цохогдох өргөдөл гомдлуудад хийгдэж буй ажиллагаа их байгаа зэрэгтэй холбоотойгоор эзэн холбогдогч тодорхой боловч эрэн сурважлагдаж байгаа этгээдийн байгаа газрыг тогтоох чиглэлээр мэдээ, мэдээлэл цуглуулан ажиллах ажиллагаа хангалтгүй, үндсэн ажил болох мөрдөн шалгах нууц ажиллагаа чанар, үр дүн хангалтгүй зэрэг сөрөг нөлөөтэй байна.

Тасгийн хэмжээнд нийт шалгагдаж буй хэрэг бүртгэлтийн 1489 хэргийн 422 буюу 28.6% нь шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэг Бусдын эд хөрөнгийн залилан мэхэлж авах гэмт хэрэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээгдсэн хэргүүд эзэлж байгаа ба нийт хэрэг бүртгэлтийн хэргийн 162 буюу 9.07%-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гээгдэл эд хөрөнгөтэй холбоотой гэмт хэргүүд эзэлж байна.

Эрүүгийн мөрдөгч нарын ажлын цаг ашиглалт:

Эрүүгийн мөрдөгч нар нь ажлын цаг ашиглалтыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн мөрдөгчийн хариуцсан хороон дээр эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд эрүүгийн цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн бүгд буюу багаар ажиллаж байна. Мөн хэлтсийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт бага түвшинд байгаа энэ үед зохион байгуулагдаж байгаа арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлэх, явц байдлыг чанаржуулах зорилгоор өдөр тутам 23 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна.

Амралтын өдрүүдэд ажилласан байдал: 7 хоног бүрийн бямба, ням гарагуудад 1-5 дугаар хороо, 6-9 дүгээр хороод хариуцсан эрүүгийн мөрдөгч нараар хуваарилж хуваарьт өдрөө цуглаж, хариуцсан баримт бичгүүдийг цэгцлэх, бүртгэл судалгаагаа бүртгэх ажлыг зохион байгуулж, хариуцсан хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн материал цохогдсон үед хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчдөд албан үүргээ гүйцэтгэхэд учирч буй бэрхшээлийн талаар:

- Ажлын ачаалал эрс нэмэгдүүлсэн;
- Түдгэлзүүлсэн хэргүүдийг ажиллагаанд оруулсан нь зохиомол ачаалал үүсгэсэн;
- Сэжигтнийг баривчлах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэг бүртгэлтийн шатанд 48 цаг байгаа нь хүндрэлтэй байгаа учир 72 цаг болгох саналтай байна. /Учир нь: долоо хоногийн Баасан гарагт таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд ням гарагт гаргадаг. Ням гарагт бусад төрийн байгууллагуудын алба хаагч нар амарч байдаг учир ажиллахад хүндрэлтэй.
- Нэг эрүүгийн өмрдөгчид 100-150 хэрэг бүртгэлтийн хэрэг, 20-25 өргөдөл гомдол байнга шалгаж байна.
- Алба хаагч нар ажлын ачаалал их байгаа учир өглөө 08:30-аас орой 22:00 цаг хүртэл байнга ажиллаж байна. Зарим тохиолдолд хагас, бүтэн сайн өдөр ажиллаж байна.
- Банк, Оюуны өмч улсын бүртгэлийн газар, Автотээврийн газараас лавлагаа мэдээлэл авахад прокурорын зөвшөөрөл шаардаж хугацаа алдаж байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, ЭХХШТХ-ийн хэрэгжүүлэхэд маш их хүндрэл учруулж цаг хугацаа алдах, иргэдийг чирэгдүүлэх асуудал гарч байна.

- Хэрэг бүртгэлтийн хэрэг дээр хилийн хориг тавьж болохгүй байгаа нь гэмт хэргийн холбогдогчийг алдах асуудал гарч байгаа нь үйл ажиллагаанд хүндрэлтэй байна.
- Шинжээчийн дүгнэлт тогтоосон хугацаандаа гардаггүй нөхцөл байдлаас үүдэн хугацаанд шахагдаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээгддэг. /Энэ нь гэмт хэргийн тоо зохиомлоор өсгөх шалтгаан болж байна/
- Хэргийн сэжигтэн байсан ч гэрчээр асуудаг зохицуулалт нь хэрэг шалгах тактикт сөргөөр нөлөөлж байна.
- Яллагдагч нарт таслан сэргийлэх арга хэмжээ авахад хүндрэлтэй болсон.
- Яллагдагч оргон зугтах бүрэн боломжтой. Яллагдагчийн хувийн байдлыг тогтооход прокурорын тогтоолоор авч байгаа чирэгдэл их, хугацаа их алдаж үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Дүгнэлт

Гүйцэтгэх ажлын чиглэлээр хийгдэх ажиллагаа хангалттай түвшинд хүрэхгүй байгаа нь шалгагдаж буй хэрэг бүртгэлтийн хэргийн тоо, тэдгээрт хийгдэж байгаа ажиллагаа болон өдөр тутам бүртгэгдэж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо мэдээнээс хамаарч байна гэж дүгнэж болохоор байна.

Мэдээ, мэдээллийн чанарыг ахиулах, шалгагдаж буй хохирол ихтэй буюу хүнд хэргүүдэд гүйцэтгэх ажлын идэвхтэй арга хэмжээ, мөрдөн шалгах нууц ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвших чиглэлд анхаарахгүй бол хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа хэргүүдийн өнгө жилээс жилд өөрчлөгдөж, түүнийг илрүүлэх эрх бүхий албан тушаалтнуудын ажлын ачаалал өдөр ирэх тусам ихсэж байгаа нь хууль, эрх зүйн зохицуулалт болон цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолтыг өөрчлөх шаардлагатай байгааг харуулж байна.

Хэрэв эрх зүйн зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулахгүй бол хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн ажлын байрны ачааллаас болж ажилдаа хандах хандлага буурч, боловсон хүчний дутагдалд орох эрсдэл үүсч болзошгүй байна.

Санал

Гүйцэтгэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, ачааллыг тэнцвэржүүлж, хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн гүйцэтгэх ажлын идэвхтэй арга хэмжээ болон МШНА-нд чиглүүлж, энэ чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хэвшил болгох, хэргийн илрүүлэлтийг ахиулах, оргодол этгээдийг эрэн сурвалжлах ажилд дэвшил гаргах, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр хэрэг бүртгэлтийн ажиллагааг эрүүгийн мөрдөгчнөөр хийлгэхгүй байх шаардлагатай байна.

ЭХХШТХ-д хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалт нэмэх шаардлагатай.

Ном зүй

- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль.УБ.2002
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018
- Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн тоон мэдээ. УБ. 2021

СУДЛААЧИЙН ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

А.Пүрэвдулам

*Сити их сургуулийн багш, бизнесийн удирдлагын доктор,
ДХИС-ийн докторант*

Товч агуулга: Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, хийдэл, зөрчлийг тодруулж, эрх зүйн зохицуулалт, ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулсан.

Түлхүүр үг: Үл хөдлөх эд хөрөнгө, газар, өмчлөх эрх, эд хөрөнгийн эрхийн бүртгэл.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2-д “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан. Тодруулбал, Газрын тухай хууль (2002), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003) болон “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” (2018) хуулиар тус тус хамгаалжээ. Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу Монгол Улсын иргэнд гэр бүлийн болон аж ахуйн зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэхээр болсон.

Энэ ажил 2003 онд эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 336,106 иргэн буюу нийт хүн амын 11.8 хувь нь 37044.4 га газрыг өмчилж авчээ. Харин хашааны газраа эзэмшиж байгаа 214,068 иргэн, шинэ байршилд 120,184 иргэн гэр бүлийн зориулалтаар газар өмчилсөн бөгөөд 21 аймагт 31627.33 га газрыг нийт хүн амын 15.3 хувь, нийслэлд 4849.62 га газар буюу нийт хүн амын 7.6 хувь нь тус тус газраа үнэ төлбөргүйгээр өмчилж авчээ. Тэгвэл 2018 онд нийслэлд харьяалалтай 9005 иргэнд 21 аймгийн 149 сумдад гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1791.82 га газрыг²⁰² өмчлүүлжээ. Энэ нь хүн амын тоотой харьцуулахад хангалтгүй үзүүлэлт бөгөөд үнэ төлбөргүйгээр 0.07 га газар олгох ажил ахиц багатай явагдаж байгааг харуулсан үзүүлэлт юм. Холбогдох хуулийн зарим зохицуулалтаас шалтгаалж иргэд газрыг гэр бүлийн хэрэгцээний болон аж ахуйн зориулалтаар өмчилж авч чадахгүй байж болох талтай. Иргэдийн газар өмчлөх эрх хэрэгжих эсэх нь тухайн засаг захиргааны нэгжийн газрын албад болон сумын төв, тосгоны тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээс хамаарч байна. Энэхүү судалгаа үл хөдлөх хөрөнгө болох газрыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлэхэд тулгарч буй хууль зүйн асуудлыг тандан судаллаа.

Судалгааны арга зүй: Түүврийг нийслэл болон аймаг, сум, тосгон, гадаадад удаан хугацаагаар оршин сууж буй иргэдээс хамруулан хийсэн бөгөөд судалгаанд 146 иргэн хамрагдсан. Тооцооллыг статистикийн SPSS v22 программ ашиглан гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүн: Холбогдох хуулиудын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд, газар өмчилж авах хүсэлтэй иргэдийн хүсэлт шийдвэрлэгдэхгүй байгаа шалтгаан нь газрын холбогдох төлөвлөгөө, баримт бичиг болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, хот тосгоны тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээс хамаарч байгааг баталлаа. Иргэнд газар өмчлүүлж буй ажлын талаархи иргэдийн сэтгэл ханамжийг судлахад судалгаанд оролцогчдын 65 нь “огт сэтгэл ханамжгүй”, 31 хүн “сэтгэл ханамжгүй” гэж хариулсан байна. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4-д "Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлнэ" заалтыг судалгаанд оролцогчдын 86.3 хувь нь “мэднэ” гэж хариулснаас харахад газар өмчлөх эрхтэй гэдгээ сайн мэдэж байна.

²⁰² Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Нийслэлийн харьяалалтай иргэд Аймаг, сумын газарт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилсөн байдлын судалгаа, 2018

Харин Газрын тухай хуулийн дагуу иргэний эзэмшсэн газар нь Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг түүнд өмчлүүлнэ гэсэн заалтыг судалгаанд оролцогчдын 70 буюу 47.9% хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ. Эндээс иргэд эрх зүй, хуулийн мэдлэгтэй байх, хууль тогтоомж хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд газар өмчлөлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэл илт тод байх, иргэд тогтмол үнэлгээ өгч Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд саналаа өгч тусгуулж байх шаардлагатайг харууллаа.

Удиртгал

Хүний жам ёсны эрхийн нэг бол өмчтэй байх явдал. Энэ үзэл баримтлалтай холбоотойгоор хувийн өмчийн тухай ойлголт, үзэл санаа үүсэн хөгжсөөр иржээ. Тухайлбал, барууны эрх зүйн сэтгэлгээ МЭӨ VI зуунд эртний Грект үндэс сууриа тавьсан бөгөөд “хувийн өмч”, “өмчлөх эрхийн” талаархи сэтгэлгээний хөгжилд чухал нөлөө үзүүлсэн. (Г.Агар-Эрдэнэ “Хувийн өмчийн онол”). Тэгвэл Аристотель / МЭӨ 384-322/ хувийн өмчийн талаарх үзэл санааг дэвшүүлэхдээ өмч хөрөнгийг “гэр бүлийн”, “бүх нийтийн” хэмээн ангилсны гол утга бол өмч хувь хүнд байх нь чухал гэдгийг сануулжээ. ь хүн ямагт хувьдаа өмчтэй байхыг хичээдэг байгалиас заяагдсан хүсэл сонирхолтой.

Хувийн өмч бол тухайн хүний амьдрах гол нөөц, хөрөнгө, баталгаа, барьцаа болж байгаа учраас түүнийг хуулиар хамгаалах шаардлагатай. Эрнандо Сотэ “Капиталийн нууц” бүтээлдээ (2010) Монгол улсад газар “үхмэл хөрөнгө” болж байгаа бөгөөд үүнийг бүртгэж нэн яаралтай эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлагатайг онцолжээ. Иргэдэд газар өмчлүүлэх ажил удаашралтай явагдаж байгаа шалтгаан нь төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын шийдвэр, төлөвлөгөө, баримт бичгүүд чөдөр тушаа болж байгааг энэхүү судалгаа таамаглан хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг шинжилж иргэдээс мөн асуулга авч дүгнэлт гаргахыг зорилоо. Иргэдэд гэр бүлийн хэрэгцээнд зориулж төлбөргүйгээр 0,07 га газар олгох ажлыг эрчимжүүлэн бүртгэлд бүрэн хамруулнаар өрх, иргэн үл хөдлөх эд хөрөгөтэй болох, тухайн газраа эдийн засгийн эргэлтэнд оруулж үр өгөөжийг нь хүртэх боломж өсөн нэмэгдэнэ.

1. Эрх зүйн зохицуулалтын судалгаа, үр дүн

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тус хуульд иргэнд газрыг²⁰³ гэр бүлийн хэрэгцээний болон аж ахуйн зориулалтаар өмчлүүлнэ гэж²⁰⁴ заасан. Газар өмчлөх гэдэгт газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг ойлгоно.

Монгол Улсын иргэнд гэр бүлийн болон аж ахуйн зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэхээр хуульд заасан. Энэ ажил 2003 оноос эхэлсэн бөгөөд 21 аймагт 31627.33 га газрыг нийт хүн амын 15.3 хувь, нийслэлд 4849.62 га газар буюу нийт хүн амын 7.6 хувь нь тус тус газраа үнэ төлбөргүй өмчилж авсан байна. Гэр бүлийн зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлэх газар нь байршлаасаа хамаарч дараах хэмжээтэй байхаар хуульчлагджээ.

Хүснэгт 1. Иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ (га-гаар)

Иргэнд өмчлүүлэх газрын байршил		Хэмжээ /га/
1.	Нийслэлд	0.07 хүртэл га
2.	Аймгийн төвд	0.35 хүртэл га
3.	Сумын төв, тосгонд	0.5 хүртэл га
4.	Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай	0.07 хүртэл га

²⁰³ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 3.1.1-д зааснаар газар гэж газрын гадаргуу, түүний хөрс, ургамал бүхий орон зайн давхаргыг ойлгоно.

²⁰⁴ Монгол улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай /2002 он/ хуулийн 4 дүгээр зүйл.

Тайлбар: Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар уг хуулийн 7 дугаар зүйлд нэмэлт оруулснаар иргэд улсын чанартай дээрх авто зам дагуу газар өмчлөх боломжтой болсон байна.

Нийслэл хотын орон сууцанд амьдардаг зуслангийн газартай иргэд тухайн газраа өмчилж авах хүсэлтэй байдаг. Гэтэл өндөр хүчдэлийн цахилгаан утас дайрсан, эсхүл авто зам барих төлөвлөгөөнд орсон зэрэг шалтгаанаар зуслангийн газар эзэмшиж байгаа иргэдэд өмчлөх эрхийг олгохгүй удааширсаар байна. Зуслангийн газрыг тухайн зуслангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг тодорхойлохын зэрэгцээ орц, гарцын зохицуулалтыг шаардлагатай газруудад хийж байж өмчлүүлэх боломжтойг газрын мэргэжилтэн, судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг.

Нийслэлийн хувьд Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт иргэдийн зуслангийн зориулалтаар эзэмшиж байгаа газрыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд урьдчилсан тооллого, судалгаа хийж 47943 нэгж талбар байгаагаас 24793 нэгж талбарыг өмчлүүлэх боломжтой гэсэн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гарсан байдаг.

Иргэдийн зайлшгүй мэдэх, мөрдөж байх хууль, холбогдох заалт бол Монгол Улсын Үндсэн хуулийн 5.2-д “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална; 6.3-д Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно”. Мөн тус хуулийн 16 дугаар зүйлийн 3-д “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” хэмээн баталгаажуулж өгсөн. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө гэсэн заалт мөн үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалж өгсөн зохицуулалт болжээ. Дээрх заалттай холбоотой иргэний өрх зөрчигдсөн гэж үзвэл төрийн захиргааны байгууллагад гомдол, шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээлттэй гэсэн үг юм.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.1-д “Газар өмчлүүлэх арга хэмжээг газар өмчлөн авахыг хүссэн иргэний сайн дурын үндсэн дээр зөвхөн энэ хуульд заасан зориулалтаар төр, олон нийтийн хяналтын дор ил тод явуулах”-ыг хуульчилсан хэдий ч төр, олон нийтийн хяналт тавьдаггүй, мөн тухайн сум, дүүргийн иргэд бүрэн оролцдоггүй, тэднээс санал авдаг эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Дээрх хуулийн 5.1.2-д Иргэнд газар тариалангийнхаас бусад зориулалтаар газар өмчлүүлэхдээ “аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (АНГЗБЕТ), аймгийн төвийн болон хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө (АТБХХЕТБХТ), сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд (СДТЖГЗБТ) тусгагдсан, сумын төв, тосгоны тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт заасан иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, газар өмчилж авахыг хүссэн иргэдийн тоог иш үндэс болгох” хэмээн хуульчилсан ч иргэд өөрсдийн ахуй амьдралд хэрэгтэй байгаа газраа сонгох, мөн хүн бүрт газар өмчилж авах боломж хязгаарлагдмал байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд “иргэнд газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлэхдээ тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн газар тариалан хөгжүүлэх хэтийн болон тухайн жилийн төлөвлөгөөнд заасан иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, газар өмчилж авахыг хүссэн иргэдийн тоог иш үндэс болгох тухай” заалт мөн тусгагдсан. Тухайн жил эсхүл ойрын хугацаанд хаана байрлалтай, хэдий хэмжээний газрыг иргэдэд тариулангийн зориулалтаар өмчлүүлэх, холбогдох төлөвлөгөөний хэрэгжилт тухайн орон нутгийн иргэдэд танилцуулагдаж ил тод байхыг нутгийн иргэд шаардаж байгаа.

Иргэнд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх тохиолдолд газар зохион байгуулалт²⁰⁵ заавал хийгдэх ёстой бөгөөд үүнийг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан Газар зохион байгуулалт хийх журамд заасны дагуу мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ. Уг журмын 3-д хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын судалгааг хийж, хэмжилт, бүртгэл, зураглал үйлдэх, тэдгээрийн хил, заагийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох; 5/ улс, бүс нутгийн хэмжээгээр ашиглах, хамгаалах газрын хэтийн төлөвийг тогтоож, бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахаар зохицуулж өгчээ. Дээрх зохицуулалтын үр нөлөө иргэдэд бодитой харагдахгүй, иргэдийн “газар өмчлөх хүсэлт” хүлээлтийн байдалтай байна. Газар өмчлөлтэй холбоотой асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад харъяалуулсан. Энэ нь “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуульд (ЗЗНДНТУ) “газрын нэгдмэл сангийн данс бүртгэлийг хөтлөх, тайлан гаргах, нутаг дэвсгэртээ газар зохион байгуулалт хийх тухай шийдвэр гаргаж, Засгийн газраас тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэх” хэмээн тусгагдсан. 2018 оны газар харилцааны албан тайлангийн дүнгээр гэр хорооллын газар 4.5 мянган га-аар өссөн нь нийслэл, орон нутагт Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлж, өмчлүүлж байгаатай холбоотой юм. Хэдий тийм боловч гэр хорооллын дахин төлөвлөлтөөр гэр хорооллын газраа худалдсан иргэд орон сууцтай болсон эсэх тодорхой бус байна. Мөн тайлант онд уурхайн газар 14.4 мянган га-аар өссөн нь Дорноговь аймагт уурхайн газар 45.0 мян.га, Баянхонгор, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудад тус бүр 174.2 га-гаас 4087.3 га-аар тус тус нэмэгдсэнтэй холбоотой юм (Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны ажлын тайлангаас). Газар эзэмших болон өмчлөхтэй холбоотой гомдлыг дээд шатны захиргааны байгууллагад хуулийн²⁰⁶ дагуу гаргана гэжээ. Энэ талаарх тоон мэдээ, тайлан хангалттай бус мөн хүртээмжгүй.

Газрын тухай хуулийн 4.1.6-д газар зохион байгуулалтын төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах тухай заалтыг 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн байна. Энэ нь олзуурхууштай заалт бөгөөд 2015 оноос өмнө газар зохион байгуулалтын төлөвлөлтөд иргэд оролцдоггүй байсан нь харагдаж байна. Энэ заалтыг сурталчилж иргэдийн оролцоог хангаснаар газар өмчлөх, хяналт тавих, мэдээлэх ажилд ахиц үр дүн гарна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4-д Монгол Улсын иргэнд энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар (гэр бүлийн хэрэгцээний) газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлнэ гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй байна. 2019 оны эцсийн байдлаар санамсаргүй түүврийн аргаар 219 иргэнээс нэг удаа төлбөргүй олгох 0.07 га газраа өмчилж авсан эсэх талаар асуулга явуулахад ердөө 2 иргэн 0.07 га газраа өмчлөн авсан, 212 иргэн хараахан өмчилж авч чадаагүй гэж хариулжээ.²⁰⁷ **Гэр бүлийн хэрэгцээний** зориулалтаар газрыг өмчлүүлэхдээ “Газрын тухай” хуулийн дагуу иргэний эзэмшсэн газар нь МУИГӨТХ-ийн 5.1.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг түүнд өмчлүүлнэ. Зуслангийн газар эзэмшиж²⁰⁸ буй иргэд газраа өмчилж авч чадахгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод

²⁰⁵ Газрын тухай хуулийн 24.1-д заасан цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор хийх газар зохион байгуулалтаар дараахь ажил гүйцэтгэнэ: 1/ газрыг хэмжээ, хил, заагийг өндөр түвшний нарийвчлал бүхий гео-багажаар газар дээр нь тодорхойлж, газрын зурагт буулгах; 2/ хил, заагийг газар дээр нь тогтоож тэмдэгжүүлэн кадастрын зураглал хийж, актаар хүлээлгэж өгөх.

²⁰⁶ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргах өргөдөл, гомдлын тухай хууль (1999 он)-ийн

²⁰⁷ /А. Пүрэвдулам, “Газрын эрхийн бүртгэл баталгаажуулалт тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд нөлөөлөх нь” судалгааны үр дүнгээс, хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020, №1 /.

²⁰⁸ Газрын тухай хуулийн 3.1.2.“газар өмчлөх” гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг ойлгоно.

байгаа. Газрын албаны мэргэжилтнүүд газар өмчлөх эрхийн зөрчилгүй бол хүсэлтээ гаргаж газраа өмчлөх боломжтой гэж зөвлөдөг. МУИГӨТХ-ийн 7.2-д Нийслэлд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын хэмжээ нь 0.07 га хүртэл байна гээд мөн хуулийн 5.1.4-т гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрын нэг удаа үнэгүй өмчлүүлнэ гэж заасан тул иргэдийн хувьд одоо эзэмшиж байгаа 0.07 га газрыг нэг л удаа өмчлүүлнэ. Хэрэв иргэн хүсвэл эзэмшиж байгаа 0.07 га газраа хүлээлгэн өгч, улмаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө /ГЗБТ/-д иргэдэд өмчлүүлэхээр тусгагдсан, бусдын эзэмших эрх үүсээгүй газраас 0.07 га-даа хүргэн газар өмчлөн авч болно.

2. Асуулгын судалгааны үр дүн

SPSS тооцооллын програм дээр өгөгдлийн шинжилж давтамж, эзлэх хувь болон сэтгэл ханажмийн түвшинг тооцож гаргалаа. Хүснэгт №1-т судалгааны нэгдүгээр хэсэг болох оролцогчдын хүйс, нас, байнга оршин суудаг газар болон 0,07 га газраа өмчилж авсан эсэхийг тандан судалсан.

Хүснэгт №2. Оролцогчдын мэдээлэл

№	Хүн ам зүйн хувьсагч		Тоо	Хувь
1	Хүйс	Эрэгтэй	47	32.2
		Эмэгтэй	99	67.8
2	Нас	18-28	58	39.7
		29-38	43	29.5
		39-48	28	19.2
		49-58	8	5.5
		59-ээс дээш	9	6.2
3	Боловсрол	Бага, дунд	3	2.1
		Бүрэн дунд	18	12.3
		Тусгай дунд	8	4.8
		Дээд /дипломын/	117	80.1
		Боловсролгүй	1	.7
4.	Таны байнга оршин суудаг газар	Улаанбаатар	106	72.6
		Аймгийн төв	21	14.4
		Сумын төв	9	6.2
		Баг	3	2.1
		Хөдөө, тосгон	3	2.1
		Гадаадад удаан хугацаагаар амьдарч байгаа	4	2.7
5	Та 0.07 хүртэл га газар нэг удаа үнэгүй өмчилж авсан уу?	Өмчилж авсан	36	24.7
		Өмчилж авч чадаагүй	110	75.3

Судалгаанд 146 иргэн оролцсон бөгөөд 47 (32.2%) нь эрэгтэй, 99 (67.8%) нь эмэгтэй байна. Насны бүтцийн хувьд оролцогчдын 39.7% (58) нь 18-28 насныхан, 29.5% (43) нь 29-38 насныхан, 19.2% (28) нь 39-48 насныхан, 59-өөс дээш насныхан 6.2% (9), 49-58 насныхан 5.55% (8) тус тус байна.

Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой 117 (80.1%), бүрэн дунд боловсролтой 18 (12.3%), тусгай дунд боловсролтой 8 (4.8%), бага болон бүрэн бус дунд боловсролтой 3 (2.1%) бол боловсролгүй 1 (0.7%) тус тус байна. Судалгаанд оролцогчдын 72.6 хувь нь Улаанбаатар хотод байнга оршин суудаг бол аймгийн төвд 21 (14.4%), сумын төвд 9 (6.2%), гадаадад удаан хугацаагаар ошин суугаа 4 (2.7%) харин баг, хөдөө тосгонд байнга оршин суудаг иргэд тус тус 3 (2.1%) байв.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 0.07 га газар нэг удаа үнэ төлбөргүй өмчилж авсан иргэд 36 буюу 24.7 хувь бол 110 буюу 75.3% нь газар өмчилж авч чадаагүй байна.

Хүснэгт №3. Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн талаар

№	Хуулийн заалт	“Энэхүү заалтыг мэднэ” Давтамж/хувь	“Энэхүү заалтыг мэдэхгүй” Давтамж/хувь
1	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.1 дэх заалт	93/63.7%	53/36.3%
2	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.2 дэх заалт	66/45.2%	80/54.8%
3	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4-д "Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлнэ" заалт	126/86.3%	20/13.7%
4	Газрын тухай хуулийн 3.1.10-д“нэгж талбарын хувийн хэрэг” гэж газар өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхтэй холбоотой цаасан болон цахим баримт бичгийн бүрдлийг хэлнэ”	60/41.1%	86/58.9%
5	"хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын судалгааг хийж, хэмжилт, бүртгэл, зураглал үйлдэх, тэдгээрийн хил, заагийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох тохиолдолд газар зохион байгуулалт хийнэ"	73/50%	73/50%
6	Улс, бүс нутгийн хэмжээгээр ашиглах, хамгаалах газрын хэтийн төлөвийг тогтоож, бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах тохиолдолд газар зохион байгуулалт хийнэ”	58/39.7%	88/60.3%
7	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэхдээ Газрын тухай хуулийн дагуу иргэний эзэмшсэн газар нь МУИГӨТХ-ийн 5.1.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг түүнд өмчлүүлнэ	76/52.1%	70/47.9%
8	Иргэнд газар өмчлүүлэхдээ дараах байршилд өмчлүүлнэ: Үүнд Нийслэлд-0.07 хүртэл га, Аймгийн төвд-0.35 хүртэл га, Сумын төв, тосгонд-0.5 хүртэл га, Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад/-0.07 хүртэл га гэдгийг	87/59.6%	59/40.4%
9	Сум, дүүргийн Засаг дарга Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх эрхтэй гэдгийг	95/65.1%	51/34.9%
10	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх эрхтэй гэдгийг	89/61%	57/39%

11	Газрын тухай хуулийн 4.1.6-д газар зохион байгуулалтын төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах тухай заалтыг 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн.	48/32.9%	95/65.1%
----	--	----------	----------

Хүснэгт №4. Иргэдийн сэтгэл ханамжийн түвшин

№		Сэтгэл ханамжийн түвшин /1-5 түвшин/				
		1 Огт сэтгэл ханамжгүй	2 Сэтгэл ханамжгүй	3 Сэтгэл ханамж дунд	4 Сэтгэл ханамжтай	5 Үнэхээр сэтгэл ханамжтай
1	Иргэнд газар өмчлүүлж буй ажилд та хир сэтгэл ханамжтай байна вэ?	65	31	29	8	13

Дүгнэлт

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 2002 оноос хойш иргэн бүр 0,07 га газар өмчлэх эрхтэй болсон.

Судалгааны үр дүнгээс харахад 146 оролцогчдын дээрх хуулийн дагуу 0.07 га газраа 110 буюу 75.3% нь газар өмчилж авч чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх 110 иргэн газрын харилцааны албанаас “Газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ” аваагүй, хууль ёсны өмчлөгч нь болоогүй гэсэн үг. Сум, дүүргийн газар зохион байгуулагч нь газрын харилцааны талаархи Аймаг, Нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх бодлогыг гардан зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг танилцуулж, тайлагнах, иргэдийн хүсэлтийг хүлээн авч дүүргийн хэмжээнд газрыг үр ашигтай зохистой ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх хамгаалах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, газрын нэгдмэл сангийн бүртгэл хөтлөх, ажлын зураг үйлдэх ажлыг хийж гүйцэтгэх чиг үүрэгтэй.

НИТХ-ын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 28/27 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.2-дахь ухаалаг төлөвлөлт, илт од газрын харилцаа” хэсгийн 2.2.7-д газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгоно гэж тусгасан хэдий ч иргэд газар өмчлөхтэй холбоотой зарим чухал зохицуулалтыг мэдэхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Мөн иргэдэд газар өмчлөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сурталчилах, хяналт тавих, газар өмчлөлийн ажилд иргэдийг оролцуулахгүй байгаа гэж дүгнэж болох юм. Хууль тогтоомжийн заалтыг мэдэхгүй, иргэд хүссэн газраа өмчилж авч чадахгүй байгаа нь Газар өмчлөх ажил иргэдийн хяналтын дор ил тод, нээлттэй явагдахгүй байгааг нотолж байна. Иргэд газар өмчилж авахыг хүссэн ч Улаанбаатар хот болон, төв суурин газарт өмчлөх боломж бүхий газар байхгүй бол энэ тухай иргэдэд мэдэгдэж хотоос захдуу газар олголтыг зохион байгуулах нь зүйтэй. Аймаг, нийслэлийн Засаг дарга газар, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, тэдгээрийн биелэлтийг хангах чиглэлээр Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж биелэлтийг нь хангуулах эрхтэй. Тиймээс Аймаг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас газар өмчлөлтэй холбоотой гаргасан шийдвэр болон “Газрын тухай” болон “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын биелэлтийг хангаж ажиллах шаардлагатай. Тодруулан авч үзвэл ЗЗНДНТУт хуулийн 12.1.7-д нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах эрхтэй. Энэ тухайгаа иргэдэд зайлшгүй тайлагнаж байх нь зүйтэй.

Санал

Судалгааны үр дүнг үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Иргэд хурлын төлөөлөгчөөрөө дамжуулан газар өмчлөлтэй холбоотой өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх боломжтой. Энэ дагуу иргэд идэвхитэй, оролцоотой байх
- Газрын тухай хууль тогтоомж сурталчлах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.
- Иргэд эрх зүйн акт, дүрэм, журамтай тогтмол танилцаж байх
- Кадастрын зураг тодорхойгүйгээс газар давхардуулан олгосонтой холбоотойгоор иргэд газраа өмчилж авч чадахгүй байгаа тохиолдлууд цөөнгүй байна. Иймд кадастрын зургийг тодорхой болгох засах ажлыг зохион байгуулж өмчлөлийг хурдасгах шаардлагатай. “Газар зохион байгуулалт”-ыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх, ингэснээр иргэдийн хооронд үүссэн газрын маргаан багасах боломжтой. Газрын маргааныг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэснээр газар өмчлөл нэмэгдэнэ.
- Газрыг хэмжээ, хил, заагийг өндөр түвшний нарийвчлал бүхий гео-багажаар газар дээр нь тодорхойлж, газрын зурагт буулгаснаар иргэд өмчлөлийн газраа цаг алдалгүй өмчилж авах боломж бүрдэнэ.
- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг тухайн газар дээр нь хэмжиж шалгах шаардлагатай.
- Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн талаар шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах, тэдний саналд тулгуурлах ажлыг зохион байгуулах
- Одоо эзэмшиж, ашиглаж байгаа гэр бүлийн хэрэгцээний болон хувийн өмчлөлийн нэг давхар нийтийн орон сууцны хашааны газар, зуслангийн газрыг хууль тогтоомжийн дагуу өмчлүүлж баталгаажуулж дуусгах
- Доод шатны Засаг даргын захирамжийг дээд шатны Засаг дарга хүчингүй болгосноос иргэдийн газар өмчлөх эрх зөрчигдөж байгаа. Иймд газар өмчлөлтэй холбоотой захирамжийг гаргахаас өмнө ямар нэгэн маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч байх
- Иргэдийн зүгээс гаргадаг зөрчил газар өмчлөх ажлыг удаашруулж байж болох талтай. Тухайлбал газрын албанд мэдэгдэлгүй хашаа барих, орц гарц хаах, хашааны газраа сунгах зэрэг зөрчил бусад иргэдийн газраа өмчилж авахад саад болж байна.

Ном зүй

Нэг. Ном, сурах бичиг, гарын авлага

- Агар-Эрдэнэ. Г. Хувийн өмчийн онол. УБ хот 2009 он
- Нарангэрэл.С. “Эрх зүйн толь бичиг” УБ.2008 он
- “Хууль зүйн клиникийн удирдлага-зохион байгуулалт” УБ. 2008 он
- “Хууль зүйн клиник” УБ. 2003 он
- Ясутомо.М.” Хуульчийн ёс зүй” УБ. 2007 он
- The General Principles of EU Administrative Procedural Law, 2017
- Б. Баярсайхан. Эрх зүйн онол
- Ш. Цогтоо. Нийтийн захиргааны удирдлага. УБ, 2012 он
- Захиргааны хэрэг. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ 2013 он.
- Эрнандо До Сота. Капиталийн нууц.
- Б. Баярсайхан. Эрх зүйн онол. 2010, 2015 он
- А. Одгэрэл. Захиргааны эрх зүй, 2004, 2011 он
- Ц. Мөнхдэлгэр. Захиргааны эрх зүй. 2018 он.
- А. Эрдэнэцогт . Захиргааны Процессын эрх зүй. УБ, 2013 он
- Захиргааны эрх зүйн бодлогын хураамж , 2011 он
- Бастиа. Хууль, 2003 он
- Монгол улсын Үндсэн хууль /1992 он/
- Захиргааны Ерөнхий хууль /2016 он/

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар УБ 2000
- " Б.Баярсайхан "Хууль зүйн тайлбар толь УБ 2003
- Б. Батзориг, Л. Отгонбаяр. "Хууль зүйн шинжлэх ухааны ном зүй" УБ 2006 он
- Д.Ганзориг "Захиргааны эрх зүйн тайлбар толь" УБ 2004
- С.Нарангэрэл "Хууль зүйн нэр томъёоны тайлбар толь" УБ 2008
- Д.Чимид "БНМАУ-н захиргааны эрх зүй" УБ 1986
- Ж.Долгорсүрэн "Захиргааны эрх зүй" УБ 1999
- Ж. Долгорсүрэн. "Монгол улсын захиргааны эрх зүйн удиртгал" УБ 2006 он
- Ж.Сүхбаатар "Монгол Улсын Захиргааны эрх зүй" УБ 2000
- Д. Баасанхорол. "Бизнесийн эрх зүй" УБ 2007 он.
- Д. Эрдэнэчимэг, Н. Баярмаа. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа. Гарын авлага. 2017 он.
- В. Энхтамир. Газрын харилцаа., хөрөнгийн бүртгэл. 250 асуултын хариулт. УБ. 2015 он.
- Ian Williamson, Stig Enemark8 Jude Wallac and Abbas Rajabifard. Land Adminstration for Sustainable Development. Тогтвортой хөгжлийн газрын харилцааны удирдлага. ESRI Press Academic. Redlands, California.

Хоёр. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он
- Ашигт малтмалын тухай хууль, 2006 он
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
- Газрын тухай хууль, 2002 он
- Газрын хэвлийн тухай хууль, 1988 он
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009 он
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994 он
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006
- Захиргааны ерөнхий хууль, 2015 он
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
- Зөрчлийн тухай хууль, 2017 он
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, 1995 он
- Статистикийн тухай хууль, 1997 он
- Төрийн албаны тухай хууль, 2017 он
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003 он
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль, 2018 он
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль, 2000 он
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он
- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Газар зохион байгуулалт хийх журам
- Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл /НИТХ-ын 2019 оны 10 сарын 31-ний өдрийн 28/27 дугаар тогтоолоор батлагдсан

МОНГОЛ УЛСЫН НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Ц.Түвшинбаяр
Хууль зүйн магистр

Товч агуулга: Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдлыг шинжлэн судалж, онолын баримжаатай үнэлгээ хийж, сайжруулах, боловсронгуй болгох санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Нутгийн удирдлага, нутгийн удирдлагын тогтолцоо, нутгийн өөрөө удирдах ёс, төрийн удирдлага.

Удиртгал

Нутгийн өөрийн удирдлага гэдэг нь тухайн орон нутгийн уугуул иргэд, оршин суугчид өөрсдийн нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлыг өөрсдөө бие даан хэлэлцэж, шийдвэрлэх, татварын бодлогоор дамжуулж өөрсдийн төсвөө бүрдүүлэх, иргэдийн сонгуулийн байгууллагаар дамжуулж нутгийн удирдлагыг дангаараа буюу төрөөс шилжүүлсэн зарим чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх чадавхи бүхий Үндсэн хуульт ёсны чухал шаардлага” гэж тодорхойлж болно. “Нутгийн удирдлага нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд өөрийн болон төрийн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо, орон нутаг дахь төрийн механизмын гол санаа” юм.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.²⁰⁹

Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухай Хурлын хуралдааны чөлөөт цагт түүний Тэргүүлэгчид мөн.²¹⁰

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ хэмээн Үндсэн хуульд заажээ.²¹¹

Орчин цагийн соёлт нийгмийн хамгийн чухал ололтуудын нэг бол ганцаар захирах ёс халж, ардчилсан ёсыг бэхжүүлэхийг зорьж, тэмүүлсэн явдал мөн. Үүний нэг тод жишээ бол Монгол 1992 онд шинэ Үндсэн хууль баталж, “...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго...” тодорхойлсон билээ. Энэхүү зорилгодоо хүрэх нэг арга зам нь төрийн удирдлагын төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, үүднээс орон нутгийн иргэдэд удирдлагын эрхийг олгосон шийдэл байлаа. Хэдийгээр энэ замаар алхаад 30-аад жилийг ардаа орхисон ч орон нутгийн удирдлагын Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүний хэрэгжилт, эрх зүйн орчны талаар шүүмжлэл, хэлэлцүүлэг өрнөсөөр ирсэн билээ. Тухайлбал, гавьяат хуульч Б.Чимэд “Шинэ парламент Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг түүхий байна, сайтар боловсруулъя гэсээр байтал хуучин хууль, зарлигийг хуулж угсараад баталчихсан”, доктор Ш.Цогтоо, нутгийн өөрийн удирдлагыг ялангуяа социализмын үед нэлээдгүй гажуудуулсан байх бөгөөд өдгөө ч өөрийн гэсэн заяагдмал чиг хандлагаа олж чадахгүй байна²¹² гэж дүгнэсэн бол, доктор Я.Долгоржав “..Цаашдаа төрийн босоо удирдлагын хамрах хүрээ, үзүүлэх үйлчилгээний хэмжээг багасгаж хэвтээ удирдлагын буюу орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын ажиллах талбар, хариуцах хариуцлагыг өндөржүүлэх чигт дорвитой алхам хийх хэрэгтэй”²¹³ гэсэн бол доктор, дэд профессор С.Нармандах “Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд... нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулна хэмээн зааснаар энэхүү

²⁰⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 59.1

²¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн 59.2

²¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 60.1

²¹² Цогтоо.Ш, “Нийтийн захиргааны удирдлага” УБ., 2011, хууд- 96

²¹³ Чимэд.Б, “ багийн өнгөрсөн одоо ирээдүй-Монгол Улсын төрийн байгууламжийн язгуур нэгж, түүний удирдлага” УБ., 2002, хууд-52

чадамж нь биеллээ олж чадсангүй, харин ч хямрал дагуулж ирлээ гэх зэргээр талаас шүүмжилжээ. Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль нь анх 1992 онд батлагдаж, 2006 онд батлагдсан шинэчилсэн найруулга хийгдэж, үүнээс хойш 2008, 2009, 2010, 2012, 2013, 2015-2020 онуудад, нийт 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд одоо шинэ хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд явж байна. Эрдэмтэн судлаачдын санал, дүгнэлт, эрх зүйн хэм хэмжээний тогтворгүй байдал нь Монгол Улс дахь нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо, үндсэн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтыг эргэн харах, судлан шинжлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна.

1.Нутгийн удирдлагын тогтолцоо

Нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо бүрэлдсэн нь:

Монголчууд бид төрт ёсны он удаан жилийн түүхтэй улс, үндэстэн билээ. Эртний Хүннүгийн нүүдэлчдийн дотроос анх удаа цэрэг-засаг захиргааны зохион байгуулалтын гурвалсан бүтэц, аравтын системийг бий болгосон. Хүннү улсын үес төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ төв, зүүн, баруун гэсэн 3 хэсэгт хувааж, аравтын зохион байгуулалт хийж, Улсын төв хэсгийг шаньюй өөрөө, зүүн, баруун гарыг хааны томилсон вангууд захирч, вангуудад зонхилогчид захирагдах бөгөөд тийм зонхилогч 24 байсан нь тус бүрдээ нэг түмэн морин цэрэгтэй, түмний ноёд ажил хэргээ залгуулахын тулд аравт, зуут, мянгатын дарга нарыг томилдог ба тэдний дундаас үе залгамжлуулан ван, цэргийн томоохон дарга нарыг дэвшүүлдэг байсан талаар түүхэнд тэмдэглэжээ. Хүннүгийн төрийн байгууллын эл онцлог нь хожмын нүүдэлчин Монгол улсын төрийн байгуулалтад хадгалагдсаар ирсэн бөгөөд өргөн уудам газар нутагтай, нүүдэлчин ард иргэдийн хувьд хамгийн ухаалаг шийдэл байсан хэмээн судлаачид дүгнэдэг.

Баримт 1

1912 онд Монгол Улс дөрвөн аймаг, хоёр хязгаар, 129 29 хошуу, 1923 онд 6 аймаг, 110 хошуунд хуваагдаж, хошууны нутаг дэвсгэрийг нь тухайн бүс нутгийн байгаль экологийн онцлог болон нүүдлийн мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаатай уялдан зохицсон байдаг байжээ. 1921-1990 он хүртэл Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь дараах үе шатыг дамжсан иржээ. Үүнд: -1923-1929 онд 10 гэр, баг, сум, хошуу, аймаг - 1927-1931 онд 10 /20/ гэр, сум, хошуу, аймаг -1932-1959 онд баг, сум, аймаг, Улаанбаатар хот, хот нь хороо, хоринтой -1960-1992 онд сум, түүнтэй адил зэрэглэл бүхий орон нутгийн хот, хороо, аймаг -1992 оноос баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэл 1922-1925 онд “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”, “Их шавийн захиргааны дүрэм”, “Ховдын харьяат газрын захиргааны дүрэм”, “Дарьгангийн нутгийн захиргааны дүрэм”, “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж явах дүрэм”-ийг тус тус баталсан байна.

Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь үйл ажиллагааныхаа ерөнхий зарчим, бүтэц, арга хэлбэрийн хувьд өөр хоорондоо ялгаатай байжээ.

Баримт 2

1922 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан “Нутгийн захиргааны дүрэм” нь арван гэрээс эхлээд баг, сум, хошуу, аймаг, Засгийн газар хүртэл бүх шатны засаг, захиргааны байгууллагын бүтэц, чиг үүргийг маш тодорхой заасан байна. 150 өрх бүрийг нэг сум, сумын доторх 50 өрх бүрийг нэг баг болгон тогтоож, хэрэв үлдсэн өрх сум ба багийн тоонд үл хүрэх нь буй аваас 2 хувьд хүрэхийг нь нэг сум буюу баг болгон, үл хүрэхийг нь бусад сум багт хавсаргана гэж заажээ.

Өмнөх түүхэн цаг үеүдэд засаг захиргааны нэгжийн хуваарилалт хийж орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх дүрэм журмыг боловсруулж байсан гэдэг ч нутгийн өөрийн удирдлага сонгодог утгаараа бүрэлдэн бий болж чадаагүй, тийм боломж ч байхгүй байсан гэж хэлж болно. Сонгодог утгаараа “нутгийн удирдлага нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд өөрийн болон төрийн удирдлагыг

хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо, орон нутаг дахь төрийн механизмын гол санаа” юм. ²¹⁴

Өнөөгийн байдал:

Монгол орон ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих үеийн эрх зүйн үндсийг тавьсан шинэ Үндсэн хуулийн /1992 он/-иар төрийн байгуулал, түүний дотор нутгийн удирдлагын тогтолцоог өөрчлөн байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд:

1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. ²¹⁵
2. Монгол улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана гэжээ. ²¹⁶

Мөн Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцооны тухай хуульчлан тогтоож өгсөн байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. ²¹⁷



Нутгийн өөрөө удирдах ёсыг ямар байгууллага хэрэгжүүлэх тухай Монгол улсын үндсэн хуульд заасан байдаг. ²¹⁸

Мөн төрийн удирдлагыг хэрэгжүүлэх субъектыг ч зааж өгсөн байна. ²¹⁹

Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргаас бүрдэж байна.

Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулна гэдгийг тодруулж авч үзсэн байна. “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга, баг хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн засаг дарга тус тус дарвөн жилийн хугацаатай томилно. ²²⁰

Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү зохицуулалт нь ардчилсан нийгмийн нэг чухал үнэт зүйл нь иргэд нь эрх чөлөөтэй, төрийн удирдах хэрэгт шууд болон шууд бусаар оролцох боломжтой байх явдал юм. Иймээс ардчиллыг бэхжүүлж, нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн асуудлуудаа шийдэн, үндэсний тусгаар

²¹⁴ Лүндэндорж.Н., Төрийн онол УБ., 2008, хууд-188

²¹⁵ Монгол улсын Үндсэн хуулийн 2.1

²¹⁶ Монгол улсын Үндсэн хуулийн 2.2

²¹⁷ УИХ-ын тамгын газар (2015). Судалгааны эмхэтгэл. ХХ Боть.

²¹⁸ Монгол улсын Үндсэн хуулийн 59.1

²¹⁹ Монгол улсын Үндсэн хуулийн 60.1

²²⁰ Монгол улсын Үндсэн хуулийн 60.2

тогтнолоо бэхжүүлэхийн тулд юуны өмнө төвлөрлийг сааруулж орон нутгийн бие даасан байдлыг ханган орон нутгийн үр бүтээлтэй удирдлагын тогтолцоо бүрдүүлэх нь чухал байдаг.

Нутгийн өөрийн удирдлага нь “..тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил хэргийг иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэж эрхлэн хөтлөх, хариуцах” чиг үүрэгтэй хэмээн бичжээ.²²¹

Дүгнэлт

Нутгийн өөрийн удирдлага нь хүний язгуур мөн чанартай холбоотой зохион байгуулалтын хэлбэр бөгөөд ардчиллын суурь үндэс юм. Нутгийн өөрийн удирдлагын ухаалаг шийдэл нь улс орны хөгжлийн тулгуур хүчин зүйл мөн. Иймээс уг тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болоход багагүй анхаарал хандуулж, олон онол, үзэл боловсруулж, турших, сайжруулах үйл явц тасралтгүй үргэлжилсээр байна. Манай улсын хувьч мөн адил эртний Хүннүгийн үеэс төрийн тогтолцооны бүрдэл хэсэг байсаар ирсэн бөгөөд өдгөө “Монгол төр”-ийн уламжлалт тогтолцоог төвлөрлийг сааруулж, эрх мэдлийг хуваарилсан “Тэргүүн үгүй” (David Sneath, 2007, р 51) төр, өөрөөр хэлбэл, орон нутгийн өөрийн удирдлагад эрх мэдлийг шилжүүлэх бодлого хүчтэй байсан талаар гадны судлаачид онолын түвшинд авч үзжээ.

Манай судлаачид 1992 оны Үндсэн хуулиар нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог сонгодог утгаар нь бүрдүүлсэн гэж үздэг. Ийнхүү 1992 онд нутгийн удирдлагын бие даасан хууль баталж, 2006 онд шинэчлэн найруулж 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулж, 2020 онд дахин шинэ хуулийн төслийг хэлэлцүүлэх үйл явц өрнөж байна. Манай улсын хувьд нутгийн өөрийн удирдлагыг тойрсон олон асуудал байгаа ч уг судалгааны ажлаар төрийн удирдлага болон нутгийн өөрийн удирдлагын эрх мэдлийн хяналт тэнцвэржилтийн зарим асуудал, нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах эрх хэмжээний асуудлыг онцлон авч үзэв. Үүнд:

1. Нутгийн өөрөө удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмын хэрэгжилтийн зарим асуудал,

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэж зааснаар орон нутгийн удирдлагын гол зарчим болсон билээ. Энэ зохицуулалт бодит байдалд биелэлээ олсон гэж хэлэхэд учир дутагдалтай байна.

Аливаа зүйл хослоно гэдэг бол хоорондоо холилдох биш харилцан шүтэлцээнд зэрэгцэн орших тухай асуудал юм. Энэ агуулгаар авч үзвэл манай улсын хувьд нутгийн өөрөө удирдах ёс, төрийн удирдлага хоёр хоорондоо хослох биш холилдсон байдалтай явж 50 ирсэн. Үүний гол шалтгаан нь Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн төрийн төлөөлөгч буюу Засаг даргыг нутгийн өөрийн удирдлагын байгууллага нэр дэвшүүлэх зохицуулалттай холбоотой гэж үзэж байна. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр энэ зохицуулалтыг залруулаагүй. Үүнээс үүдээд практикт олон хүндэрэлтэй байдал үүсдэг бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд органик хуулийн хүчин чадал хүрэхгүй тул одоо өргөн бариад байгаа шинэ хуулийн төсөлд тусган асуудлыг шийдэх боломжгүй юм. Өмнө тэмдэглэснээр хос ёсны зарчмын талаар дуалист онолын төлөөлөгчид онцолсон ба манайхтай төстэй төрийн байгууламж бүхий улс орнуудад Засгийн газраас томилсон төрийн төлөөлөгч/ төрийн албан хаагч/ хэрэгжүүлдэг. Түүний томилгоонд нутгийн өөрийн удирдлагыг оролцохгүй байхаар хуулиараа зохицуулжээ.

Шийдвэр гаргах эрх хэмжээний тухайд “...нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд юуны өмнө төрийн харьяаллын нутаг дэвсгэрийн нэгж дэх нутгийн бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн боломж статус гэдгийг нь хүлээн зөвшөөрөх ёстой” талаар төрийн үйлчилгээний онолд онцолдог. Манай Үндсэн Хуульд “Нутгийн өөрийн удирдлагын байгууллага ...нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн

²²¹ Чимэд.Б., Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нутгийн удирдлага УБ., 2004, хууд 13)

амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх ...Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно....” гэснээр шийдвэр гаргах эрх хэмжээг тодорхойлсон байна. Ялгангуяа “төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэж хуульд үндэслэхгүйгээр хэм хэмжээ тогтоож, шийдвэр гаргах онцгой бүрэн эрх олгосон. Гэсэн хэдий ч шинээр баталсан Захиргааны ерөнхий хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн зохицуулалтуудын зөрчил, уялдаа холбоогүй байдлаас үүдэж, нутгийн өөрийн удирдлагын шийдвэр гаргах эрх хязгаарлагдах байдал практикт үүссэн. Үүнийг холбогдох хуулиудад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар органик хуулийн түвшинд шийдвэрлэх боломжтой юм. Тухайлбал, Үндсэн хуулийн 62.2-т заасны дагуу гарч буй нутгийн өөрөө удирдах ёсны зарчмын 51 хүрээнд орон нутгийн шинжтэй асуудлыг шийдвэрлэхээр бие даан гаргаж буй хэм хэмжээний акт, хуулиар тусгайлан олгогдсон эрхэд үндэслэн гаргаж буй хэм хэмжээний акт хэмээн үндсэн хоёр төрөлд ангилан ялгаа заагтай авч үзэх, хуульчлах боломж бололцоо бий. Мөн нутгийн өөрөө удирдах байгууллагаас бие дааж гаргасан хэм хэмжээний акт нь нутгийн өөрөө удирдах байгууллагын өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудал мөн эсэхийг шүүхээс хянах тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ байгааг тэмдэглэх нь зүйтэй.

УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЗЭЛ СУРТЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

А.Мөнхцэцэг

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш, магистр

Товч агуулга: Монголын улс төрийн намуудын үзэл суртлын өөрчлөлт, гадаадын зарим орнуудтай харьцуулан судалж сайжруулах, боловсронгуй болгох.

Түлхүүр үг: Улс төрийн нам, үзэл суртал, үзэл баримтлал, Их Британи, Холбооны Бүгд Найрамдах Герман улс.

Удиртгал

Өнөөдөр дэлхийн улс төрийн намууд тэр дундаа ардчилал амжилттай хөгжсөн гэгдэх өрнөдийн нөлөө бүхий томоохон улс орны улс төрийн намууд улс төрийн үзэл, бодлогын харьцангуй прагматик чиглэлийг баримжаалж буй нөхцөлд тэдгээр орнууд намуудын үзэл, онолын эрс, хатуу зааграл нийгэмд төдий шаардлагагүй болсон нь үнэн юм. Улс төрийн ийм орчинд намууд болон олон түмний улс төрийн үзэл, ухамсар, соёл харьцангуй өндөр түвшинд хүрсэн байх нь ойлгомжтой.

Улс төрийн намын тухай Монгол Улсын хууль 1990 онд батлагдаж 1991, 1996, 2005, 2020 онд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Европын орнуудын олон түмний намын бүтэц, зохион байгуулалтыг шууд хуулбарлах замаар намын хуулийн концепцийг боловсруулсан нь намуудыг төвлөрсөн, том нам байхыг шаардсан хууль болсон юм.²²² Төвлөрсөн гэдгийг сахилга баттай, нэгдсэн удирдлагатай байх, том гэдгийг орон даяар бүтэц зохион байгуулалттай, гишүүнчлэлтэй байх явдал гэж ойлгодог.

Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирголоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг”²²³ гэж тодорхойлсон байна. Монгол улсын Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд: “Нам нь Монгол улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол улсын иргэдийн нэгдэл мөн” гэжээ.

Намуудын улс төрийн баримт бичигт тусгагдсан үзэл санаа, тэдгээрийн үйл ажиллагааны шинж байдлаас үзэхэд улс төрийн нийтлэг зорилгодоо хүрэх арга зам, шийдэл нь нам бүрийн хувьд харилцан адилгүй байгаа билээ.

Улс төрийн намын үзэл суртал

Үзэл баримтлал гэдэг бол (латин хэлний *concretio* – хүртэхүй гэсэн үгнээс гаралтай бөгөөд англиар *concept*, оросоор *концепция*) бодит байдлын аль нэг үзэгдэл, үйл явцын тухай үзэл санааны систем бүхий тогтолцоо, бас тэдгээр үзэгдэл, үйл явцыг үзэж ойлгоход баримталдаг, хөтөч болдог үзэл санаа юм. Үзэл баримтлал нь байгаль, нийгмийн шинжлэх ухааны аль ч салбарт боловсрогдон гарч хэрэглэгдэж байдаг. Нийгмийн хөгжлийн талаарх шинжлэх ухааны үндэслэгээтэй, системчлэгдсэн үзэл санаа, ойлголт, итгэл үнэмшлийг цогцыг үзэл баримтлал гэнэ.

Нийгмийн амьдралын социал, эдийн засаг, улс төр, гадаад бодлого, экологи зэрэг бүхий л салбарыг хамарч үзэл баримтлал нь эцсийн дүндээ тухайн үндэстэн, түүнийг бүрдүүлэгч хувь хүмүүсийн эрх, эрх чөлөөг хангахад чиглэнэ.

Үзэл суртал гэдэг бол (идея буюу үзэл санаа, логия буюу судлал, сургаал гэсэн хоёр үгний нийлбэр утга бүхий ойлголт, англиар *ideology*, оросоор *идеология*) нийгмийн тодорхой бүлгийн үйл ажиллагааны туршлага, амьдралын нөхцөлөөс үүдэн бий болдог онол, үзэл санаа, эдгээрт үндэслэсэн үйл ажиллагааны удирдамжийг

²²² “Улс төрийн намын тухай хууль” 2005


²²³ Sartori G. Parties and Party System. London. 1976. P.23

багтаасан үзэл бодлын систем юм.²²⁴ Үзэл суртал нь энгийн ухамсараас гагцхүү онолын баримтлалтай байдгаараа чанарын хувьд ялгагддаг бөгөөд онолын үндэс, номлол нь боловсрогдсон нөхцөлд л тодорхой үзэл суртал болж чадна.

Улс төрийн үзэл суртал бол нийгмийн байгууллыг бүхэлд нь болон түүний социал, улс төр, эдийн засаг, оюун санааны амьдралын байгаа бодит байдал хийгээд тэдгээрийг цаашдаа хэвээр байлгаж бэхжүүлэх, эсвэл хувиргаж өөрчлөх зорилтыг нийгмийн тодорхой анги, давхрааны язгуур эрх ашиг, байр суурийн үүднээс системтэй тусган илэрхийлж томъёолсон улс төрийн онол, үзэл санаа, үндэслэлүүдийн нийлбэр цогц байдаг. Улс төрийн үзэл сурталыг тухайн анги давхрааны төлөөлөгч, тусгайлан бэлтгэгдсэн үзэл сурталч буюу мэргэжлийн хүмүүс, сэтгэгчид боловсруулдаг.


“Үзэл суртал”гэсэн нэр томъёог XVIII зуунд амьдарч байсан Францын эрдэмтэн Дэстют дэ Траси зохиол бүтээлдээ анх хэрэглэсэн гэдэг. Тэр үед үзэл санааны үүсэл, хөгжлийг судалдаг шинжлэх ухааныг ингэж нэрлэдэг байжээ.²²⁵

Их Британи улсын гол гурван намын бодлогын өөрчлөлт: Хамгийн их шилжилттэй нам нь хөдөлмөрийн нам байна. Одоогоос 30 жилийн өмнөх европын социал демократ намууд өдгөө илүү нео-либерал шинжтэй болсон байгааг графикаар үзүүлбэл:



²²⁴ Д.Болд-Эрдэнэ “Монголын улс төрийн нам, намын систем” УБ., 2008


²²⁵ МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2010 тал118



Герман улсын улс төрийн намуудын байр суурийг аваад үзвэл,
Тайлбар:

CDU –христийн ардчилсан эвсэл

SPD –социал демократ нам



Эх сурвалж нь: 2012 оны 11 сарын улс төрийн барометрийн судалгаа

Ардчилсан улс орнууд дахь социал демократ намууд нео-либерал эдийн засгийн бодлогыг баримтлах болсон билээ. Намуудын хооронд дахь үзэл сурталын ялгаа улам бүр ойртсон. Үүнийнэг тод жишээ нь, Данийн социал демократ засгийн газар тэтгэвэрийг бууруулж, хамгийн баян хүн амын хэсэгт татварын хөнгөлөлт

үзүүлээд зогсохгүй Сири лүү довтлох АНУ-ын төлөвлөгөөг “Социал демократ” ерөнхий сайд нь дэмжсэн. Германы социал демократуудыг зүүн жигүүрийнх гэж харагдахааргүй болж FDP буюу чөлөөт ардчиллагчид CDU –аас ч илүү либерал социал бодлого баримталж байна.

Эдийн засгийн асуудал, шинэ ажлын байр бий болгох тал дээр CDU социал демократуудаас илүү байгаа бол нийгмийн бодлогын тал дээр SPD илүү чадамжтай гэдэгт иргэд итгэлтэй байгаа нь графикаас шууд харагдаж байна. Герман улсын социал демократууд болон Христийн ардчилсан эвслийн бодлогын хамгийн том зөрөө нь татварын асуудал байна. SPD болон Ногоон намынхан 100.000 еврогоос дээш орлоготой иргэдээс 49 хувь (өмнө нь 42) татвар авах түүнчлэн Өв залгамжлалын татварыг хоёр дахин нэмэх, Орлогын татварыг 25-32 болгох зэрэг татварыг өөрчлөлтийн бодлогыг хүчтэй оруулж ирсэн байна. Шалтгаан нь орон нутгийн түвшинд ялангуяа боловсрол, дэд бүтцийг хөгжүүлэхэд илүү их хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж үзсэн. Эрх баригчид татварыг хэвээр үлдээж харин илүү үр дүнтэй татвар хураах, татварын онгорхой үлдээхгүй байх тал дээр анхаарч ажилладаг байна. Европын холбооны бодлого бүхэлдээ баруун тийш хазайсны дээрх зураглалаас харж болно. Бид өндөр хөгжилтэй орнуудын замыг дагаад яваад байвал өнөөгийн хөгжлийн түвшинд нь хэзээ хүрэх вэ? Хөгжлийн замыг товчилсон гэгддэг манай бүс нутгийн сингапур, Өмнөд Солонгос гээд “Азийн бар” орнуудын туршлага бидэнд хэрэгтэй юу? Монголын онцлог болох тархай сууршисан цөөн хүн ам, эрс тэс уур амьсгал зэрэг онцлог байдлаараа гуравдагч замыг түлхүү баримталдаг Канад, Скандинавын орнуудын туршлага сонирхол татах уу? гэсэн маргаан ч өрнөж байна. Дэлхийн ертөнц улам даяаршиж, даян дэлхийд чөлөөт зах зээлийн эдийн засаг тархаж, мэдээллийн чөлөөт урсгал, шинжлэх ухаан технологийн ололтууд сүүлийн 20 жил дэлхийн хөгжлийг тодорхойлох болсонтой холбогдуулан дэлхийн социалист хөдөлгөөний нэртэй удирдагчид шинэ нөцөл байдалд тохиорсон үзэл баримтлалын эрэлд гарсан билээ. Зах зээлийн эдийн засаг зүүний нийгмийн чиг баримжаатай бодлогыг хослуулах оролдлогыг 50-иад оноос эхлэн, 80-аад онд эрчимжиж ирсэн юм. Социалист систем задран бутарч, коммуникмын онол явцгүй гэдэг нь тодорхой болсон энэ үед социал демократ болон хөдөлмөрийн намууд хүчээ авч буй неолиберализмын үзлийн эсрэг Гуравдагч замын онолыг сэргүүлэн тавьсан билээ.

Баримт №1:

Монголын зарим улс төрийн намуудын хувьд өөрсдийн улс төрийн үзэл, онолоо улс төрийн үзэл, урсгалын аль хэсэгт хамаарахыг ил тод зарлахаас зайлсхийх тал ажиглагддаг. Иймд тэдгээр намуудыг харьцангуй прагматик чиглэлийн намууд гэж үзэж болох юм шиг санагддаг. Учир нь энэ намууд одоогоор хүн төрөлхтөний нийтээр хүлээн зөвшөөрсөн улс төрийн үзэл номлолын чухам аль чиглэлийг нь сонгож буйгаа ил тод зарлаагүй ч улс төрийн үзэл баримтлалын сонголтын асуудалд өвөрмөц байдлаар хандаж байдгаараа онцлог юм.


Үүнээс үзэхэд *нэгд*, улс төрийг намууд тодорхой нэг улс төрийн үзэл урсгалыг ягштал баримтлан шүтэх албагүй. Намын үзлийн сонголт чөлөөтэй "прагматик" шинжтэй байх ёстой; *хоёрт*, намууд улс төрийн үзэл баримтлалын сонголтоо хийхдээ аль болохоор улс орныхоо амьдралын бодит хөрс суурь, өвөрмөц онцлог, уламжлалт үзэл сэтгэлгээ, ахуй, иргэншлийн уламжлалт үнэт зүйлст тулгуурлах ёстой; *гуравт*, улс төрийн намуудын үзэл онолын нийтлэг шинж, төвлөрөн илэх гол цэг нь улс орны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал байх ёстой гэсэн үндэслэлүүдээр илэрч байдаг.

Баримт №2:

Өнөөгийн бидний үед хүн төрөлхтний орчин үеийн засаглалын хэлбэрүүдээс хамгийн сайн нь болох олон намын оролцоотой ардчилсан тогтолцоогоор төр, засгаа байгуулж байна. XX зууны эхэн хагаст У.Черчилын “Ардчилал бол засаглалын хамгийн муу хэлбэр, гэхдээ бид үүнээс сайн загварыг олоогүй байгаа” хэмээн хэлснийг дэлхийн хүмүүс өөрчилж чадаагүй ч хэт баруун болон хэт зүүнээс төврүүгээ таталцах хандлагаруу эрчимтэй урагшилж явна. Хэт баруунаас хэт зүүнийг хүртэлх орон зайд фашист, либерал, консерватив, социал демократ, социалист,

коммунистгэх мэтийн улс төрийн үзэл баримтлалууд оршдог. Дэлхийн улс төрийн намууд аль нэг үзэл номлолыг дагнан хэрэглэхээс илүү хосолмол хэлбэрийг сонгох, төврүү тэмүүлэх хандлага (Т.Блейр нарын гаргаж, манайд хуулахыг оролдож байсан “Гурав дахь зам /Third way/-ийн жишээ)-ыг түлхүү барих болсонд технологийн үсрэнгүй хөгжил, хүний ухамсарын хандлагын эрс өөрчлөлт, нөөц ашиглах хуваарилалт зэрэг хүчин зүйл шууд нөлөөлж буй нь мэдээж юм. Түүний зэрэгцээ технократуудыг шүтэх, эрэлхийлэх хандлага ч гадаад улсад төдийгүй манай оронд зарим талаар илэрч байна. Монголын хувьд зүүний буюу социал демократизмыг онолын иш үндсээ болгосон МАН, МАХН болон барууны ардчиллын либерализмыг тунхагласан АН, МҮАН, ИЗНН гэх цөөн хэдэн улс төрийн нам идэвхитэй ажиллаж байна. Хуулийн дагуу улсын дээд шүүхэд бүртгэлтэй 35 нам байх хэдий ч улс төрийн үзэл баримтлал нь тодорч төлөвших байтугай, үйл ажиллагаагаа эхлүүлж “бүртгэлийн манцуй”-наасаа сугараагүй намууд нэлээд хэд бий. Угтаа улс төрийн намууд ард түмний санаа бодлыг нэгтгэн зохион байгуулах, боломжтой хэлбэр (тухайлбал; уулзалт, хурал, цуглаан, жагсаал гэх мэт)-үүдээр илэрхийлэх, үзэл бодлын төсөөтэй хэсгийг нэгтгэн дагуулах хамгийн гол нь өөрийн үзэл баримтлалын хүрээнд улс орны хөгжил, бүтээн байгуулалтын хөтөлбөрөө боловсруулж, түүнийгээ үзэл суртлаараа дамжуулан түгээх үүрэгтэй. Гэвч манайд байгаа намууд энэ үүргээ биелүүлж чадахгүй байна. Харин зүүний нам нь барууны үйлдэл гаргах, барууны нам нь зүүний шинжтэй ажил зохион байгуулах төдийгүй олон нийтийг улс төрийн популист амлалтуудын доор улс төрийн үзэл баримтлалын гүнзгий төөрөгдөлд оруулах манлайлалд өрсөлддөг гэж дүгнэж болно.

Улс төрийн намуудын үзэл баримтлал



Монголын улс төрийн намуудыг ингэж үзэл номлолоор нь хатуу зааглан ангилах нь угтаа харьцангуй шинжтэй юм. Учир нь нийгэм дэх улс төрийн олон янзын үзэл бодлууд нь өвөрмөц давтагдашгүй шинжтэй байлаа гэсэн ардчилсан, хүмүүнлэг нийтлэг шинжээрээ шүтэлцэн авцалдаж, бие биенийхээ дотоод агуулгыг сэлбэн баяжуулж байдаг. Энэ тохиолдолд намуудын үзэл баримтлалд янз бүрийн үзэл санааны элементүүд агуулагдаж байх нь зүйн хэрэг. Тиймээс ч либерал шинж төрх бүхий намуудын үзэл баримтлалд социал-демократ, консерватив үзлийн элементүүд байх юм уу, эсвэл консерватив намын үзэл номлолд либерал болон бусад үзлийн элементүүд байх явдал түгээмэл ажиглагддаг. Энэ онцлог манай намуудад ч бүрэн хамаатай билээ. Дээр дурдсан ангилалын хувилбар нь онолын хувьд байж болох үндэслэл, таамаглалд шинжлэл судлалын ажлын эргэлтэнд оруулж буй хэрэг юм. Сүүлийн үед Монголын намуудад улс төрийн тогтвортой онол, үнэлэмж байхгүй, тэдгээр нь үзэл суртал, итгэл үнэмшлээрээ биш, харин зохион байгуулалттай засгийн эрхийн төлөө улайран тэмцэж буй хэсэг бүлэг цөөн хүмүүсийн бөөгнөрөл болсон гэсэн үзэл, байр суурийг манай зарим судлаачид хатуу илэрхийлдэг бөгөөд тэдгээрийн тоонд судлаач Д.Ганхуяг, Ч.Тамир нарыг дурдаж болно.

Тэд өөрсдийн гаргаж тавьсан дүгнэлтүүдээ тодорхой нотолсон олон сонирхолтой нийтлэлүүдийг бичиж, хэвлүүлсэн байдаг. Тухайлбал судлаач Д.Ганхуяг "Монголын төрийг зочид буудаё болгож байна" /Өнөөдөр.2005, № 286/, "Намуудын

мандал 61 бууралт" /Өдрийн сонин. 2005. № 286/ зэрэг нийтлэлүүддүү "Намууд социалист, либерал, консерватив гэх мэтийн улс төрийн эсэргүүцлийн (протест) аль нэг үзэл санааг тунхагладаг боловч энэхүү үзэл санааныхаа эх үндэс, түүх, өөрчлөлт, түүнийг... Монголын нийгэмд тохируулан буулгах, хэрэгжүүлэх, сурталчлах талаар зорилго чиглэлтэй үйл ажиллагаа огт явуулж байгаагүй юм. Иймээс Монголын намуудыг тунхаглан зарласан үзэл санаагаар нь ангилан үзэх нь ихээхэн учир дутагдалтай болно. Намуудын үзэл санаа нь улс төрийн лоозон төдий бөгөөд тэр нь ямагт хоёрдугаар зэргийн ач холбогдолтой байдаг" гэсэн нь сонирхолтой дүгнэлт хийсэн байдаг бол судлаач Ч.Тамир "Үзэл суртал, мөрийн хөтөлбөр, бодлого бидэнд бий юу?" /Шинэ толь. 2006, № 55/ өгүүлэлдээ "Үзэл баримтлал нь хүмүүсийн итгэл үнэмшлээс л эхтэй юм. Гэвч Монголд иргэний улс төрийн суурь үнэт зүйл бүрэлдээгүй, үзэл суртал нь хөгжиж чадсангүй... үзэл суртлаа зүгээр тунхаглаад орхих, хүмүүсийн итгэл үнэмшил болгох нь ялгаатай юм. Өнөөдрийн хямралын гол шалтгаан бол намууд үзэл сурталгүй болсон явдал юм. Үүний шалтгаан нь: *Нэгд*, Тодорхой үнэ цэнэ, итгэл үнэмшил, байр суурьгүй учраас эрх мэдэлд ойрхон хэсэг нь олигархи болж хувирхад амархан байна. *Хоёрт*. Намын тасрахдаа амархан, жирийн гишүүд ч удирдлагатайгаа үзэл суртлын амьд холбоо үгүй учир байнга тэдний араас зууралдах сонирхолгүй, тэр хэрээрээ дарга нар хариуцлага хүлээдэггүй. *гуравт*, Үзэл сурталгүй учир бодлого тодорхойгүй байна; *дөрөвт*, Улс төрийн тодорхой үнэт зүйл бүрэлдэж чадахгүй байгаагаас намууд өөр хоорондоо ялгарахгүй, сонгогчид ч үзэл суртал дагаж санал өгч хэвшихгүй байна" гэсэн зарчмын хувьд зөв зүйтэй анхаарал татсан дүгнэлт хийжээ гэсэн байр суурийг судлаач Доктор Д.Болд-Эрдэнэ өөрийн бүтээлдээ гаргаж тавьсан байна.

Өнөөдөр манайд намуудын тодорхой үзэл, номлолд суурилсан хөгжлийн тодорхой хөтөлбөр, үзэл суртал илт үгүйлэгдэж байна. Нийтлэг зорилгод хүрэх өвөрмөц арга зам, шийдлийн илрэл болсон намуудын тодорхой үзэл, хөтөлбөрүүд байж гэмээжин тэр дундаас монголын нийгмийн хөгжлийн жинхэнэ үзэл, баримтлал боловсрогдон томъёологдох учиртай юм.

Дэлхийн түвшинд ч асуудал мөн л ийм байгаа юм. Тухайлбал, Социнтерны сүүлийн үеийн баримт бичгүүдтэй танилцах явцад дэлхийн нийтийн хүрээний томоохон асуудлыг улс төрийн прагматик шийдлээр, хамтын хүч чармайлтаар шийдвэрлэх нь чухал боловч эцсийн дүнд зарчмын асуудлуудтай тулгарахдаа Социалист интернационалийн намууд тулгуур үзлийнхээ уламжлалт үнэт зүйлст үнэнч байж, чухам тэр хүрээнд асуудлыг шийдвэрлэх болно хэмээн онцлон заасан нь анхаарал татаж байгаа юм.

Түүнчлэн Манай улс төрийн намуудыг ямар ч үзэл сурталгүй хэмээн шууд үнэлэн дүгнэх нь ерөнхийдөө өрөөсгөл хандлага юм. Хэдийгээр монголын улс төрийн намуудын үзэл санааны хөгжлийн үйл явцад асар их бэрхшээл, асуудал тохиолдож буй боловч энэ бүхэн нь бидний үзэж байгаагаар цаг хугацаа, танин мэдэхүйн болон үйл ажиллагааны чадвар чадамж, эдийн засаг, оюун санаа, боловсон хүчний нөөц боломж, олон түмний дэмжлэг илтгэл тодруулж хэлбэл, шилжилтийн үеийн улс орнуудын намын дүр төрхийн нийтлэг илэрхийлэл, нийгмийг ардчилах үйл явцын боловсроогүй байдлын тусгал болж байгаа юм. Гэхдээ манай намууд цаг үеийн өөрчлөлт, хувьслын явцад үзэл санааны хувьд улам бүр хөгжиж цэгцэрч, орчин үеийн намуудын түвшинд хүрэх нь гарцаагүй.

Манай Үндсэн хуулинд улс орон, ард түмний зорилго, хүсэл эрмэлзлэлийг "улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх; хүний эрх, эрх чөлөө, шудрага ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж; хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж; эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" гэж нэгтгэн томъёолсон байдаг. Үндсэн хуулийн энэ заалт, үзэл санаа нь манай улс төрийн намуудын үйл ажиллагааны стратегийн зорилго, бодлогын гол агуулгыг илэрхийлж байгаа юм. Энэ нь уг чанартаа намууд хоорондоо үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж, хамтран ажиллах үндэс нь болж байдаг." Гэхдээ намуудын улс төрийн үйл ажиллагааны зорилго нэг нэгдмэл

байх нь түүндээ хүрэх арга зам, боломжнам тус бүрийн хувьд харилцан адилгүй, өвөрмөц онцлогтой байхыг үгүйсгэдэггүй. Үнэхээр ч намуудын улс төрийн баримт бичигт тусгагдсан үзэл санаа, тэдгээрийн үйл ажиллагааны шинжбайдлаас үзэхэд улс төрийн нийтлэг зорилгодоо хүрэх арга зам, шийдэл нь нам бүрийн хувьд харилцан адилгүй болох нь тодорхой байна.

Монголын улс төрийн намуудын нэг хэсэг нь нийтлэг зорилгоо хэрэгжүүлэхдээ бүх бодлогынхоо төвд хүнийг тавьж, хүний эрх, эрх чөлөө, хувийн овсгоо самбаа, санаачлага идэвхийг хөхүүлэн дэмжиж, нийгэмд хөрөнгөлөг чинээлэг давхарга, жижиг өмчтөнүүдийг олноор төрүүлэх замаар хувийн өмч, хувийн хэвшлийг Монгол орны эдийн засагт зонхилох чиглэлтэй болгохыг зорьж байхад нөгөө хэсэг нь нийгмийн амьдралын бүх талыг ардчилах, нийгэм хүмүүсийн эрх, эрх чөлөө, эв нэгдэл, шудрага ёсыг амьдралын бодит хэм хэмжээ болгон төлөвшүүлэх, эх болсон байгал дэлхийгээ хамгаалах асуудлыг төрийн бодлогын төвд тавьж, хүмүүсийг экологийн цэвэр сайхан орчинд амьдарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг баталгаажуулахыг сонирхож байдаг. Гэтэл гуравдах хэсэг нь улс орныхоо үндэсний онцлог, аж төрөх арга ухаан, нүүдлийн иргэншлийн өвөрмөц үнэт зүйлсийг орчин үеийн хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан сэргээж, улс орныхоо тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлийг онцлон үзэж байна. Ингэж нийтлэг зорилгодоо хүрэх арга зам нь нам тус бүрийн хувьд харилцан адилгүй байдаг нь:

- Улс төрийн намууд нийгэмд бодитой илэрч байгаа харилцан адилгүй олон янзын эрх ашиг, сонирхолын өвөрмөц тусгал болж байдагтай;
- Нам бүхэн амьдралын алив асуудлыг үнэлэн цэгнэх онол баримтлал, чиг бодлогын өөрийн гэсэн онцлогтой, улс төрийн үзэл бодлын үнэ цэнэтэй зүйлст тулгуурлаж байдгаар;
- Нийгмийн оюун санааны амьдралын олон ургальч шинж байдал, түүний зохистой тэнцвэрийг хангагч гол хүчин зүйл мөнийн хувьд намууд нь нийгмийн хөгжлийн бодит явцаар дэвшигдсэн аливаа асуудлыг шийдвэрлэхдээ өөрийн гэсэн өвөрмөц байр суурь, үзэл бодлын үүднээс хандаж байдагтай холбоотой юм.

Ардчилсан төрийн тогтолцоон дахь нам нь бусдаас ялгарах өөрийн гэсэн үзэл сурталтай байдаг. Энэ нь намын үйл ажиллагааны зорилгын үнэт зүйлсийн гол тулгуур, үндэс нь болдог.

Дүгнэлт

Үүнээс үзэхэд өнөө үед ямар ч улс төрийн үзэл урсгал өөрийн цэвэр сонгодог утгаараа оршин үйлчилж буй нь ховор юм. Харин тэдгээр нь хэлбэр агуулгаа ихээхэн өөрчилж барууны үзэл нь харьцангуй сүүнжиж, зүүнийх нь баруунжих хандлагатай болж байгаа юм.

Улс төрийн намуудын үзэл суртал нь төрийн бодлого, бүхэл бүтэн үзэл баримтлалын тулгуур нь болж өгөх учиртай. Пљураль ардчиллын нөхцөлд аль нэг үзэл суртлыг амьдрал дээр сонгуулийн дүнгээр парламентад олонхи суудал авсан намын үзэл суртал тухайн үедээ давамгайлах шинжтэй байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ сонгуулийн үр дүнгээс үл шалтгаалан залгамжлан авах зарчмууд суурь үнэт зүйлстэй байдгаараа төрийн бодлогын онцлогийг тодорхойлдог. Учир нь олон түмний сэтгэл санаа, оюун ухааныг эзэмдэн гарч ирсэн үзэл суртал төрийн өмнө тулгарч байгаа зорилтуудыг шийдвэрлэхэд том хүч нь болдог. Ийм учраас өнөөгийн нөхцөлд үзэл суртлын үүрэг, ач холбогдол өндөржиж байна. Намууд төрийн бодлого боловсруулж тодорхойлох гол институт болдогийн хувьд үзэл сурталтай байдаг. Үзэл суртал нь намыг дэмжсэн бүлгүүдийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалдаг үнэт зүйлсийн систем юм.

Үзэл суртал улс төрд чухал үүрэгтэйгээс гадна хүмүүсийн учир шалтгааныг тодорхойлох шинжтэй байдаг. Иймд намуудын үзэл баримтлалаар дамжуулж олон нийтийг нэгтгэх, нягтруулах, дайчлах хэрэгцээ их өсч байна. Нам үзэл суртлаа сайн боловсруулна гэдэг бол онолын болон практик мэдлэг чадварыг шаарддаг.

Сүүлийн үед үзэл суртлууд интеграчилагдаж байгаатай холбоотойгоор намууд ижилсэх, ойртох хандлагатай болж, төлөвшөөгүй, чадавхгүй, мөнгөтэй нэгний карьер хөөдөг хэрэгсэл болсон учраас олон нийт дургүйцэх нь ойлгомжтой. Үүний үр дүнд парламент ямар ч чадавхгүй болж харагдаж байна.

Санал

- Улс төрийн намууд гоё бодлого ярьж ирсэн ч түүнийгээ хэрэгжүүлэх санаачилга гаргах, манлайлах ямар ч идэвх оролцоогүй байна. Нам гэдэг байгууллага үзэл суртал дээрээ тулгуурлаад үнэт зүйлийг олборлодог уурхай байх үүрэг, зарчмаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Улс төрийн намууд үзэл суртлынхаа хувьд баруун, зүүн, төвийнх гэж нэрлэдэг ч бодлогын концепциос эхлээд улс төрчид нь хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- Улс төрийн намууд бодлого импортолж чадахгүй, үнэт зүйлгүй байгаагаас өнөөдөр яаж хагарч байгааг харж байна. Намд хувь хүн, бүлэг хоорондын талцал явагдаж байгаагаас биш ямар ч үнэ цэнэтэй маргаан алга. Тиймээс өнөөгийнх шиг үеэ өнгөрөөсөн улс төрийн намуудтай цааш явахгүй. Иймд Намуудын бодлогыг шинэчлэхгүйгээр ирээдүйгээ тодорхойлох боломжгүй байна.

Ном зүй

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
- Монгол Улсын намын тухай хууль 2005 он

Ном бүтээл

- Д.Болд-Эрдэнэ. “Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил, УБ.,2008.
- Э.Гэрэлт-Од. Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 2009
- М.Энхсайхан. “Орчин үеийн улс төрийн намууд”, УБ., 1996.
- G.Sartori. Parties and Party systems.London, 1976.
- Duverger M. Political Parties. London., 1970.
- W.Phillips Shively. “Power and choice”, Boston., 1997.
- МУИС “Улс төрийн шинжлэх ухаан”,УБ.,2010.
- А.Цанжид”Улс төрийн шинжлэх ухаан”УБ.,1996
- А.Цанжид”Социал демократ үзэл”УБ.,1995
- Улс төрийн боловсролын академи “Улс төр судлал”УБ.,1996
- “Монголын улс төрийн ууган байгууллага МАХН ба улс төрийн үзэл баримтлал.”УБ., 2010
- “Нийгмийн ардчиллын ирээдүй” Томас Майер, Николе Врайертай хамтран бүтээв УБ., 2009
- Сонгуулийн Ерөнхий Хороо <http://www.gec.gov.mn/>

Хавсралт

Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй намууд

№	Нэр	Нэрийн товчлол	Байгуулагдсан он	Гишүүний тоо	Тайлбар
1	Монгол ардын нам	МАН	1921.03.01	161,300	1924-2010 онд Монгол Ардын хувьсгалт нам (МАХН) нэртэй байсан
2	Ардчилсан нам	АН	2000.02.06	150,000	МҮАН, МСДН, МШАН,

					МАСМН, МоАН зэрэг нам нэгдэж байгуулагдсан
3	Монголын ногоон нам	МНН	1990.05.13	2,100	2012 онд ИЗНН-тай нэгдэхгүй гэсэн хэсэг нь намаа авч үлдсэн
4	Иргэний зориг ногоон нам	ИЗНН	2000.03.23	35,000	2002 онд БНН-тай нэгдэж Иргэний зориг- Бүгд найрамдах нам болсон ч 2006 онд эргэн ИЗН болсон.2012 онд МНН-ын хэсэгтэй нэгдэж ИЗНН болсон.
5	Монголын уламжлалын нэгдсэн нам	МУНН	1993.12.05	1,503	ММТНН, МХӨНН, МТТ зэрэг нам нэгдэж байгуулагдсан
6	Монголын либерал ардчилсан нам	МЛАН	1998.03.05	863	
7	Эх орон нам		1998.12.16	160,000	Монголын ардчилсан шинэ социалист нам (МАШСН) нэртэй үүсч, 2000 онд Эх орон- МАШСН, 2005 онд одоогийн нэрээ авсан
8	Монголын либерал нам	МЛН	1999.12.17	1300	МИАШЛН нэртэй үүссэн
9	Бүгд найрамдах нам	БНН	1992.04.07	50,000	2002 онд ИЗНН-тай нэгдэж, 2004 онд тусгаарлаж, 2006 онд шинээр бүртгүүлсэн
10	Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нам	МЭҮН	2003.12.16	1,069	
11	Монголын социал демократ нам		2004.12.19	3,000	1990-1999 онд МСДН байсан. 2000 онд бусад намуудтай нэгдэн АН-ын нэг хэсэг болсон.2004 онд намаа сэргээн байгуулсан.
12	Ард түмний нам	АТН	2005.12.11	11,859	
13	Монгол үндэсний ардчилсан нам	МУАН	2006.05.19	26,000	Үндэсний шинэ нам нэрээр байгуулдсан, 2011 онд нэрээ одоогийнхоор сольсон
14	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам		2006.10.09	1,600	

15	Иргэний хөдөлгөөний нам	ИХН	2007.08.17	815	
16	Хөгжлийн хөтөлбөрийн нам	ХХН	2007.10.28	933	
17	Монголын ардчилсан хөдөлгөөний нам		2008.02.01	850	
18	Монгол ардын хувьсгалт нам	МАХН	2011.01.28	35,000	МАХН нэрээ МАН болгож солихыг эсэргүүцсэн хэсэг олонхоосоо салан байгуулсан нам
19	Хамуг монголын хөдөлмөрийн нам	ХМХН	2011.09.23	2,000	
20	Хөдөлмөрийн Үндэсний Нам	ХҮН	2011.12.05	1,024	
21	Эх орончдын нэгдсэн нам	ЭОНН	2012.03.12	2,150	
22	Монгол консерватив нам	МКН	2012.06.20	959	
23	Тусгаар тогтнол, эв нэгдлийн нам	ТТЭНН	2015.04.18	3,131	
24	Ард түмнээ хайрлая нам	АТХН	2015.04.20	1,388	
25	Монголын хүний төлөө нам	МХТН	2017.02.17	1,135	
26	Үнэн ба зөв нам	ҮБЗН	2017.03.10	2,100	
27	Зон олны нам	ЗОН	2017.06.12	2,022	
28	Дэлхийн Монголчууд Нам	ДМН	2018.03.05	1800	
29	Ард түмний олонхийн засаглал нам	АТОЗН	2018.08.26	1080	
30	Их эв нам	ИЭН	2018.09.29	1056	
31	Гэр хороолол хөгжлийн нам	ГХХН	2018.11.28	1023	
32	Миний Монгол нам	ММН	2019.4.10	979	
33	Монгол шинэчлэлт нам	МШН	2018.10.19	1023	
34	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	ШИНЭН	2019.6.6	913	
35	Зүй Ёс нам	ЗЁН	2019.6.8	1533	

36	Ардчилал шинэчлэлийн нам		2019.12.18	893	
----	--------------------------------	--	------------	-----	--

ТӨГСӨГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ /ДХИС-ИЙН ЭЗНУС-ИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Д.Бадамцэцэг

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн
ахлах багш, докторант, цагдаагийн хошууч*

Э.Хишигбайгаль

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн
багш, докторант, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Бидний судалгаа төгсөгчдийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн уялдааг судлан, нэгтгэн дүгнэхэд чиглэсэн. Сургалтын хөтөлбөрийн чанарт төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлэмж нөлөөлдөг эсэхийг судлахдаа, мэдлэг түгээх байдал, хувийн ур чадвар, мэргэжлийн ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх байдал, оролцоо, карьер өсөлт, манлайлал, хэрхэн нөлөөлж байгааг дэлгэрэнгүй судаллаа. Бид төгсөгчийн сэтгэл ханамжид нөлөөлж буй хувьсагчдад олон хүчин зүйлийг шинжилгээ хийн үр дүнг гарган дараагийн судалгааны ажлын суурь үзүүлэлтийн үнэлгээг боловсруулах боломжийг ач холбогдол гэж үзэж байна.

Түлхүүр үг: Ур чадвар, мэдлэг, сэтгэл ханамж.

Удиртгал

Петр Картер, (2014), Дээд боловсрол дахь сэтгэл ханамж нь хугацаандаа багтан төгсөх, сэтгэл санааны сайн сайхан байдал, төгсөлтийн дараах амжилтаа хадгалсаны үр дүнд мэдэгдэж байгаа шалгуур байдаг. Тэрээр судалгааныхаа ажилд оюутнуудын дуу хоолой боловсролд ихээхэн хамаатай сэтгэл ханамжийг ойлгох судалгааны ажил болдог.

Жусин Чун, Жун Чол Шин нар (2018), “Солонгосын их сургуулийн багш нарын ур чадвар ба ажлын байрны сэтгэл ханамж” судалгаандаа ажлын талбар, ажлын байр, ажил үүрэг гэсэн 3 үзүүлэлтийг ажлын байрны сэтгэл ханамжийн нөлөөлөх хүчин зүйл гэж батлан судалжээ.

Дээрх эрдэмтдийн судалгааны ажлаас, дүгнэлтээс харахад, хүн ажлаасаа сэтгэл ханамж хүртэж чаддагтай адил оюутнууд, төгсөгчид сургалтын үйл явц, хөтөлбөр, багшийн заах арга барил, сургалтын орчин, сургалтын хөтөлбөрт оролцогч талуудын зэргээс сэтгэл ханамж хүртэх боломжтой.

Сэтгэл ханамж ба ур чадварын уялдаа холбоо


Сэтгэл ханамж: Хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн үйлчилгээнээс хүлээн авч буй чанар буюу тус бүтээгдэхүүнийг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг. Сэтгэл ханамж ажилчдын цалин, урамшуулал болон тэдний бодлоор авах ёстой гэж бодож байгаа хэрэгцээний түвшний нийлбэрүүдийн хоорондын харьцаагаар тодорхойлогддог. Сэтгэл ханамжтай байхын үндэс нь дотоод сэтгэлийн баялаг, амьдралд хандах идэвхтэй харьцаа байдаг. Сэтгэл ханамж өндөр байх нь ажилчдын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг учир аль болох өндөрт байлгах нь ашигтай. (П.Увш, 2004).

Төгсөгч: Сургалтын төлөвлөгөөний дагуу тухайн үндсэн мэргэшлийн хөтөлбөрийн заавал болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай судалж, тэнхим /профессорын багаас холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн хүн. Тухайн сургалтын байгууллагын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдаж, болзлыг бүрэн хангаж гэрчлэх баримтыг /диплом, сертификат/ авсан хүн.

Чадвар, ур чадвар, мэргэжлийн ур чадвар: Суралцагч мэдлэгээ хэрэглэх ур чадвар, нөгөө талаас гүйцэтгэл, практик чадамж нь юм. Мэдлэг болон дадал эзэмших үйлийн цогц байдлыг хангадаг, үйлдлийг гүйцэтгэхэд хүний эзэмшсэн аргууд.

Судлаачид чадварыг HARDSKILLS буюу гадаад чадвар, SOFTSKILLS буюу дотоод чадвар. Softskills, Hardskills-ийн холбогдолтой ойлголтуудыг судалгааны ажлуудад бүрхэг, ойлгомжгүй тайлбарласан байдаг тул уг нийтлэлд өргөн өнцгөөс тайлбар өгөв. Ур чадварыг “ажилтны мэдлэг, чадвар болон мэргэжлийн хувьд чухалд тооцогдох чанаруудын нийлбэр, байгууллагын стратеги зорилт болон албан тушаалд тавигдах шаардлагад нийцсэн, ажлыг амжилттай гүйцэтгэхэд шаардагдах шинж чанарууд, нийгмийн болон хөдөлмөрийн үзүүлэлт” гэж ойлгодог үүднээс тайлбарлах болно. Хүний мэргэжлийн салбарт гаргах амжилтын 85% нь дотоод ур чадвар, 15% нь гадаад ур чадвараас шалтгаалдаг. World Economic Forum-ийн шинжээчид таамаг дэвшүүлж 2020 онд эрэлттэй байх 10 гол чадварыг жагсаажээ. Судалгааны баг дээрх нэр томъёо, нэршилийг судлан олон эрдэмтдийн судалгааны ажлаас өөрийн судалгааны ажлын дараах загвар, таамаглалыг санал болгож байна. Үүнд:

Загвар №1. Төгсөгчдийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн уялдаа



Таамаглал-1.

Мэдлэгээ түгээх нь төгсөгчийн сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-2.

Хувийн ур чадвар нь төгсөгчийн сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-3.

Мэргэжлийн ур чадвар нь төгсөгчийн сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-4.


Өөрийгөө хөгжүүлэх нь төгсөгчийн сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлнө.

Тайлбар: Судалгааны багийн таамаглал

Судалгааны боловсруулалт

Судалгаанд нийт 2019, 2020 оны нийт төгсөгчдөөс 81 оролцогч хамрагдсан нь судалгааны боловсруулалт хийх шаардлага хангасан гэж үзэн SPSS-25.0, SMART-PLS 3.0 программаар боловсруулалт хийлээ /Хавсралт/.

Загвар №2. Төгсөгчдийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ /Algorithm/



Тайлбар: per sk-хувийн ур чадвар, prof sk-мэргэжлийн ур чадвар, kn.mgt-мэдлэг түгээх, per dev-өөрийгөө хөгжүүлэх, SAT-төгсөгчдийн сэтгэл ханамж

Хүснэгт №1. Төгсөгчдийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Хувьсагчид	Далд хувьсагч	Хүчин зүйлийн үр дүн	Кронбах Альфа	Нийлмэл найдвартай байдал	Дундаж хэлбэлзэл
Хувийн ур чадвар	per sk-1	0.952	0.968	0.975	0.790
	per sk-2	0.964			
	per sk-3	0.943			
	per sk-4	0.935			
	per sk-5	0.917			
Мэргэжлийн ур чадвар	prof sk-1	0.933	0.919	0.745	0.762
	prof sk-2	0.944			
	prof sk-3	0.661			
	prof sk-4	0.886			
	prof sk-5	0.911			
Мэдлэг түгээх	kn.mgt-1	0.893	0.932	0.949	0.790
	kn.mgt-2	0.941			
	kn.mgt-3	0.756			
	kn.mgt-4	0.919			
	kn.mgt-5	0.923			
Өөрийгөө хөгжүүлэх	per dev-1	0.877	0.804	0.745	0.440
	per dev-2	0.777			
	per dev-3	0.570			
	per dev-4	0.246			
	per dev-5	0.492			
Төгсөгчийн сэтгэл ханамж	SAT-1	0.870	0.975	0.977	0.769
	SAT-2	0.889			
	SAT-3	0.918			

SAT-4	0.891
SAT-5	0.891
SAT-6	0.920
SAT-7	0.889
SAT-8	0.874
SAT-9	0.874
SAT-10	0.802
SAT-11	0.878
SAT-12	0.897
SAT-13	0.760

Тайлбар: per sk-хувийн ур чадвар, prof sk-мэргэжлийн ур чадвар, kn.mgt-мэдлэг түгээх, per dev-өөрийгөө хөгжүүлэх, SAT-төгсөгчдийн сэтгэл ханамж

Төгсөгчдийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн хэмжил зүйн шинжилгээний үр дүнгээс дараах байдлаар хувьсагч бүрээр нь шинжиллээ. Үүнд:

Төгсөгчдийн хувийн ур чадварыг үнэлэн 5 далд хувьсагчаар судлахад хүчин зүйлийн үр дүн 0.917-0.964 хооронд хэлбэлзэж байгаа нь төгсөгчид хувийн ур чадварыг сайн гэж үнэлж байгаа нь илт байна гэж дүгнэх боломжтой, **Кронбах альфа утга 0.968** байгаа нь тухайн хувьсагчдын дотоод тогтвортой байдал, нэг хувьсагч болж нэгдэн уялдсан байдал маш сайн байгааг илэрхийлж байна. Нийлмэл найдвартай байдлын утга 0.975 байгаа нь маш сайн үр дүнг, дундаж хэлбэлзэл 0.790 байгаа нь сайн үр дүнг тус тус илэрхийлж байна. Бид энэхүү хувьсагчдийн Кронбах альфа утгыг SPSS-25.0 программаар давтан шалган шинжилж баталгаажуулсанг хувьсагч бүрийн доор нэмэлт тайлбаргүйгээр дүрслэн үзүүлээ

Reliability Statistics of Personal skills

Cronbach's Alpha	N of Items
.968	5

Тайлбар: Судалгааны үр дүн, SPSS-25.0

Мэргэжлийн ур чадварыг үнэлэн 5 далд хувьсагчаар судлахад хүчин зүйлийн үр дүн 0.661-0.944 хооронд хэлбэлзэж байгаа нь төгсөгчид мэргэжлийн ур чадварыг сайн гэж үнэлж байгаа ч 0.7 үр дүнд хүрэхгүй байгаа “Мэргэжлийн гадаад хэл эзэмшсэн байдал” далд хувьсагч 0.661 байгаа анхаарал татсанг анхаарах хэрэгтэй гэж дүгнэж байна. **Кронбах альфа утга 0.919** байгаа нь маш сайн үр дүнг, нийлмэл найдвартай байдлын утга 0.745 байгаа нь маш сайн үр дүнг, дундаж хэлбэлзэл 0.762 байгаа нь сайн үр дүнг тус тус илэрхийлж байна.

Reliability Statistics of Professional skills

Cronbach's Alpha	N of Items
.919	5

Тайлбар: Судалгааны үр дүн, SPSS-25.0

Мэдлэгээ хэрхэн үнэлж, түгээж байгаа байдлыг үнэлэн 5 далд хувьсагчаар судлахад хүчин зүйлийн үр дүн 0.756-0.923 хооронд хэлбэлзэж байгаа нь төгсөгчид мэдлэгээ сайн гэж үнэлж байгааг, **Кронбах альфа утга 0.932** байгаа нь маш сайн үр дүнг, нийлмэл найдвартай байдлын утга 0.949 байгаа нь маш сайн үр дүнг, дундаж хэлбэлзэл 0.790 байгаа нь сайн үр дүнг тус тус илэрхийлж байна. Төгсөгчид өөрийн мэдлэгийг мэргэжлийн ур чадвараас арай ахицтай гэж үнэлсэн нь өмнөх хувьсагчдын үр дүнгээс өссөн байгаагаас дүгнэх боломжтой.

Reliability Statistics of Knowledge sharing

Cronbach's Alpha	N of Items
.932	5

Тайлбар: Судалгааны үр дүн, SPSS-25.0

Өөрийгөө хөгжүүлэх, өөрийн мэдлэг чадвараа хэрхэн өсгөж байгааг үнэлэн 5 далд хувьсагчаар судлахад хүчин зүйлийн үр дүн 0.246-0.877 хооронд хэлбэлзэж байгаа нь төгсөгчид өөрийгөө хөгжүүлэхэд анхаардаггүй, нийт 5 далд хувьсагчийн 3 далд хувьсагч болох Ажлын байранд богино хугацааны сургалтад хамрагсан байдал /1-5 хоногийн сургалт/ 0.570, Гадаад улсад богино хугацааны сургалтад биечлэн болон цахимаар хамрагдсан байдал /5-21 хоногийн сургалт/ 0.246, Бусад сургалтад хамрагдсан байдал /7-21 хоногийн сургалт/ 0.492 байгаагаас манай сургууль төгсөгчидтэй хамтран ажиллаж, богино хугацааны сургалт зохин байгуулах, төгсөгчийг хөгжүүлэх шаардлага байгаа гэж дүгнэж байна. **Кронбах альфа утга 0.804** байгаа нь сайн үр дүнг, нийлмэл найдвартай байдлын утга 0.745 байгаа нь маш сайн үр дүнг, дундаж хэлбэлзэл 0.440 байгаа нь дунд үр дүнг тус тус илэрхийлж байна. Энэхүү хувьсагч энэ загварт таамаглал болгон дэвшүүлсэн хувьсагчдаас хамгийн их анхаарал татаж байгааг бид анхаарах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Учир нь дундаж хэлбэлзэл 0.5 үнэлгээнд хүрэхгүй байгаа тохиолдолд хувьсагчийг дахин судалж, цаашид сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг эрдэмтэд санал болгодог. Кронбах альфа утгыг 2 программ хооронд 0.012 утгын зөрүү гарсан ба энэ нь ерөнхий үр дүнд нөлөөлөхгүй гэж дүгнэж байгаа.

Reliability Statistics of Self-development

Cronbach's Alpha	N of Items
.816	5

Тайлбар: Судалгааны үр дүн, SPSS-25.0

Төгсөгчийн сэтгэл ханамжийг бид 13 далд хувьсагчаар судалсан нь бусад судалгааны ажлуудтай харьцуулахад маш их мэдээлэл цуглуулах, төгсөгчдийн сэтгэл ханамжийн үр дүнгээс хэд хэдэн хүлээлт үүсгэсэн үр дүнг харах боломжтой гэж үзсэн. Сэтгэл ханамжийн далд хувьсагчийг судлахад хүчин зүйлийн үр дүн 0.760-0.920 хооронд хэлбэлзэж байгаа нь төгсөгчид сэтгэл ханамжаа сайн үнэлж байгааг, **Кронбах альфа утга 0.975** байгаа нь маш сайн үр дүнг, нийлмэл найдвартай байдлын утга 0.977 байгаа нь маш сайн үр дүнг, дундаж хэлбэлзэл 0.769 байгаа нь сайн үр дүнг тус тус илэрхийлж байна. Төгсөгчдийн сэтгэл ханамжтай байдал нь бусад хувьсагчдаас харьцангуй үнэлэмж өндөр байгаа нь харагдаж байна. Өмнөх хувьсагчтай адил, Кронбах альфа утгыг 2 программ хооронд 0.001 утгын зөрүү гарсан ба энэ нь ерөнхий үр дүнд нөлөөлөхгүй гэж дүгнэж байна.

Reliability Statistics of Graduates' satisfaction

Cronbach's Alpha	N of Items
.974	5

Тайлбар: Судалгааны үр дүн, SPSS-25.0

Тайлбар: Судалгааны үр дүн, SPSS-25.0, хувьсагчдын Кронбах альфа утгын харьцуулалт

Хүснэгт 2. Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээ

№	Хувьсагчид	[A]	[B]	[B]	[C]	[D]
1	Төгсөгчийн сэтгэл ханамж [A]	0.877				
2	МэдлэгТүгээлт [B]	0.688	0.889			
3	Хувийн ур чадвар [B]	0.732	0.785	0.942		
4	Мэргэжлийн ур чадвар [C]	0.689	0.900	0.789	0.873	
5	Өөрийгөө хөгжүүлэлт [D]	0.567	0.600	0.557	0.605	0.633

Тайлбар: Судалгааны үр дүн

Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээг SMART PLS-3.0 программаар шинжилсэн ба хамгийн их хамааралтай байгаа хувьсагчид нь төгсөгчийн сэтгэл ханамж 0.877, төгсөгчийн мэргэжлийн ур чадвар ба мэдлэг түгээлт хоорондоо 0.900, хувийн ур чадварын хамаарал үнэлгээ 0.942, мэргэжлтийн ур чадвараа үнэлсэн хамаарал 0.873 гэсэн үнэлгээтэй байгаагаас эдгээр хувьсагчдын төгсөгчид сайн үнэлсэнтэй шууд хамааралтай гэж дүгнэж байна. Хамгийн бага хамааралтай байгаа хувьсагчдын хувьд, өөрийгөө хөгжүүлэх болон төгсөгчийн сэтгэл ханамж 0.567, өөрийгөө хөгжүүлэн мэдлэг түгээж байгаа байдал 0.600, өөрийгөө хөгжүүлэн хувийн ур чадвараа хөгжүүлэх хамаарал 0.605 байгаагаас бид төгсөгчөө хөгжүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй гэж дүгнэлтийг өгөх боломж байгааг шинжилгээний үр дүн бодитоор харуулж байна.

Хүснэгт 3. Замын шинжилгээний үр дүн

Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хэлбэлзэл	T статистик утга	P үнэ цэнэ	Үр дүн
Хувийн ур чадвар-> TCX	0.429	0.149	2.926	0.004	Батлагдсан.
Мэргэжлийн ур чадвар-> TCX	0.146	0.173	0.700	0.484	Батлагдсангүй.
Мэдлэг түгээх-> TCX	0.115	0.189	0.717	0.473	Батлагдсангүй.
Өөрийгөө хөгжүүлэх-> TCX	0.174	0.104	1.629	0.104	Батлагдсангүй.

Тайлбар: Судалгааны үр дүн, TCX-Төгсөгчийн сэтгэл ханамж

Бид замын шинжилгээний үр дүнг SMART PLS-3.0 программын bootstrapping шинжилгээний үр дүнгээр таамаглал батлагдаж буй байдлыг тусгайлан шинжилсэн.

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, хувийн ур чадвар төгсөгчийн сэтгэл ханамжид нөлөөлнө таамаглалын хувьд дундаж утга 0.429, стандарт хэлбэлзэл 0.149, T статистик утга 2.926, P үнэ цэнэ 0.004 үр дүнтэйгээр таамаглал батлагдсан. Мэргэжлийн ур чадвар төгсөгчийн сэтгэл ханамжид нөлөөлнө таамаглалын хувьд дундаж утга 0.146, стандарт хэлбэлзэл 0.176, T статистик утга 0.700, P үнэ цэнэ 0.484 үр дүнтэйгээр таамаглал батлагдсангүй. Мэдлэгээ түгээх нь төгсөгчийн сэтгэл ханамжид нөлөөлнө таамаглалын хувьд дундаж утга 0.146, стандарт хэлбэлзэл 0.176, T статистик утга 0.700, P үнэ цэнэ 0.484 үр дүнтэйгээр таамаглал батлагдсангүй. Өөрийгөө хөгжүүлэх нь төгсөгчийн сэтгэл ханамжид нөлөөлнө таамаглалын хувьд дундаж утга 0.176, стандарт хэлбэлзэл 0.104, T статистик утга 1.629, P үнэ цэнэ 0.104 үр дүнтэйгээр таамаглал батлагдсангүй. Бид таамаглал батлагдаагүй хувьсагчдыг олон улсын их дээд сургуулиудын төгсөгчдийг мөшгих судалгааны үр дүнтэй харьцуулахад төгсөгчөө давтан сургалтад байгааг хамруулдаг, төгсөгчийн дараах сургалтын төв ажиллууддаг их дээд сургуулийн судалгааны үр дүн сайн байсантай харьцуулан туршлага судлах шаардлагатай байгааг шинжилгээний үр дүнгээс олж харлаа.

Дүгнэлт

ДХИС-ийн ЭЗНУС-ийн төгсөгчдийг 2020-2021 оны хичээлийн жилд 2 удаагийн давтамжтай, судалгаануудын асуумжууд хоорондоо өөр өөр хувьсагчтайгаар судалсан. Энэхүү судалгаа нь боловсруулалтын хувьд өмнөх судалгааны ажлаас олон хүчин зүйлийн шинжилгээг хийснээрээ онцлог давуу талтай гэж дүгнэж байна.

Судалгааны үр дүнгээс, төгсөгчдийн өөрийгөө хөгжүүлэхэд нь анхаарч сургуулийн зүгээс цаашид хамтран ажиллах, давтан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах боломжтой гэж үзэж байна. Суурь судалгааны ажлын дүгнэлтэд

авахдаа зарим хувьсагчийг ахин судалж, харьцуулан дүгнэх шаардлагатай гэсэн уялда ахангагдсан гэж дүгнэж байна. Бид судалгаанаас гарсан үр дүнг бүх багш нарт танилцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад анхаарах зүйлийн талаар энэхүү судалгааны ажлынхаа тайланд тусгаж өгсөнг ач холбогдол гэж үзэж байна.

Судалгааны ажлын давуу тал:

- Онолын үндэслэлтэй загвар боловсруулсан.
- Загвартаа таамаглал дэвшүүлж судалсан.
- Таамаглалыг батлагдсан эсэхийг программын тусламжтай шинжилсэн.
- Хувьсагч бүрийн үр дүнг дэлгэрэнгүй тайлбарласан.
- Судалгааны үр дүнгээр олон улсын эрдэм шинжилгээний өгүүлэл бичих эхлэл тавигдсан.
- Хувьсагч бүрийн дундаж үзүүлэлтийг дүрслэн харуулсан.

Судалгааны ажлын сул тал:

- Олон улсын ижил төстэй судалгааны ажилтай харьцуулахад таамаглал батлагдаагүй.
- Судалгааны боловсруулалтын ерөнхий мэдээлэлд график дүрслэл оруулаагүй.

Судалгааны хязгаарлагдмал байдал:

- Хугацааны хувьд нэг удаагийн тандалттай судалгаа байсан.
- Олон улсын судалгааны ажилтай хувьсагчийн нарийвчлан харьцуулаагүй.

Судалгааын ажлыг жил бүр авч, харьцуулалт хийн цуврал болгохыг санал болгож байна.

Ном зүй

Сурах бичиг:

- Г.Амартогтох, “Хүний нөөцийн онол практик”, УБ., 2016 он
- Б.Батсайхан, М.Дэлгэржав “Боловсрол судлалын тайлбар толь” УБ., 2019 он
- Д.Болормаа, “Менежмент”, УБ., 2001 он
- Н.Бэгз, “Монголын боловсрол судлалын шинэ парадигм”, УБ., 2017 он
- Н.Чулуундорж. Мэдлэгийн менежмент, УБ, 2001 он
- П.Мөнхтогт, Мэдлэгийн менежмент, УБ, 2014 он
- Л.Наранцэцэг, Стратегийн менежмент, УБ, 2012 он
- Б.Намсрай, “Эдийн засгийн онолын түүх”, УБ., 1999 он
- Ч.Пүрэвдорж, “Менежментийн Удирдлага”, УБ., 2002 он
- Б.Цэрэндорж, “Хүний нөөцийн удирдлага” сурах бичиг, Улаанбаатар хот, 2005 он
- Н.Цэнд Н, Г.Батхүрэл, Ц.Цэцэгмаа нар “Менежмент”. УБ., 2013 он
- Л.Эрдэнэсүвд, “Бизнесийн статистик”. УБ., 2008 он

Олон улсын судалгаа:

- Battogtokh. D, (2012), Mediation effect of Knowledge Management in the relationship between Technology and Organizational Effectiveness – an Empirical, Study of Mongolian Academy of Sciences, Oral Presentation, Feb 2012 at 17:12.
- Bayasgalan Tsogtsuren, (2015), Job Satisfaction as a Determinant of Effective Performance on Academic Staff in Selected Public and Private Universities in Mongolia, The Korean Journal of Policy Studies, Vol. 30, No. 1 (2015), pp. 115-145. 160
- Bolormaa. D, (2015), Knowledge management capability level assessment of the higher education institutions: Case study from Mongolia, Procedia - Social and Behavioral Sciences 174 (2015), 3633 – 3640.

Интернэт эх үүсвэр:

- <http://en.wikipedia.org/wiki/Motivation>
- <http://www.scribd.com/search?query=compensation>
- <http://en.wikipedia.org/wiki/Compensation>
- <http://www.thefreedictionary.com/compensation>